



**БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН  
ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ**



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

Хөгжлийн  
Агентлаг

Швейцарийн  
Хөгжлийн  
Агентлагийн  
Санхүүжилтээр

Энэхүү судалгааг "Тогтвортой Хөгжлийн Боловсрол"  
төслийн хүрээнд боловсруулав.

**Захиалагч:** "ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ" ТӨСӨЛ

**Гүйцэтгэгч:** НИЙГМИЙН БОДЛОГО, ХӨГЖЛИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

Швейцарийн Хөгжлийн  
Агентлагийн санхүүжилтээр хэвлэв.

© 2016. ESD project

## АГУУЛГА

<b>СУДАЛГААНЫ БАГ</b> .....	<b>3</b>
<b>ТОВЧИЛСОН ҮГС</b> .....	<b>4</b>
<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>5</b>
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>7</b>
<b>УДИРТГАЛ</b> .....	<b>8</b>
Боловсролд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар олон улсын хэрэгжүүлж буй зорилт арга хэмжээ .....	12
Боловсролд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар төрөөс бодлого, эрх зүйн орчны хувьд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ .....	13
Боловсролын салбарт жендэрийн тулгамдсан асуудлуудын судлагдсан байдлын тойм .....	16
“Ерөнхий боловсролд жендэрийн дүн шинжилгээ” судалгааны зорилго .....	19
<b>СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ</b> .....	<b>21</b>
Судалгааны зорилго: .....	21
Мэдээлэл цуглуулах аргачлал .....	21
Түүврийн загвар .....	22
Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт, дүн шинжилгээ .....	23
<b>БҮЛЭГ 1. ЖЕНДЭРИЙН НИЙЦТЭЙ СУРГУУЛИЙН ОРЧИН</b> .....	<b>24</b>
1.1 Бага болон суурь боловсролын чанар, хүртээмж .....	24
1.1.1 Сургуульд элсэлт, хамрагдалт ба төгсөгчдийн харьцаа .....	24
1.2 Сургуулийн эрүүл, аюулгүй орчин .....	29
1.2 Хичээлээс гадуурх сургалт, хүмүүжлийн ажил .....	33
1.4 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, мэргэжил сонголт .....	35
<b>БҮЛЭГ 2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ОРЧИН</b> .....	<b>40</b>
2.1 Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь жендэрийн тэгш байдал .....	40
2.2 Сургуулиудын баримт бичиг дэх жендэрийн бодлогын талаарх зохицуулалт .....	46
<b>БҮЛЭГ 3. ЦӨМ ХӨТӨЛБӨР, ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖИЛГЭЭ</b> .....	<b>51</b>
3.1 Ерөнхий боловсролын сургалтын 12 жилийн болон цөм хөтөлбөр дэх жендэрийн дүн шинжилгээ .....	51
3.1.1 Үндэсний хэмжээний сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц .....	51
3.1.2 Бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн жендэрийн мэдрэмжит байдал .....	52
3.1.3 Монгол хэл, нийгмийн ухааны судлагдахууны бага боловсролын цөм хөтөлбөрийн жендэрийн мэдрэмж .....	54
3.1.4 Монгол хэл, нийгмийн ухааны суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн жендэрийн мэдрэмж .....	55
3.1.5 12 жилийн сургуулийн монгол хэл, нийгмийн ухааны 10-12 ангийн сургалтын хөтөлбөрийн жендэрийн мэдрэмж .....	56
3.2 Багш нарын хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээний үр дүн 58	
3.2.1 Багш нарын хөтөлбөрийн жендэрийн дүн шинжилгээ: тэгш боломж олгож буй байдал .....	58
3.2.2 Хөтөлбөрийн агуулга ба жендэрийн асуудлууд .....	61
3.3 Сурах бичигт хийсэн жендэрийн дүн шинжилгээ: Монгол хэл, нийгмийн ухаан 62	
3.3.1 Сурах бичгийг зохиох үйл явц .....	62
3.3.2 Сурах бичигт хийсэн жендэрийн дүн шинжилгээ .....	63
3.3.3 Сурах бичиг дэх жендэрийн дүр-үүргийн шинжилгээ .....	65
3.3.4 Сурах бичиг дэх жендэрийн ялгаанд холбогдох бусад асуудлууд .....	70

<b>БҮЛЭГ 4. ЖЕНДЭРИЙН НИЙЦЭМЖТЭЙ БАГШЛАХУЙ БА СУРАЛЦАХУЙ .....</b>	<b>75</b>
4.1 Жендэрийн мэдрэмжтэй багшлахуй .....	75
4.2 Хичээлийн танхимын зохион байгуулалт ба багш сурагчдын харилцан үйлдэл .....	80
4.2.1 Жендэрийн нийцэмжтэй хичээлийн танхим .....	80
4.2.2 Жендэрийн мэдрэмжтэй ангийн динамик .....	81
4.3 Суралцах үйл ажиллагаан дахь жендэрийн хэв шинж .....	84
4.3.1 Суудал хуваарилалт сургалтад нөлөөлөх нь .....	84
4.3.2 Охид хөвгүүдийн суралцах үйл ажиллагаан дахь ялгаатай байдал .....	85
4.4 Багш бэлтгэх, давтан сургахад жендэрийн агуулгыг тусгах хэрэгцээ ба хэрэгжүүлэх арга зам .....	92
4.4.1 Багш бэлтгэх сургуулиудын хөтөлбөрт жендэрийн агуулгыг тусгасан байдал .....	92
4.4.2 Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд жендэрийн агуулгыг тусгасан байдал .....	95
<b>БҮЛЭГ 5. ЖЕНДЭРИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА 98</b>	
5.1 Эцэг эхчүүдийн жендэрийн талаарх хандлага 98	
5.1.1 Эцэг эхчүүдийн жендэрийн үүрэг, жендэрийн хэвшмэл ойлголт.....	98
5.1.2 Эцэг эхчүүдийн охид, хөвгүүдийн боловсролд хандах жендэрийн хандлага .....	100
5.2 Сурагчдын жендэрийн талаарх ойлголт мэдлэг, хандлага .....	109
5.2.1 Сурагчдын жендэрийн үүрэг, жендэрийн хэвшмэл ойлголт.....	109
5.3 Багш нарын жендэрийн ойлголт, хандлага .....	112
5.4 Сургуулийн удирдах ажилтнуудын жендэрийн ойлголт, хандлага .....	115
5.5 Сургууль дахь жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт ба хүчирхийллийн талаарх үзэл, хандлага .....	120
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>124</b>
<b>ЗӨВЛӨМЖ.....</b>	<b>129</b>
<b>НОМЗҮЙ .....</b>	<b>133</b>

## СУДАЛГААНЫ БАГ

### Судалгааны багийн ахлагч

Ц.Одгэрэл МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн докторант

### Судалгааны багийн гишүүд

С.Түмэндэлгэр	МУБИС-ийн багш, доктор, проф
Т.Бүрэнжаргал	МУИС-ийн багш, доктор, проф
С.Цэнгэлмаа	Судлаач, Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэн
Н.Болдмаа	МУИС-ийн багш, доктор, проф
Д.Оюунцэцэг	МУИС-ийн багш
Б.Доржпагма	Судлаач, Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэн

Тус судалгааны тайланд тусгагдсан дүгнэлтүүд зөвхөн судалгааны багийн гишүүдийн байр суурийг илэрхийлж буй болно.

## ТОВЧИЛСОН ҮГС

АУБ	Анги удирдсан багш
БЗД	Баянзүрх дүүрэг
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БСШУ	Боловсрол соёл шинжлэх ухаан
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
БСГ	Боловсрол соёлын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЕБ	Ерөнхий боловсрол
ЗАН	Заах аргын нэгдэл
ЛГБТ	Лесби, гей, бисексуаль, трансжендэр
МАА	Мал аж ахуй
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МУ	Монгол улс
МУБИС	Монгол улсын боловсролын их сургууль
МУИС	Монгол улсын их сургууль
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТҮБД	Төрийн үйлчилгээний бага, дунд
УБ	Улаанбаатар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЭМ	Эрүүл мэнд

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Судалгаанд хамрагдсан хүн ам, аргаар, байршлаар .....	22
Хүснэгт 2	Экспертийн ярилцлагын түүвэрлэлт .....	23
Хүснэгт 3	ЕБС-ийн суурь үзүүлэлтүүд, 2005/06–2013/14) .....	24
Хүснэгт 4	ЕБС-ийн суурь үзүүлэлтүүд, хүйсээр .....	25
Хүснэгт 5	ЕБС-ийн суурь үзүүлэлтүүд, хүйс болон байршлаар .....	25
Хүснэгт 6	ЕБС-д суралцдаггүй (сургууль завсардсан) 6-14 насны хүүхдийн тоон мэдээлэл .....	26
Хүснэгт 7	Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн, ерөнхий шалгалтын 10 хичээлээр болон шалгуулагчдын хүйсээр .....	27
Хүснэгт 8	Багш нарын тоо, хүйсээр, байршлаар .....	28
Хүснэгт 9	ЕБС-ийн багш нарын мэргэжлийн зэрэг болон сургалтанд хамрагдсан байдал, хүйсээр .....	28
Хүснэгт 10	Сургуулийн гадаад орчны ерөнхий мэдээлэл .....	30
Хүснэгт 11	ЕБС-иудын эрэгтэй эмэгтэй сурагчдыг бие засах байраар хангасан байдал .....	32
Хүснэгт 12	Сургуулийн дотоод орчинтой холбоотой ерөнхий мэдээлэл .....	33
Хүснэгт 13	Хүмүүжлийн ажлын төлөвлөгөө боловсруулахад охид, хөвгүүдийн оролцоог хангаж буй байдал .....	34
Хүснэгт 14	Сурагчдын мэргэжил сонголтод сургуулийн удирдах ажилтан, багш нар, эцэг эхийн оролцоо .....	35
Хүснэгт 15	Үндсэн багш нарын тоо, хүйсээр, 2004-2015 он .....	40
Хүснэгт 16	Сургуулийн удирдах ажилтнуудын тоо, хүйсээр, хувиар 2014-2015 оны хичээлийн жил, тоогоор, хувиар .....	42
Хүснэгт 17	Мэргэжлийн зэрэг олгох зарим шалгуур үзүүлэлт .....	45
Хүснэгт 18	Хөтөлбөрийн зарчим, зорилго (бага болон суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр) .....	52
Хүснэгт 19	Сургалтын арга зүй .....	53
Хүснэгт 20	Нийгмийн ухааны суурь боловсролын агуулга дахь жендэрт холбогдох гол санаанууд .....	56
Хүснэгт 21	10-12 ангийн Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрийн жендэрт холбогдох агуулга .....	57
Хүснэгт 22	Сургалтын хэрэглэгдэхүүн дэх жендэрийн дүр үүрэг, шинжүүд (судлагдсан багш нарын хөтөлбөр дэх агуулгын шинжилгээний үр дүнгээс) .....	62
Хүснэгт 23	Дүн шинжилгээ хийсэн сурах бичгийн нэрс, ангиар .....	64
Хүснэгт 24	Сурах бичгийн зураг дүрслэл, эх дэх жендэрийн дүр үүргүүд (хувиар, агуулгын шинжилгээ) .....	66
Хүснэгт 25	Зураг дүрслэл, эх дэх жендэрийн шатлал (хувиар) .....	72
Хүснэгт 26	Охидтой харилцах ур чадвар аль хүйсийн багшид илүүтэй ажиглагддаг вэ? /багш нарын хариулт/ .....	75
Хүснэгт 27	Сурагчдын бодлоор эрэгтэй, эмэгтэй багшийн ялгаатай ур чадвар, сурагч болон багшийн хүйсээр.....	75
Хүснэгт 28	Эрэгтэй, эмэгтэй багшийн сурагчдыг чиглүүлэх ур чадварын ялгаатай байдал .....	76
Хүснэгт 29	Эрэгтэй, эмэгтэй багшийн сурагчидтай ганцаарчлан, ойр ажиллах байдал .....	76
Хүснэгт 30	Эрэгтэй, эмэгтэй багшийн ангийн нийт сурагчидтай ажиллах байдал .....	76
Хүснэгт 31	Анги доторх багшийн хөдөлгөөний дундаж, сурагчдын хүйсээр .....	82
Хүснэгт 32	Багш сурагчдын хоорондын харилцан үйлдлийн тоо, багшийн хүйсээр .....	82
Хүснэгт 33	Багш сурагчийн харилцсан хугацаа, хүйсээр .....	83
Хүснэгт 34	Багштай харилцахад суудлын зохион байгуулалт нөлөөлөх байдал, охид болон хөвгүүдийн хувиар .....	84
Хүснэгт 35	Хэн нь хичээлээ илүү сонирхолтой хэлбэрээр заадаг вэ? .....	85
Хүснэгт 36	Хэн нь таны хичээлийг илүү суралцаж байна вэ? .....	85

Хүснэгт 37	Багш нарын заадаг судлагдахуунд охид хөвгүүдийн ялгаа, хувиар .....	86
Хүснэгт 38	Эрэгтэй багш нарын багшлах үйл ажиллагаан дахь жендэрийн ялгаатай хандлагын талаарх сурагчдын үзэл баримтлал .....	87
Хүснэгт 39	Эмэгтэй багш нарын багшлах үйл ажиллагаан дахь жендэрийн ялгаатай хандлагын талаарх сурагчдын үзэл баримтлал .....	88
Хүснэгт 40	Сурагчдын хамгийн дуртай хичээлийг анги, хүйсээр харьцуулсан байдал .....	90
Хүснэгт 41	Сурагчдын хамгийн дургүй хичээлийг анги, хүйсээр харьцуулсан байдал .....	91
Хүснэгт 42	Багш нарыг дахин бэлтгэж буйд байдал, хүйс болон байршлаар .....	96
Хүснэгт 43	Гэр бүлд нөхөр, эхнэрийн үүргийн талаар судалгаанд оролцогчдын үзэл хандлага, хүйсээр (n=290) .....	99
Хүснэгт 44	Эрэгтэй, эмэгтэйчүүд гэр бүлдээ ялгаатай үүрэг хүлээж буй талаарх эцэг эхчүүдийн үзэл хандлага .....	99
Хүснэгт 45	Ирээдүйд хүү охиндоо боловсрол эзэмшүүлэх талаарх эцэг эхчүүдийн хүлээлт, хүйсээр(n=290) .....	100
Хүснэгт 46	Охин, хүүгийнхээ хэнийг нь үргэлжлүүлэн сургах талаарх эцэг эхчүүдийн санаа бодол, хүйсээр .....	101
Хүснэгт 47	Эцэг эхчүүдийн охид хөвгүүдийн боловсролд хандах хандлага, хүйсээр .....	101
Хүснэгт 48	Хүүхдэд хичээл заадаг эрэгтэй, эмэгтэй багшийн багшлах үйл ажиллагааны талаарх ээж, аавуудын жендэрийн төсөөлөл (n=290) .....	102
Хүснэгт 49	Эцэг эхчүүд хүүхдийнхээ багшаар сонгохдоо аль хүйсийн багшийг илүүд үзэж буй талаарх үзэл хандлага.....	103
Хүснэгт 50	Охид хөвгүүдийн талаарх дараах ойлголтуудтай санал нийлж буй байдал, хүйсээр.....	105
Хүснэгт 51	Хүүхдийнхээ суралцдаг сургуулийн үйл ажиллагаан дахь эцэг эхчүүдийн оролцоо, хүйсээр.....	108
Хүснэгт 52	Охид, хөвгүүдийн гэртээ хийдэг ажлууд (олон сонголттой хариултаар).....	109
Хүснэгт 53	Гэр бүлийн гишүүдийн дүр үүргийн талаар сурагчдын ойлголт, хандлага.....	111
Хүснэгт 54	Сургуулийн удирдах түвшний ажилтнуудын жендэрийн талаарх ойлголт, хүйсээр.....	116
Хүснэгт 55	Сургуулийн удирдлагын зүгээс шийдвэр гаргахад багш, ажилтан, сурагч, эцэг эхчүүдийг оролцуулж буй байдал, хувиар.....	117
Хүснэгт 56	Сургуулийн холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлтэй холбоотой заалтуудыг тусгасан байдал .....	120
Хүснэгт 57	Сургуулийн орчинд бие махбодийн хүчирхийлэлд өртөх .....	121
Хүснэгт 58	Сургуулийн орчинд бага ангийн сурагчдын ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт, хүчирхийлэлд охид хөвгүүд өртөх байдал (сурагчдын хариултаар) .....	122
Хүснэгт 59	Сургуулийн орчинд дунд, ахлах ангийн сурагчдын ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт, хүчирхийлэлд охид хөвгүүд өртөх байдал (сурагчдын хариултаар) .....	122



## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1	Бүх шатны боловсролын шатанд суралцагчдын харьцаа, хүйсээр .....	25
Зураг 2	Боловсролын түвшин дэх суралцагчдын харьцаа.....	25
Зураг 3	Элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүн, хүйсээр .....	27
Зураг 4	Хөдөө сумын сургуулийн нүхэн бие засах ариун цэврийн байр.....	31
Зураг 5	Хотын сургуулийн боловсон ариун цэврийн өрөө .....	32
Зураг 6	Хүмүүжлийн ажлын төлөвлөгөөнд жендэрийн тэгш байдлыг тогтооход чиглэсэн үйл ажиллагааг анхаардаг байдал (n=23).....	34
Зураг 7	Дунд, ахлах ангийн сурагчдын мэргэжил сонголтыг хүйсээр харьцуулсан байдал .....	38
Зураг 8	Удирдах ажилтныг сонгон шалгаруулах үе шат .....	43
Зураг 9	Багш сонгон шалгаруулахад жендэрийн тэгш байдлыг хангах зохицуулалт байдаг эсэх.....	47
Зураг 10	Жендэрийн тэгш байдлыг хангах хуулийг мэдэх байдал, хувиар.....	49
Зураг 11	Хөтөлбөрт төлөвлөгдсөн сургалтын аргууд, багшийн хүйсээр.....	59
Зураг 12	Сурагчдын сурах үйлийг төлөвлөсөн байдал.....	60
Зураг 13	Охид, хөвгүүдийн сурах үйл ажиллагааг төлөвлөсөн байдал.....	60
Зураг 14	Хичээлийн хөтөлбөртөө сурагчийн хэрэгцээ, сонирхлыг тусгаж буй байдал, багш нарын асуулгад хариулсан дүнгээр (n=492).....	61
Зураг 15	Сурах бичгийн зураг дүрслэл, текст дэх хүйсийн харьцаа, хувиар .....	64
Зураг 16	Хүн-Орчин 1 сурах бичиг дэх зураг дүрслэлийн жишээ (А.Энхтогтох, Г.Баярмаа) .....	64
Зураг 17	Сурах бичигт ашигласан эхийн жагсаалт (Өнөрбаян Ц, Жумдаан Л, Мөнхсайхан Ж нар (2015) Монгол хэл-VI, Улаанбаатар, 44 дүгээр тал.....	65
Зураг 18	Охид, хөвгүүдийг дүрсэлсэн байдал (Олзвой Л ба бусад (2014) Монгол хэл, Улаанбаатар, 60; 63 дугаар тал).....	67
Зураг 19	Сурах бичиг дэх орос ардын үлгэр, бэлгэтэй сайхан үгсийн тухай дүрслэл (Оюунцэцэг болон бусад (2014) Монгол хэл I, УБ.,8; 145-р тал).....	68
Зураг 20	Сурах бичиг дэх жендэрийн дүр үүрэг (эсрэгцэлсэн дүрүүдээр, хувиар).....	69
Зураг 21	Сурах бичгийн эх дэх нөхөн үржихүйн болон үйлдвэрлэлийн дүр үүрэг (хүйсээр, хувиар).....	69
Зураг 22	Сурах бичиг дэх эрэгтэй, эмэгтэй хүнийг дүрсэлсэн газар (дунджаар).....	70
Зураг 23	Жендэрчлэгдсэн зураг дүрслэл (Алтанзаяа ба бусад (2012) Нийгмийн ухаан IV. 23, 111, 131-р тал).....	70
Зураг 24	Сурах бичиг дэх эрэгтэй эмэгтэй хүний оюуны болон сэтгэл хөдлөлийн шинжүүдийн дүрслэл (эхэд дүрслэгдсэн дундаж тоогоор).....	71
Зураг 25	Жендэрийн хэвшмэл ойлголт бүхий дасгалын хуулбар (Алтанзаяа Л, Алтангэрэл Ч, Нэмэхжаргал Т ба бусад (2012). Нийгмийн ухаан III, Улаанбаатар101 дүгээр тал).....	73
Зураг 26	Хүйс ба жендэрийг тайлбарлан бичсэн хуудасны хуулбар (Алтанзаяа Л,Алтангэрэл Ч, Нэмэхжаргал Т ба бусад(2014). Нийгмийн ухаан VI, Улаанбаатар, 19 дүгээр тал) .....	74
Зураг 27	Сурах бичиг орсон философич, сэтгэгчдийн зураг (мөн тэнд, 57; 70 дугаар тал) .....	74
Зураг 28	Ахлах, дунд, бага ангийн багш нарын заах арга зүй, хувиар .....	77
Зураг 29	Багш нарын ур чадвар, хүйсээр, хувиар .....	78
Зураг 30	Багшийн хөтөлбөрт жендэртэй холбоотой агуулгыг тусгадаг эсэх, хувиар.....	79
Зураг 31	Ажиглалтын үеэр зурсан хичээлийн танхимын суудал засалт.....	81
Зураг 32	Эрэгтэй, эмэгтэй багшийн ялгаа, 6-12 дугаар ангийн сурагчдын хариултаар (хувиар) .....	87
Зураг 33	Багшаар суралцаж байхад жендэрийн талаарх мэдлэг олгогдсон эсэх, нас, хувиар .....	94
Зураг 34	Жендэрийн ойлголт сэтгэл судлал, сурган, дидактикийн хичээлүүдэд.....	94
Зураг 35	Гэр бүл дэх ажил үүргийн хуваарилалт.....	98
Зураг 36	Эцэг эхчүүдийн хүүхдийн багшаа сонгох сонголт, судалгаанд оролцогчдын хүйс болон нутагшилтаар (n=290) .....	103
Зураг 37	Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ялгаатай үүрэг хүлээж байгаагийн шалтгааныг тайлбарлах байдал.....	112
Зураг 38	Багш нарын жендэрийн дүр үүргийн талаарх хандлага, хувиар.....	113
Зураг 39	Охид хөвгүүдийн талаарх хэвшмэл ойлголт, эрэгтэй эмэгтэй багш нарын санал нийлж байгаа хариултын хувийн жингээр .....	114
Зураг 40	Охид, хөвгүүдийн авьяаслаг хичээлүүд, багш нарын санал нийлж буй хариултын хувийн жингээр.....	115
Зураг 41	Нөхөр, эхнэрийн гэр бүл дэх ажил үүргийн хуваарилалт.....	117
Зураг 42	Жендэрийн сургалтад хамрагдсан байдал, хувиар .....	119

## УДИРТГАЛ

### Бодлого, эрх зүйн орчны хувьд

Монгол улсын Үндсэн хууль (1992)-ийн хоёрдугаар бүлгийн 16-р зүйлийн 7-д хүн бүр сурч боловсрох эрхтэй ба төрөөс ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно хэмээн заасан нь охид хөвгүүдийн сурч боловсрох эрхийг баталгаажуулсны хамт иргэдийнхээ өмнө боловсролын чиглэлээр хүлээх төрийн үүргийг тодорхойлсон байна. Түүнчлэн тус хуулиар хувийн хэвшлийн байгууллага боловсролын үйлчилгээ үзүүлж болохыг хүлээн зөвшөөрсөн.

2002 онд Боловсролын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан бөгөөд тус хуулиар боловсролын зорилгыг *“иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино”* хэмээн заасан байдаг. Уг хуулинд:

- Олон нийтийн хяналтад байх,
- Хүмүүнлэг, ардчилсан байх
- Бүх нийтэд адил тэгш хүртээмжтэй байх,
- Суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн байх,
- Олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байх,
- Ялгаварлан гадуурхахгүй байх зэргийг боловсролын үндсэн зарчим хэмээн тодорхойлжээ.

Охид, хөвгүүдийн сурч боловсрох тэгш эрхийг дахин баталгаажуулахын зэрэгцээ боловсролоор дамжуулан жендэрийн тэгш байдалд хүрэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлж өгчээ. Түүнчлэн хүн бүрт ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй сурах эрх, суурь боловсролыг заавал эзэмших үүргийг тогтоож, бүх төрлийн ялгавардлан гадуурхалт, хүчирхийлэл, дарамт үзүүлэхийг хориглосон нь ихээхэн ач холбогдолтой юм.

Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрддэг. Албан боловсролын агуулга, стандартыг хуульд заасан журмын дагуу тогтоох ба бага, дунд, боловсролыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр олгож болно<sup>1</sup> гэжээ. Бага дунд боловсролын тухай хууль (2002)-иар бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилийн хугацаанд эзэмшүүлнэ гэсэн ба хувь сурагч богино хугацаанд дүүргэх боломжийг олгосон. Тус хуулиар бага, дунд боловсролын агуулгыг хуульчлан тогтоосон юм. Үүнд үндэсний болон хүн төрөлхтний дэвшилтэт соёл, үнэт зүйлс, соёлоос суралцах, үнэнч шударга, хүмүүнлэг, хууль ёсыг сахин хэрэгжүүлдэг, гэр бүлийн амьдралаа хөтлөх арга барилд суралцуулна хэмээн тусгасан нь жендэрийн боловсролтой зохих ёсоор холбогдоно.

2011 онд Улсын Их Хурал Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг баталсан бөгөөд энэ нь цогц бодлогыг хэрэгжүүлж буй нэгэн чухал алхам болсон юм. Тус хууль нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн юм. Үүнийг тодруулан авч үзье<sup>2</sup>:

- Энэхүү хуулийн 12 зүйлд “Соёл, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа”-г тодорхойлсон ба эрэгтэй, эмэгтэй хүн боловсрол эзэмших тэгш боломжтой

<sup>1</sup> Боловсролын тухай хууль. 2002 он.

<sup>2</sup> Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. 2011

байх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх ёстойг тогтоосон.

- **Жендэрийн сургалт, гэгээрлийн үйл ажиллагааг төлөвлөгөө, хөтөлбөрийн үндсэн дээр хэрэгжүүлэх, бүх шатны боловсролын стандарт, зохих түвшний сургалтын хөтөлбөрт суралцагчийн зайлиггүй эзэмшвэл зохих жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой агуулга, арга зүй, үнэлгээг тусгана** хэмээн заажээ.
- Бүх шатны боловсролын байгууллагад хэрэглэдэг ном, сурах бичиг болон сургалтын хэрэглэгдэхүүн нь **жендэрийн тэгш эрхийг үгүйсгэсэн агуулгатай байж үл болно** гэсэн заалтууд нь боловсролын хөтөлбөр, хэрэглэгдэхүүний агуулга дахь жендэрт холбогдох шаардлагыг тодорхой болгож өгсөн байна.
- Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны тайланд **жендэрийн тэгш байдлыг хангах ажлын үр дүн, гарсан зөрчил, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээг тусгах** бөгөөд байгууллагын **удирдлагын үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлтийн нэг байна** гэжээ.

2010 онд МУ-ын Засгийн газраас “Боловсрол” үндэсний хөтөлбөрийг (2010-2021) батлан хэрэгжүүлж эхэлсэн. Чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх, боловсролын стандарт хөтөлбөрийг суралцагчийн хэрэгцээ, нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, багшийн хөгжлийг дэмжих, боловсролын тогтолцоог олон улсын жишигт ойртуулахад төрийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, иргэд боловсролоо нэмэгдүүлэх, ажил мэргэжлээ хөрвөн суралцах нээлттэй, уян хатан агуулга хэлбэрийг бий болгох, сургууль төвт менежментийг хөгжүүлэх зэрэг стратегийн 6 зорилтыг уг хөтөлбөрөөр дэвшүүлжээ.

Стратегийн зорилт 1-ийн хүрээнд хэрэгжүүлэх хоёрдугаар арга хэмжээ нь бүхэлдээ жендэрийн тэгш байдлыг тогтооход чиглэсэн байв. Үүнд<sup>3</sup>:

- Бүх шатны боловсролын байгууллагын суралцагчид болон багш, ажиллагчдын хүйсийн тэгш байдлыг хангах:
  - Хөвгүүдийн боловсролыг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
  - Сурган хүмүүжүүлэх салбар дахь хүйсийн тэгш байдлыг бодлогоор дэмжих;
  - Боловсролын салбарын хөгжлийн асуудлаар шийдвэр гаргах түвшин дэх хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Ийнхүү энэ бодлогын баримт бичиг нь жендэрийн тэгш байдлыг тогтооход бодлогын түвшинд анхаарч, тодорхой бодлого боловсруулж, хэрэгжүүлэх үндсийг тавьж өгсөнөөрөө ихээхэн ач холбогдолтой юм. Гэхдээ 10-р бүлэг дэх хүлээгдэж буй үр дүн хэсэгт эдгээр арга хэмжээнд холбогдох үр дүнг тодорхойлоогүй орхигдуулсан байв.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024) нь дурдсан хуулиудад нийцүүлэн Монгол улсын иргэн бүрт хүртээмжтэйгээр чанартай боловсролын үйлчилгээг хүргэх тухай үзэл баримтлалд тулгуурлажээ. Түүнчлэн уг баримт бичгийн Гуравдугаар бүлгийн 12-т “Боловсролын салбарт жендэрийн тэгш байдлыг хангах бодлого боловсруулж, үе шаттай хэрэгжүүлнэ”<sup>4</sup> хэмээн заасан нь ач холбогдолтой ч, таван жилийн өмнө батлагдсан “Боловсрол” үндэсний хөтөлбөрөөр дэвшүүлсэн зорилтын цар хүрээнээс хальж чадсангүй. Тус бодлогын хэрэгжилтийн шалгуур

<sup>3</sup> МУ-ын Засгийн газар. “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021). 2010

<sup>4</sup> УИХ. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024). 2015

үзүүлэлтэд жендэртэй холбоотой тодорхой шалгуурыг багтаагаагүй байв.

2013 онд “Зөв монгол хүүхэд” Үндэсний хөтөлбөрийг батлаад байна. Тус хөтөлбөр нь “Монгол хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, хамтран ажиллаж амьдрах, насан туршидаа суралцах чадвартай, үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг иргэн болж төлөвших гэр бүл, боловсрол, нийгмийн орчныг бүрдүүлэх<sup>5</sup>”-ээр зорьжээ. Энэхүү хөтөлбөр нь нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн байдал, нийгмийн гарал зэрэг ялгаатай ч “хүүхэд бүр”-т боловсролын чанартай үйлчилгээг адил тэгшээр хүргэх, тэдгээрийг хөгжүүлэхэд анхаарч байгаагаараа ач холбогдолтой юм. Түүнчлэн уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ гэр бүл, олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах зарчмыг баримтлах ажээ.

Тус хөтөлбөр нь хүүхэд бүрийг хөгжүүлэх багшлах, суралцах орчин бүрдүүлэхэд тусгайлан анхаарчээ. Энэ хүрээнд сургалтын технологийн сан бүрдүүлэх, багш бэлтгэх, дахин бэлтгэх үйл ажиллагааг чанаржуулах, дэмжлэг үзүүлэхүйц менежментийн таатай орчин бүрдүүлэх, сургууль, багшийн хяналт, үнэлгээнд эдгээрийг нэгэн шалгуур болгон оруулах зэрэг цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан байна. Энэ нь анги танхим дахь сургалтын бодит үйл ажиллагаанд хүүхэд бүр оролцох боломжийг олгоход анхаарч байгаагаараа жендэрийн тэгш байдлыг тогтооход эерэг нөлөөтэй.

Мөн уг үндэсний хөтөлбөр нь сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн стандартыг шинэчлэн боловсронгуй болгох, сурах бичгийн чанарыг дээшлүүлэхэд хэрэглэгч, олон нийтийн саналыг тусгах механизм бүрдүүлэх, сурах бичиг зохиогч, судлаачдыг бэлтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр зорьж байгаа ба эдгээрт жендэрийн хувьд анхаарвал зохих саналуудыг тусгах боломж бүрдээд байна. Мөн сургууль, цэцэрлэгийн удирдлага, улс төрийн нам, хүчнээс хамааралтай байх нөхцлийг өөрчлөхөд анхаарч, удирдах ажилтныг орон нутгийн мэргэжлийн байгууллага, олон нийтийн оролцоотой сонгон шалгаруулж, томилдог байх эрх зүйн орчныг бий болгож, удирдах ажилтныг бэлтгэх, ур чадварыг нь дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно гэсэн нь менежментийн таатай орчинг бүрдүүлэх юм. Гэхдээ тус хөтөлбөр нь жендэртэй шууд холбогдох үйл ажиллагааг төлөвлөгөөгүй, хэрэгжилтийн үнэлгээний шалгуурт жендэрт холбогдох шалгуур үзүүлэлт оруулаагүй ажээ.

НҮБ-аас баталсан Мянганы хөгжлийн зорилтуудтай уялдуулан боловсруулагдан хэрэгжиж байсан Монгол улсын үндэсний хөгжлийн цогц бодлогыг сайжруулан, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-30”-ийг хурлаас 2016 оны 19-р тогтоолоор баталсан. Энэхүү бодлогод хүний хөгжил, боловсрол, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогын талаар авч үзсэн. Энэхүү бодлогын хүлээгдэж буй үндсэн үр дүнд “Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болно” гэж оруулсан нь боловсрол, жендэрийн тэгш байдлын үзүүлэлтийг ахиулахад ихээхэн анхаарлаа хандуулж байгааг харуулах юм. Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд **“жендэрийн тэгш байдлыг хангах, бүх ... иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх...** -д чиглэнэ гэж заасан. Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчимд:

---

<sup>5</sup> МУЗГ. “Зөв Монгол хүүхэд” Үндэсний хөтөлбөр. 2013

- хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлт нь хүртээмжтэй өсөлтөд суурилсан хүний хөгжил байх;
- иргэний болон насан туршийн боловсролын тогтолцоо нь нээлттэй, хүртээмжтэй, чанартай байх;
- нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх гэсэн зарчмуудыг оруулсан бөгөөд энэ нь хөгжлийн үр шимийг тэр дундаа боловсролын үр шимийг хүн бүрт, эрэгтэй, эмэгтэйчүүд адил тэгш хүртэх, оролцоог хангах үзэл баримтлалыг дэвшүүлжээ.

Цаашлаад нэг багшид ногдох хүүхдийн тоог бууруулах, сургуулийн хичээллэх ээлжийн тоог бууруулах, сургууль бүрийг сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах зэрэг тодорхой бөгөөд хэмжигдэхүйц зорилтуудыг дэвшүүлсэн нь эрэгтэй, эмэгтэй хүүхэд бүрт, чанартай, хүртээмжтэй боловсролын үйлчилгээг хүргэхэд анхаарснаараа ихээхэн ач холбогдолтой юм.

Гэхдээ зургаан жилийн тэртээгээс боловсрол дахь жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлнэ гэсэн зорилт өнөө хэр бодит биелэлээ олоогүй хэвээр байгаагийн зэрэгцээ дараа дараагаар нь батлагдсан бодлогын баримт бичгүүдэд жендэрийн тэгш байдлыг хангахтай шууд холбогдох тусгайлсан зорилт, арга хэмжээ тусгагдаагүй хэвээр байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011 онд батлагдан хэрэгжсээр даруй 5 жил өнгөрч байгаа ч, боловсролын салбарт хэрэгжиж эхэлсэн томоохон хөтөлбөрүүдийн агуулгад уг хуулийн үзэл санаа тусгагдаагүй байгааг анхаарах шаардлагатай байна.

Монголын боловсролын тогтолцоонд сүүлийн арван жилд олон тооны өөрчлөлт шинэчлэл хийгдлээ. Тухайлбал ерөнхий боловсролын тогтолцоог 3 удаа өөрчилсөн, хичээлийн хөтөлбөрийг 3 үе шаттайгаар шинэтгэсэн, сургуульд элсэх нас 8 байсныг 6 нас болгосон, 2007-2015 оны хооронд ерөнхий боловсролын сургалтыг 12 жил болгох ажлыг шат дараатайгаар хийж гүйцэтгэсэн байна. Арван хоёр жилийн сургалтыг бүрэн дүүргэсэн сурагчдын анхны төгсөлт 2020 онд болно.

2015-2016 оны хичээлийн жилд Монгол Улсын хэмжээнд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн 330 сумдын нийт 762 ерөнхий боловсролын сургуульд 500 мянга гаруй сурагчид суралцсан байна. Одоогийн ерөнхий боловсролын тогтолцоо нь бага сургуулийн 5 жил, бүрэн бус дунд боловсролын 4 жил, бүрэн дунд боловсрол олгох 3 жил гэсэн бүтэцтэй байна. Бага, дунд ангийн боловсролыг 6 наснаас нь элсүүлж, охид хөвгүүд хамтдаа 9 жилийн бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй бөгөөд заавал суралцах заалттай байдаг. Ахлах сургуулийн боловсрол мөн л үнэгүй боловч хүсвэл суралцаж болох буюу их сургуульд элсэн суралцахад тавигдах үндэслэл болдог.

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (БСШУЯ) нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага юм. БСШУЯ улсын боловсролын талаар баримтлах бодлогыг томъёолж, боловсролын түвшин тус бүрт стандарт тогтоодог. Мөн БСШУЯ багш боловсон хүчнийг сургах, сургалтын хөтөлбөр боловсруулах, улсын шалгалт зохион байгуулах, дээд боловсрол олгох байгууллагуудыг магадлан итгэмжлэх ажлыг хариуцдаг. Аймаг, дүүрэг бүрт тухайн орон нутгийнхаа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалт, санхүүгийн асуудлыг хянан шийдвэрлэх үүрэгтэй БСШУЯ-ны харьяа Боловсрол, соёлын хэлтэс ажилладаг. Сургуулиуд удирдлага зохион байгуулалтын зөвлөлтэй.

БСШУЯ чанартай боловсролыг хөгжлийн түлхүүр гэж үзэн боловсролын тогтолцоог дэлхийн стандартад нийцүүлэхийг зорьж байна. Боловсролын чанарын шинэчлэл төслийг хэрэгжүүлж

байгаа ба боловсролын чанарыг дээшлүүлэх хүрээнд дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгийн хүрэлцээ муу байгаа нь сурагчдын суралцах боломжийг хязгаарлаж байгаа,

- Суралцагчдын сурлагын амжилтын үзүүлэлт доогуур, Улаанбаатар хот, аймгийн төв болон сумдын сургуулийн суралцагчдын сурлагын амжилт зөрүүтэй байгаа,

- Суралцагчдын сурлагын амжилтыг бага ангиас эхлэн тасралтгүй, тогтвортой үнэлэн харьцуулах институцилагдсан бүтэц байхгүй нь суурь боловсролын чанарыг сайжруулахад саад болсоор байгаа,

- Бага, дунд боловсролын сургалтын чанар тулгамдсан асуудал болж байгаа,

- Багш бэлтгэх, давтан сургах, багш ажлын байранд тасралтгүй хөгжих бололцоог бүрэн хангаж чадахгүй, боловсролын салбарт хийгдэж буй өөрчлөлтийн хурдацаас хоцрогдсон тул чанартай багш бэлтгэгдэн төгсгөх нь доголдолтой байгаа,

- Багшийн сурагчидтай ажиллах сургалтын цаг харьцангуй бага байгаа зэрэг асуудлуудыг шийдвэрлэхээр БСШУЯ суурь боловсролын чанарыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.

***Боловсролд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар олон улсын хэрэгжүүлж буй зорилт арга хэмжээ***

Боловсролын салбарт Засгийн газрын хэрэгжүүлж байгаа өөрчлөлтүүд нь олон улсын хэмжээнд дэвшүүлж байгаа зорилт, хөтөлбөрүүдтэй уялдаж бүх нийтэд чанартай боловсрол эзэмшүүлэх, боловсролын агуулга, стандартыг дэлхийн стандартад хүргэхэд чиглэж байна. ЮНЕСКО болон бусад олон улсын байгууллагууд боловсролын салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах, боловсролоор дамжуулж жендэрийн эрх тэгш байдалд хүрэхийн тулд охид хөвгүүдэд суралцах адил боломж олгох, суралцах явцад ялгаварлалгүй хандах, сурлагын тэнцвэртэй амжилт гаргах, амьдралын бүхий л хүрээнд дэвшил гаргахыг дэмжихэд анхаарч байна. Дараах олон улсын баримт бичгүүдэд тусгагдсан боловсролд жендэрийн тэгш байдлыг хангах зорилтуудыг Засгийн газрын мөрдлөг болгон хэрэгжүүлж байна.

- Бүх нийтэд боловсрол олгох үйл ажиллагааны ДАКАР-ын төлөвлөгөө 2000-2015
  - Зорилт 5. Бага ба дунд боловсролын түвшинд жендэрийн ялгаатай байдлыг 2005 он гэхэд арилгасан байх, ба 2015 он гэхэд суурь боловсролын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан байх,
- Эх дэлхийгээ өөрчлөх нь: Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр-2030
  - Зорилт 4. Чанартай боловсролд хүүхэд бүрийг тэгш хамруулах, бүх нийтийг насан туршийн боловсрол эзэмшихийг дэмжих
  - Зорилт 4.7: 2030 он гэхэд бүх суралцагч тогтвортой хөгжлийг хөхүүлэн дэмжих мэдлэг, ур чадварыг тогтвортой хөгжлийн ба тогтвортой амьдралын хэв маягийн тухай боловсрол, хүний эрх, жендэрийн тэгш эрх, хүчирхийлэлгүй, энх тайвнаар амьдрах соёл, дэлхийн иргэншил, соёлын ялгаатай байдлыг талархан үзэх, тогтвортой хөгжихөд соёлын үзүүлэх нөлөө зэргийг судлах замаар олж авахыг баталгаажуулах

Сүүлийн арваад жилд Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүдийн дунд боловсролын салбарт, бага дунд боловсролын түвшинд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарч буй нь сургуульд хамрагдалт, төгсөлт, сургууль завсардалт зэрэг статистик үзүүлэлтүүд эерэг өөрчлөгдсөнөөс харагдаж байна (Бүлэг 1). Гэхдээ хүйсийн тооны тэнцвэртэй байдал ба жендэрийн эрх тэгш байдал саланги ойлголтууд ба хүйсийн тэнцвэртэй байдал нь жендэрийн эрх тэгш байдалд хүргэх зайлшгүй урьдчилсан нөхцөл болдог. Өөрөөр хэлбэл, охид хөвгүүдийг тэгш хүртээмжтэй хамран сургах нь боловсролд жендэрийн тэгш байдлыг хангах зөвхөн урьдчилсан нөхцөл юм.

Боловсролд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь илүү өргөн хүрээтэй ойлголт бөгөөд суралцах орчин, багшлах ба суралцах үйл явц, суралцагчдын сурлагын амжилт, сурагчдын бие хүний хөгжил зэрэг асуудлууд багтана. Боловсролд жендэрийн тэгш байдал хэр хангагдаж байгааг сургуулийн орчин, сургуулийн менежмент, багшийн ойлголт хандлага, хичээлийн танхим дахь үйл явц, сургалтын хэрэглэгдэхүүн, сурагчдын оролцоо зэрэгт жендэрийн дүн шинжилгээ хийж үнэлдэг. Дэлхий даяар боловсролд жендэрийн эрх тэгш бус байдал, ялангуяа боловсролын хүртээмж, дэвшин суралцах, сурлагын амжилт, мэргэжил сонголт ба ажил эрхлэх боломж зэрэгт илэрсээр байгаа нь ялгаварлал, жендэрийн хоцрогдмол хэв шинж бий болох шалтгаан хийгээд үр дагавар болж байна.

Дакарын төлөвлөгөөний зорилтууд тогтвортой хөгжлийн үзэл санаагаар баяжигдан "Эх дэлхийгээ өөрчлөх нь: Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр-2030"-ийн Зорилт 4-т чанартай боловсролд хүүхэд бүрийг бүрэн, тэгш хамруулахаар дахин тусгагдсан. Тогтвортой хөгжил нь ирээдүй үеийнхний хэрэгцээгээ хангах нөхцөлийг алдагдуулахгүйгээр өнөөгийн хэрэгцээг хангах боломж бөгөөд хүний сайн сайхан, нэр төрийн халдашгүй байдал, экологийн тэнцвэртэй байдал, жендэрийн тэгш байдал ба нийгмийн шударга ёсыг хангасан эдийн засаг, нийгэм, байгаль орчны цогц хөгжил юм. Тогтвортой хөгжил ба жендэрийн эрх тэгш байдал нь харилцан шүтэлцээтэй ойлголтууд бөгөөд учир нь тогтворгүй байдал, жендэрийн тэгш бус байдал нь харилцан хамааралтай ба адил учир шалтгаан, нөхцлөөс үүссэн байдаг. Боловсролд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь нийгмийн хөгжилд эрэгтэйчүүд эмэгтэйчүүд тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүд нийгмийн хөгжилд тэгш оролцох нь тогтвортой хөгжлийг хангах зайлшгүй хүчин зүйл юм.

- Нийгмийн амьдралд эрэгтэйчүүд эмэгтэйчүүд тэгш оролцох, хөгжлийн үр шимийг адил хүртсэнээр
- Тэгш бус байдал, хүйсээр ялгаварлах хандлагыг өөрчилснөөр тогтвортой хөгжлийг цогцлоох болно.

***Боловсролд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар төрөөс бодлого, эрх зүйн орчны хувьд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ***

Монгол улсын Үндсэн хууль (1992)-ийн хоёрдугаар бүлгийн 16-р зүйлийн 7-д хүн бүр сурч боловсрох эрхтэй ба төрөөс ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно хэмээн заасан нь охид хөвгүүдийн сурч боловсрох эрхийг баталгаажуулсны хамт иргэдийнхээ өмнө боловсролын чиглэлээр хүлээх төрийн үүргийг тодорхойлсон байна. Түүнчлэн тус хуулиар хувийн хэвшлийн байгууллага боловсролын үйлчилгээ үзүүлж болохыг хүлээн зөвшөөрсөн.

2002 онд Боловсролын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан бөгөөд тус хуулиар боловсролын зорилгыг *"иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино"* хэмээн заасан байдаг. Уг хуулинд:

- Олон нийтийн хяналтад байх,

- Хүмүүнлэг, ардчилсан байх
- Бүх нийтэд адил тэгш хүртээмжтэй байх,
- Суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн байх,
- Олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байх,
- Ялгаварлан гадуурхахгүй байх зэргийг боловсролын үндсэн зарчим хэмээн тодорхойлжээ.

Охид, хөвгүүдийн сурч боловсрох тэгш эрхийг дахин баталгаажуулсны хамт боловсролоор дамжуулан жендэрийн тэгш байдалд хүрэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлж өгчээ. Түүнчлэн хүн бүрт ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй сурах эрх, суурь боловсролыг заавал эзэмших үүргийг тогтоож, бүх төрлийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, дарамт үзүүлэхийг хориглосон нь ихээхэн ач холбогдолтой юм.

Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрддэг. Албан боловсролын агуулга, стандартыг хуульд заасан журмын дагуу тогтоох ба бага, дунд боловсролыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр олгож болно<sup>6</sup> гэжээ. Бага дунд боловсролын тухай хууль (2002)-иар бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилийн хугацаанд эзэмшүүлнэ гэсэн ба хувь сурагч богино хугацаанд дүүргэх боломжийг олгосон. Тус хуулиар бага, дунд боловсролын агуулгыг хуульчлан тогтоосон юм. Үүнд үндэсний болон хүн төрөлхтний дэвшилтэт соёл, үнэт зүйлс, соёлоос суралцах, үнэнч шударга, хүмүүнлэг, хууль ёсыг сахин хэрэгжүүлдэг, гэр бүлийн амьдралаа хөтлөх арга барилд суралцуулна хэмээн тусгасан нь жендэрийн боловсролтой зохих ёсоор холбогдоно.

2011 онд Улсын Их Хурал Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг баталсан бөгөөд энэ нь цогц бодлогыг хэрэгжүүлж буй нэгэн чухал алхам болсон юм. Тус хууль нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн юм. Үүнийг тодруулан авч үзье<sup>7</sup>:

- Энэхүү хуулийн 12 зүйлд “Соёл, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа”-г тодорхойлсон ба эрэгтэй, эмэгтэй хүн боловсрол эзэмших тэгш боломжтой байх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх ёстойг тогтоосон.
- ***Жендэрийн сургалт, гэгээрлийн үйл ажиллагааг төлөвлөгөө, хөтөлбөрийн үндсэн дээр хэрэгжүүлэх, бүх шатны боловсролын стандарт, зохих түвшний сургалтын хөтөлбөрт суралцагчийн зайлиггүй эзэмшвэл зохих жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой агуулга, арга зүй, үнэлгээг тусгана хэмээн заажээ.***
- Бүх шатны боловсролын байгууллагад хэрэглэдэг ном, сурах бичиг болон сургалтын хэрэглэгдэхүүн нь ***жендэрийн тэгш эрхийг үгүйсгэсэн агуулгатай байж үл болно*** гэсэн заалтууд нь боловсролын хөтөлбөр, хэрэглэгдэхүүний агуулга дахь жендэрт холбогдох шаардлагыг тодорхой болгож өгсөн байна.
- Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны тайланд ***жендэрийн тэгш байдлыг хангах ажлын үр дүн, гарсан зөрчил, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээг тусгах*** бөгөөд байгууллагын ***удирдлагын үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлтийн нэг байна*** гэжээ.

2010 онд МУ-ын Засгийн газраас “Боловсрол” үндэсний хөтөлбөрийг (2010-2021) батлан хэрэгжүүлж эхэлсэн. Чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх, боловсролын

<sup>6</sup> Боловсролын тухай хууль. 2002 он.

<sup>7</sup> Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. 2011



стандарт хөтөлбөрийг суралцагчийн хэрэгцээ, нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, багшийн хөгжлийг дэмжих, боловсролын тогтолцоог олон улсын жишигт ойртуулахад төрийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, иргэд боловсролоо дээшлүүлэх, ажил мэргэжлээ хөрвөн суралцах нээлттэй, уян хатан агуулга хэлбэрийг бий болгох, сургууль төвт менежментийг хөгжүүлэх зэрэг стратегийн 6 зорилтыг уг хөтөлбөрөөр дэвшүүлжээ.

Стратегийн зорилт 1-ийн хүрээнд хэрэгжүүлэх хоёрдугаар арга хэмжээ нь бүхэлдээ жендэрийн тэгш байдлыг тогтооход чиглэсэн байв. Үүнд<sup>8</sup>:

- Бүх шатны боловсролын байгууллагын суралцагчид болон багш, ажиллагчдын хүйсийн тэгш байдлыг хангах:
  - Хөвгүүдийн боловсролыг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
  - Сурган хүмүүжүүлэх салбар дахь хүйсийн тэгш байдлыг бодлогоор дэмжих;
  - Боловсролын салбарын хөгжлийн асуудлаар шийдвэр гаргах түвшин дэх хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Ийнхүү энэ бодлогын баримт бичиг нь жендэрийн тэгш байдлыг тогтооход бодлогын түвшинд анхаарч, тодорхой бодлого боловсруулж, хэрэгжүүлэх үндсийг тавьж өгсөнөөрөө ихээхэн ач холбогдолтой юм. Гэхдээ 10-р бүлэг дэх хүлээгдэж буй үр дүн хэсэгт эдгээр арга хэмжээнд холбогдох үр дүнг тодорхойлоогүй орхигдуулсан байв.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024) нь дурдсан хуулиудад нийцүүлэн Монгол улсын иргэн бүрт хүртээмжтэйгээр чанартай боловсролын үйлчилгээг хүргэх тухай үзэл баримтлалд тулгуурлажээ. Түүнчлэн уг баримт бичгийн Гуравдугаар бүлгийн 12-т “Боловсролын салбарт жендэрийн тэгш байдлыг хангах бодлого боловсруулж, үе шаттай хэрэгжүүлнэ”<sup>9</sup> хэмээн заасан нь ач холбогдолтой ч, таван жилийн өмнө батлагдсан “Боловсрол” үндэсний хөтөлбөрөөр дэвшүүлсэн зорилтын цар хүрээнээс хальж чадсангүй. Тус бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтэд жендэртэй холбоотой тодорхой шалгуурыг багтаагаагүй байв.

2013 онд “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийг батлаад байна. Тус хөтөлбөр нь “Монгол хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, хамтран ажиллаж амьдрах, насан туршидаа суралцах чадвартай, үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг иргэн болж төлөвших гэр бүл, боловсрол, нийгмийн орчныг бүрдүүлэх”<sup>10</sup>-ээр зорьжээ. Энэхүү хөтөлбөр нь нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн байдал, нийгмийн гарал зэрэг ялгаатай ч “хүүхэд бүр”-т боловсролын чанартай үйлчилгээг адил тэгшээр хүргэх, тэдгээрийг хөгжүүлэхэд анхаарч байгаагаараа ач холбогдолтой юм. Түүнчлэн уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ гэр бүл, олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах зарчмыг баримтлах ажээ.

Тус хөтөлбөр нь хүүхэд бүрийг хөгжүүлэх багшлах, суралцах орчин бүрдүүлэхэд тусгайлан анхаарчээ. Энэ хүрээнд сургалтын технологийн сан бүрдүүлэх, багш бэлтгэх, дахин бэлтгэх үйл ажиллагааг чанаржуулах, дэмжлэг үзүүлэхүйц менежментийн таатай орчин бүрдүүлэх, сургууль, багшийн хяналт, үнэлгээнд эдгээрийг нэгэн шалгуур болгон оруулах зэрэг цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан байна. Энэ нь анги танхим дахь сургалтын бодит үйл ажиллагаанд хүүхэд бүр оролцох боломжийг олгоход анхаарч байгаагаараа жендэрийн тэгш байдлыг тогтооход эерэг нөлөөтэй.

<sup>8</sup> МУ-ын Засгийн газар. “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021). 2010

<sup>9</sup> УИХ. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024). 2015

<sup>10</sup> МУЗГ. “Зөв Монгол хүүхэд” Үндэсний хөтөлбөр. 2013

Мөн уг үндэсний хөтөлбөр нь сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн стандартыг шинэчлэн боловсронгуй болгох, сурах бичгийн чанарыг дээшлүүлэхэд хэрэглэгч, олон нийтийн саналыг тусгах механизм бүрдүүлэх, сурах бичиг зохиогч, судлаачдыг бэлтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр зорьж байгаа ба эдгээрт жендэрийн хувьд анхаарвал зохих саналуудыг тусгах боломж бүрдээд байна. Мөн сургууль, цэцэрлэгийн удирдлага, улс төрийн нам, хүчнээс хамааралтай байх нөхцлийг өөрчлөхөд анхаарч, удирдах ажилтныг орон нутгийн мэргэжлийн байгууллага, олон нийтийн оролцоотой сонгон шалгаруулж, томилдог байх эрх зүйн орчныг бий болгож, удирдах ажилтныг бэлтгэх, ур чадварыг нь дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно гэсэн нь менежментийн таатай орчинг бүрдүүлэх юм. Гэхдээ тус хөтөлбөр нь жендэртэй шууд холбогдох үйл ажиллагааг төлөвлөгөөгүй, хэрэгжилтийн үнэлгээний шалгуурт жендэрт холбогдох шалгуур үзүүлэлт оруулаагүй ажээ.

НҮБ-аас баталсан Мянганы хөгжлийн зорилтуудтай уялдуулан боловсруулагдан хэрэгжиж байсан Монгол улсын үндэсний хөгжлийн цогц бодлогыг сайжруулан, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-30”-ийг УИХ-аас 2016 оны 19-р тогтоолоор баталсан. Энэхүү бодлогод хүний хөгжил, боловсрол, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогын талаар авч үзсэн. Энэхүү бодлогын хүлээгдэж буй үндсэн үр дүнд “Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болно” гэж оруулсан нь боловсрол, жендэрийн тэгш байдлын үзүүлэлтийг ахиулахад ихээхэн анхаарлаа хандуулж байгааг харуулах юм. Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд **“жендэрийн тэгш байдлыг хангах, бүх ... иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх...** -д чиглэнэ гэж заасан. Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчимд:

- *хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлт нь хүртээмжтэй өсөлтөд суурилсан хүний хөгжил байх;*
- *иргэний болон насан туршийн боловсролын тогтолцоо нь нээлттэй, хүртээмжтэй, чанартай байх;*
- *нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх гэсэн зарчмуудыг оруулсан бөгөөд энэ нь хөгжлийн үр шимийг тэр дундаа боловсролын үр шимийг хүн бүрт, эрэгтэй, эмэгтэйчүүд адил тэгш хүртэх, оролцоог хангах үзэл баримтлалыг дэвшүүлжээ.*

Цаашлаад нэг багшид ногдох хүүхдийн тоог бууруулах, сургуулийн хичээллэх ээлжийн тоог бууруулах, сургууль бүрийг сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах зэрэг тодорхой бөгөөд хэмжигдэхүйц зорилтуудыг дэвшүүлсэн нь эрэгтэй, эмэгтэй хүүхэд бүрт, чанартай, хүртээмжтэй боловсролын үйлчилгээг хүргэхэд анхаарснаараа ихээхэн ач холбогдолтой юм.

Гэхдээ зургаан жилийн тэртээгээс боловсрол дахь жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлнэ гэсэн зорилт өнөө хэр бодит биелэлээ олоогүй хэвээр байгаагийн зэрэгцээ дараа дараагаар нь батлагдсан бодлогын баримт бичгүүдэд жендэрийн тэгш байдлыг хангахтай шууд холбогдох тусгайлсан зорилт, арга хэмжээ тусгагдаагүй хэвээр байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011 онд батлагдан хэрэгжсээр даруй 5 жил өнгөрч байгаа ч, боловсролын салбарт хэрэгжиж эхэлсэн томоохон хөтөлбөрүүдийн агуулгад уг хуулийн үзэл санаа тусгагдаагүй байгааг анхаарах шаардлагатай байна.

#### ***Боловсролын салбарт жендэрийн тулгамдсан асуудлуудын судлагдсан байдлын тойм***

Боловсролын асуудлаар судалсан судалгааны тоо жилээс жилд өсч байна. Гэхдээ тэдгээрийн дунд

боловсрол дахь жендэрийн асуудлыг хөндсөн нь хуруу дарам цөөн юм. Боловсролын хүрээлэн 2000-аад оны эхээр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулгад жендэрийн дүн шинжилгээ хийсэн<sup>11</sup> бөгөөд энэ хүрээнд судлаач О.Пүрэв судалгааны үр дүнд тулгуурлан бичсэн өгүүллээ “Монголын боловсрол, сургалтын хүмүүншүүлэх онол, арга зүйн зарим асуудалд (2007) бүтээлдээ хэвлүүлсэн<sup>12</sup> ажээ. Тэрээр түүхийн сурах бичгийн зураг, дүрслэл, эх, дасгал, даалгавар зэргийн агуулгад жендэрийн дүн шинжилгээ хийсэн ба уг судалгааны үр дүнд 352 хүний дүрслэлийн зөвхөн 3.4 хувь нь эмэгтэй хүний талаар болохыг илрүүлэн, жендэрийн мэдрэмжийн хувьд учир дутагдалтай бөгөөд жендэрийн дүр үүрэг, эрэгтэй, эмэгтэй хүүхдийн сурах арга барилын онцлогийг харгалзах, жендэрийн боловсрол эзэмшсэнийг шалгах, үнэлэх талаар анхаарууштай байгаа тухай дүгнэжээ<sup>13</sup>.

Судлаач С.Түмэндэлгэр боловсролын салбарын хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн сегрегацийн талаар судалсан ба багшийн ажил эрхэлж буй эцэг эхчүүд, тэр дундаа эмэгтэйчүүд хүүхдээ асрах хийгээд багшлах ажлаа хэрхэн хослуулж байгаа талаар хөнджээ. Түүнийхээр боловсролын салбарт эмэгтэйчүүд зонхилох болсонд нэгдүгээрт, “сурган хүмүүжүүлэх багшийн ажилд эмэгтэйчүүд илүү авъяаслаг” гэсэн хэвшмэл ойлголт, хоёрдугаарт, уян хатан цагийн хуваарь бүхий байдал нь эхчүүдэд тааламжтай байдаг гэсэн шалтгаанууд нөлөөлсөн<sup>14</sup> хэмээн тайлбарласан байна.

Мөн Боловсролын төлөөх ТББ-уудын түншлэл, Монфемнет байгууллагаас ЕБС-ын 7-11 ангийн 31 сурах бичиг, 27 багшийн номонд жендэр, нийгмийн орчны дүн шинжилгээ<sup>15</sup> хийсэн бөгөөд уг судалгааны үр дүн, түүнд тулгуурлан гаргасан зөвлөмжийг БСШУЯ-д хүргүүлсэн байдаг. Тэрхүү зөвлөмжид сурах бичигт жендэрийн асуудлыг анхаарах нь жилээс жилд өсөж байгаа ч, жендэрийн өрөөсгөл хандлага, жендэрийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлэхүйц санаанууд нь сурах бичгийн үндсэн эх хийгээд дасгал даалгавар зэргийг агуулгад ажиглагдсаны хамт асуудалд олон ургалч хандлагаар хандахаас илүүтэй зөвхөн нэг “үнэн”-ийг тулгасан зэрэг алдаа дутагдал байгааг батлан харуулсан байв. Мөн сурах бичиг зохиогчдын хүний эрх, жендэрийн талаарх боловсролыг дээшлүүлэх, сурах бичигт жендэрийн мэдрэмжтэй байдлыг хангах бодлого үгүйлэгдэж байгаа тухай өгүүлжээ.

Судлаач С.Энхтүвшин, Ц.Монголхатан нар Швейцарийн хөгжлийн агентлагийн захиалгаар “Монголын баруун бүсийн МСҮТ-ийн багш, суралцагчдын жендэрийн судалгаа” -г 2015 онд хийж гүйцэтгэжээ. Уг судалгаа нь мэргэжлийн боловсролын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай эрх зүйн орчин ямар болох, МСҮТ-д жендэрийн соёл хэр зэрэг бүрдсэн тодруулсны үндсэн дээр жендэрийн тэгш байдлыг тогтооход анхаарвал зохих санаануудыг олж авах зорилготойгоор хийгджээ. Судалгаагаар судалгаанд хамрагдагсдын дийлэнхэд нь жендэрийн уламжлалт хандлага ажиглагдсан ба түүний дотроос “эмэгтэй хүн техниктэй ажиллах ур чадвараар дутмаг” гэсэн өрөөсгөл хандлага маш нийтлэг илэрчээ<sup>16</sup>. Түүнчлэн уг судалгаагаар эрэгтэй, эмэгтэй багш нарын дунд хүйсээр ялгаварлах байдал хийгээд дарамт ялгаатай илэрдэг болохыг харуулсан байна. Тодруулбал, эрэгтэй багш нарт ажлын байрны тодорхойлолтоос гадуурх ажлын үүрэг хариуцлага оногдуулах дарамт олонтаа ирдэг бол эмэгтэй багш нарт удирдлагын зүгээс үзүүлэх эерэг бус харилцааны шинжтэй, сэтгэл зүйн дарамт илүү ирдэг аж. Мөн мэргэжил

<sup>11</sup>Боловсролын хүрээлэн, ЮНЕСКО (2003). Монголын боловсрол дахь жендэрийн асуудлууд. Судалгааны үр дүн. [http://forum.mn/res\\_mat/Study\\_Report\\_MON\\_gender.pdf](http://forum.mn/res_mat/Study_Report_MON_gender.pdf)

<sup>12</sup> О.Пүрэв (2007) Нийгмийн ухааны сурах бичиг дэх жендэрийн дүн шинжилгээний үр дүнгээс. *Монголын боловсрол, сургалтын хүмүүншүүлэх онол, арга зүйн зарим асуудалд*. УБ.,

<sup>13</sup> мөн тэнд, 119-р тал

<sup>14</sup> С.Түмэндэлгэр (2008) Монгол хөдөлмөр эрхлэлт жендэрийн тусгаарлалт (социологийн шинжилгээ). УБ.,

<sup>15</sup> Д. Тунгалаг (2015). 7-11-р ангийн сурах бичиг, багшийн номонд жендэр ба орчны шинжилгээний багийн нэгдсэн санал дүгнэлт, зөвлөмж (хэвлэгдээгүй)

<sup>16</sup> SAD (2015) Gender survey among TVET teachers and students in Western region of Mongolia. Pp: 19-22

дээшлүүлэх боломж хийгээд урамшуулал, дэмжлэг авах талаар хүйсийн ялгаа ажиглагддаг хэмээн судалгаанд оролцогчид дүгнэсэн байна. Багш нар гэр бүлийн үүргээ ажил хөдөлмөртэйгээ хослуулах боломж, сургуулиас энэ талаар дэмжлэг үзүүлэх байдал сул болохыг басхүү илрүүлсэн байна. Судалгааны үр дүнд МСҮТ-д жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, энэ хүрээнд байгууллагын эерэг соёлыг бүрдүүлэх, багш, суралцагчдад жендэрийн боловсрол олгоход чиглэсэн зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай болохыг зөвлөмжилсөн<sup>17</sup> ажээ.

Боловсрол дахь жендэрийн дүн шинжилгээнд шууд холбоогүй ч, судалгааны үр дүн нь тодорхой хэмжээгээр холбогдож буй зарим судалгаануудын талаар товч авч үзье. Тухайлбал, Швейцарийн хөгжлийн агентлагийн захиалгатайгаар БСШУЯ-аас бүрдүүлсэн баг “Монгол улс дахь тогтвортой хөгжлийн боловсрол: Олон түвшинт суурь судалгаа”-г гүйцэтгэсэн байна. Уг судалгаагаар бага ангид хөвгүүд, охидын оролцооны ялгаа бараг байхгүй атал суурь болон бүрэн дунд шатанд охидын оролцоо хөвгүүдийнхээс илүү болохыг тогтоожээ. Ажиглалт хийгдсэн сургалтуудын 42 хувьд нь жендэрийн эрх тэгш байдлыг дэмжсэн стратегийг ашигласан ба жендэрийн эрх тэгш байдлыг дэмжсэн стратегийг хэрэгжүүлэх тохиолдолд охид, хөвгүүдийн оролцоо илүү тэнцвэртэй болж байгааг ажигласан байна. Жендэрийн тэгш байдлыг дэмжсэн танилцуулга, плакат хуудас нийт судлагдсан сургуулиудын 84 хувиас илүүд нь<sup>18</sup> ажиглагдсан гэжээ. Гэхдээ жендэрийн өрөөсгөл хандлага, хэвшмэл үзэл санааг дамжуулж буй танилцуулга, зурагт хуудас байсан эсэхийн талаар тайланд дурдаагүй байв.

Бага боловсролын математик, унших чадварын үндэсний үнэлгээ-2008 судалгаагаар математикийн ч чадварын охид, хөвгүүдийн хооронд бараг ялгаагүй, харин монгол хэлний чадварын хувьд охид хөвгүүдээс ялимгүй өндөр болохыг<sup>19</sup> илрүүлжээ. Анги ахих тусам хөвгүүдийн оролцоо, сурлагын амжилт буурч байгааг бусад судалгаанууд баталдаг. Элсэлтийн ерөнхий шалгалтын хувьд охидын дундаж оноо хөвгүүдийнхээс өндөр<sup>20</sup> байгааг анхаарахгүй орхиж үл болно.

Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хийсэн “Монгол дахь сургууль завсардалт” судалгааны үр дүн нь сургуулийн гадна, сургууль завсардсан хүүхдийн тухай албан ёсны статистик нь бодит мэдээллийг бүрэн хамарч чадахгүй байгаа асуудлыг хөндөөд, хөвгүүд сургууль завсардалтад илүүтэй өртөж байгааг илрүүлжээ. Ялангуяа ядуурал, мал аж ахуй, хөдөлмөр эрхлэлт зэрэг нь тэдгээрийг сургуульд завсардахад хүргэж байна гэжээ<sup>21</sup>. Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсээс хийсэн судалгаагаар нийслэлд нийт 439 хүүхэд сургууль завсардсанаас 290 нь хөвгүүд<sup>22</sup> болохыг дурджээ. Хотын захын хорооллын нийгмийн үйлчилгээ: Боловсролд хамрагдалт (2011) кейс судалгаагаар сургууль завсардалт, сургуулийн гадна байгаа хүүхдийн албан ёсны статистик бодит байдал дахь нөхцөл байдлаас бараг 3 дахин цөөхөн үр дүнг харуулж байгаад шүүмжлэлтэй хандаж, нотолсны хамт сургууль завсардсан, сургуулийн гадна байгаа хөвгүүдийн тоо, охидынхоос даруй 2 дахин илүү байгааг<sup>23</sup> судалжээ.

Дээрх судалгааны бүтээлүүд нь боловсрол дахь жендэрийн эрх тэгш байдалд холбогдох олон асуудлуудыг тусгайлан анхаарч судалжээ. Эдгээр судалгаануудыг нэгдүгээрт, сургалтын хөтөлбөр,

<sup>17</sup> мөн тэнд, Рр:59-62

<sup>18</sup> ШХА, БСШУЯ (2014) Монгол улс дахь тогтвортой хөгжлийн боловсрол: Олон түвшинт суурь судалгаа. 22-23-р тал

<sup>19</sup> БҮТ (2008) Бага боловсролын математик, унших чадварын үндэсний үнэлгээ. УБ., 32-р тал

<sup>20</sup> БҮТ (2013) 2013 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын тайлан УБ., 77-р тал

<sup>21</sup> БХАН (2005) Монгол дахь сургууль завсардалтын судалгаа

<sup>22</sup> Нийслэлийн ХГБХХ (2014) Сургууль завсардсан хүүхдийн судалгаа. 5-р тал.

<http://child.ub.gov.mn/wp-content/uploads/2013/06/сургууль-завсардсан-хүүхдийн-судалгаа.pdf>

<sup>23</sup> Зохистой хөгжлийн жендэр төв (2011) Хотын захын хорооллын нийгмийн үйлчилгээ: Боловсролд хамрагдалт. 14-р тал. [http://forum.mn/forum\\_topics/Social/Survey%20report\\_%20OSI\\_24%20March%202011.pdf](http://forum.mn/forum_topics/Social/Survey%20report_%20OSI_24%20March%202011.pdf)

сурах бичиг дэх жендэрийн дүн шинжилгээ, хоёрдугаарт, боловсролын тодорхой түвшин дэх оролцогчдын жендэрийн ойлголт, хандлагын судалгаа, гуравдугаарт, боловсролын үйлчилгээний тэгш хүртээмжийн судалгаа хэмээн ангилж болохоор байна. Гэхдээ эдгээр нь боловсрол дахь жендэрийн ямар бодлого хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагын хангалттай үндэслэгээ нотолгоо болж чадахгүй байна. Иймд боловсрол дахь жендэрийн тэгш эрхийн хэрэгжилт, боловсролоор дамжуулан жендэрийн эрх тэгш байдлыг тогтоох боломж бүрдсэн эсэхийг тодруулан, бодлогын өөрчлөлтийг хэрхэн хийхийг тодруулсан судалгаа явуулах шаардлага буйг нотолж байна.

### ***”Ерөнхий боловсролд жендэрийн дүн шинжилгээ” судалгааны зорилго***

”Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн захиалгаар гүйцэтгэсэн “Ерөнхий боловсрол дахь жендэрийн шинжилгээ” бол бага, дунд боловсролд жендэрийн асуудлаар хийгдсэн анхны цогц судалгаа болсон. Судалгаагаар бүрэн дунд боловсрол олгох үйл явцыг жендэрийн үүднээс шинжлэх, жендэрийн асуудал орхигдож байгаа буюу жендэрийн асуудлыг бодолцолгүй гаргасан бодлого зохицуулалтыг илрүүлэх, улмаар сургуулийн орчинд жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг зөвлөх зорилго тавьсан. Дараах асуудлуудыг судалсан. Үүнд

- Ерөнхий боловсролын сургуулийн орчин охид хөвгүүдийн суралцах, бие хүний хувьд хөгжин төлөвших, ялангуяа жендэрийн эрх тэгш байдлыг хангахыг дэмжсэн таатай орчин эсэх, тодруулбал, хүчирхийлэл ялгаварлалаас ангид эсэх, жендэрийн дэвшилтэт дүр, үүргийг дэлгэрүүлдэг эсэх
- Сургуулийн удирдлага менежмент ажиллагсад ба суралцагчдын жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар жендэрийн мэдрэмжтэй үйл ажиллагаа явуулдаг эсэх, тухайлбал сургуулийн бодлогын болон зохицуулалтын баримт бичгүүдэд жендэрийн тэгш байдлыг хангах талаар хэрхэн тусгагдсан, сургуулийг удирдах үйл явцад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангадаг эсэх, багшийн болон суралцагчийн амжилтыг үнэлэхдээ жендэрийн шалгүүр үзүүлэлтээр үнэлдэг эсэх,
- Сургалтын хөтөлбөрүүд жендэрийн эрх тэгш байдлыг дэмжсэн эсэх, эрх тэгш байдлыг хангах арга замыг тодорхойлсон эсэх, цаашлаад хөтөлбөр боловсруулах үйл явцад жендэрийн тэгш оролцоог хангасан эсэх
- Багшийн хичээлийн хөтөлбөр охид хөвгүүдэд суралцах адил боломж олгох, тэгш оролцоог хангах, сонирхол хэрэгцээг тусгах талаар жендэрийн мэдрэмжтэй боловсруулагдсан эсэх, багш хичээлийн явцад тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлж байгаа
- Сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн болох сурах бичиг жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл санааг хэр шингээсэн, жендэрийн дэвшилтэт дүр, үүрэг, үзэл санааг тусгасан эсэх
- Багш, эцэг эх, үе тэнгийнхний боловсрол болон жендэрийн талаарх ойлголт хандлага охид хөвгүүдийн суралцах байдалд хэрхэн нөлөөлж байгаа, охид хөвгүүдийн жендэрийн эрх тэгш байдлыг ханган хувь хүний хувьд авьяас чадавхиа бүрэн дайчлан хөгжих боломжийг олгож чадаж байгаа эсэх

Судалгааны тайланг 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хийгдсэн цуврал судалгаанд үндэслэн нэгтгэж гаргасан. Үүнд: нэгдүгээрт, баримтын судалгаа буюу хоёрдогч мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үндэсний болон цөм хөтөлбөр болоод багш нарын хичээлийн төлөвлөгөөнд хийсэн баримтын судалгаа, зарим онцлох сурах бичиг болоод сургуулийн дотоод журам, бусад удирдлага зохион байгуулалттай холбоотой баримт бичигт хийсэн

судалгаа багтаж байна. Хоёрдугаарт хээрийн судалгаа буюу сургуулийн орчинд хийсэн ажиглалт, анги танхимын зохион байгуулалт, тохижилт болоод багш сурагчдын хооронд харилцааны ажиглалт судалгаа, гуравдугаарт сургуулийн удирдлага, багш, сурагчид, эцэг эхчүүдийг хамруулсан асуумж судалгаа болоод ярилцлага, дөрөвдүгээрт сурагчид ба тэдний эцэг эхчүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлага, төгсгөлд нь буюу тавдугаарт энэ салбарын бодлого боловсруулах түвшний эрх бүхий хүмүүстэй хийсэн ярилцлага гэсэн бүтэцтэй байна.

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

**Судалгааны зорилго:** Уг судалгааны зорилго нь ерөнхий боловсролын бодлого, хөтөлбөр, хэрэглэгдэхүүн, сургалтын үйл ажиллагаа, орчин, ажиллагсад, суралцагсдын харилцаанд жендэрийн дүн шинжилгээ хийн, боловсролоор дамжуулан жендэрийн тэгш байдлыг тогтооход хувь нэмэр оруулах үйл ажиллагааны чиглэл, анхаарвал зохих зөвлөмжүүдийг боловсруулахад оршино.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Боловсролын салбарын бодлого, хууль, эрх зүйн актад жендэрийн дүн шинжилгээ хийх,
- ЕБС-ийн бодлого, эрх зүй, менежмент, материаллаг орчинд жендэрийн дүн шинжилгээ хийх,
- Бага, дунд боловсролын цөм хөтөлбөр, бүрэн дунд боловсролын үндэсний хөтөлбөр, сурах бичиг, багшийн нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр, хэрэглэгдэхүүнд жендэрийн дүн шинжилгээ хийх,
- ЕБС-ийн хичээлийн үйл явцыг ажиглах замаар суралцахуй болон багшлахуйн үйл явц дахь жендэрийн асуудлуудыг тодруулах,
- Багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх хүрээний жендэрт холбогдох асуудлуудыг тодруулан шинжлэх,
- Оролцогч талуудын жендэрийн талаарх ойлголт хандлагыг судлах,
- Судалгааны үр дүнд тулгуурлан боловсрол ба жендэрийн тэгш байдал хоорондын зохист уялдаа холбоог хангахад чиглэсэн үйл ажиллагааны чиглэл, санал зөвлөмжийг боловсруулах,

Уг судалгаа нь Харвард, Мозер, Жендэрийн дүн шинжилгээний матриц, Эмэгтэйчүүдийн чадавхжуулалтын хүрээ, Нийгмийн харилцааны хандлага гэсэн жендэрийн дүн шинжилгээний аргачлалуудын хосолмол хувилбарыг ашигласан болно. Жендэрийн дүн шинжилгээний хосолмол хувилбар нь тухайн нөхцөл байдлыг шинжлэх, ойлголт, хандлагыг сайжруулах, жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван алхамтайгаар хэрэгждэг. Уг судалгаа нь дүн шинжилгээний нэгдүгээр алхамын хүрээнд буюу буюу Ерөнхий боловсролын түвшин дэх жендэрийн өнөөгийн төлөв байдлыг тодруулан, хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагааны чиглэлийг тодрууллаа.

Өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах судалгааны аргачлал, үндсэн хэрэглэгдэхүүнийг УПСАЛЖА их сургуулийн профессор Стефан Венстонтой хамт боловсруулсан ба “Promoting gender equality in education” (UNESCO, 2009) гарын авлагыг ашигласан болно. Хэдийгээр асуулга, стандартчлагдсан ажиглалт, контент анализ зэрэг тоон судалгааны аргуудыг ашиглаж байгаа ч, боловсролын салбарын нүдэнд ил харагдах үзэл баримтлал, бодлого, хөтөлбөр, сургалтын хөтөлбөр, сурах бичигт дүн шинжилгээ хийх, сургалтын үйл ажиллагааг ажиглах, оролцогч талуудтай ярилцах, асуулгаар мэдээлэл цуглуулах зэргээр цаана нь буй ноёрхогч үзэлд суртал, өрөөсгөл хандлага, хэвшмэл ойлголтыг тодруулах, улмаар цаашид өөрчлөх, сайжруулахад чиглэсэн санал зөвлөмжийг боловсруулахаар зорьж ажиллаж байгаа тул судалгаа бүхэлдээ шүүмжлэлт онолын хандлагын дагуу буюу чанарын судалгааны арга зүйн хандлагад тулгуурлаж байгаа болно.

### **Мэдээлэл цуглуулах аргачлал**

Судалгаанд баримт бичгийн чанарын шинжилгээ, контент анализ, ажиглалт, асуулга, ганцаарчилсан ярилцлага, бүлгийн ярилцлага, экспертийн ярилцлага зэрэг тоон болон чанарын судалгааны үндэн аргуудыг зэрэгцүүлэн хэрэглэв.

1. *Баримт бичгийн чанарын шинжилгээ.* Уг шинжилгээг 2 түвшинд хийв.

- a. Боловсрол, жендэрийн асуудлаарх бодлого, хууль тогтоомжийн агуулга дахь жендэрийн мэдрэмжит байдлыг тодруулах.
  - b. ЕБС-ийн бодлого, эрх зүйн баримт бичгүүд (сургууль хөгжүүлэх, сургуулийн дотоод журам, ёс зүйн дүрэм, сургуулийн дэг, багшийн ажлыг үнэлэх журам, хүүхэд хамгааллын бодлого, сургуулийн орчны стандарт г.м), сургуулийн гадаад болон дотоод орчин, багш бэлтгэх хөтөлбөрт жендэрийн дүн шинжилгээ хийх.
2. *Контент анализ.* Бага, суурь боловсролын цөм хөтөлбөр, 12 жилийн сургалтын хөтөлбөр, Нийгмийн ухаан, Монгол хэлний хичээлийн сурах бичиг (I-XII анги)-ийн агуулга хэр зэрэг жендэрийн мэдрэмжтэйгээр боловсруулагдсан эсэхэд дүн шинжилгээ хийхдээ ашиглав.
  3. *Ажиглалтын арга.* Хичээлийн танхим дахь охид, хөвгүүдийн сурах болон багшийн багшлах үйл ажиллагааг 35-40 минутын туршид стандарчлагдсан хэлбэрээр ажиглав. Уг аргаар багшийн хичээлээ хөтлөн явуулж буй арга зүй, аргачлал, суудал хуваарилалт, хөдөлгөөн, сурагчидтай харилцах харилцаа, сахилга бат тогтоож буй арга барил, сургалтын явц дахь охид, хөвгүүдийн оролцоонд гол анхаарлаа хандуулан мэдээлэл цуглуулав.
  4. *Ганцаарчилсан ярилцлага.* Тус аргаар ажиглалтын судалгаанд хамрагдсан багшаас хичээлийн үйл явц, хөтөлбөрийн талаар тодруулга авсан бөгөөд жендэрийн хариуцлагатай багшлах үйл ажиллагаатай нь холбогдох хэрэгцээг тодорхойлов.
  5. *Асуулгын арга:* Багш, хүүхэд, эцэг эхчүүдийн жендэрийн талаарх ойлголт, хандлага, сурах болон сургах үйл ажиллагаан дахь жендэрийн мэдрэмжтэй байдал, сургуулийн орчин дахь ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл дарамтын талаарх мэдээллийг цуглуулсан.
  6. *Экспертийн ярилцлага:* Салбарын яам, сурах бичиг, хөтөлбөр боловсруулах баг, багш бэлтгэдэг их сургуулийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулан тэдний жендэрийн туршлага, чадавхжилт, хөтөлбөр, сурах бичиг зохиоход жендэрийн агуулгыг хэр харгалздаг, жендэрийн тэгш байдлыг тогтооход хэр анхаарч буй байдлын талаар судлав.

### Түүврийн загвар

Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл хэрэгжих 7 аймгийн (зорилттойгоор сонгон) 14 сум, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 23 сургуулийн нийт 1520 зорилтот бүлгийн хүн амыг (удирдах ажилтан, багш, хүүхэд, эцэг эх) хамрууллаа. Сургууль, судалгааны нэгж хүн амыг энгийн санамсаргүй аргаар сонгосон бөгөөд судалгааны талбар болоод түүврийн хэмжээг доорх хүснэгтэд нэгтгэн харуульа.

Хүснэгт 1 Судалгаанд хамрагдсан хүн ам, аргаар, байршлаар

Сонгосон үзүүлэлт	Асуулга				Удирдах ажилтны ярилцлага	Бүлгийн ярилцлага		Багшийн хичээлийн ажиглалт, ярилцлага, анализ			Орчны шинжилгээ
	Удирдах ажилтан	Багш	Сурагч	Эцэг эх		Сурагч	Эцэг эх	Хичээл	Ярилцлага	Хөтөлбөр	
<b>Байршил</b>											
Өвөрхангай	6	34	46	20	3	2	2	4	4	4	2
Орхон	6	35	45	20	5	2	2	4	4	4	2
Дундговь	6	34	45	20	5	2	2	4	4	4	2
Сэлэнгэ	6	33	51	20	4	2	2	4	4	4	2
Сүхбаатар	4	34	46	20	5	2	2	4	4	4	2
Ховд	6	35	50	20	4	2	2	4	4	4	2
Завхан	5	34	46	20	4	2	2	4	4	4	2
Улаанбаатар	11	253	409	150	7	9	9	36	36	36	9



<b>Хүйс</b>											
Эрэгтэй	18	141	351	121							
Эмэгтэй	50	351	357	169							
<b>Яс үндэс</b>											
Халх	-	-	530	248	-	-	-	-	-	-	-
Казак	-	-	26	11	-	-	-	-	-	-	-
Бусад	-	-	182	31	-	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>68</b>	<b>492</b>	<b>738</b>	<b>290</b>	<b>36</b>	<b>16</b>	<b>16</b>	<b>64</b>	<b>64</b>	<b>64</b>	<b>23</b>

Нэг удаагийн бүлгийн хэлэлцүүлэгт дунджаар 8 эцэг эх, суралцагчдын төлөөллийг хамруулсан ба хот хөдөөд нийт 32 удаагийн бүлгийн ярилцлагад 256 эцэг эх, хүүхэд хамрагджээ. Ажиглалтын аргад 23 сургуулийн 36 багш хамрагдлаа.

#### Хүснэгт 2 Экспертийн ярилцлагын түүвэрлэлт

№	Экспертүүд	Экспертийн ярилцлага	Бүлгийн ярилцлага
1.	МУБИС-ийн сургалт, хөтөлбөрийн албаны дарга	1	
2.	Сурах бичиг зохиогчдын багийн гишүүд		1
3.	Боловсролын үнэлгээний төв	1	
4.	Боловсролын хүрээлэнгийн сурах бичиг хариуцсан секторын мэргэжилтэн	1	
5.	Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтын багш, арга зүйч	1	
6.	Хөтөлбөр боловсруулагчдын баг		1
7.	Боловсролын төлөөх ТББ-уудын түншлэл	1	
8.	Аймаг, дүүргийн БСГ, хэлтсийн дарга, мэргэжилтэн	16	
	<b>Нийт</b>	<b>21</b>	<b>2</b>

#### Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт, дүн шинжилгээ

Мэдээлэл цуглуулалтын шатны ажлыг 2016 оны 1-3 дугаар саруудад гүйцэтгэсэн бөгөөд мэдээлэл цуглуулах 7 баг ажиллалаа.

Судалгааны мэдээлэл цуглуулалтын шатны ажил дууссаны дараа тоон болон чанарын аргаар цуглуулсан мэдээллүүдийг Майкрософт-Эксел, SPSS программд шивэлт, боловсруулалтын шатны ажлыг гүйцэтгэж дүн шинжилгээ хийв.

- Боловсруулалтын эхний шатанд нээлттэй болон хагас нээлттэй асуултуудыг багцлан хаалттай хэлбэрийн хувьсагчуудыг үүсгэсэн.
- SPSS программд асуулгын мэдээллийг бүтцээр бааз үүсгэн бүх хувьсагчуудыг оруулсан.
- Мэдээллийн баазад асуулгын хуудсуудын өгөгдлүүдийг оруулсны дараа санамсаргүй болон логикийн алдаа зөрчлийг бүх асуулгын хуудастай тулган засварласан.
- SPSS-г оруулж дууссаны дараа мэдээллийн баазад үр дүнгийн хүснэгтэн төлөвлөгөөг хийж, дан тооллын болон харьцуулсан хүснэгтүүдийг боловсруулсан.
- SPSS-г оруулсан тоон болон интервал түвшний хувьсагчийг дахин кодлож судалгааны мэдээллийг шинжлэхэд шаардлагатай шинэ хувьсагчуудыг үүсгэсэн.
- Чанарын судалгааны мэдээллүүдийг шивэх, категорчлон агуулгын шинжилгээ, хэв маягчлал, ангилал хийх, ишлэл, кейс мэдээллүүдийг боловсруулсан.

## БҮЛЭГ 1. ЖЕНДЭРИЙН НИЙЦТЭЙ СУРГУУЛИЙН ОРЧИН

Энэ бүлэгт ерөнхий боловсролын салбарын суурь үзүүлэлтүүд болон судлагдсан сургуулиудын орчны аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, сургуулиас гадуурх сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа, мэргэжил сонголтод жендэрийн агуулгаар дүн шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.

### 1.1 Бага болон суурь боловсролын чанар, хүртээмж

#### 1.1.1 Сургуульд элсэлт, хамрагдалт ба төгсөгчдийн харьцаа

Үндэсний хэмжээнд хамран сургалт ач холбогдолын түвшинд сайжирсан нь ерөнхий боловсролын сургуульд хамран сургалтын цэвэр жин 97 хувьтай, бага болон ерөнхий боловсролын түвшинд 91.6 хувьд хүрчээ. Бага анги төгсөгчдийн хувь өссөн нь 1995 онд 75 хувьтай байсан бол одоо 100 хувьд хүрчээ. Анхан болон дунд шатны сургуулиудын шилжилтийн харьцаа 1995 онд 85 хувь байсан бол 2014 онд 98.7 хувь болж өссөн дүнтэй байна.<sup>24</sup>

Хүснэгт 3 ЕБС-ийн суурь үзүүлэлтүүд, 2005/06–2013/14)


Сонгосон үзүүлэлтээр	2005/06	2007/08	2010/11	2011/12	2012/13	2013/14
ЕБС-ийн тоо	724	754	751	752	755	756
Улсын сургуулийн тоо	585	602	609	614	621	628
Хувийн сургуулийн тоо	139	152	142	138	134	128
Үндсэн багш нарын тоо	22,628	22,891	26,358	26,492	26,863	27,205
Багш сурагчийн харьцаа	24.6	25.5	19.4	19.1	18.5	18.3
Элссэн сурагчдын тоо	556,876	537,546	512,213	505,409	496,123	497,022
Эмэгтэй элсэн сурагчдын тоо	285,128	273,271	257,302	253,456	248,974	248,893
Ахлах ангид сурагчдын тоо	83,486	85,640	73,727	79,550	95,418	93,124
Дунд ангид сурагчдын тоо	223,768	212,243	172,847	169,275	155,318	146,632
Бага ангид сурагчдын тоо	249,622	239,663	265,639	256,584	245,387	239,343

Эх сурвалж.: УСХ, 2005-2015


Ерөнхийдөө, бага боловсролын түвшинд жендэрийн тэнцвэртэй байдал хадгалагдаж байгаа ч суурь болон дээд боловсролын түвшинд жендэрийн зөрөө гарч эмэгтэй суралцагчид давамгайлж байна. 2015 онд бага боловсролын түвшинд охид хөвгүүдийн харьцаа \жендэрийн зөрөөний индекс\ 0.96, дунд болон ахлах шатанд 0.99, 1.13 байгаагаас үзвэл охидын эзлэх хувь өндөр байгааг харуулж байна. Их дээд боловсролын түвшинд охид хөвгүүдийн харьцааг дараах зурагт харуулав.

<sup>24</sup>(ADB, 2015) J. Sarvi et al. Transitions to k–12 education systems: experiences from five case countries. Mandaluyong City, Philippines: Asian Development Bank, 2015.

Зураг 1 Бүх шатны боловсролын шатанд суралцагчдын харьцаа, хүйсээр



Зураг 2 Боловсролын түвшин дэх суралцагчдын харьцаа



Хүснэгт 4 ЕБС-ийн суурь үзүүлэлтүүд, хүйсээр

Сонгосон үзүүлэлтээр	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
Суралцагчдын тоо	49.9	50.1	505816
Шинээр элсэгчдийн тоо	51.3	48.7	60205
Дотуур байранд амьдардаг сурагчдын тоо	48.2	51.8	32858
Сургууль завсардсан сурагчдын тоо (6-14 нас)	65.4	34.6	1169

Эх сурвалж: Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын статистикийн эмхтгэл, 2015

Боловсролын статистикаар 6-14 насны 1169 хүүхэд сургууль завсардсанаас хүйсийн хувьд хөвгүүд (65.4%) нутагшилтын хувьд хөдөөд (91.9%) сургууль завсардалт илүү байгааг мэдээлжээ.

Хүснэгт 5 ЕБС-ийн суурь үзүүлэлтүүд, хүйс болон байршлаар

Сонгосон үзүүлэлтээр	Хот		Нийт	Хөдөө		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй	
Дотуур байранд амьдардаг сурагчдын тоо	52.7	47.3	2771	65.3	34.7	180758
Сургууль завсардсан сурагчдын тоо (6-14)	58.9	41.1	95	65.6	34.4	1075

Эх сурвалж: Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын статистикийн эмхтгэл, 2015

Нийслэлийн Боловсролын газрын статистик мэдээллээр, 2014-2015 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд суралцдаггүй 6-14 насны 94 хүүхэд бүртгэгдсэн нь өмнөх хичээлийн жилээс 19.0 хувиар өсчээ. Улсын хэмжээнд 45 хувийг өвчний улмаас, 31.4 хувь нь амьдралын гачигдлаар, 11.3 хувь нь тодорхой шалтгаангүйгээр, 10.9 хувь нь сурах дургүйгээс, 1.3 хувь нь ажил эрхлэхээр сургууль завсардажээ. БСШУЯ сургууль завсардалтыг сургуульд огт ороогүй, сургуульд ороод завсардсан 2 ангиллаар бүртгэгдгээс сургуульд огт ороогүй хүүхдийн тоо өндөр гарч байгаа нь анхаарал татахаар үзүүлэлт мөн. Сургуулийн насны сургуульд суралцаагүй хүүхдүүд өвчнөөр, амьдралын гачигдлаар сургууль завсардсан нь зонхилох шалтгаанууд болж байна.

Хүснэгт 6 ЕБС-д суралцдаггүй (сургууль завсардсан) 6-14 насны хүүхдийн тоон мэдээлэл

Үзүүлэлтээр	Хөвгүүд	Охид	Нийт
Амьдралын гачигдал	148	119	<b>367</b>
Сурах дургүй	92	36	<b>128</b>
Ажил эрхлэхээр	15	-	<b>15</b>
Өвчний улмаас	329	198	<b>527</b>
Тодорхой шалтгаангүй	76	56	<b>132</b>
<b>Нийт</b>	<b>760</b>	<b>409</b>	<b>1169</b>

Эх сурвалж: <http://www.meds.gov.mn/data/1503/BDB14-15.pdf>

ЕБС-ийн хамран сургах тойрогтой холбоотой сургууль завсардалт, сургууль хооронд шилжин явсан, 6 настуудтай холбоотой сургууль завсардсан хүүхдийн тоо албан ёсны статистикт бүртгэгддэг эсэх нь эргэлзээтэй. Сургууль завсардалтыг арилгаж, хүүхдийн сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд салбарын статистикт тодорхой шалтгаангүйгээр ангиллаар сургууль завсардалтыг бүртгэж байгаа нь анхаарах асуудал юм.

“Ерөнхий боловсролын жендэрийн дүн шинжилгээ” судалгаааар, хөдөөд сургууль завсардалтын түвшин буурсныг ЕБС-ийн удирдлагууд тэмдэглэсэн ч малчдын хүүхэд, 6 настангууд, өвчний шалтгаанаар, хөгжлийн бэрхшээлтэй, ар гэрийн гачигдал, эцэг эх болон хүүхдийн сонголт, шийдвэрээр хүүхэд сургууль завсардах явдал байсаар байна. Ялангуяа хөвгүүдийн хувьд гэр бүлийн амьжиргаанд нэмэр болох зорилгоор цалинтай ажил хийх, МАА-н ажилд элбэлцэхээр сургууль завсардаж байна.

### 1.1.2 Суралцагчдын элсэлтийн шалтгалтын үнэлгээ

Сүүлийн 10 жилд боловсролын салбарт гарсан өөрчлөлтийн нэг бол охид хөвгүүдийн элсэлтийн ерөнхий шалгалтын хичээлүүдээр зөрүү гарч, ялангуяа хөвгүүд амжилт үзүүлдэг уламжлалт судлагдахууны хувьд охидын үзүүлж буй гүйцэтгэлийн оноо илүү байгааг албан ёсны мэдээлэл харуулаад байна.

2014-2015 оны хичээлийн жилд улсын хэмжээгээр 19293 суралцагч, иргэн ЭЕШ өгсөн байдаг. Өмнөх онуудтай харьцуулахад сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдаж цөөхөн элсэгч шалгуулжээ. 2015 оны ЭЕШ-ын тайланд дурьдснаар ЭЕШ-ын 10 хичээлээр шалтгалт авсан ба шалгуулагчдын 43 хувь эрэгтэй, 57 хувь нь эмэгтэй байсан ЭЕШ-ын гүйцэтгэлийг хүйс болон шалгуулсан хичээлээр авсан оноогоор Хүснэгт 1.3-г үзүүлэв. Эмэгтэй шалгуулагчдын гүйцэтгэл монгол хэл, нийгмийн тухай мэдлэг, англи хэл, газар зүй, үндсэн хөтөлбөрийн биологи хими, МУ-ын түүхийн хичээлүүдэд эрэгтэйгээсээ илүү сайн байхад эрэгтэй шалгуулагчдын хувьд түүх, газар зүй хичээлээр эрэгтэйчүүдийн гүйцэтгэлийн оноо илүү байгааг элсэлтийн ерөнхий шалгалтын дүн харуулж байна.

Элсэлтийн ерөнхий шалгалтаар 800 оноо авсан шалгуулагчид байсангүй, эрэгтэй шалгуулагчийн хамгийн өндөр оноо 526.49, эмэгтэй шалгуулагчийн хамгийн дээд оноо 530 байна.

2014-2015 оны хичээлийн жилд элсэгчдийн тоо цөөрөхөд анхны 12 жилийн сургалтын


шинэчлэлтэй холбоотойгоор элсэгчдийн тоо буурахад нөлөөлснийг албаны эх сурвалжид тэмдэглэжээ.

Хүснэгт 7 Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн, ерөнхий шалгалтын 10 хичээлээр болон шалгуулагчдын хүйсээр

Хичээлийн нэр	Эрэгтэй			Эмэгтэй		
	Оноо	Анхны онооны дундаж	Хэмжээс онооны дундаж	Оноо	Анхны онооны дундаж	Хэмжээс онооны дундаж
Математик	7721	25.5	499.49	8881	24.93	500.66
Математик туршилт	131	23.44	497.06	170	22.49	493.08
Монгол хэл	3768	51.77	474.25	6539	57.51	514.71
Нийгмийн тухай мэдлэг	5931	43.10	478.65	7307	47.75	517.39
Англи хэл	5762	30.82	491.71	8093	32.11	506.00
Орос хэл	333	53.23	506.23	592	56.43	530.06
Газар зүй	1252	26.10	507.06	882	24.70	489.83
Физик	5691	28.95	497.10	4419	29.20	502.74
Физик туршилт	107	32.34	526.49	57	31.79	528.75
Биологи	1081	44.54	491.69	3372	46.59	502.70
Биологи туршилт	8	40.63	474.13	40	46.58	500.78
Хими	1187	29.93	485.23	3409	32.52	505.30
Хими туршилт	24	30.54	502.13	37	30.49	496.05
Монголын түүх	543	35.77	508.88	679	33.79	492.78

Эх сурвалж: 2015 оны ЭЕШ-ын тайлан, 2015

Зураг 3 Элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүн, хүйсээр



Нийслэлийн статистикийн газрын мэдээгээр<sup>25</sup> их, дээд сургууль, коллежид нийт 178.3 мянган оюутан суралцаж байгаагаас 90.7 хувь нь нийслэл Улаанбаатарт суралцаж байна. 91.2 эмэгтэй оюутан буюу нийт суралцагчдын 56.4 хувь нь эмэгтэй байна. БСШУЯ-ны мэдээгээр өмнөх хичээлийн жилүүдтэй харьцуулахад дээд боловсролын түвшинд эмэгтэй оюутнуудын тоо буурч жөндөрийн зөрөө багасч байна. Гэсэн хэдий ч охидтой харьцуулахад хөвгүүдийн коллеж,

<sup>25</sup> <http://ubstat.mn/>

бакалаврын түвшний сургуульд хамрагдалт бага хэвээр байсаар байна. Үүний зэрэгцээ охид техник, инженер, компьютерийн салбарт үргэлжлүүлэн суралцах явдал бага байна. Охид хөвгүүдийн амжилттай суралцахад гарч буй жендэрийн зөрүүг арилгахад сургууль, анги танхим чухал үүрэгтэй.

Элсэлт, элсэлтийн ерөнхий шалгалтын гүйцэтгэлд жендэрийн зөрүү гарч байгаа нь ЕБС-ийн анги танхимаас эхэлдэг. Охид сургуульдаа урт хугацаагаар амжилттай суралцахад анхаарч хичээллэдэг, хичээлийн ирц сайн, хөвгүүд элсэлтийн ерөнхий шалгалтын гүйцэтгэлийн дүнгээр түүх, газар зүйн хичээлд амжилт үзүүлснийг салбарын статистикаас харж болно.

### 1.1.3 Багшлах боловсон хүчин

2014-2015 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 762 ЕБС-д 27205 үндсэн багшаар ажиллаж байгаагаас 81.2 хувь, бага ангийн багш нарын 96.1 хувь, захирлуудын 55.9 хувь, сургалтын менежерүүдийн 77.9 хувь, сургуулийн нийгмийн ажилтнуудын 73 хувь нь эмэгтэйчүүд байгааг БСШУЯ-ны Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны салбарын 2015 оны статистик мэдээлэл харуулж байна. Боловсролын салбарын ерөнхий боловсролын сургуулиудад ажиллагсадад эмэгтэйчүүд зонхилсон бүтэцтэй байна. Жилээс жилд ЕБС-иудын удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өсч ирснийг боловсролын салбарын эксперт түвшний хүмүүс, судлагдсан ЕБС-ийн удирдах ажилтнууд өгүүлсэн билээ.

“Ерөнхий боловсролын сургуулийн жендэрийн дүн шинжилгээ”-судалгаанд хамрагдсан 23 ЕБС-ийн 68 удирдах албан тушаалтны 73.5 хувь, 492 багшийн 71.3 хувь нь, 146 бага ангийн багшийн 93 хувь, 738 сурагчийн 52.4 хувь нь эмэгтэй байсан нь улсын хэмжээний статистиктай ойролцоо түвшний үзүүлэлт юм.

Бага боловсролын түвшинд эмэгтэй багш нар 97.4%, эрэгтэй багш 5-6 хувийг эзэлж байгаа жендэрийн тэнцвэртэй бус харьцаатай байна. Цаашид ерөнхий боловсролын салбарт ажиллаж буй эрэгтэй багш нарын тоог нэмэгдүүлэхэд анхаарах асуудал мөн.

Хүснэгт 8 Багш нарын тоо, хүйсээр, байршлаар

Сонгосон үзүүлэлтээр	Хот		Нийт	Хөдөө		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй	
Үндсэн багшийн тоо	16.3	83.7	10047	19.9	80.1	17265
Үүнээс бага ангийн багшийн тоо	2.5	97.5	3243	4.7	95.3	5658
Захирлын тоо	39.4	60.6	246	46.2	53.8	546
Сургалтын менежерийн тоо	31.4	68.6	1069	25.3	74.7	973
Нийгмийн ажилтны тоо	25.0	75.0	192	33.9	66.1	558

Эх сурвалж: Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын статистикийн эмхтгэл, 2015

Улсын хэмжээнд нийт багш нарын 52.4 хувь нь мэргэжлийн зэрэг эзэмшсэнээс 36.8 хувь нь заах арга зүйч, 15 хувь нь тэргүүлэх, 1 хувь нь зөвлөх багш, мэргэжлийн зэрэгтэй багш нарын ихэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж буйг салбарын статистик харуулж байна. Эндээс харахад ЕБС-иудад хүүхэд хөгжүүлэх арга технологитой, бусад сургуулиудад түгээн дэлгэрүүлсэн, багшийн хөгжилд хувь нэмэр оруулсан, хүүхэд хөгжүүлэх хамтын судалгаа хийсэн туршлага бүхий мэргэжлийн зэрэгтэй эмэгтэй багш нар ажиллаж байна.

Хүснэгт 9 ЕБС-ийн багш нарын мэргэжлийн зэрэг болон сургалтанд хамрагдсан байдал, хүйсээр

Сонгосон үзүүлэлтээр	Хүйс		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	
<b>Мэргэжлийн зэрэг</b>			
Зөвлөх багш	20.3	79.7	<b>187</b>
Тэргүүлэх зэрэгтэй багш	12.6	87.3	<b>4119</b>

Арга зүйч багш	19.0	81.0	<b>10089</b>
<b>Багш давтан бэлтгэх сургалт</b>			
Олон улсад түвшний сургалт	19.0	81.0	<b>3693</b>
Үндэсний түвшинд хамрагдсан сургалт	18.5	81.5	<b>973</b>
Бүсийн сургалт	15.6	84.4	<b>10365</b>
Орон нутгийн сургалт	15.9	84.1	<b>7197</b>

*Эх сурвалж: Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын статистикийн эмхтгэл, 2015*

2015-2016 оны хичээлийн жилд багш нар олон улсын, үндэсний, бүсийн, орон нутгийн сургалтад хамрагдаж мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлжээ. ЕБС-ийн сургуулийн багш нар төрөл бүрийн сургалт, уулзалтанд оролцох, илтгэл тавих, олон улсын түвшний хурал, сургалтанд тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зэрэг олон талт хэлбэрээр чадавхи бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлээд байгааг боловсролын салбарын статистик илтгэж байна.

Бодлогын түвшинд багш бэлтгэх, багшийн мэргэжил олгоход жендэрийн тэнцвэртэй байдалд анхаарах асуудал сул байна. Бодлогын түвшинд анхаарал хандуулахгүй байгаа явдал нь багшлах болон суралцах үйл ажиллагаанд эрэгтэй багшийн загвар байхгүй байгаа нь багшийн мэргэжлийн нэр хүнд унах, хүүхдүүдэд эрэгтэй багшийн ач холбогдолтой дүр үүргээр дутах зэрэг асуудал гарч байна. Гэсэн хэдий ч багш бэлтгэдэг МУБИС сургууль эрэгтэй оюутнуудыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байна. 1970 оноос багшийн мэргэжил ялангуяа бага боловсролын шатанд эрэгтэй багшийн тоо тасралтгүй буурсаар ирсэн байдаг.

### **1.2 Сургуулийн эрүүл, аюулгүй орчин**

Сургууль бол хүүхэд насны ихэнх хугацаа өнгөрдөг орчин юм. Сургуулийн орчин нь хүүхэд бүр сурч хөгжихөд таатай, аюулгүй, хүүхдэд ээлтэй орчин байх ёстой. Монгол улс ЕБС-ийн орчинтой холбоотой заалтуудыг хууль, эрх зүйн баримт бичгүүдэд тусган, холбогдох стандартуудыг батлан мөрдөж байна. Тодруулбал, 2002 онд батлагдан гарсан “Боловсролын тухай багц хуульд” материаллаг нөхцөл бол сургалтын орчныг бүрдүүлж буй нэг үндсэн хүчин зүйл хэмээн тусгасан байдаг бөгөөд цааш нь тодотгож, тус хуулийн 42.1-д: “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна” гэжээ.

Мөн Монгол улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний Бага, дунд боловсролын зорилго, стратеги хэмээх хэсгийн 2 дугаар зүйлд “Хичээлийн болон дотуур байрны барилга, тэдгээрийн тавилга хэрэгсэл, сургалтын кабинет, лаборатори, тоног төхөөрөмж, сурах бичиг, бусад хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага, стандартыг шинэчлэн батлуулж, **жендэр, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан тохь тухтай орчинг бүрдүүлэх**” зорилтыг дэвшүүлсэн юм./ Боловсрол үндэсний хөтөлбөр. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого/

Монгол улсын БСШУЯ-наас 2010 оны 10 сарын 25 баталсан Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэмд “Сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсролын үйлчилгээг стандартын шаардлага, эрүүл, аюулгүй байдал хангасан орчин нөхцөлд зохион байгуулах бөгөөд үйл ажиллагаандаа багш, ажилчид, суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад холбогдох дүрэм, журмыг мөрдөнө” гэж заасан байна.

Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламж, барилгын норм ба дүрэм БНБД /66-88 стандартын 3.40-д зааснаар “**Биеийн тамирын задгай талбай нь гүйлтийн тойрог, гимнастикийн дасгал хөдөлгөөн хийхэд зориулагдсан турник, гар бөмбөг, сагсан бөмбөгийн талбайтай**” гэжээ.

Ариун цэврийн тухай хуулийн 9.1 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлагын 2.1.1, 2.1.13, 3.1.1 дах заалтууд /БСШУ- ны

сайд, ЭМС-ын сайд, Сангийн сайдын 2015 оны 06 сарын 29-ны өдрийн А/253, 251,163 дугаар тушаал/-д тусгаснаар “30 эмэгтэй хүүхдийн дунд 1 суултууртай, 40 эрэгтэй хүүхдэд 1 суултуур /1 шээлтүүр/ байхаар тооцож байгуулсан, хүүхдийн өндөрт тохирсон байна. 40 сурагчид 1 гар угаах угаагуур ногддог, хүүхдийн өндөрт тохирсон. Биеийн тамирын танхимын дэргэд хувцас солих болон ариун цэврийн өрөөтэй байна” гэж заажээ.

Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Хүүхэд өсвөр үеийнхний сургалт хүмүүжлийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуйн үлгэрчилсэн дүрмийн 10.9 дэх заалтад “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эмчтэй. Шаардлагатай тоног төхөөрөмж бүхий эмчийн өрөөтэй байна” гэж тусгасан байна.

Дээрх хууль эрхзүйн акт, баримт бичгүүд, стандартуудад сургалтын байгууллагын материаллаг нөхцөл гэдэгт сургуулийн барилга байгууламж, анги танхим, сургалтын тоног төхөөрөмж, сурах бичиг, сурагчдын дотуур байр зэргийг авч үзэхдээ тэдгээрийн эрүүл ахуй, аюулгүй байдал болон тусгай хэрэгцээ бүхий үйлчлүүлэгчдийн (тухайлбал хөгжлийн бэрхшээл бүхий) хэрэгцээ шаардлагад нийцэж, багш сурагчдад ээлтэй орчныг бүрдүүлсэн байхаар зохицуулсан байна<sup>26</sup>. Гэхдээ ЕБС-ийн орчинд эрэгтэй, эмэгтэй багш, сурагчдын онцлог хэрэгцээг харгалзах талаар эрх зүйн баримт бичгүүдэд тусгасан зүйл дутмаг байгааг анхаарах хэрэгтэй байна.

### Сургуулийн орчны жендэрийн шинжилгээ

Судалгаанд хамрагдсан 23 сургуулийн орчны эрүүл мэнд ба физиологийн аюулгүй орчинд хийсэн ажиглалтын үр дүнд тулгуурлан гадаад болон дотоод орчны өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлохыг зорьсон юм.

Сургуулийн гадаад орчны ажиглалтаар спортын талбай, тоглоомын талбай, тэдгээрийн хэрэглэгдэхүүн, сургуулийн бие засах газрын хүртээмж, эмэгтэй, эрэгтэй төрөлжилтийг судаллаа.

Хүснэгт 10 Сургуулийн гадаад орчны ерөнхий мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		Хот	Хөдөө
1	Сургууль спортын талбайтай	Байгаа	100.0	85.7
		Байхгүй		14.3
2	Сургуулийн бие засах газар	Боловсон бие засах газар	100.0	42.9
		Нүхэн бие засах газар		57.1

Судалгаанд хамрагдсан 23 сургуулиас 20 буюу 87.0 хувь нь сурагчдын бие бялдарыг хөгжүүлэхэд зориулсан задгай биеийн тамирын талбайтай, 7 буюу 30.4 хувь нь тоглоомын талбайтай байв. Сургуулийн задгай биеийн тамирын талбай дахь хэрэглэгдэхүүнийг хүйсээр шинжлэхэд хөвгүүдэд зориулсан дасгал хөдөлгөөний хэрэглэгдэхүүний тоо дунджаар 4-5, харин охидууд зориулагдсан 1-2 хэрэглэгдэхүүн байна. Ихэнх ЕБС-д охид хөвгүүдэд тохиромжтой хэрэглэгдэхүүн нь цементэн болон шороон гүйлтийн зам, сагсны талбай байх бөгөөд сурагчдыг осол гэмтэлд учруулах, аюулгүй байдлыг хангаж чадахгүй нөхцөл байдал харагдав.

Сургуулиудын тоглоомын талбай нь 14-өөс доош насны эрэгтэй, эмэгтэй хүүхэд тоглох зориулалт бүхий гулсуур, дүүжин даажин, эргэдэг, авирдаг уул зэрэг хөдөлгөөнт хэрэглэгдэхүүнтэй байгааг MNS 8124-4-2011<sup>27</sup> стандарттай харьцуулахад тоглоом цөөн, социалист нийгмийн үед барьж байгуулсан төмөр ган хийцийн хурц ирмэгтэй, хуучран эвдэрч гэмтсэн хэрэглэгдэхүүнтэй, шороон эсвэл цементэн талбайтай ба энэ нь эрүүл ахуй, чанарын шаардлага хангахгүй байна. Үүнээс

<sup>26</sup>НҮБХХ, БСШУЯ (2011) Сургуулийн орчны судалгаа. УБ.,

<sup>27</sup> Тоглоомын аюулгүй байдал, MNS ISO 8124, 2011.



дүгнэхэд эрэгтэй, эмэгтэй сурагчдын онцлог хэрэгцээг хангасан жендэрийн нийцтэй, ээлтэй гадаад орчинг бүрдүүлэх нь сургуулиудын анхаарах асуудал мөн.

Судлагдсан сургуулиудын 15 буюу 65.2 хувь нь боловсон бие засах өрөөтэй байхад 8 буюу 34.8 хувь нь сургуулийн гадна талд нүхэн бие засах байрыг барьж ашигладаг байна. Улаанбаатар хотын сургуулиудын хувьд боловсон бие засах өрөөг эмэгтэй, эрэгтэй хүйсээр нь тусгаарласан, аймгийн төвийн зарим сургуульд хүйсээр нь тусгаарласан ч засвартай шалтгаанаар ажиллахгүй тохиолдол мэдээлэл цуглуулах үеэр ажиглагдсан юм. Сумдын сургуулиуд нь нүхэн бие засах байрыг нэг стандартаар бус, янз бүрээр барьсан нь сургуулийн гадаад орчинд тавигдах стандартын шаардлага хэрэгжихгүй, эрэгтэй эмэгтэй сурагчдын ялгаатай хэрэгцээг харгалзах тухай заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал,

- эрэгтэй, эмэгтэй тусдаа;
- эрэгтэй, эмэгтэй цуг, таславчтай үргэлжилсэн, хаалгагүй;
- эрэгтэй, эмэгтэй цуг, таславчтай үргэлжилсэн, тусдаа хаалгатайгаар барьсан байна.

Сургуулийн захирал, нийгмийн ажилтны өгсөн мэдээллээр өвлийн улиралд нүхэн бие засах байрны гишгүүр хөлдөх, бага ангийн сурагчид хальтарч болзошгүй эрсдэл гардаг аж.

**Зураг 4 Хөдөө сумын сургуулийн нүхэн бие засах ариун цэврийн байр**



**Зураг 5 Хотын сургуулийн боловсон ариун цэврийн өрөө**



Судалгаанд хамрагдсан сургуулиудын нүхэн бие засах ариун цэврийн болон боловсон ариун цэврийн өрөө бүрт хог хаягдлын савыг байршуулсан байсан нь сайшаалтай юм.

Сургуулиудын эрэгтэй эмэгтэй бие засах суултуурын тоо стандарт шаардлагад хэр нийцэж байгааг судлахад дараах үр дүн гарч байна. Хөдөө орон нутаг болон Улаанбаатар хотын зарим сургуулийн жишээн дээр дүн шинжилгээ хийснийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 11 ЕБС-иудын эрэгтэй эмэгтэй сурагчдыг бие засах байраар хангасан байдал

<b>Хөдөө орон нутагт</b>						
Сургуулийн нэр	Эрэгтэй сурагчдын нийт тоо	Эрэгтэй суултуурын тоо	Нэг суултуурт оногдох эрэгтэй сурагчдын тоо	Эмэгтэй сурагчдын нийт тоо	Эмэгтэй суултуурын тоо	Нэг суултуурт оногдох эмэгтэй сурагчдын тоо
Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сумын ЕБ-ын 1-р сургууль	624	12	52	696	12	58
Дундговь аймаг, Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургууль	498	17	29	551	19	29
Орхон аймаг, Жаргалант сумын ЕБС	258	8	32	220	7	31
Завхан аймаг, Ургамал сумын ЕБС	104	3	34	92	3	30
<b>Улаанбаатар хотод</b>						
Хан-Уул дүүрэг, 75-р сургууль	645	6	107	561	3	187
Баянгол дүүрэг, Монгени цогцолбор сургууль	759	12	63	800	16	50
Багануур дүүрэг, Гүн-галуутай ЕБС	995	8	124	988	14	70

Судалгааны мэдээллээр “30 эмэгтэй хүүхдийн дунд 1 суултууртай, 40 эрэгтэй хүүхдэд 1 суултуур /1 шээлтүүр/ байхаар тооцож барьсан хүүхдийн өндөрт тохирсон байна” заалтыг ихэнх

сургуулиуд мөрдөхгүй байгааг анхааралдаа аван, эрэгтэй эмэгтэй сурагчдын суралцах таатай орчинг бүрдүүлэхэд анхаарах нь зүйтэй.

Сурагчдад жендэрийн дүр үүрэг, хэвшмэл ойлголтыг бий болгоод сургуулийн ханын мэдээллийн самбар, өлгөсөн хөрөг зураг, зурагт хуудас нөлөөтэй байж болзошгүй юм. Судалгаанд хамрагдсан сургуулиудын нийтийн талбайд харуулсан үзүүлэн, хүндэт самбар, ишлэл хэлц үг зэрэгт охид эмэгтэйчүүд, хөвгүүд эрэгтэйчүүдийн хэнийг онцлон дүрсэлсэн байгааг дүгнэн харахад эмэгтэй хүний дүрслэл дунджаар 35, эрэгтэй хүний дүрслэл 17, аль аль нь дүрслэгдсэн дунджаар 21 байв. Эмэгтэй хүний дүрслэл их байгаа нь хүндэт самбар дахь зургууд тоологдож байгаатай холбоотой.

Судалгаанд хамрагдсан сургуулиудын лаборатори, кабинетийн тоо дунджаар 5 байна. Тухайлбал, сургуульд байгалийн ухаанаас хими, физик, мэдээлэл зүй, харин нийгэм-хүмүүнлэгийн ухаанаас түүх, монгол хэл, нийгмийн ухаан, урлагаас хөгжим зэрэг анги танхимийг тохижуулан нэрлэсэн нийтлэг тал ажиглагдлаа. Лаборатори, кабинетын орчныг бүрдүүлэхдээ жендэрийн мэдрэмжтэй болгоход багш, удирдах ажилтнууд анхаарах хэрэгтэй. Тухайлбал, анги танхимуудад эрэгтэй эрдэмтэд, зохиолчид, яруу найрагчид, хаад, баатрууд, хөгжмийн зохиолчийн зургууд өлгөх нь нийтлэг ажиглагдаж байв.

Хүснэгт 12 Сургуулийн дотоод орчинтой холбоотой ерөнхий мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		Хот	Хөдөө
1	Биеийн тамирын заал	Байна	100.0	85.8
		Байхгүй		14.2
2	Сургуулийн эмчийн өрөө	Байна	100.0	71.4
		Байхгүй		28.6
3	Номын сан	Байна	100.0	92.9
		Байхгүй		7.1
4	Урлагийн заал	Байна	100.0	85.7
		Байхгүй		14.3

Судалгааны үр дүнгээс харахад 17 сургууль нь биеийн тамирын заал, эмчийн өрөө, номын сан, урлагийн заал бүгд байна. Харин хөдөө орон нутгийн сургуулиуд материаллаг орчны хувьд учир дутагдалтай ажээ. Биеийн тамир, номын сан болон урлагийн зааланд ашиглагддаг хэрэглэгдэхүүнүүд нь аль нэг хүйсэд онцгойлон зориулсан, гэхээсээ илүүтэйгээр нийт сурагчдад зориулагдсан байв. Сургуулийн эмчийн үзлэгийн өрөөнд хөвгүүдэд зориулсан эрүүл мэндийн мэдээлэл дунджаар 2, охидууд зориулсан мэдээлэл дунджаар 6, охид хөвгүүдийн аль алинд нь зориулсан мэдээлэл дунджаар 5 байгаа нь охидын эрүүл мэндэд илүү анхаардаг хандлага ажиглагдав. Сургуулиудын эмчийн үзлэгийн өрөө охид, хөвгүүдэд тусгайлан зориулж тохижуулагүй, үзлэгийн нэг өрөөтэй байна.

## 1.2 Хичээлээс гадуурх сургалт, хүмүүжлийн ажил

Бага, дунд боловсролын цөм хөтөлбөрийн сургалтыг дэмжих үйл ажиллагаанд байгаль, нийгэм, соёлын орчинд хэрэгжих иргэний боловсрол, амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, хичээлээс гадуурх үйл ажиллагаа гэсэн агуулгатай байна. Судалгаагаар сургалтыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй хичээлээс гадуурх үйл ажиллагааны хүрээнд хүмүүжлийн ажлын төлөвлөлт, хэрэгжилтэд охид хөвгүүдийн оролцоо, жендэрт хамаарах агуулгыг шинжилсэн юм. Судалгаанд хамрагдсан 23 сургуулийн удирдлагын өгсөн мэдээллээр, хүмүүжлийн ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа охид хөвгүүдийн оролцоог анги удирдсан багш, сурагчдын өөрөө удирдах байгууллага, ангийн дарга нараар дамжуулан санал авах замаар хангадаг гэж 65.2 хувь нь хариулсан. Харин охид, хөвгүүдийн ялгаатай хэрэгцээг харгалзсан үйл ажиллагааг төлөвлөдөггүй гэдгээ 73.9 хувь нь хүлээн зөвшөөрчээ. Хэдийгээр төлөвлөгөө боловсруулахад бүх сурагчийн саналыг дам байдлаар авч байгаа ч, сургуульд тогтсон уламжлал, нийгмийн ажилтан, багш нарын

санаанд дулдуйдсан менежмент хэвээр байна.

...“Хүмүүжлийн ажлын төлөвлөгөө боловсруулахдаа багш, ангийн дарга, сурагчдын оролцооны байгууллагаар уламжлуулж сурагчдын саналыг авдаг.”

(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)


Хүснэгт 13 Хүмүүжлийн ажлын төлөвлөгөө боловсруулахад охид, хөвгүүдийн оролцоог хангаж буй байдал

Сонгосон үзүүлэлтээр	Тийм	Үгүй	Нийт
Хүмүүжлийн ажлын төлөвлөгөө боловсруулахад охид хөвгүүдийн сонирхол хэрэгцээг харгалздаг эсэх	26.1	73.9	100.0
Хүмүүжлийн ажлын төлөвлөгөө боловсруулахад охид хөвгүүдийн оролцоог хангадаг эсэх	65.2	34.8	100.0

Зарим нэг судалгаанд хамрагдсан сургуулийн жишээгээр хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагаар жендэрийн уламжлалт дүр үүргийг бэхжүүлсэн Үнсгэлжин-Загварын тэмцээн зохион байгуулсан байхад, охидын эрхийг хамгаалах сургалт, эрүүл мэнд, биеэ авч явахад зориулсан зөвлөмж, охидын шивнээ гэх мэт үйл ажиллагаанууд төлөвлөгдөн хэрэгжиж байна. Түүнчлэн хөвгүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааг явуулахад анхаарчээ. Энэ нь тодорхой хэмжээгээр хүйсийн ялгаатай хэрэгцээг харгалзсан болохыг харуулж байна.

Хүүхдийн сургалтын үйл ажиллагааг дэмжсэн хүмүүжлийн үйл ажиллагааны төлөвлөлт, үйл ажиллагаанд хүүхэд нэг бүрийг оролцуулах, хөгжүүлэх санаачлага гарган ажиллаж байгаа нь жендэрийн эерэг хандлага, харин ЕБС-ийн удирдлага, багш, нийгмийн ажилтнуудын жендэрийн боловсролоос шалтгаалж хүмүүжлийн ажлын агуулгад жендэрийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлэхүйц үйл ажиллагаа цөөн тохиолдолд байгааг тэмдэглэж байна.

Зураг 6 Хүмүүжлийн ажлын төлөвлөгөөнд жендэрийн тэгш байдлыг тогтооход чиглэсэн үйл ажиллагааг анхаардаг байдал (n=23)



ЕБС-ийн нийгмийн ажилтнуудын өгсөн мэдээллээр Sa Sa сургалт буюу жендэрт суурилсан хүчирхийллийн сургалт, хүүхдийн эрх, үүрэг, гэр бүлийн үнэ цэнэ, эрсдлээс сэргийлэх сургалт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үе тэнгийнхний багш хөтөлбөр ТББ, хүүхдийн байгууллагатай хамтран зохион байгуулж, охид хөвгүүдийг оролцуулах, оролцох боломжийг анхаарч байгаа ажээ.

#### 1.4 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, мэргэжил сонголт

Хувь хүн мэргэжлээ зөв сонгосноос хувь хүний амжилт, амьжиргаа, айл гэрийн сайн сайхан байдал, улс орны хөгжил дэвшил шалтгаалж байдаг. БСШУЯ болон Хөдөлмөрийн яамнаас “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих” төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү төсөл хэрэгжсэнээр ЕБС-ийн сурагчдад сонирхол, авьяас чадвартаа тохируулан, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжлийг сонгоход нь дэмжлэг үзүүлж байгаагаараа ач холбогдолтой юм.

Судалгаанд хамрагдсан сурагчдаас мэргэжлээ хэрхэн сонгож байгаа талаар асууж тодрууллаа.

Хүснэгт 14 Сурагчдын мэргэжил сонголтод сургуулийн удирдах ажилтан, багш нар, эцэг эхийн оролцоо

Оролцогчид	Асуулт	Хариулт	Эрэгтэй		Эмэгтэй	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
Удирдах ажилтан (n=68)	Сургуулийн удирдах ажилтнууд сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох талаар ажил зохион байгуулдаг уу?	Тийм	15	83.3	48	96.0
		Үгүй	3	16.7	2	4.0
Багш нар (n=492)	Багш нар сурагчдад мэргэжил сонголтын талаар ярилцаж зөвлөгөө өгдөг үү?	Тийм	119	84.4	291	82.9
		Үгүй	22	15.6	60	17.1
Эцэг эх(n=290)	Эцэг эхчүүдийн бодлоор хэн охид хөвгүүдийн мэргэжил сонголтод нөлөөлдөг вэ?	Аав	2	1.7	8	4.7
		Ээж	1	0.8	7	4.1
		Аав ээж хоёулаа	40	33.1	42	24.9
		Хүүхэд	72	59.5	99	58.6
		Аав, ээж, хүүхэд хамтдаа	6	5.0	13	7.7
6-12 ангийн сурагчид (n=492)	Сургуулийн зүгээс сурагчдад мэргэжил сонголтын талаар ямар нэгэн зөвлөгөө, сургалт явуулдаг уу?	Тийм	127	55.2	146	55.9
		Үгүй	103	44.8	115	44.1
	<b>Нийт</b>			<b>100.0</b>		<b>100.0</b>

Судалгаанд хамрагдсан 5 удирдах ажилтан нь өөрийн сургууль дээр зохион байгуулагддаг мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөөгүй бөгөөд харин 65 удирдах ажилтан нь сурагчдад дараах үндсэн ажлуудыг зохион байгуулжээ. Үүнд:

- Мэргэжил сонголтын талаар сургалт, уулзалт хэлэлцүүлэг (8 эрэгтэй ба 36 эмэгтэй)
- Мэргэжил сурталчлах аян (6 эмэгтэй ба 10 эрэгтэй)
- Сурталчилгааны самбар гаргах (1 эрэгтэй)
- Зөвлөгөө өгөх (2 эмэгтэй) зэрэг ажлыг хийсэн байна.

#### Хөдөө орон нутагт

...”ЕБС-иуд өөр өөрийнхөө чиглэлээр харьцангуй их л сурталчилгаа хийдэг. Улс орны хэмжээнд инженерийн мэргэжил илүү хэрэгтэй байна гээд л сургалт сурталчилгаа, хүмүүст лекц унших, мэргэжил сонгох зөвлөгөөнүүд хийж байна.”

*(Ганцаарчилсан ярилцлага, Аймаг, дүүргийн боловсролын газрын төлөөлөл)*

...”Тогтмол гэж хэлж болно. Намар 9 сард эцэг эхчүүдэд нэгдсэн сургалт зохион байгуулдаг.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...”Сүүлийн үед энэ хувийн их дээд сургуулиуд өөрсдийн сургуулиа сурталчилахын хамт, мэргэжил сурталчлах ажлыг хамтад нь хийж байгаа нь хүүхдүүдэд хэрэгтэй байгаа нь харагддаг. Тэгэхгүй бол бид нар чинь энэ их ажлын хажуугаар ийм зүйл хийж барахгүй шүү дээ.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...”Хөдөө орон нутагт охид эмч, багш мэргэжлийг, харин хөвгүүд инженер, эдийн засаг, эрх зүйч

мэргэжлээр явдал их байна. Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүйсээс хамааран сонголт хийдэг хандлага өөрчлөгдөөгүйтэй холбоотой.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...”Мэргэжил сонголтын хувьд эцэг эхчүүд эрэгтэй хүүхдээ ихэвчлэн хуульч, инженер болгох сонирхолтой байдаг. Охид эцэг эхийнхээ үгнээс гардаггүй болохоор харилцан ярилцаж тохироод хичээл сонголтоо хийдэг. Сургуулийн зүгээс мэргэжил сонголтонд зөвлөгөө өгөх үйл ажиллагаа зохион байгуулдаг.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

### **Хотын сургуулиуд**

...”Сурагчдад хүсэл сонирхлын үүднээс мэргэжлээ сонгоорой гэж зөвлөдөг. Төгсөх ангийн багш нар сурагчдын мэргэжил сонголтыг чиглүүлж явдаг.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...”Техник технологийн их сургуулийн захирлыг урьж хүүхдүүдэд мэргэжлийн талаар яриа хийсэн, хүүхдүүд их сонирхсон. Сургууль, нийгмийн ажилтан, АУБ, мэргэжлийн багш нар зөвлөн туслах үйл ажиллагааг хүүхдүүдэд үзүүлдэг.

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...”Манай сургууль хүүхдийг 1 ангиас нь байгалиас заяасан өгөгдөл, авьяас, хүсэл сонирхлын харгалзан хөгжүүлэхийг хичээдэг. Сурагчдад зориулсан мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг нийгмийн ухааны тэнхимийн багш нар сургууль дээр тогтмол зохион байгуулдаг.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...”Ахлах ангийн хүүхдүүдийг эцэг эх болон хүүхдийн сонирхолд тулгуурлан, ирээдүйдээ ямар мэргэжлийг сонирхож байгаагаас хамааран 4 хуваасан. Мэргэжлийн сэтгэл судлаачийг авчран, зөвлөгөө өгсөн. Боловсролын Үнэлгээний төвөөс мэргэжилтэн урьж сурагчдыг эцэг эхтэй нь хамт зохион байгуулсан.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

Судалгааны чанарын мэдээллээр мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголтод сургуулийн удирдах ажилтнууд, мэргэжлийн багш нар, заах аргын нэгдэл болон нийгмийн ажилтны үүрэг чухал байр суурьтай байна. Сургуулийн нийгмийн ажилтан, удирдлага, анги удирдсан багш, мэргэжлийн багш нар жил бүр төгсөх ангийн суралцагчдад зориулсан ажлуудыг зохион байгуулдаг аж. Тухайлбал,

- Мэргэжлээ сонгох, сонирхсон мэргэжилтэй холбоотой яриа танилцуулга хийх;
- Эцэг эх, сурагчдыг оролцуулсан уулзалтыг зохион байгуулах;
- Их дээд сургуулиас мэргэжлийн багш нарыг урин, лекц зохион байгуулах;
- Их дээд сургуулиудад бэлтгэдэг мэргэжлийн чиглэлүүдийг сурталчилан танилцуулах;
- Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй байгаа мэргэжлүүдийг танилцуулах зэрэг болно.

Харин дунд, ахлах ангийн (6-12 анги) багш нарын эрэгтэй 45.5 хувь, эмэгтэй 57.7 хувь нь охид хөвгүүдэд зөвлөгөө өгөхдөө нийгмийн эрэлт хэрэгцээг харгалзан мэргэжлийн зөвлөгөө өгдөг гэж хариулсан байна. Харин эрэгтэй эмэгтэй багш нарын аль аль нь сурагчдад авьяас сонирхолд нь тохируулж зөвлөгөө өгөхийг эрмэлздэг байна. Судалгааны үр дүнгээс харахад эрэгтэй эмэгтэй багшийн 90 гаруй хувь нь сурагчдад зөвлөхдөө эмэгтэй хүнд багшийн ажил тохиромжтой, эрэгтэй хүнд барилгын ажил тохиромжтой гэх зэргээр жендэрийн өрөөсгөл үзэл, хандлага гаргадаггүй байгаагаас үзэхэд мэргэжлийн чиг баримжаа олгох тал дээр багш нарт жендэрийн үзэл санаа төлөвшиж байгааг харууллаа.

Судалгаанд хамрагдсан нийт 290 эцэг эхчүүдийн хувьд аав ээж хоёулаа хүүхдийнхээ мэргэжил сонголтод нөлөөлөх ёстой гэж үзсэн хариултыг хүйсээр шинжлэн үзэхэд эрэгтэй 33.1 хувь, эмэгтэй 24.9 хувь эзэлж байна. Үүнээс харахад зарим эцэг эхчүүд хүүхдийнхээ мэргэжил сонголтод нөлөөлдөг байдал оршсоор байгаа ч хүүхэд өөрөө мэргэжлээ сонгох нь чухал гэх хандлага эцэг эхчүүдийн 1/2 байгаа нь энэ талын ойлголт мэдлэг байна гэж үзэв.

### **Эцэг эхийн хүүхдийнхээ мэргэжил сонголтод хандах байдал**

...”Охиноо эмч, харин хүүгээ юунд авъяастай, хүсэл сонирхлын харгалзан сонголт хийлгүүлнэ.”

*Ховд аймаг, эцэг эхийн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

...”Охиноо эмч, багш, эдийн засагч мэргэжлийн аль нэгийг, харин хүүгээ цэргийн хүн болгоно. Охид, хөвгүүдийн мэргэжил сонголтонд аав ээж ч оролцдог, хүүхэд өөрөө ч сонирхлоор сонгодог.”

*Сэлэнгэ аймаг, эцэг эхийн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

...”Охин хүүгийн аль алиныхан сонирхлыг дэмжих хэрэгтэй. Сонирхолгүй мэргэжлээр суралцсанаас үүдэн сургуулиа орхих, төгссөн ч мэргэжлийн ажлаа хийхгүй асуудал үүснэ.”

*Дундговь аймаг, эцэг эхтэй хийсэн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

...”Хүүхдүүд өөрсдөө мэргэжлээ сонгох ёстой, харин эцэг эх чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Сургууль дээр мэргэжил сонголтын талаар сургалт, лекц боллоо гэсэн мэдээллийг хүүхдүүд аав ээждээ өгдөг.”

*БЗД-ийн эцэг эхтэй хийсэн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

...”Мэргэжил сонголтын хувьд хүүхэд өөрөө хүссэн, сонирхсон чиглэлээр суралцах нь зөв гэж боддог.”

*Баганхангай дүүрэг, эцэг эхтэй хийсэн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

...”Хүүхэдтэйгээ сайн ярилцан, ямар хичээлд илүү дуртай сонирхолтой, ямар чадвар авъяас байгаагаас хамааран мэргэжил сонголт хийнэ гэж боддог. Гэхдээ эцэг эхийн зүгээс хүүхдийг чи өөрөө мэд гээд орхих бус зөвлөх чиглүүлэх үүрэг байх ёстой.”

*СХД-ийн эцэг эхтэй хийсэн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

Улаанбаатар хотод ажиллаж амьдардаг эцэг эхчүүд нь охид хөвгүүд өөрийн хүсэл сонирхол, авъяас чадварт суурилан мэргэжлээ сонгохыг дэмжиж байсан бол хөдөөд сурагчийн мэргэжил сонголтод эцэг эх оролцох ёстой гэсэн хандлага ажиглагдсан.

Судалгаанд хамрагдсан эрэгтэй эмэгтэй сурагчдын 55.5 хувь нь сургуулийн удирдлага, багш нарын зүгээс мэргэжил сонголтын талаар зөвлөгөө өгдөг, 44.5 хувь нь сургуулийн зүгээс ямар нэгэн мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголтын талаар үйл ажиллагаа явуулдаггүй гэжээ. Сурагчид мэргэжил сонголтод эцэг эх нөлөөлдөг ч, хүүхэд бүр өөрийн хүсэл сонирхолдоо үндэслэн мэргэжлээ сонгох нь чухал гэдэгтэй санал нэгдэж байв.

### **Сурагчдын мэргэжил сонголтод хандах байдал**

...”Сурагчид өөрсдийнхөө сонирхлоор мэргэжил сонгохыг хүсдэг ч эцэг эх, багш нөлөөлдөг. Сургуулийн зүгээс мэргэжил сонголтын талаар лекц зохион байгуулсан.”

*Орхон аймаг, хөвгүүдтэй хийсэн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

...”Охидын мэргэжил сонголтонд ээжүүд их нөлөөлдөг. Сургуулийн зүгээс мэргэжлийн чи баримжааны талаар багш нар зөвлөгөө өгдөг.”

*Завхан аймаг, охидтой хийсэн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

...”Мэргэжлээ сонгохдоо хамаатан садны оюутан ах эгчээс зөвлөгөө авдаг. Сургуулийн нийгмийн ажилтан мэргэжил сонголтын талаарх зөвлөгөөг сурагчдад өгдөг.”

*Өвөрхангай аймаг, хөвгүүдтэй хийсэн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

...”Сургууль дээр гаднаас мэргэжилдээ амжилт гаргасан хүмүүсийг урьж лекц уншуулдаг. Мэргэжил сонгоход аав ээжийн үүргээс илүү өөрийн хүсэл сонирхол чухал гэж үздэг.”

*БЗД-ийн охидтой хийсэн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

...”Хүүхдийн мэргэжил сонголтонд эцэг эх нөлөөлдөг тал ажиглагддаг. Ээж өөрийн мэргэжлээ охиндоо, аав өөрийн мэргэжлээ хүүгээ сонгоосой гэж хүсдэг. Гэхдээ Ихэнх эрэгтэй эмэгтэй хүүхэд хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй мэргэжлийг сонгох болсон.”

*Хан-Уул дүүрэг, охидтой хийсэн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

Мэргэжил сонголтын зөвлөх үйл ажиллагаа нь зөвхөн төгсөх ангийн сурагчдад чиглэж байгааг цаашид анхааран, бага ангиас нь мэргэжлүүдийг таниулах ажлуудыг зохион байгуулах хэрэгцээ байгааг сурагчид илэрхийлсэн юм.


Асуулгын үр дүнгээс харахад сурагчид ерөнхий боловсролын сургуулиа төгсөөд дараах

алхамуудыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:

- ✚ Их дээд сургуульд элсэн суралцана –эрэгтэй, эмэгтэй сурагчдын 64.8 хувь,
- ✚ Гадаадын аль нэг улс орны их дээд сургуульд элсэн суралцана –эрэгтэй, эмэгтэй сурагчдын 22.2 хувь,
- ✚ Монголдоо ажил хийнэ –эрэгтэй сурагчдын 4.5 хувь.

Сурагчдыг хүйсээр нь шинжилж харвал судалгаанд хамрагдсан хөвгүүдийн 62.3 хувь нь, охидын 66.9 хувь нь дотоодын их дээд сургуульд суралцахаар төлөвлөж байна. Судалгаанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй сурагчдын хувьд 1/5 нь сургуулиа төгсөөд гадаадын аль нэг их дээд сургуульд элсэн суралцана гэжээ. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 5 эрэгтэй, 4 эмэгтэй сурагч суралцана гэж байгаагаас үзэхэд сурагчид хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй байгаа нарийн мэргэжлийн ажилчин болохоос илүүтэй их дээд сургуульд сурч, дээд боловсролтой мэргэжилтэн болохыг чухалчлан үзэж байна.

Зураг 7 Дунд, ахлах ангийн сурагчдын мэргэжил сонголтыг хүйсээр харьцуулсан байдал



Судалгаанд хамрагдсан сурагчдын мэргэжил сонголтыг судлахад нийт 21 мэргэжлийн жагсаалт гарсан юм. Эдгээр мэргэжлүүдийг чиглэлээр нь нэгтгэн, хүйсээр харьцуулбал:

Эмэгтэй сурагчдын хувьд:

- ✓ Багш, уран бүтээлч, сэтгэл зүйч, эмч, хуульч, нягтлан бодогч, санхүүч, эдийн засагч, дизайнер, сэтгүүлч гэх мэт.

Эрэгтэй сурагчдын хувьд:

- ✓ Гаалийн байцаагч, тамирчин дасгалжуулагч, цэргийн офицер, нисэгч, цагдаа, хуульч, инженер, компьютерийн программист мэргэжилтэй болохыг хүсдэг байна.

Судалгаанд хамрагдсан эрэгтэй сурагчдын 14.6 хувь, эмэгтэй сурагчдын 13 хувь нь хариулаагүй буюу шийдээгүй гэж хариулсан байна. Сурагчдын хариултаас харахад охид, хөвгүүд мэргэжлээ сонгохдоо илүү уламжлалт байр сууринаас хандаж байна.



### Сурагчдын мэргэжил сонголт

...”Аав нар өөрсдийнхөө хүссэн мэргэжлийг эзэмшүүлэхийг хүсдэг, чи том болоод эмч бол гэдэг. Ээж болохоор миний охин дуртай мэргэжлээ сонгоод яваарай гэж хэлдэг.”

*Улаанбаатар хот, Охидын бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*

...”Ирээдүйд би архитектурч, цахилгааны инженер, уул уурхайн инженер, хөл бөмбөгийн тамирчин болно. Мэргэжил сонголтонд өөрийн хүсэл сонирхол чухал.”

*Улаанбаатар хот, Хөвгүүдийн бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*

Сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан нарын өгсөн мэдээллээс харахад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө нь сургуулиудад харьцангуй тогтмолжсон үйл ажиллагаа болж байгаа тал ажиглагдсан бол сурагчдын зүгээс тэдгээрийн 50 орчим хувь нь энэ төрлийн үйлчилгээ аваагүй гэсэн хариулт өгсөнийг анхааралдаа авах шаардлагатай. Үйлчилгээний хэлбэр, төрөл, хүртээмжийг сайжруулах талаар анхаарахын хамт жендэрийн хувьд баримтлах зарчим, үйл ажиллагааны чиглэлийг тогтоох нь чухал юм.

## БҮЛЭГ 2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ОРЧИН

Энэ бүлэгт судалгаанд хамрагдсан Ерөнхий боловсролын сургуулиудын бодлогын баримт бичигт жендэрийн асуудал туссан байдал, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн (2011) боловсрол, хөдөлмөрийн харилцаатай холбогдох зарим зүйл заалт Ерөнхий боловсролын сургуулийн орчинд хэрхэн хангагдаж буй байдлыг авч үзсэн бөгөөд 23 сургуулийн тодорхой баримт бичгүүдийн мэдээлэл багтсан.

### 2.1 Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь жендэрийн тэгш байдал

Ерөнхий боловсролын сургуулийн багшлах боловсон хүчний хүйсийн харьцаа тэнцвэргүй буюу сүүлийн 10 жилийн дундажаар үндсэн багш нарын 25 орчим хувь нь эрэгтэй багш нар (Хүснэгт 2.1.) байжээ. Энэ нь Ерөнхий боловсролын сургуулийн 4 багш тутмын 1 нь эрэгтэй багш байгааг харуулах бөгөөд бага ангийн багш нарын дунд эрэгтэй багшийн төлөөлөх хувь хэмжээ илүү багасч 30 багш тутмын 1 нь эрэгтэй байна.<sup>28</sup> Энэ тоо нь Ерөнхий боловсролын сургуулийн багшлах боловсон хүчинд эрэгтэйчүүдийн хангалттай хэмжээний төлөөлөл байхгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 15 Үндсэн багш нарын тоо, хүйсээр, 2004-2015 он

Хичээлийн жил	2004-2005	2005-2006	2006-2007	2007-2008	2008-2009	2009-2010	2010-2011	2011-2012	2012-2013	2013-2014	2014-2015	
Үндсэн багш	21,458	22,628	22,891	23,897	25,543	26,070	26,358	26,492	26,863	27,205	27,449	
Хүйсээр	эмэгтэй	17,205	18,337	18,621	19,46	20,75	21,320	21,614	21,717	21,93	22,05	22,285
	эрэгтэй	4,253	4,291	4,270	4,435	4,788	4,750	4,744	4,775	4,927	5,154	5,164

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсэгт зааснаар Жендэрийн ялгаварлан гадуурхалт гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг” ойлгоно гэжээ. Энэ нь ажилд орох, чөлөөлөгдөх, албан тушаал дэвших, цалин хөлс, шагнал урамшуулал авах, тэтгэвэрт гарах, гэр бүлийн үүргээ биелүүлэх зэрэгт аль нэг хүйст давуу байдал олгох, адил тэгш хандахгүй байх, эмэгтэй, эрэгтэй болж төрснөөр нь ялгаварлан гадуурхах, дарамтад оруулах байдлаар илэрдэг байна. Иймд сургуулийн хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах, эмэгтэй, эрэгтэй багшид ажил болон гэр бүлийн үүргээ хослуулах, ижил ажилд адил цалин, нэмэгдэл хөлс тогтоох, ажлын байран дахь бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх нөхцөл байдал хэрхэн хангагдаж буйд анхаарал хандуулсан юм.

*Сургуулийн орчин дахь жендэрийн ялгаварлан гадуурхалтын нөхцөл байдал ба ажил олгогч буюу удирдах ажилтны үүрэг*

Ишлэл\* Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1

“Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах ба Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, хязгаарлалт тогтоох, мөн жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтныг ажлаас халахыг хориглоно”.

<sup>28</sup>БСШУЯ Бага, дунд боловсролын 2014-2015 оны хичээлийн жилийн статистик <http://www.meds.gov.mn/data/1503/BDB14-15.pdf> 2016.06.01

Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт хүнийг ажилд авахдаа эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд түүний хувийн амьдрал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, намын харьяалал, шашин шүтлэг, жирэмсэн эсэх талаар асуулт тавихыг хориглосон байдаг. Судалгаанд хамрагдсан удирдах ажилтнууд багш сонгон шалгаруулах ярилцлагын үеэр гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн байдлын талаарх асуултыг 77.5 хувь нь асуудаг гэсэн хариулт өгчээ. Үлдсэн 22.5 хувь тус асуултуудыг огт асуудаггүй байна. Гэр бүлийн байдлын талаар асуухдаа 47.2 хувиас нь гэр бүлтэй эсэх, 13.5 хувиас нь хүүхэдтэй эсэх, 11.2 хувиас нь бага насны хүүхэдтэй эсэх, 5.6 хувиас нь ойрын хугацаанд хүүхэдтэй болохоор төлөвлөж байгаа эсэхийг асууж байжээ.

Манай сургуулийн хувьд бага насны хүүхэдтэй эсвэл 5, 6 сартай жирэмсэн хүнийг ажилд авдаггүй. Учир нь хүн хүүхдээ эрүүл өсгөх үүрэгтэй. Мөн бид дотоод журмандаа хүүхэд асрах чөлөөгөө авсан бол 1 жил хүртэл нь ажилдаа орох ёсгүй гэдгийг хатуу анхааруулдаг.

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

Манайд хичээлийн үйл ажиллагааны тэнцвэртэй байдлаа бодоод ажилд авахдаа гэр бүлийн байдлыг асуудаг. Сурагчдын сурлагын амжилтад багш солигдох шууд нөлөөтэй байдаг. Энэ утгаар багшийн тогтвортой ажиллах асуудал чухал байдаг.

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

Удирдах ажилтнуудын зүгээс боловсролын байгууллагын хувьд сурагчдад хичээлийн үйл явцыг тасралтгүй хүргэх шаардлагатай холбоотойгоор шинэ ажилтнаас гэр бүл төлөвлөлтийн талаар асуудаг гэжээ. Тэдний зүгээс энэ хариултыг өгөхдөө сургуульд шинээр ихэвчлэн эмэгтэй хүн ажилд ордог буюу сургуулиа төгссөн нөхөн үржихүйн идэвхтэй насны хүмүүс байгаатай холбон тайлбарлаж байв. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтыг судалгаанд хамрагдсан удирдах ажилтнууд сайн мэддэггүй болохыг асуулгын судалгааны үр дүн болон ярилцлагын мэдээлэл харуулж байна.

*Ижил ажилд адил цалин хөлс олгох, шийдвэр гаргах, албан тушаал дэвших байдал*

Боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2, 52 дугаар зүйлийн 52.1, 53 дугаар зүйлийн 53.1-д заасан болон Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан хувь, хэмжээгээр нэмэгдэл хөлс авдаг. Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9-д заасны дагуу нэмэгдэл, нэмэгдэл хөлсний доод хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтоож байгаа бөгөөд боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 219 дүгээр тогтоолыг мөрдөж байна.<sup>29</sup>

Боловсролын салбарт ажиллагсдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээг тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 219 тоот тогтоолоор Ерөнхий боловсролын сургуулийн багшид анги даавал 10%, кабинет, лаборатори хариуцан ажиллавал 5%, ЗАН-ийг удирдсанаар 5% гэх зэргээр үндсэн цалин дээр нийт 20 хүртэл хувийн нэмэгдэл хөлс авах боломжтой. Мөн мэргэжлийн зэргийн нэмэгдэлд заах аргач багш 10%, тэргүүлэх багш 15%, зөвлөх багш 20% нэмэгдэл хөлсийг үндсэн цалингаас тооцуулан авахаар журамд тусгажээ.

Ерөнхий боловсролын сургуулийн багшаар шинээр ажилд орж буй залуу багш ТҮБД 4-1-ээр 539.000 мянган төгрөгийн үндсэн цалинтай байгаа бол олон жил ажилласан ахмад багш ТҮБД 4-5-аар цалинжиж байна. Энэ нь багш нарын цалингийн доод жишиг 539000 төгрөг, цалингийн дээд тал нь холбогдох нэмэлтүүдийг тооцсоноор гарах бөгөөд ажилласан жил, мэргэжлийн зэргээс хамаарч ялгаатай байна. Хөдөлмөрийн судалгааны институтийн Цалин хөлсийн бүтцийн судалгаагаар (2013) Боловсролын салбарын ажилтнуудын дундаж цалинг 627300 төгрөгөөр, улсын дунджаар 642200 төгрөг байгаа бага зэрэг зөрүүтэй үзүүлэлтэр тооцжээ. Сургуулийн багшлах

<sup>29</sup>Төрийн албаны зөвлөл <http://www.csc.gov.mn/faq/40> 2016.06.01

боловсон хүчинд эрэгтэй багш цөөн байгаа шалтгааны нэг нь багшийн цалин хөлс бага байгаа явдал болохыг удирдах ажилтнууд онцолсон.

Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтнууд нь төрийн үйлчилгээний салбарын албан хаагчид бөгөөд “ижил хөдөлмөр эрхэлж, ажил үүрэг гүйцэтгэдэг эсрэг хүйсийн ажилтантай адил хэмжээний цалин хөлс авч байгаа эсэх” нь тодорхой буюу Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн шатлалын дагуу цалин авч, Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээ тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу нэмэгдэл хөлсөө авч байна.

Хөдөө, орон нутагт багшлах боловсон хүчин дутагдалтай байгаатай холбоотойгоор Боловсролын тухай хуулийн 43.1.7-дахь хэсэгт сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, сургууль, цэцэрлэгийн эмч нарт 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгохоор заажээ. Энэ нь алслагдмал сум, багт ажиллаж буй багшлах боловсон хүчнийг дэмжих зорилготой тул ижил ажилд адил цалин хөлс олгох асуудлыг зөрчиж байна гэж үзэх боломжгүй бөгөөд хүйсийн хувьд аль нэг хүйсийг онцолж ялгаагүй, тэгш боломжийг өгсөн байна.

*Албан тушаал ахих боломж*

Албан тушаал ахих боломж эрэгтэй, эмэгтэй хүмүүст адил тэгш боломжоор хангагдсан байх нь жендэрийн мэдрэмжтэй сургуулийн орчин бүрдэхэд чухал нөлөөтэй. Судалгаанд оролцсон удирдах ажилтнуудын зүгээс эрэгтэй болон эмэгтэй удирдах ажилтнуудын асуудлыг харах өнцөг, анхаарал хандуулдаг асуудал зэргээр хоорондоо ялгаатай байдаг талаар өөрсдийн туршлагад үндэслэн авч үзэж байна.


Хүснэгт 16 Сургуулийн удирдах ажилтнуудын тоо, хүйсээр, хувиар 2014-2015 оны хичээлийн жил, тоогоор, хувиар

№	Удирдах албан тушаалтан	Эрэгтэй		Эмэгтэй		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Захирал, дэд захирал	349	44.1	443	55.9	792	100
2	Сургалтын менежер	304	22.2	1069	77.8	1373	100
3	Нийгмийн ажилтан	189	26.8	516	73.2	705	100

Сургуулиудын багшлах боловсон хүчинд эрэгтэй багш 25 орчим хувийг эзэлж буйтай холбоотойгоор удирдах түвшинд мөн үзүүлэлт (хүснэгт 2.2.) хадгалагдах төлөвтэй байна. Тухайлбал сургалтын менежерүүдийн 22.2 хувь нь эрэгтэйчүүдийн төлөөлөл байгаа бол нийгмийн ажилтнуудын 26.8 хувь нь эрэгтэй ажилтнууд байгаа юм. Харин сургуулийн бүх шатны захирлын албан тушаалд эрэгтэйчүүдийн хувь илүү өндөр буюу нийт захирлуудын 44.1 хувь байна. Энэ нь сургуулийн захирлын албан тушаалд хүйсийн төлөөллийн тэнцвэр илүү хадгалагдаж буйг харуулж байна.

Сургуулийн удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулахад Төрийн албаны зөвлөл, аймаг, дүүргийн Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс болон Боловсрол, соёлын газар, Аймаг, дүүргийн засаг дарга нар оролцож байна.

Зураг 8 Удирдах ажилтныг сонгон шалгаруулах үе шат



Сургуулийн захирал, сургалтын менежерүүд нь аймаг, дүүргийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ хийн ажилладаг тул аймаг, дүүргийн Засаг дарга, сургуулийн захирал, эрхлэгч нарыг томилох эрх бүхий субъект юм. Удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг Боловсролын тухай хуулийн 281.1.7, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу явуулж байна. Сонгон шалгаруулалтад орох иргэд нь Төрийн албаны тухай хуулийн 10.1-д заасан ерөнхий шаардлага болон томилох эрх бүхий этгээдийн баталсан тухайн албан тушаал /Ажлын байрны тодорхойлолтод заасан/-д тавигдах шаардлагыг хангасан<sup>30</sup> байх шаардлагыг тавьж байна.

Нийслэлийн боловсролын газрын даргын 2016.04.15-ны өдрийн А/32 тоот тушаалаар баталсан “Нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах заавар”-т Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй иргэдэд дараах шаардлагыг тавина гэжээ. Үүнд:

- 3.1.1 Сургуулийн захирал боловсролын салбарт 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай,
- 3.1.2 Заах арга зүй сайтай байх;
- 3.1.3 Санхүүгийн болон хууль, эрх зүйн тодорхой мэдлэгтэй байх;
- 3.1.4 Сургуулийн захирлын ажлын байрны сонгон шалгаруулалтанд орох иргэн ерөнхий боловсролын багшийн мэргэжилтэй байх;
- 3.1.5 Дипломын дээд болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
- 3.1.6 Удирдан зохион байгуулах, хамт олныг манлайлах чадвартай байх зэрэг ерөнхий шаардлагыг тавьж байна.

Дээрхээс үзвэл удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулахад хүйсийн хувьд ялгасан шаардлага тусаагүй бөгөөд тэгш байдлаар сонгон шалгаруулалтад оролцох боломжтой харагдаж байна. Мөн удирдах албан тушаалтныг томилох эрх бүхий этгээдийн баталсан тухайн албан тушаал /Ажлын байрны тодорхойлолтод заасан/-д тавигдах шаардлагыг хангасан байх шаардлагыг тавьж байгаа нь сургуулийн захирлын албан тушаалд нэгдсэн нэг шаардлага тавигдахгүй байгааг харуулж байна. Энэ нь зарим тохиолдолд тодорхой хүнд чиглэсэн, шаардлагуудыг оруулах боломжийг бий болгох бөгөөд улсын хэмжээнд сургуулийн удирдах ажилтныг сонгон шалгаруулахдаа нэгдсэн шаардлагыг тавих нь зүйтэй юм. Тухайлбал удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа туршлага болон боловсролын түвшний хувьд нэгдсэн

<sup>30</sup>Төрийн албаны зөвлөл <http://www.csc.gov.mn/faq/40> 2016.06.01

шалгуур тавигдахгүй байна.

2016 онд зарлагдсан сонгон шалгаруулалтад туршлагын хувьд дараах байдлаар ялгаатай шаардлага тавигдсан байна.

1. Боловсролын салбарт 15-аас доошгүй жил ажилласан, удирдах албан тушаалд 8-аас дээш жил ажилласан байх<sup>31</sup>
2. Боловсролын салбарт 8-аас доошгүй жил ажилласан, удирдах албан тушаалд 1-ээс дээш жил ажилласан байх<sup>32</sup>
3. Боловсролын салбарт 7-оос дээш жил ажилласан, удирдах албан тушаалд 1-ээс дээш жил ажилласан байх<sup>33</sup>

Мөн сонгон шалгаруулалтад боловсролын хувьд дараах байдлаар ялгаатай шаардлага тавигдсан байна.

1. Дээд, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй байх<sup>34</sup>
2. Бакалавраас доошгүй боловсролын зэрэгтэй байх<sup>35</sup>

Удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулахад тавигдах шаардлага зарим тохиолдолд ялгаатай байгаа нь албан тушаал ахих боломж эрэгтэй, эмэгтэй хүмүүст адил тэгш байдлаар хангагдсан ч зарим тохиолдолд тодорхой нэг хүнд тусгайлан зориулсан шинжтэй шаардлагууд ажиглагдаж байна. Мөн сонгон шалгаруулалтын тусгай шаардлагад сургуулийн хэв шинж, онцлогийн талаар зохих мэдлэг, дадлага, туршлагатай байх гэж оруулж өгчээ. Энэ нь тухайн сургуульдаа ажилласан туршлагатай, багш, сургалтын менежер, нийгмийн ажилтнаар ажиллаж байгаад сул орон тоон дээр өрсөлдөх боломжийг хангасан байна.

Сургуулийн удирдах албан тушаалд эрэгтэй хүнийг тохиромжтой, байгалиасаа удирдах авьяастай зэргээр жендэрийн хэвшмэл үзэл бүхий хариултаудыг оролцогчид өгч байсан юм. Эрэгтэй, эмэгтэй удирдах ажилтнуудад хүйсээс хамаарсан давуу болон сул тал (хүснэгт 2.2.4) байгааг судалгаанд оролцогчид тэмдэглэсэн. Эрэгтэй удирдах ажилтан эмэгтэй багшийн асуудлыг ойлгохгүй байх явдал гардаг бөгөөд эмэгтэй хүн ажлаасаа гадна гэр бүлдээ үүрэг хүлээсэн эх хүн байдаг атал хүүхэд өвдөхөд чөлөө өгөхгүй байх зэрэг асуудал тулгардаг гэж байлаа.

...“Сургуулиудын хувьд эрэгтэй эмэгтэй захирлуудын тоо нь харьцангуй тэнцүү болж байгаа. Боловсролын таатай орчинг бүрдүүлэх тал дээр эмэгтэй нь сайн, менежмент тал дээрээ эрэгтэйчүүд илүү байдаг.”

*(Ганцаарчилсан ярилцлага, Аймаг, дүүргийн боловсролын газрын төлөөлөл)*

...“Эрэгтэй удирдагч илүү буурьтай. Үүрэг даалгавар өгсөн бол хүндээ итгэж даатгадаг онцлогтой. Хүмүүсийн ярианаас үзэхэд эмэгтэй хүн хов жив хөөх гээд байдаг талтай.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...“Эрэгтэй хүнд илүү тохиромжтой. Эрэгтэй хүн нь хөөцөлдлөгөө илүү. Эрэгтэй түлхүү байвал зүгээр. Эрэгтэй захирал байхын давуу тал нь асуудалд буурь суурьтай ханддаг. Юм болгон руу үсчээд байхгүй, хэрэгтэй зүйлээ л барьж авдаг. Эрэгтэй хүмүүс ноён нуруутай байдаг.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

Ярилцлагын мэдээллээс үзвэл эрэгтэй болон эмэгтэй удирдах ажилтнуудад өөр өөр онцлог, ялгаа болон давуу, сул талууд байгааг онцолсон байна. Ярилцлагад оролцогчдын зүгээс эрэгтэй захирлууд нарийн ширийн зүйлийг орхигдуулах, ажлын хяналт сулрах сөрөг талтай гэж үзсэн бол эмэгтэй захирлууд жижиг асуудлаар хөөцөлдөх, сургуульд талцал үүсгэх, хов жив хөөцөлдөх зэрэг

<sup>31</sup> <http://www.csc.gov.mn/uploads/SHalgaltZar/2016/0512/4.htm> 2016.06.01

<sup>32</sup> <http://www.csc.gov.mn/uploads/SHalgaltZar/2016/0512/6.htm> 2016.06.01

<sup>33</sup> <http://www.csc.gov.mn/uploads/SHalgaltZar/2016/0512/1.htm> 2016.06.01

<sup>34</sup> <http://www.csc.gov.mn/uploads/SHalgaltZar/2016/0512/4.htm> 2016.06.01

<sup>35</sup> <http://www.csc.gov.mn/uploads/SHalgaltZar/2016/0512/6.htm> 2016.06.01

сөрөг тал ажиглагддаг гэж байлаа.

Мөн сургалтын менежер, нийгмийн ажилтнуудын зүгээс “эрэгтэй удирдлагатай байхдаа дуртай, эрэгтэй хүн төрөлхөөсөө удирдах чадвар сайн” гэжээ. Энэ нь удирдах албан тушаалд хүйс харгалзан үзэх жендэрийн хэвшмэл үзэл, жендэрийн өрөөсгөл хандлага хадгалагдаж буйг илтгэж байна.

Чанарын судалгаагаар ЕБС-ийн шийдвэр гаргах түвшин дэх хүйсийн тэгш байдлыг тогтоох асуудлаар эрэгтэй, эмэгтэй багш, захирал, сургалтын менежерүүдэд ялгаатай үзэл баримтлал бүхий хандлага илэрч байгаа. Эрэгтэй удирдах ажилтнуудад нийгмийн бүтэц дэх патриарх соёлын нөлөө илэрч байгаа нь анзаарагдсан бол эмэгтэй удирдах ажилтнуудын хувьд эл хандлагыг сөргөсөн, удирдах албыг заавал эрэгтэй линзээр харах бус, адил тэгш боломжоор хангагдахыг чухалчилсан санааг дэвшүүлсэн. Харин бага боловсролын шатанд багшлах үйл ажиллагаан дахь эрэгтэй багшийг илт дэмжихгүй байх үзэл хандлагатай, цөөн тооны эмэгтэй удирдах ажилтан таарч байлаа. Эрэгтэй багшийг дэмжихгүй байгаа шалтгааныг хүүхэд нэг бүртэй тулж ажиллах, хүүхдийн онцлог, ялгааг харгалзах, тэднийг хөгжүүлэх ур чадвар, арга барил эмэгтэй багштай харьцуулахад учир дутагдалтай, дэлхийн нийтийн чиг хандлага ч манайхтай төстэй гэдэг үндэслэлээр тайлбарласан юм.

*Мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэргээ ахиулах адил боломж*

Судалгааны хүрээнд нийт 23 сургуульд мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулахад 23 сургуульд нийт 1008 багш ажиллаж байгаа бөгөөд сүүлийн жилийн байдлаар үүнээс 823 багш мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна. Энэ үзүүлэлт нь харьцангуй өндөр байгаа бөгөөд сүүлийн жилд сургалтын цөм хөтөлбөр шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор цөөнгүй сургалт зохион байгуулагдаж, түүнд хамрагджээ. Үүнээс хүйсийн хувьд аваад үзвэл нийт 173 эрэгтэй багшаас 108 буюу 62.4 хувь, нийт 835 эмэгтэй багшаас 539 буюу 64.5 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагджээ. Энэ нь багш нар мэргэжил дээшлүүлэх сургалтад хүйсийн хувьд тэгш хамрагдаж буйг илтгэж байна.

Ишлэл\* Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.9;

“Хүүхэд төрүүлэх, асрах чөлөө авсан ажилтны мэргэжил, мэргэшлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөж чадахуйц түвшинд байлгах зорилгоор тэднийг давтан сургалтад хамруулах”.

Сургуулийн удирдах албан тушаалтнууд багш нартаа мэргэжил дээшлүүлэх, албан тушаал, мэргэжлийн зэргээ ахиулах зэргээр өсөж хөгжих бололцоог “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ын 2.3., 2.4., 2.5-ын дагуу эрэгтэй, эмэгтэй ялгаагүй анхны жил болон тав, арав дахь жилдээ ажиллаж буй багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад тэгш хамруулж ажилладаг болохоо хэлж байв. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 сарын 15-ны өдрийн А/305 дугаар тушаалаар батлагдсан “Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам” сургуулиудад хэрэгжиж байгаа юм.

Хүснэгт 17 Мэргэжлийн зэрэг олгох зарим шалгуур үзүүлэлт

Нийтлэг шалгуур	Тусгай шалгуур
3.1.1. Ерөнхий боловсролын сургуульд багшлах эрхтэй байх;	3.2.1. Багшид “Заах аргач багш” мэргэжлийн зэрэг олгоход Ерөнхий боловсролын сургуульд багшаар тав ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх
3.1.2. Багшийн ёс зүйг чанд сахин, холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажилласан байх;	3.2.2. Багшид “Тэргүүлэх багш” мэргэжлийн зэрэг олгоход Ерөнхий боловсролын сургуульд багшаар арав ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх;
3.1.3. Суралцагч нэг бүрийн авьяасыг нээх, хөгжлийг дэмжих арга зүй, технологийг эзэмшсэн байх;	3.2.3. Багшид “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг олгоход Ерөнхий боловсролын сургуульд багшаар арван тав ба
3.1.4. Судалгаа хийх, гадаад хэл, мэдээлэл	

технологийн зохих түвшний мэдлэг, чадвартай байх;	түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх;
---	---

Тус журамд багш болон ажилтанд мэргэжлийн зэрэг олгох үе шат, шаардлагыг тодорхой зааж өгсөн бөгөөд хүйсийн хувьд адил тэгш боломжийг олгосон байна.

## 2.2 Сургуулиудын баримт бичиг дэх жендэрийн бодлогын талаарх зохицуулалт

*Ажилтны ажил, гэр бүлийн үүргээ хослуулах боломж*

Сургуулиудын дотоод журамд багш, ажилтан хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, нийгмийн баталгаагаар хангагдах нөхцөлийг бүрдүүлж амьдралын гачигдал болон бусад зайлшгүй үзүүлэх тэтгэмж тусламжийг байгууллагын дотоод журмын дагуу олгохоор тусгажээ.

Ишлэл\* Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2;

“Хөдөлмөрийн харилцаанд талууд хамтын гэрээ, хэлэлцээрт эмэгтэй, эрэгтэй ажилтанд ажил, мэргэжлийн эрх ашиг, гэр бүлийн үүргээ хослуулах, хүүхэд төрүүлэх, асрах нөхцөл бололцоо олгох, эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй нөхцөлд ажиллах, түүнчлэн ижил ажилд адил цалин, нэмэгдэл хөлс тогтоох, ижил нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тусгана.”
---

Сургуулиудад нийтлэг гарч буй өрх гэр бүл дэх үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой дэмжлэг үзүүлсэн заалтуудыг харвал орон нутгийн сургуулиуд илүү нарийвчилсан хэлбэрээр зохицуулж өгсөн байна. Орон нутгийн сургуулиуд дараах байдлаар өрх гэр бүл дэх үүргээ хослуулах боломжийг дотоод журамдаа тусгасан. Үүнд:

- Багш, ажилчид жил бүр шинжилгээ өгч эмчийн үзлэгт бүрэн хамрагдана. Багш ажилчдын чөлөөг өргөдлийн дагуу чөлөөний хуудсаар /ар гэрийн гачигдал, эмчилгээ хийлгэх/ захирал олгоно.
- Багш ажилчид өөрөө эсвэл өөрийн үр хүүхэд найр хурим сумаас 450 км дотор хийвэл 1-5 хоногийн цалинтай чөлөө олгож, багш ажилчид 5000 төгрөгийн тусламж үзүүлнэ.
- Жилд 2 хүнийг түлээний хөнгөлөлтөд хамруулна.
- 8 хүртэл насны хүүхдээ ажлын дундуур эмнэлэгт үзүүлэхэд 3-14 хоног цалинтай чөлөө олгоно.
- Багш нарын эцэг эх, эхнэр\нөхөр, хүүхэд нь өвдөж УБ хотод онош тодруулахаар бол 13-р маягтыг үндэслэн замын 2 талын зардлыг автомашинаар тооцож олгоно.
- Багш нарын аав ээж, хадам аав ээж, хүүхэд нас барсан тохиолдолд давхардуулахгүйгээр нэг удаад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх мөнгөн тусламж байгууллагаас олгоно.
- Гэр бүлийн хэн нэг хүн хүнд өвчтэй сахих шаардлага гарвал 5-10 хоногийн цалинтай чөлөө олгоно гэх мэт зохицуулалтууд сургуулийн дүрэмд нийтлэг байдлаар оржээ.
- Хуримлах тохиолдолд хүн бүрээс 3000 төгрөг хураана.
- Төрсөн хүүхэд нь их, дээд сургуульд элсэн суралцах тохиолдолд цалинтай 5 хоногийн чөлөө олгоно.

Улаанбаатар хотын сургуулиуд багш, ажилтны өрх гэр бүл дэх үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дараах дэмжлэг үзүүлсэн заалтуудыг дотоод журамдаа оруулжээ. Үүнд:

- Сургуулийн ажилтан шинээр гэр бүл болж хуримлах, алдар цолны мялаалга хийхэд 150000 төгрөг олгоно.
- Багш, ажилтны ажлын үр дүн, хандлага, ажилласан хугацаа зэргийг харгалзан тэдний төрсөн хүүхэд тус сургуульд суралцаж байвал сургалтын төлбөрөөс 100%, ач зээ байвал 50% тус тус чөлөөлнө.
- Эхнэр нь төрсөн тохиолдолд шинэ аавын 5 хоногийн цалинтай чөлөө олгоно.
- Асрамжид нь байдаг хүн өвдөх үед 5-3 хоногийн цалинтай, мөн бусад төрлийн гачигдал гарах үед нь цалинтай чөлөө олгох, мөнгөн дэмжлэг өгөх тухай заалтууд байв.



○ Бусад тохиолдолд жилд 2-оос дээшгүй удаа 14 хоног цалингүй чөлөө олгоно. Эцэг эх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардсан гэр бүлийн гишүүнээ асрах, хамгаалах, эсвэл өвдөх, тохиолдолд цалинтай болон цалингүй чөлөө олгох, мөнгөн дэмжлэг, туслалцаа үзүүлэх тухай судалгаанд хамрагдсан сургуулиуд 100 хувь тусгажээ.

*Удирдах албан тушаалтны үүрэг*

Ишлэл\* Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр 11.3.1;

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөгөө, хөтөлбөрийн үндсэн дээр хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар ажилтнуудад мэдээлж байх”.

Судалгаанд хамрагдсан 23 сургуулийн баримт бичигт шинжилгээ хийхэд 5 сургууль “Сургуулийг хөгжүүлэх бодлогын баримт бичиг буюу Сургуулийн стратеги төлөвлөгөө”-ндөө жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч энэ талаар үйл ажиллагаа явуулаагүй байв.


Судлагдсан ЕБС-ийн удирдах ажилтнуудын 38.2 хувь нь жендэрийн тэгш байдлыг хангах зохицуулалт сургуулийн бодлогын баримт бичигт туссан гэж үзсэн. Сургуулийн дотоод дүрэм, журам, стратеги төлөвлөгөөнд багш, сурагчийг хөгжүүлэх арга хэмжээг хүйс харгалзахгүй эрх тэгш байдлаар хамруулахаар тусгаж өгчээ. Сургуулийн дүрэм, журамд өөрчлөлт оруулах замаар хүйсийн онцлогоос хамаарсан ялгаатай хэрэгцээ шаардлагыг анхаарсан нарийвчилсан зохицуулалтуудыг оруулах шаардлагатай юм.

Сургуулиуд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөгүй, тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлэхгүй байгаагийн гол шалтгаан нь тухайн үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар ойлголт, мэдлэггүй, түүнийг хэрхэн боловсруулах талаар удирдамж, чиглэл байхгүйтэй холбоотой байна.

Ишлэл\* Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3;

“Иргэнийг ажилд авахдаа тухайн байгууллага болон түүний бүтцийн нэгж дэх хүйсийн төлөөллийн тэнцвэртэй байдлыг харгалзан цөөн тоотой хүйсийн хүнийг сонгох”.

Зураг 9 Багш сонгон шалгаруулахад жендэрийн тэгш байдлыг хангах зохицуулалт байдаг эсэх



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар иргэнийг ажилд авахдаа тухайн байгууллага болон түүний бүтцийн нэгж дэх хүйсийн төлөөллийн тэнцвэртэй байдлыг харгалзан цөөн тоотой хүйсийн хүнийг сонгох талаар тусгаж өгсөн ч сургуулийн удирдах ажилтнууд хуулийн тус

заалтыг мэдэхгүй байна. Судалгаанд хамрагдсан удирдах албан тушаалтнуудын хувьд эрэгтэй багш ажилд авах сонирхолтой байна. Тухайлбал багшийн сонгон шалгаруулалт зарлахад эрэгтэй багш ирвэл илүү давуу тал болгож үнэлдэг ч, эрэгтэй багш сонгон шалгаруулалтад ирж бүртгүүлэхгүй байгааг онцолж байв.

...“Бодлогын хувьд багш нарын хүйсийн харьцааг тэнцүү барихыг хичээдэг ч шаардлагатай багш нарын орон тоон дээр эмэгтэй багш нар ирдэг. Харин ажилчдын хувьд бол сантехник (байрны жижүүр, галч) хүйсийн харьцаа тэгш байдаг, багш нарын хувьд бол хүйсийн харьцааг тэнцвэртэй байлгахад бэрх.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...“Багшийг сонгон шалгаруулахтай холбоотой жил бүр сонгон шалгаруулалт явагдаж хүмүүсээ авдаг. Манай аймагт ил тод телевиз, радиогоор зарладаг. Жил болгон статистик мэдээлэл гаргадаг. Ямнаас хэдэн хувь нь эрэгтэй багш ав, хэдэн хувь нь эмэгтэй багш ав гэх юм бол дагах л байх. Миний бодлоор шаардлага байхгүй санагдаж байна. Багш нар бол авьяас чадвар дээрээ суурилах ёстой.”

*(Ганцаарчилсан ярилцлага, Аймаг, дүүргийн боловсролын газрын төлөөлөл)*

“...Ажлын сонгон шалгаруулалтад эрэгтэй хүн байвал авах сонирхол их байдаг. Гэхдээ тэр нь дийлэнхдээ эмэгтэй байж таардаг.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

... “Хүүхнүүд зэргээ ахиулах гээд гүйж байхад эрэгтэй хүн бүх шаардлага нь хангагдсан атлаа зэрэг авахгүй л яваад байсан. Нэг эрэгтэй багш тун дажгүй өсөж байгаа, дээр нь ажилласан жил өнгөрчихөөд байж заах арга зэргээ аваагүй байсан. Иймээс эрэгтэй багш нарынхаа ийм онцлогт анхаарч, дэмжих хэрэгтэй.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

Ярилцлагын тэмдэглэлээс үзэхэд сургуулиудад багш сонгон шалгаруулахад хүйсийн тэгш байдлыг бодлогоор дэмжих нь хангалтгүй байгааг судалгааны дүнгээр ажиглагдлаа. Мөн аймаг, дүүргийн боловсролын газрын төлөөллийн ярилцлагаар багш нарын хүйсийн харьцааны тэнцвэр нь төдийлөн чухал асуудал биш бөгөөд багшийн мэдлэг, чадвар дээр үндэслэх шаардлагатай ажил, мэргэжил гэж үзэх хандлагатай байна.

...“Эмэгтэйчүүд их тул эрэгтэй багш авах дуртай. Багш захиалахдаа сайн эрэгтэй багш авмаар байна гэдэг. Энэ нь бодлогын баримт бичигт байхгүй. Сургуулиуд эрэгтэй багш авах зорилгоор эмэгтэй багш авахгүй эрхийг нь зөрчих тал гаргадаг.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...“Эрэгтэй багш нарыг авах талаар ярьдаг ч мэргэжлийн багш нар байж байхад ч эмэгтэй учраас ажлаасаа гар энэ эрэгтэй багшийг авна гэсэн ойлголт байхгүй.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

Ганцаарчилсан ярилцлагаас үзвэл сургуулийн удирдах ажилтнуудын зүгээс багш нарын хүйсийн харьцааг ойртуулах хүсэл сонирхолтой байдаг ч багшийн сонгон шалгаруулалтад эрэгтэй багш ирж бүртгүүлдэггүй явдлыг онцолж байв. Үүнийг эрэгтэй хүн ар гэрээ тэжээх хэмжээний цалин хөлстэй ажлыг сонирхдог, багшийн цалин хөлс бага учраас эрэгтэй багш ирдэггүй хэмээн тайлбарласан.


Судалгааны хамрах хүрээнд сонгогдсон ЕБС-ийн асуулга судалгаанд оролцсон удирдах түвшний ажилтнуудын 38.2 хувь нь жендэрийн тэгш байдлыг хангах зохицуулалт сургуулийн баримт бичигт туссан гэж үзсэн. Сургуулийн дотоод дүрэм, журам, стратеги төлөвлөгөөнд багш, сурагчийг хөгжүүлэх арга хэмжээг хүйс харгалзахгүй эрх тэгш байдлаар хамруулахаар тусгаж өгсөн байна. Мөн түүнчлэн цаашдаа дүрэм, журамдаа өөрчлөлт оруулах замаар хүйсийн онцлогоос хамаарсан ялгаатай хэрэгцээ шаардлагыг анхаарсан шаардлагатай зохицуулалтуудыг оруулах боломжтой гэж хүлээн авч байв.

Ишлэл\* Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.10;

“Аж ахуйн нэгж, байгууллага нь хүйсийн тэнцвэртэй байдлын тухай тайлангаа жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх”.

Судалгаанд хамрагдсан сургуулиудаас хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг тусад нь авч үзэж гаргахгүй байгаа бөгөөд энэ нь хуулийн тус заалт хэрэгжихгүй байгааг илтгэж байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, сургуулийн удирдах албан тушаалтан хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй байна. Удирдах албан тушаалтан үүргээ биелүүлэхгүй байгаа нь хуулийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаатай холбоотой байна. Тухайлбал судалгаанд хамрагдсан удирдах албан тушаалтнуудын 41.2 хувь нь энэ хуулийн талаар мэдэхгүй гэж хариулжээ. Тус хуулийг мэднэ гэж хариулсан оролцогчид 58.8 хувь буюу өндөр байгаа ч хуульд туссан үүргээ хэрэгжүүлээгүй байгаа нь хуулийн талаар сайтар ойлголт, мэдлэггүй байгааг харуулж байна.

Зураг 10 Жендэрийн тэгш байдлыг хангах хуулийг мэдэх байдал, хувиар



Ишлэл\* Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3;

“Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны тайланд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн, гарсан зөрчил, түүний гарилгах талаар авсан арга хэмжээг тусгах бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн нь сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлтийн нэг байна”.

Ерөнхий боловсролын сургуулийн удирдах албан тушаалтантай тухайн аймаг, дүүргийн Засаг дарга Үр дүнгийн гэрээ хийн ажилладаг. Мөн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд тухайн албан тушаалтныг үнэлэхдээ жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны холбогдох тайланг авч, тайланд үндэслэн үнэлэх тус заалт хэрэгжээгүй байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулинд заасан хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх үүргийг сургуулийн удирдах албан тушаалтан болон түүнийг үнэлж буй албан тушаалтанд мэдээлэх, таниулах шаардлагатай юм.

...”Жендэрийн сургалтад хамрагдаж байгаагүй. Төрийн албаны шалгалт өгөх гээд явж байхад энэ талаар уншиж байсан учраас Жендэрийн тэгш байдлыг хангах хуулийн тухай ойлголт бол бий.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...”Манай сургууль жендэрийн харьцааг хангаж ажиллахыг хичээдэг. Боловсон хүчин авахдаа аль болох эрэгтэйг нь авахыг хичээдэг. Гэхдээ багшийн сонгон шалгаруулалт зарлахад эрэгтэй хүн ирдэггүй.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

*Ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх*

Ишлэл\* Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.1;

“Хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах”.

Мөн тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт удирдах албан тушаалтанд ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх үүргийг хуульчилж өгсөн байна. Судалгаанд хамрагдсан 23 сургуулийн баримт бичигт шинжилгээ хийхэд хөдөлмөрийн дотоод журамдаа ажлын байрны бэлгийн дарамтыг хориглосон, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон заалтыг тусгасан сургууль байхгүй байна. Мөн аль нэг хүйсийг онцгойлон авч үзсэн эсвэл дорд үзсэн заалт байгаагүй юм. Мөн 5 сургууль буюу 21.7 хувь нь Стратеги төлөвлөгөөндөө жендэрийн талаар баримтлах бодлого /багшлах боловсон хүчний хүйсийн тэнцвэртэй харьцааг бий болгох/ тусгасан байна.

## **БҮЛЭГ 3. ЦӨМ ХӨТӨЛБӨР, ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖИЛГЭЭ**

### **3.1 Ерөнхий боловсролын сургалтын 12 жилийн болон цөм хөтөлбөр дэх жендэрийн дүн шинжилгээ**

Энэхүү бүлэг нь үндэсний түвшний сургалтын хөтөлбөр, судалгаанд хамрагдсан багш нарын боловсруулсан хичээлийн хөтөлбөр, 1-12-р ангид судалж буй Монгол хэл, Нийгмийн ухааны сурах бичиг хэр зэрэг жендэрийн мэдрэмжтэй боловсруулагдсан тухай өгүүлэх юм. Тус бүлгийн эхэнд бага, суурь, бүрэн дунд боловсролын үндэсний хэмжээний хөтөлбөрт жендэрийн асуудалд хэр зэрэг анхаарсан болохыг тодруулна. Дараагийн хэсэгт багш нар өөрсдийн хөтөлбөрт жендэрийн асуудлыг хэр зэрэг анхаарсан болохыг харуулах баримтуудыг дэлгэнэ. Бүлгийн гурав дахь хэсэгт сурах бичгийн стандарт, холбогдох журам болон сурах бичгийн агуулгад жендэрийн дүн шинжилгээ хийсэн гол үр дүнгүүдийг танилцуулах юм.

#### **3.1.1 Үндэсний хэмжээний сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц**

1990 оны Ардчилсан хувьсгалтай хамт боловсролын үзэл баримтлал, агуулга, сургалтын болон үнэлэх арга зүй, аргачлалд эрс шинэчлэл хийх бодлого, хөтөлбөр, төслүүд хэрэгжиж байна. Монгол улсын төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулиудад боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр, хичээлийн жилийн бүтэц гэсэн үндэсний хэмжээний баримт бичгүүдийг мөрддөг. Бага, суурь, бүрэн дунд боловсролын нийт 20 стандартыг 2004 оноос хэрэгжүүлж байна. Тус стандартуудад 2009 онд үнэлгээ хийгдсэн байдаг. 2008 оноос 11 жилийн сургалтын тогтолцооноос 12 жилийн тогтолцоонд батлагдсан графикайн дагуу шилжсэнтэй зэрэгцэн судлагдахуун тус бүрээр үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлсэн болно. Хөтөлбөрийг боловсруулах шаардлага нь нэг талаас сургалтыг прагматжуулах бодит хэрэгцээ, нөгөө талаас 12 жилийн тогтолцоонд шилжсэн нөхцөлтэй холбогдох юм.

Харин “Зөв монгол хүүхэд” Үндэсний хөтөлбөр, Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын чанарын шинэчлэл дэд хөтөлбөрийг 2013 оноос хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд цөм хөтөлбөрүүд боловсруулагдан хэрэгжиж байна. 2010 онд явуулсан ТИМСС/ПИРЛС-2011 туршилтын судалгаагаар 8-р ангийн сурагчдын математик, байгалийн ухааны үнэлгээний дундаж 25,8 хувь, 4-р ангийн сурагчдынх 39.6 хувьтай гарсан нь боловсролын чанар хангалтгүй байгааг нотолжээ<sup>36</sup>. Энэхүү судалгааны үр дүн нь бүх нийтийн боловсролын чанарыг сайжруулахын тулд сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах шаардлага буйг харуулсан байна. “Зөв монгол хүүхэд” Үндэсний хөтөлбөрийг боловсруулахаас өмнө судлаачдыг баг ажиллан, Зөв монгол хүүхдийн загварыг боловсруулан гаргажээ. Гэхдээ сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулахдаа охид, хөвгүүдээс хэрэгцээ сонирхлыг нь тандах судалгааны ажил хийгдээгүй ажээ<sup>37</sup>.

Бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр нь 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжиж эхлээд байна. Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг боловсруулан, лаборатори 40 сургуульд турших ажил энэ хичээлийн жилээс эхэлж байгаа тул бусад бүх сургуульд 12 жилийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх үйл ажиллагааг бодлого, менежментийн, хэрэгжилт туршилтын, хөтөлбөр шинэчлэх 3 багаар зохион байгуулагдан ажиллаж байна. Эдгээр багийн гишүүдийн дийлэнх нь эмэгтэйчүүд аж. Тухайлбал, хөтөлбөр боловсруулагч багийн гишүүдийн 67%, багийн ахлагчдын 87% хувь нь эмэгтэйчүүд байна. Цөм

<sup>36</sup>МУЗГ (2013) “Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр”.

<http://www.legalinfo.mn/annex/details/5962?lawid=9349>

<sup>37</sup>Сургалтын цөм хөтөлбөр боловсруулах багийн гишүүдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас, 2016 он 3 сар.

хөтөлбөрт БСШУЯ захиалагч, Боловсролын хүрээлэн зохицуулагч болон арга зүйн зөвлөх, МУБИС, МУИС зэрэг багш бэлтгэдэг их сургуулиуд зөвлөх, ЕБС, лаборатори сургууль туршин хэрэгжүүлэгчийн үүрэгтэйгээр оролцож байна. Багуудад оролцогч талуудын төлөөлөл хангагдсан бөгөөд багийн гишүүнээр сонгохдоо боловсролын хөтөлбөр, сурах бичиг зохиоход оролцсон туршлагатай, сургалтын арга зүй, дидактикийн чиглэлээр чадварлаг, тухайн судлагдахууны боловсролын чиглэлээр мэргэжсэн байх шаардлагуудыг тавьжээ. Гэхдээ хөтөлбөрийн багийн гишүүний сонгон шалгаруулалт нь сонирхсон бүх хүнд нээлттэй байгаагүй. Боловсролын хүрээлэнгийн хөтөлбөрийн судалгааны нэгжийн судлаачдаас бидний фокус бүлгийн ярилцлагад оролцсон бөгөөд тэд жендэрийн мэдрэмжтэйгээр сургалтыг хөтлөх болон сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг хэрхэн тооцох талаар чадвар дутмаг байгаагаа илэрхийлсэн юм. Тэдгээрээс тун цөөхөн нь жендэрийн сургалтад хамрагдсан байв. Эдгээр үр дүн нь жендэрийн тэгш эрхийн ойлголт, жендэрийн асуудлыг тооцсон сурган хүмүүжүүлэхүйн талаар хөтөлбөрийн багийн гишүүдийг бэлтгэх хэрэгцээ буйг нотолж байна.

### 3.1.2 Бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн жендэрийн мэдрэмжит байдал

Бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрүүдийг боловсруулахдаа баримталсан зарчим, зорилго, зорилтууд нь юуны өмнө хүүхэд (сурагч) хэмээн “ерөнхий” түвшинд биш, харин “хүүхэд, сурагч бүр”<sup>38</sup> хэмээн тусгайлан нэгж түвшинд онцгойлон анхаарсан нь охин, хөвгүүн бүрт хөгжих, сурах арга барил эзэмших адил тэгш боломжийг бүрдүүлжээ. Ийнхүү хөтөлбөрийг судлах адил тэгш боломж бүрдүүлэх үзэл баримтлал нь *жендэрийн тэгш байдал тогтооход эерэг* үр нөлөөтэй юм. Суурь боловсролын хөтөлбөрийг боловсруулахад баримталсан зарчимд “сурагч бүрт адил тэгш боломж олгох” нөхцлийг бүрдүүлсэн байх хэмээн заасан нь хэдийгээр ерөнхий утгатай байгаа ч, сурах үйл ажиллагаанд охид, хөвгүүд адил тэгшээр оролцох нөхцлийг бүрдүүлэх тухай үзэл баримтлалын суурь болж байгаа юм. (Хүснэгт 18).

Хүснэгт 18 Хөтөлбөрийн зарчим, зорилго (бага болон суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр)

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр	Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр
Боловсруулахад баримталсан зарчим	Боловсруулахад баримталсан зарчим
<ul style="list-style-type: none"> <li>- <i>Хүүхэд бүрийн</i> авъяас, сонирхол, чадвар, хувийн онцлог шинжийг <i>нээх, дэмжих, хөгжүүлэх үндэс болох</i></li> <li>- <i>Хүүхэд бүртэй ажиллах</i> арга зүйд суурилан сургалтыг уян хатан төлөвлөх, зохион байгуулах <i>нөхцлийг бүрдүүлсэн байх</i><sup>39</sup></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- <i>Тогтвортой хөгжлийн болон хүний эрхийн үзэл санааг тусгасан байх,</i></li> <li>- <i>Сурагч бүрийн</i> бүтээлч үйл ажиллагаанд суурилан үйлийн явцад <i>суралцах нөхцөлийг бүрдүүлсэн байх,</i></li> <li>- <i>Сурагч бүр сурах арга барил эзэмшихэд</i> чиглэсэн байх,</li> <li>- <i>Сурагч бүрийн</i> ахиц, амжилт, <i>хөгжлийг дэмжихүйц</i> байх,</li> <li>- <i>Сурагчдад суралцах адил тэгш боломж олгохүйц</i> байх<sup>40</sup></li> </ul>
Зорилго	Зорилго
“Хүүхэд бүрийг <i>эх хэл, үндэсний соёл, ёс заншил, уламжлалаа эрхэмлэдэг, сурах арга барилтай, ... хамтран ажиллаж амьдрах чадвартай иргэн</i> болж төлөвшихөд чиглэсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна <sup>41</sup> ”	“... <i>сурагч бүрийг сурах арга барил ... эзэмших, үндэстний хэл, түүх, соёлоо дээдлэн хөгжүүлэх, ардчилсан, хүмүүнлэг үзэлтэй иргэн болж төлөвших боломж олгох</i> <sup>42</sup> ”

<sup>38</sup>БСШУЯ (2014) Бага боловсролын цөм хөтөлбөр. УБ., 17-р тал, БСШУЯ (2015) Суурь боловсролын цөм хөтөлбөр. УБ., 19-р тал

<sup>39</sup>БСШУЯ (2014) Бага боловсролын цөм хөтөлбөр. УБ., 16-р тал

<sup>40</sup>БСШУЯ (2015) Суурь боловсролын цөм хөтөлбөр. УБ., 19-р тал

<sup>41</sup>БСШУЯ (2014) Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ., 17-р тал

Цөм хөтөлбөр (Хүснэгт 3.1) үндэсний хэл, соёл, түүх, уламжлалаа хүндэтгэн, өвлөн хөгжүүлдэг хүн төлөвшүүлэхэд анхаарах нь гарцаагүй чухал. Гэхдээ уламжлалт соёл дахь нийгмийн тодорхой анги, категорийг дорд үзсэн, ялгаварласан, эрхийг нь зөрчсөн агуулгыг багтааж болзошгүй нөхцлийг давхар агуулж байгааг анхаарууштай. Иймээс дэвшилтэт бус, хүний эрхэд халдсан утга бүхий, уламжлалт соёлын зан заншлаас татгалзах, орхих тухай санааг тусгавал зохино. Энэ нь монгол ёс заншил, уламжлалаа мэддэг, эх орноороо бахархдаг үндэсний эерэг үзэл бүхий иргэн болж төлөвших утгыг илэрхийлж байгаа ч, жендэрийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлэхүйц агуулга сурах бичигт тусгагдахаас урьдчилан сэргийлж чадахгүй байгааг зарим судлаачдын<sup>43</sup> судалгаа харуулж байна.

Бага боловсролын хөтөлбөрийн агуулгыг тус хөтөлбөрт суралцах, эзэмших ерөнхий чадвар болон агуулгын хүрээ гэсэн хоёр дэд хэсгийн хүрээнд тодорхойлсон байна. Энэхүү хэсэгт:

- асуудлыг олж хардаг, түүнийг шийдэх янз бүрийн хувилбаруудыг дэвшүүлэн харьцуулдаг байх,
- бусдыг сонсож чаддаг байх,
- сэтгэл хөдлөлөө зөв илэрхийлдэг, бусад хүмүүст сөрөг нөлөө үзүүлэхгүйг эрмэлздэг байх,
- ялгаатай эх сурвалжуудаас мэдээлэл олж авах, түүнийгээ ялгаж, харьцуулдаг байх зэрэг ерөнхий чадваруудыг эзэмшүүлэхээр зорьж байгаа нь нэгд, ямар нэг “изм”-д үл баригдах олон ургальч хандлага, хоёрт, хүчирхийлэлт зан төлөвөөс зайлсхийх хандлагыг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах юм. Хэдийгээр тус хөтөлбөр нь жендэрийн тэгш эрхийн тухай ойлголтыг хөгжүүлэхэд анхаараагүй ч, эдгээр зорилтууд нь жендэрийн тэгш эрхийн үзэл хандлага төлөвшихөд эерэг хувь нэмэртэй юм.

#### Хүснэгт 19 Сургалтын арга зүй

Бага боловсролын хөтөлбөр	Суурь боловсролын хөтөлбөр
<ul style="list-style-type: none"> <li>- <i>Хүүхдийн хэрэгцээ, сонирхол, туршлага, чадварт суурилж</i>, тэдний бие даан суралцах арга барилыг хөгжүүлэх,</li> <li>- Хүүхэд бүр ярилцлага, хэлэлцүүлэг, мэтгэлцээнд оролцох</li> <li>- Хүүхэд өөрөө мэдлэг бүтээх, тэгш хамран сургах, суралцагчийн ялгаатай байдал (хүйс, сурах арга барил г.м)-ыг харгалзах<sup>44</sup></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сурагчдын <i>бүтээлч үйл ажиллагаа, өөрөө шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх, бусадтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах ...</i> зэрэг үйл ажиллагаанд суурилах,</li> <li>- Эх сурвалж, дасгал даалгавар зэргийг олон хувилбартайгаар бэлтгэн хэрэглэх<sup>45</sup></li> </ul>

Дээрх хүснэгтээс харвал бага боловсролын цөм хөтөлбөр нь арга зүйн зөвлөмжийн хүрээнд жендэрийн ялгаанд анхаарлаа хандуулсан ч арга зүйн зөвлөмжийн хэсэгт “жендэрийн ялгааг харгалзах” тухай оруулсан нь сургах хийгээд сурах үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй болгоход хангалттай биш юм. Суурь боловсролын сургалтын арга зүйн хэсэг нь сурагч бүрийн шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх арга барилыг хөгжүүлэхэд анхаарч байна. Эдгээр сургалтын арга зүй нь сурах үйл ажиллагаанд охин, хөвгүүн бүр оролцох адил тэгш боломжийг олгож чадах юм. Түүнчлэн сурагч бүрт янз бүрийн эх сурвалжийг судлах замаар нэг үнэнд эргэлзээтэй хандан шинэ мэдлэгийг бүтээх, өөр хувилбарыг дэвшүүлэх боломжийг олгодог. Энэ бүхэн нь сурагчдад нийгмийн зонхилогч хэсгийнхнээс ялгаатай байхыг хүлээн зөвшөөрдөг хандлага төлөвшихөд эерэг нөлөөтэй.

Суурь боловсролын хөтөлбөр нь сургалтын үнэлгээний асуудалд ач холбогдол өгсөн бөгөөд шалгуураар хэмжээсжүүлж, нотолгоонд суурилсан, шударга, цаашид хөгжих боломжийг хангасан,

<sup>42</sup>БСШУЯ (201:) Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ., 19-р тал

<sup>43</sup>Д. Тунгалаг (2015). 7-11-р ангийн сурах бичиг, багшийн номонд жендэр ба орчны шинжилгээний багийн нэгдсэн санал дүгнэлт, зөвлөмж (хэвлэгдээгүй)

<sup>44</sup>БСШУЯ (2014) Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ., 16-р тал

<sup>45</sup>БСШУЯ (2015) Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ., 20-р тал

нээлттэй ил, тод байх<sup>46</sup> зарчмуудыг баримтлахаар тодорхойлжээ. Хэдийгээр энд хүйсээр үл ялгаварлах, охид хөвгүүдийн санал, сонирхолд тулгуурлах, оролцоог хангах зарчмууд багтаагүй ч, **“ерөнхий”** утгаараа буюу шалгуураар хэмжээсжүүлэн, нотолгоонд суурилж байгаа нь субъективизмийг бууруулан, багшийн зүгээс алагчлахаас сэргийлэх юм. Нээлттэй, ил тод байх зарчим нь үнэлгээнд охид, хөвгүүдийн оролцоог хангахад чухал үүрэгтэй.

Хүйсээр тусгаарлагдан судлах хийгээд нэмэлт төлбөртэйгээр судлах судлагдахуунууд тус цөм хөтөлбөрүүдэд байхгүй нь адил тэгш боломжийг бүрдүүлэхэд анхаарч байгааг давхар нотолж байна. Гэхдээ судлагдсан хөтөлбөрүүдэд бүхэлдээ хүүхдийн хэрэгцээ, сонирхолд хэрхэн тулгуурлах, сурах үйл явцад хүйсийн ялгаа хэрхэн илэрдэг, түүнийг сургалтад хэрхэн харгалзах тухай тодорхой аргачлал, шийдлүүд орхигдсон тул тус хөтөлбөрийг төвийг сахьсан шинжтэй гэж дүгнэж болно. Учир нь тус хөтөлбөрүүд нь жендэрийн тэгш бус байдлыг өөрчилж чадах стратегиуд, арга хэмжээнүүдийг тодорхойлоогүй бөгөөд жендэрийн асуудалд хайнга хандсан байна.

### **3.1.3 Монгол хэл, нийгмийн ухааны судлагдахууны бага боловсролын цөм хөтөлбөрийн жендэрийн мэдрэмж**

Монгол хэлний бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр нь унших, бичих, ярих-сонсох, хэл зүй, үгийн санг хэрэглэх<sup>47</sup> дөрвөн төрлийн багц чадваруудыг сурагч бүрт эзэмшүүлэхээр зорьж байна. Эдгээр чадварыг аман зохиол, уран зохиолын болон найруулгын бусад төрлөөр бичигдсэн эхийг төсөөлөх, унших, хэлэлцэх, боловсруулах, бүтээлчээр зохион найруулж бичих<sup>48</sup> замаар суралцахаар тусгажээ. Ийнхүү хөтөлбөрийн ерөнхий арга зүй нь бэлэн мэдээллийг идэвхгүйгээр хүлээн авах бус, сурагчийн идэвхтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг чухалчилж байгаагаараа сурагч бүрийг хичээлд оролцох боломжоор хангаж байна. Хөтөлбөрөөс монгол хэлний сургалтад “эх” чухал үүрэгтэй болохыг харж болох ба харин ямар эхийг сонгон ашиглах вэ гэдэг нь үнэт зүйлс, хандлагын боловсролд анхаарууштай асуудлуудын нэг. Хичээлд хэрэглэх эхийг сонгоходоо 8 зарчмыг баримтлахыг зааж өгсөн ба жендэрийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлэхүйц, жендэрийн өрөөсгөл хандлагыг илэрхийлсэн эхийг ашиглахгүй байх тухай буюу хүний эрх, тэгш эрх, эрх чөлөө, шударга ёсонд холбогдох шалгуурууд дутмаг байна. Үндэсний өв уламжлал, соёлд залуу хойч үе суралцахад монгол хэлний судлагдахуун чухал үүрэгтэй. Тэр утгаараа ч энэхүү үүрэгт онцгойлон анхаарсан ч дэвшилтэт бус, бурангуй үзэл бүхий эхийг сургалтад ашиглагдахаас урьдчилан сэргийлэх утга агуулга бүхий өгүүлбэр, санааг хөтөлбөрөөс олж чадаагүй болно.

Анги тус бүрээр гаргасан хүлээх үр дүнгийн хэсэгт олон төрлийн эх сурвалж ашиглах, харьцуулах, бусдыг сонсох, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, бусадтай эерэгээр харилцах, илэрхийлэх зэрэг чадварыг хөгжүүлэхээр зорьж байгаа нь сурагчдад олон ургальч хандлагыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй юм.

Бага боловсролын шатанд нийгмийн ухааны хөтөлбөр нь түүх, нийгмийн ухаан гэсэн судлагдахуунуудад хуваагдалгүйгээр боловсруулагдан хэрэгжиж байгаа болно. Хөтөлбөрийн нарийвчилсан хүрэх дүнгийн агуулгад хэдийгээр ерөнхий агуулгатай ч жендэрийн боловсролд эерэг хувь нэмэр оруулахуйц дараах үр дүн ажиглагдаж байна. Үүнд:

- *Жендэрийн ялгааг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэхэд:*

- “Бусдыг сонсож, ойлгож, үзэл бодол, байр суурийг нь хүндэтгэж чаддаг байх”.
- “Тухайн асуудлаарх ялгаатай санаа, санал бодлыг харьцуулах, нийтлэг зүйлсийг олох, үнэлэх”.

<sup>46</sup>БСШУЯ (2015) Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ., 21-р тал

<sup>47</sup>БСШУЯ (2014) Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ., 20-р тал

<sup>48</sup>БСШУЯ (2014) Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ., 20-23р тал



- *Охид, хөвгүүдийн биеэ даасан, өөртөө итгэлтэй байдлыг хөгжүүлэхэд:*
  - “Өөрийн үнэлэлт, хандлага зэрэг үнэт зүйлээ илэрхийлж чаддаг байх”
- *Нийгмийн эерэг үнэт зүйлсийг мэдэх, өөртөө төлөвшүүлэхэд:*
  - “Хувь хүн, гэр бүл, хамт олны үнэт зүйлийг мэдэх, үнэлэх”
- *Сөрөг харилцаа тодруулбал, хүчирхийлэлт зан үйлээс татгалзахад:*
  - “Бусадтай харилцахдаа сэтгэл хөдлөлөө хянаж, зохицуулж чаддаг байх” зэрэг болно<sup>49</sup>.

Тус хөтөлбөрийн агуулга хүний эрх, үүрэг, хариуцлага, нийгмийн амьдрал дахь оролцоонд чиглэсэн нь жендэрийн тэгш эрх, эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдал, оролцоо, түүний төрөл хэлбэрийн асуудлыг шууд хөндөөгүй ч, ерөнхий утгаараа хүний эрх, тэгш эрхийн үзэл санаанд анхаарч байгаагаараа ач холбогдолтой. Түүнчлэн 5-р ангийн агуулгад “*хүмүүсийн ялгаатай байдлыг (нас, хүйс, нийгэм, соёлын г.м) мэдэж, харилцаж чаддаг болох*”<sup>50</sup> хэмээн оруулсан нь *жендэрийн тухай боловсролд* шууд чиглэж байна. Хэдийгээр нийгмийн ухааны боловсролд гол анхаарлаа хандуулж байгаа ч, бага боловсролын онцлогтой холбоотойгоор түүхийн агуулгад ямар онцлог байгаа талаар товч өгүүлье. Энэ тухайд Модун Шанью, Чингис хаан, Чингисийг залгамжлагч их хаадын талаар судлахаар оруулсан нь бүгд “эрэгтэй” хүмүүс бөгөөд үүнд жендэрийн өрөөсгөл хандлага ажиглагдаж байна. Мөн “*Чингис хааны алдар, гавъяанаас тайлбарлаж чаддаг*”, “*ололт амжилтаас тодорхойлж чаддаг болох*” зэрэг нь олон ургальч гэхээсээ зөвхөн нэг өнцөгөөр асуудалд хандахыг тулгаж байгааг анхаарууштай.

Сурагч бүр ганцаарчлан болон багаар ажиллах, сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, ялгаатай эх сурвалж, хэрэглэгдэхүүн ашиглахаар оруулсан тул охид, хөвгүүд сургалтын үйл ажиллагаанд адил тэгш оролцох боломжийг ерөнхийд нь олгожээ. Охид хөвгүүдийн ялгаа, ялгаатай, хэрэгцээг хэрхэн харгалзах, хүйсийн алагчлалаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаарч тодорхой арга хэмжээнүүдийг тусгаагүй байна. Ийнхүү нийгмийн ухааны бага боловсролын хөтөлбөрийн агуулгын тодорхой хэсэг жендэрийн боловсрол олгоход шууд анхаарч байгаа хэдий ч, зарим нь аливаад олон ургальчаар хандах хандлага төлөвшихөд саад учруулж болзошгүй байгааг анхаарууштай.

### **3.1.4 Монгол хэл, нийгмийн ухааны суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн жендэрийн мэдрэмж**

Суурь боловсролын түвшинд суралцагч монгол хэлний цөм хөтөлбөрийг судалснаар нийгмийн харилцааны тодорхой орчинд аман болон бичгийн хэлээр чадварлаг харилцдаг, хэлний мэдрэмжтэй, эх хэл, соёлоо эрхэмлэдэг, үндэсний ухамсар сэтгэлгээтэй иргэн болж төлөвших<sup>51</sup> юм. Суурь боловсролын түвшинд сурагчдын сурах арга барилыг тэр дундаа шинжлэн судлах арга барил, мэдээлэлтэй ажиллах, харилцах чадварыг хөгжүүлэхэд анхаарсан ажээ.

Тус хөтөлбөрийн анги тус бүрээр гаргасан “ярих-сонсох” чадварын хүрээнд 6-9-р ангиудад “*өдөр тутмын амьдрал, сургууль, анги хамт олон, нийгмийн хүрээнд тулгамдсан асуудал*”-ын талаар *ярих, илтгэх, мэтгэлцэх, санал бодлоо илэрхийлэх* чадварт сурагчдыг суралцуулахаар төлөвлөжээ. Энэ нь сурагчид сэдвээ нээлттэй сонгох, асуудлыг хайх, тодорхойлох, асуудлыг олон өнцгөөс харж, шийдвэрлэх ялгаатай санал, хувилбаруудыг дэвшүүлэн, өөрийн үзэл бодол, шийдлийн үндэслэлийг хамгаалахын хамт бусдын үзэл бодлыг сонсох, хүлцэх, бусдаас суралцах боломжийг олгож байгаагаараа жендэрийн эерэг хандлага төлөвшихөд эерэг нөлөөтэй юм. Бага боловсролын цөм хөтөлбөрийн нэгэн адилаар эхийг гол хэрэглэгдэхүүн хэмээсэн ч, эх сонгохдоо тавигдах

<sup>49</sup>БСШУЯ (2014) Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ., 67-72-р тал

<sup>50</sup> мөн тэнд 71-р тал

<sup>51</sup>БСШУЯ (2015) Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ., 24-р тал

шаардлагыг тодорхойлон гаргаагүй байна.

Энэ шатанд нийгмийн ухааны хөтөлбөрийг судалснаар суралцагч нь нийгмийн үйл явдал, үзэгдлийг танин мэдэх арга барилтай, үндэсний бахархал, соёл, уламжлалаа дээдлэн өвлөж, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг хүндэтгэдэг иргэн болж төлөвшинө<sup>52</sup> хэмээн тус хөтөлбөрт тусгажээ. Монгол хэлний хөтөлбөрийн адилаар сурагчдын сурах арга барилыг хөгжүүлэхэд анхаарсан. Тэр дундаа, нийгмийн, үйл явдал, үзэгдлийг шинжлэн судлах, асуудлыг шийдвэрлэх ур чадвар болон үзэл бодлоо хөгжүүлэх замаар сурах арга барил эзэмшинэ<sup>53</sup> гэж төлөвлөсөн нь аливаад нотолгоонд тулгуурлан, олон ургальчаар хандах хандлагыг төлөвшүүлэх тул жендэрийн боловсролд эерэг хувь нэмэртэй. Түүнчлэн ардчиллын үнэт зүйлсийг эрхэмлэдэг, ардчиллыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг болно<sup>54</sup> хэмээсэн нь хүний эрх, тэгш эрх, шударга ёсны үнэт зүйлс, оролцоот хандлагыг төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй байж чадах юм.

Агуулгын хувьд жендэр, хүйс зэрэг ойлголтуудыг шууд хөндөөгүй ч, хүний эрх, тэгш эрх, үл алагчлал, соёлын олон янз байдал, нийгмийн амьдрал, үйл ажиллагаан дахь бүтцийн ялгаа, ардчиллын тухай мэдлэг нь жендэрийн боловсрол олгоход зохих ёсны ач холбогдолтой (Хүснэгт 3.3). Мөн бусадтай эерэгээр харилцах, зөрчил тэмцлээс сэргийлэх, эерэгээр шийдэх арга барилд суралцахад анхаарч байгаа нь жендэрийн эерэг соёл төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй (Хүснэгт 3.3).

Хүснэгт 20 Нийгмийн ухааны суурь боловсролын агуулга дахь жендэрт холбогдох гол санаанууд

VII анги	VII анги	IX анги
<ul style="list-style-type: none"> <li>- Эерэгээр харилцах, зөрчлийг зохистойгоор шийдвэрлэх</li> <li>- Бусдын соёлыг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх</li> <li>- Хүүхдийн эрх үүрэг</li> <li>- Хамтын удирдлага дахь оролцоо</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Асуудлууд нь хүмүүсийн байр суурь, үүрэг (бүтэц), соёлоос хамааран ялгаатай болох,</li> <li>- Бусдын соёлыг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх</li> <li>- Хүний эрх үүрэг, хүний эрхийн зарчмууд</li> <li>- Орон нутгийн удирдлага дахь иргэдийн оролцоо</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүмүүс хоорондын харилцаан дахь бүтцийн ялгаа</li> <li>- Стресс, бухимдлаас ангид байх</li> <li>- Олон соёлын нөхцөлд зохицон амьдрах</li> <li>- Хүний эрхийн төрөл хэлбэр</li> <li>- Хүний эрх ба хууль</li> <li>- Ардчилсан болон ардчилсан бус дэглэм дэх иргэний итгэл үнэмшил, үнэт зүйлс, оролцоо</li> </ul>

Гэхдээ тус хөтөлбөрүүд нь ерөнхий хөтөлбөрийн адилаар сурах/сургах үйл явцад охид хөвгүүдийн ялгааг хэрхэн харгалзах, сургалтын үйл ажиллагаанд хэрхэн татан оролцуулах, хүйсээр ялгаварлан гадуурхахаас хэрхэн урьдчилан сэргийлэх тухай тодорхой арга хэмжээнүүдийг тусгалгүйгээр орхигдуулсан ажээ.

### 3.1.5 12 жилийн сургуулийн монгол хэл, нийгмийн ухааны 10-12 ангийн сургалтын хөтөлбөрийн жендэрийн мэдрэмж

Тус хөтөлбөрүүд нь 12 жилийн сургалтад шилжиж байгаатай уялдан боловсруулагдсан бөгөөд 2011-2012 оны хичээлийн жилээс албан ёсоор хэрэгжиж эхэлсэн байдаг.

Монгол хэлний хөтөлбөрийн агуулгыг өгүүлбэр, үг, эх, бүтээвэр гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байхаар төлөвлөсөн ба мэдлэг, чадвар, хэрэглээний агуулгыг хэл шинжлэлийн үүднээс анхаарч шийдсэн тул жендэрийн дүн шинжилгээ хийх боломжоор хомс байв. 11-р ангийн хөтөлбөрийн

<sup>52</sup>БСШУЯ (2015) Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ., 80-р тал

<sup>53</sup> мөн тэнд

<sup>54</sup> мөн тэнд

үнэлгээний хэсэгт “эх зохиохдоо өөрийн үзэл хандлагаа илэрхийлж чадсан эсэх”<sup>55</sup>, 12-р ангийн хэрэглээний хэсэгт “тодорхой сэдвээр эсээ зохион бичих, илтгэл яриа хийх, ярьж бичихдээ тодорхой асуудал дэвшүүлэн амьдрал ахуйтай холбон, элдэв баримтаар нотолж, баталж, үгүйсгэн ярих, бичих”<sup>56</sup> чадварт суралцуулахаар төлөвлөсөн нь иргэний боловсролд давхар анхаарсан болохыг илтгэх юм. Хэдийгээр агуулгын хувьд жендэрийн асуудлыг шууд хөндөөгүй ч, дээр дурдсан чадварууд нь жендэрийн боловсролд хувь нэмрээ оруулах юм.

Нийгмийн ухааны хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүнгийн хэсгийг нэгтгэн авч үзвэл (10-12 дугаар анги)<sup>57</sup>:

- Нийгэм, соёлын болон ёс зүй, эрх зүйн албан, албан бус хэм хэмжээг мөрдөх, эдийн засгийн амьдрал, сонголтод суралцах,
- Нийгэм, бүлэг-хамт олон, байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй, сонголттой оролцох, бусдаас суралцах, бусдад үлгэр дуурайл үзүүлэх,
- Нийгэм, бүлэг-хамт олон, хувь хүмүүстэй зохистой харилцах, өөрийн эрх, үүрэг, ёс зүй, хариуцлагыг зан үйлдээ хэвшүүлэх, бусдад хүндэтгэлтэй хандах,
- Бүлэг, хамт олон, хувь хүмүүс, байгууллага, олон нийттэй зохистой харилцах зорилтуудыг дэвшүүлсэн нь жендэрийн сэдвийг хөндөөгүй ч, эерэг хандлага төлөвшихөд тодорхой хувь нэмэр оруулах юм.

Хүснэгт 21 10-12 ангийн Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрийн жендэрт холбогдох агуулга

X анги	XI анги	XII анги
Хүн худалдаалах гэмт хэрэг, хүний эрхийн зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх,	Хүний эрхийг хангаж, хамгаалах үндэсний болон олон улсын тогтолцоо, Хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг үндэсний брoлoн oлoн улсын байгууллагаад Хүний эрхийн үндэсний болон олон улсын эрх зүйн баримт бичгүүд	Нийгмийн тэгш биш байдлын бусад хэлбэрүүд: Жендэр Алагчлал

12-р ангийн нийгмийн ухааны хөтөлбөрийн агуулгад жендэрийг нийгмийн тэгш бус байдлын тодорхой нэгэн хэлбэр болох талаас нь анхаарч оруулсан байна. Харин 10-11 ангиудад эрх зүйн агуулгын хүрээнд хүний эрхийг хангах хамгаалах үндэсний болон олон улсын тогтолцоо, хүний эрхийн зөрчил, хүн худалдаалах гэмт хэргийн агуулгын хүрээнд жендэрийн боловсрол олгохоор зорьжээ.

Түүнчлэн жендэрийн өрөөсгөл хандлага, хэвшмэл ойлголтыг бэхжүүлэхүйц санаанууд огт тусгагдаагүй зэргээс дүгнэхэд 10-12 ангийн сургалтын хөтөлбөр нь жендэрийн тэгш байдлыг тогтооход эерэг хувь нэмэр оруулахаар боловсруулагдсан гэж дүгнэхээр байна.

Тус хөтөлбөрүүд нь охид, хөвгүүдийн ялгаа, ялгаатай хэрэгцээг хэрхэн харгалзах, адил тэгш оролцох боломжийг хэрхэн бүрдүүлэх, хүйсээр ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг тусгаагүй байна.

<sup>55</sup> БСШУЯ (2012) Ерөнхий боловсролын сургуулийн X-XII ангийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж: Монгол хэл, уран зохиол, монгол бичиг. УБ., 16-р тал

<sup>56</sup> мөн тэнд, 18-р тал

<sup>57</sup> БСШУЯ (2012) Ерөнхий боловсролын сургуулийн X-XII ангийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж: Түүх, нийгмийн ухааны сургалтын хөтөлбөр, зөвлөмж. УБ.,

### **3.2 Багш нарын хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээний үр дүн**

#### **3.2.1 Багш нарын хөтөлбөрийн жендэрийн дүн шинжилгээ: тэгш боломж олгож буй байдал**

Хичээлийн үйл явцыг нь ажигласан багш нарын нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр, түүний хэрэглэгдэхүүнд жендэрийн дүн шинжилгээг хийсэн юм. Улаанбаатар хотын 8 дүүрэг, Өвөрхангай, Завхан, Ховд, Дундговь, Орхон, Сэлэнгэ аймгийн ЕБС-д загдаж буй монгол хэл, математик, дизайн технологи, зураг зүй, газар зүй, нийгмийн ухаан, иргэний боловсрол, орос болон ангил хэл, компьютер, түүх, биологи, хими, физик зэрэг хичээлүүдийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийгээд байна. Бага боловсролын 11, суурь боловсролын 21, бүрэн дунд боловсролын 10, нийт 42 хөтөлбөрийг шинжлэв.

Юуны түрүүнд багш нар хөтөлбөртөө охид, хөвгүүдийн хэрэгцээ сонирхлыг хэрхэн харгалзаж, тодорхойлж, тооцоолсон эсэхийг судлахад бүх хөтөлбөрт ямар нэг санаа, үйл ажиллагааг тусгаагүй байв. Харин тухайн хөтөлбөрийг судлах адил тэгш боломжийг хэрхэн анхаарсан талаар тодорхойлоход нийт хөтөлбөрийн 85.7 хувь нь нийт сурагчдад адил тэгш боломж олгохоор ямар нэг хэлбэрээр анхаарчээ. Хэдийгээр охид, хөвгүүдэд тусгайлан анхаараагүй ч, хүүхэд бүрийг суралцах боломжоор хангахын тулд:

- хүүхэд бүртэй тулж ажиллах,
- багаар ажиллуулах,
- шоо хаях замаар оролцогчийг сонгох,
- хэлэлцүүлэг зохион байгуулах,
- бодлого, дасгал, эх дээр ажиллах,
- бие даах ажил гүйцэтгүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг гэжээ.

Сурагч бүрт адил тэгш боломж олгох чиглэлээр анхаарч буй байдал багшийн хүйсээс төдийлөн хамаарахгүй байгаа ч, эрэгтэй багш нар уг асуудалд хайнга хандах байдал эмэгтэй багш нараас ялимгүй их дүн үзүүлсэн байв. Багш хөтөлбөрийг судлах аргачлалыг хэрхэн төлөвлөснийг судлах нь сурагч бүрт хөтөлбөрийг судлах адил тэгш боломж бүрдсэн эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Үүнийг тодруулах зорилгоор хөтөлбөрт дүн шинжилгээ хийхдээ дараах чиглүүлэх асуултуудыг ашигласан юм. Үүнд:

- 1) Сургалтын ямар арга хэрэглэхээр төлөвлөсөн байна вэ?
- 2) Хичээлийн үйл ажиллагаанд сурагчдыг оролцуулахаар хэрхэн төлөвлөсөн байна?
- 3) Охид, хөвгүүдийн оролцоог хангах талаар хэрхэн төлөвлөсөн байна вэ?

Судалгаанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй багш нарын 20 орчим хувь нь лекцлэх, 40 орчим хувь нь сурагч төвт сургалтын аргууд, эрэгтэй багш нарын 16, эмэгтэй багш нарын 15 хувь нь багаар ажиллах, эмэгтэй багш нарын 13, эрэгтэй багш нарын 4 хувь нь шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх, эмэгтэй багш нарын 10, эрэгтэй багш нарын 8 хувь нь ганцаарчлан ажиллуулах аргуудыг хэрэглэхээр төлөвлөсөн байв. Харин эрэгтэй багш нарын 12 хувь, эмэгтэй багш нарын 4 хувь нь ямар арга хэрэглэхээ төлөвлөөгүй байв. Гэвч эрэгтэй, эмэгтэй багш нарт илэрхий ялгаа ажиглагдсангүй. Гэхдээ шинжлэн судлах арга зүйгээр хичээлээ явуулахаар төлөвлөсөн эмэгтэй багш нарын хувийн жин эрэгтэйгээс 3 дахин өндөр байна. (Зураг 11)

Зураг 11 Хөтөлбөрт төлөвлөгдсөн сургалтын аргууд, багшийн хүйсээр




Хөтөлбөртөө тодорхой нэр бүхий дараах техникийг хэрэглэхээр төлөвлөсөн байв. Үүнд:

- хамтарч ажиллах,
- асуудал шийдвэрлэх
- тайлбарлан таниулах
- лекцлэх,
- ганцаарчлан ажиллуулах,
- дасгал бодлого ажиллуулах,
- багаар ажиллах,
- марафон бичлэг
- харилцан ярилцах,
- шинжлэн судлах,
- энгийн туршилт хийх,
- шоо хаях
- гэрлэн дохио ашиглах
- задлага, нийлэг хийх арга
- тоглоомын арга
- ажлын хуудас дээр ажиллах г.м


Хөтөлбөрт сурагчийг сургалтад идэвхтэй оролцох эсвэл идэвхгүй байхаар тусгасан байдлыг тодруулсан юм. Ингэхдээ хэрэв сурагч багшаас төдийлөн хамаарахгүйгээр бие даан суралцаж байгаа бол **идэвхтэй**, багшаас бүрэн хамаарахгүйгээр суралцах боломжийг бүрдүүлсэн бол **холимог**, багшаас бүрэн хамаарч дагаж, дуурайж суралцаж байгаа бол **идэвхгүй** байна гэж үзсэн. Багш нарын дунд холимог загвараар сурагчдын үйл ажиллагааг төлөвлөсөн нь зонхилж байна. Харин охид, хөвгүүдийн оролцоог хангах талаар хэр анхаарсныг тодруулахад нийт эмэгтэй багш нарын 78, эрэгтэй багш нарын 40 хувь нь нийт сурагчдыг хичээлдээ татан оролцуулах үйл ажиллагааг, эмэгтэй багш нарын 7.4 хувь нь сурагч бүрийг хичээлдээ татан оролцуулахаар, харин эрэгтэй багш нарын 53.38 эмэгтэй багш нарын 14.8 хувь нь сурагчдын үйл ажиллагааг бус хичээлийн агуулгаа төлөвлөжээ. Түүнчлэн хичээлийн үйл ажиллагаагаа огт төлөвлөөгүй багш нар 6.7 хувийг эзэлж байгаа ба бүгд эрэгтэй багш байв. Мөн сурагч бүртэй ажиллах үйл ажиллагааг төлөвлөсөн нэг ч эрэгтэй багш таараагүй ажээ. Судалгааны дүнгээс харахад багш нарын хөтөлбөртөө нэрлээд бичсэн сургалтын аргуудын нэр ба сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт хооронд уялдаагүй байдал ажиглагдаж байна (Зураг 3.1, 3.2, 3.3). Хөтөлбөрийг төлөвлөх, ялангуяа сурагч төвтэй үйл ажиллагааг төлөвлөх талаар эрэгтэй багш нар дутмаг ажиллаж байна. Харин

багш нарын дунд энэ талаар ямар хичээл заадгаас хамаарсан ялгаа ажиглагдсангүй.

Зураг 12 Сурагчдын сурах үйлийг төлөвлөсөн байдал




Зураг 13 Охид, хөвгүүдийн сурах үйл ажиллагааг төлөвлөсөн байдал



Сурагч бүрийг сургалтад оролцуулахад хүүхдүүдийн онцлог хэрэгцээг харгалзсан үйл ажиллагаануудыг төлөвлөх нь чухал. Хөтөлбөрт дүн шинжилгээ хийж үзэхэд эрэгтэй багш нарын 93 хувь, эмэгтэй багш нарын 74 хувь нь хүүхдийн онцлогийг харгалзсан үйл ажиллагааг огт төлөвлөдөггүй ажээ. Харин эмэгтэй багш нарын 11 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн, мөн адил хувь нь сурлагаар хоцорч буй хүүхэдтэй ажиллах, эрэгтэй багш нарын 7 хувь нь тодорхой нэр бүхий (ярилцлагын мэдээллээс: шилжиж ирсэн эсвэл залхуураад орших гэдэг г.м) сурагчтай ажиллахаар төлөвлөсөн байв. Энэ нь хүүхэд бүрийн бүтээлч сэтгэлгээ, сурах арга барилыг хөгжүүлэх цөм хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой багшийн хөтөлбөрт тусаж байгаа эсэхэд эргэлзэх эргэлзээг төрүүлж байна. Өөрөөр хэлбэл хөтөлбөрийн үзэл баримтлал багш, сурагчдын бодит үйл хэргээр хэрэгжих бус, цаасан дээр л байгаа юм биш биз гэсэн асуудлыг хөтөлбөрийн шинжилгээний үр дүнгээр дэвшүүлж байна (хичээлийг ажигласан судалгаагаар энэ асуулт тодорхой хариулагдах юм). Асуулгын судалгаанд оролцсон багш нар сурагч бүрийн хэрэгцээ, сонирхлыг хөтөлбөр боловсруулж, сургалт явуулахдаа хэр харгалзаж байгаа талаар хариулахдаа үндсэндээ 2 том бүлэгт хуваагджээ. Эхнийх нь, тухайн насны сурагчийн нийтлэг онцлог, хэрэгцээ, сонирхлыг ерөнхийд нь тооцдог, хоёр дахь хэсэг нь сурагч бүрийн хэрэгцээ сонирхлыг тодруулан, түүнд тохируулсан үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлдэг гэсэн 2 бүлэг зонхилж байна. Эндээс багш нарын асуулгын хариулт ба төлөвлөсөн хөтөлбөр хооронд зөрөөтэй байдал ажиглагдаж байна. Багш нар сурагч бүрийн онцлогийг харгалзах тухай ярьж эхэлсэн хэдий ч, бодит байдал дээр хэрэгжүүлэх арга зүй, аргачлалын мэдлэг, чадвар дутаж, чадавхийг бэхжүүлэх шат дараалсан арга хэмжээ хэрэгжүүлэх хэрэгцээ байгааг эдгээр баримтууд харуулж байна.

Зураг 14 Хичээлийн хөтөлбөртөө сурагчийн хэрэгцээ, сонирхлыг тусгаж буй байдал, багш нарын асуулгад хариулсан дүнгээр (n=492)



Эмэгтэй багш нарын тавны нэг нь, эрэгтэй багш нарын гуравны нэг нь хөтөлбөртөө хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх ерөнхий зарчмыг тусгасан байдаг бөгөөд ялгаварлан гадуурхалтын хэлбэрүүд, тэдгээрийн эсрэг авах арга хэмжээнүүдийг оруулсан багш нэг ч байсангүй.

### 3.2.2 Хөтөлбөрийн агуулга ба жендэрийн асуудлууд

Хөтөлбөрөөр судлах бүх агуулгыг охид, хөвгүүд адил тэгшээр судлах боломж бүрдсэн эсэх нь жендэрийн тэгш байдлыг тогтооход чухал үүрэгтэй. Хөтөлбөрийн агуулга дахь жендэрээр тусгаарлагдсан, ялгагдсан агуулга бий эсэхийг судалгаагаар тодруулав. Судлагдсан бүх сургуульд Дизайн технологийн хичээлийн зураг зүйгээс бусад агуулгыг охид, хөвгүүдээр тусгаарлагдан судлахаар төлөвлөж, зохион байгуулдаг уламжлал өнөө хэр хадгалагдсан хэвээр байв. Үндэсний хэмжээний хөтөлбөрт дүн шинжилгээ хийхэд хүйсээр тусгаарлагдан судлах нэг ч судлагдахуун байгаагүй бол бодит амьдрал дээр эсрэгээрээ хэрэгжиж байна. Энэ нь өрхийн хөдөлмөрийн болон ажил мэргэжлийн жендэрийн хуваарилалтын уламжлалт хэвшмэл ойлголтоор хадгалагдаж байгааг нотлон харуулж байна. Жендэрийн тэгш байдлыг тогтоохтой холбоотой охид, хөвгүүдийн уламжлалт бус мэргэжил сонголтыг дэмжих, өрх гэр бүл дэх үүрэг оролцоог өөрчлөх хэрэгцээг ийм нөхцөлд хэрхэн хангаж чадах вэ?

Судлагдсан хөтөлбөрүүдийн агуулгын 64 хувьд нь нийгмийн тодорхой бүлгүүд (эрэгтэй, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ЛГБТ хүн, үндэстний цөөнхийн г.м)-ийн асуудлуудыг огт хөнддөггүй байдал ажиглагдав. Үлдэх 36 хувь нь үндэстний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүн, эрэгтэйчүүдийн асуудалд анхаарчээ. Гол төлөв нийгэм-хүмүүнлэгийн ухааны хичээлүүдэд эдгээр бүлгүүдийг судлах агуулга тусгагддаг аж. Эдгээр бүлгүүдийн асуудлуудыг зөвхөн нэг талаас гэхээсээ олон ургальч хандлагаар авч үзэж байгаа нь сайшаалтай.

Судлагдсан хөтөлбөрүүдийн зөвхөн 7 орчим хувийнх нь агуулгад жендэртэй холбоотой сэдэв тусгагджээ. Энэ нь нийгмийн ухааны хичээлд хүний эрх, газар зүйн хичээлд тогтвортой хөгжил сэдвийн хүрээнд дунджаар 5 цагийн хүрээнд заагдаж байгаа ажээ.

Багш нарын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн дэх жендэрийн үүргийг тодорхойлох ажил эмпирик нөхцөлд хүндрэлтэй байв. Учир нь судлагдсан хөтөлбөрүүдийн дийлэнхэд тодорхой хүний дүрүүд дурдагдсангүй. Ялангуяа математик, байгалийн ухааны хичээлийн хөтөлбөрийн агуулгад

шинжилгээ хийх боломжгүй байв. Харин монгол хэл, нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийж болохуйц бага зэргийн мэдээлэл олдсон юм. Сурах бичгийн нэгэн адил эмэгтэй хүн эрэгтэйтэй харьцуулахад цөөхөн дүрслэгджээ. Доорх хүснэгтэд хөтөлбөрийн агуулга, хөтөлбөрийн хэрэглэгдэхүүний агуулгад эрэгтэй, эмэгтэй хүнийг дүрслэхдээ жендэрийн хэвшмэл ойлголтын үүднээс илүүтэй тодорхойлсон болохыг харуулж байна.

Хүснэгт 22 Сургалтын хэрэглэгдэхүүн дэх жендэрийн дүр үүрэг, шинжүүд (судлагдсан багш нарын хөтөлбөр дэх агуулгын шинжилгээний үр дүнгээс)

Эмэгтэй хүний үүрэг, шинж	Эрэгтэй хүний үүрэг
- Настай эмэгтэй	- Эдийн засгийн идэвхтэй
- Манлайлагч	- Манлайлагч
- Ээж	- Түүхэн зүтгэлтэн
- Насанд хүрсэн эмэгтэй	- Аав
- Охин	- Насанд хүрсэн эрэгтэй
- Гэрийн эзэгтэй	- Гэмт хэрэгтэн
- Халамжлагч	- Хөвгүүн
- Өөртөө итгэлтэй	- Өөртөө итгэлтэй
- Дуулгавартай г.м.	- Сэргэлэн сониуч
	- Дуулгавартай г.м.

Тухайлбал, 10-р ангийн монгол хэлний хичээлийн хүрээнд “Хөрөг” бичих агуулга бүхий хөтөлбөрийг төлөвлөсний дагуу сурагчдад “Шилийн сайн эр: Торой Банди”-ийн тухай хөрөг бичих даалгавар өгчээ. Баячуудын мал хөрөнгийг хулгайлан, ядуучуудад тараадаг ардын домог Торой бандийн тухай бэлтгэсэн мэдээлэл нь эрэгтэй хүний талаарх зоригтой, баатарлаг эр хүний уламжлалт дүрээр харуулсан байв. Түүхэн зүтгэлтнийг зөвхөн нэг талаас нь буюу магтан дуулсан нэмэлт материалыг хичээлдээ ашигласан бөгөөд ёс зүйн хувьд буруушаагдах ёстой үйл хэргийг шүүмжлэлтэйгээр харах боломжийг хүүхдэд олгоогүй байв.

Хөтөлбөрийн үнэлгээний хэсэгт хүйсээр ялгаварлан гадуурхахын эсрэг зарчмыг нэг ч багш хөтөлбөртөө оруулсангүй. Сурагч бүрт үнэлгээний даалгаврын төрөл, хэлбэрийг сонгох боломжийг эмэгтэй багш нарын 37 хувь, эрэгтэй багш нарын 40 хувь нь олгосон байгаа нь сайшаалтай. Ингэхдээ тухайн сурагч өөрийн чадварын хөгжлийн түвшнээс хамааруулах эсвэл өөрийн сонирхолд тулгуурлан даалгаврын сэдэв, хэлбэрээ сонгох боломжийг олгоход анхаарчээ. Мөн багаа нээлттэй бүрдүүлэн, өөрсдийн үзэл бодол, дүгнэлтээ үндэслэлтэй хамгаалах боломжийг бүрдүүлсэн нь бусадтайгаа хамтран ажиллах, цаашлаад аливаад үндэслэлтэй хандах, бусдыг үзэл бодлыг сонсох, хүндэтгэх хандлага төлөвшүүлэхэд эерэг нөлөөтэй юм.

Бүх багш сургалтын үндсэн хэрэглэгдэхүүнээр сурах бичиг, багшийн номоо ашиглаж байна. Эдгээр нь бүгд эрэгтэй, эмэгтэй зохиогчдын хамтын бүтээл юм. Цөөн тооны багш нар нэмэлт ном бүтээл ашиглаж байсан бөгөөд бүгд эрэгтэй зохиогчтой байв. Харин жендэртэй холбоотой агуулга бүхий бүтээл ашигласан нэг ч багш таарсангүй болно.

### 3.3 Сурах бичигт хийсэн жендэрийн дүн шинжилгээ: Монгол хэл, нийгмийн ухаан

#### 3.3.1 Сурах бичгийг зохиох үйл явц

БСШУ-ны сайдын 2009 оны 131-р тушаалаар “Сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам” батлагдсан бөгөөд түүнд зааснаар БСШУЯ жил бүр шинээр болон дахин хэвлэх сурах бичгийн жагсаалтыг батлах ба зохиогчийн эрхийг тус яам эзэмшихээр тогтоожээ. 2005-2009 онуудад хувилбарт сурах бичиг хэрэглэсэн боловч ард иргэдийн эдийн засгийн байдал, сурах бичгийн сонголт дахь багш нарын оролцоо дутмаг, агуулгаас хамааралтай хөтөлбөр хэрэгжиж байсан зэрэг шалтгааны улмаас зогсоосон байдаг. Иймд одоогоор уг журамд тодорхой байдлаар тусгаагүй ч,



ЕБС-иудад албан ёсоор нэг л төрлийн сурах бичиг ашиглах ёстой.

Сурах бичгийн эхийг зохиогчийн баг зохиох ёстой. Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичиг тавигдах шаардлага (MNS 5418:2008) стандартад зааснаар зохиогчийн багт сурах бичиг судлаач, арга зүйч, мэргэжлийн багш, редактор, дизайнер нарын хүмүүс багтахыг заажээ. Сурах бичгийн зохиогчдын багийг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгодог байсан бол 2014 оноос хойш цөм хөтөлбөрийн багийн гишүүдээс зохиогчдыг сонгон ажиллуулах болсон. Харин хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх компаниудын дунд нээлттэй тендэр зарлан, сонгон ажиллуулж байна.

Тус стандартад зааснаар сурах бичгийн зохиогч, шинжээчид боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцсэн, сурах бичгийн сургалтад хамрагдсан, багшийн ажлын дадлага туршлагатай, мэргэжил, арга зүйн ёс зүйтэй, сонирхлын зөрчилгүй багш, арга зүйч, судлаач, эрдэмтэн, мэргэжилтэн ажиллана хэмээн заажээ. Сурах бичгийн зохиогч, редакторуудын дийлэнх нь БМДИ, ШХА-аас зохион байгуулдаг “Тогтвортой хөгжлийн боловсрол” сургалтад хамрагджээ. Тус сургалтын хүрээнд тэд жендэрийн асуудлыг бага хэмжээгээр судалсан байна. Манай судалгааны бүлгийн ярилцлагад оролцогчдын дийлэнх нь жендэрийн талаарх ойлголт, жендэрийг харгалзсан сурган хүмүүжүүлэхүйн талаар туршлага хомс болохоо илэрхийлсэн юм.

Хэвлэлийн шинжээчид хэвлэлийн ажлын туршлагатай байх шаардлага тавигддаг байна.

Тус стандартад зааснаар

- Боловсрол эзэмших тэгш байдлыг хангасан байх,
- Үндэсний хэл, сэтгэлгээ, түүх, соёлын онцлогийг хүн төрөлхтний дэвшилтэт үнэт зүйлстэй хослуулсан байх ерөнхий шаардлагуудыг тогтоожээ.

Агуулга хийгээд арга зүйд тавигдах шаардлагад “сурагчдын хэрэгцээ, сонирхолд нийцэх, харгалзах”<sup>58</sup> тухай багтсан байдаг. Дурдсан шаардлагууд нь ерөнхий утгаараа охид, хөвгүүдэд адил тэгш боломж олгох, охид, хөвгүүдийн хэрэгцээ сонирхолд тулгуурлах зэрэг утгыг агуулж байна гэж үзэж болох юм. Эдгээрээс өөрөөр жендэрт холбоотой ямар нэгэн заалт уг стандартад тусгагдаагүй байна. Жендэрт холбогдох шаардлага тавигдаагүй байгаа нь сурах бичгийн агуулга, зураг дүрслэл, үг сонголтод жендэрийн өрөөсгөл хандлага, хэвшмэл ойлголт тусгагдах нөхцлийг бүрдүүлээд байна.

Сурах бичиг зохиогчдын багт Боловсролын хүрээлэнгийн сурах бичгийн сектороос арга зүйн дэмжлэг үзүүлэх ба ажлыг хэсэг байгуулан хөтөлбөр, стандартын дагуу бичигдэж байгаа эсэхэд явцын хяналт тавих ёстой<sup>59</sup> ажээ. Түүнчлэн сурах бичгийн агуулгын болон хэвлэлийн шинжээчид үнэлгээ хийж, гарсан саналын дагуу зохиогчдын баг зохих засварыг хийх ёстой. Сурах бичгийн секторын ажлын хэсгээс хэвлэх боломжтой гэж тооцогдсон сурах бичгийн эхийг яамны холбогдох нэгжид хүргэнэ. Тухайн нэгжээс хэвлэх боломжтой гэж үзсэн тохиолдолд шалгарсан хэвлэлийн компани эхийг бэлтгэх, хэвлэх, түгээх үүргийг хүлээн ажиллахаар журамлажээ. Сурах бичгийн журам, стандартад охид, хөвгүүдийн хэрэгцээ, онцлогийг судлах, турших зэрэг сурах бичгийн чанарт нөлөөлөх үйл ажиллагаанууд нь тусгагдаагүй, журамлагдаагүй болохыг анхаарууштай байна.

### 3.3.2 Сурах бичигт хийсэн жендэрийн дүн шинжилгээ

Одоогоор 2012 оноос хойш хэвлэгдсэн бага боловсролд 33, суурь боловсролд 62, бүрэн дунд

<sup>58</sup>Үндэсний стандартчлал, хэмжил зүйн газар (2008). MNS 5418:2008 Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичиг тавигдах шаардлага стандарт

<sup>59</sup> мөн тэнд

боловсролд 37 сурах бичиг, нийт 132 сурах бичгийг ашиглаж байна. Бидний судалгаа жендэрийн боловсролд шууд үүрэг хүлээх “Нийгмийн ухаан”, дам үүрэг хүлээх “Монгол хэл” хоёр судлагдахууны сурах бичгүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийв (Хүснэгт 3.6). Дүн шинжилгээг контент анализын аргын дагуу хийсэн бөгөөд сурах бичгийн зураг дүрслэл, эх (текст) дэх хүйсийн харьцаа, жендэрийн дүр үүрэг, сэтгэл зүйн шинжүүдээр жендэрийн линзийг ашиглан судаллаа.


Хүснэгт 23 Дүн шинжилгээ хийсэн сурах бичгийн нэрс, ангиар

Монгол хэл		Нийгмийн ухаан	
Сурах бичгийн нэр	Судлах анги	Сурах бичгийн нэр	Судлах анги
Монгол хэл I	1	Хүн-орчин	1
Монгол хэл V	5	Хүн ба нийгэм II	5
Монгол хэл VI	6	Нийгэм ухаан III	9
Монгол хэл IX	9	Нийгэм ухаан IV	10
Монгол хэл X	10	Нийгэм ухаан VI	12
Монгол хэл XII	12		

### 3.3.2.1 Сурах бичиг дэх хүйсийн харьцааг тодруулах нь

Судлагдсан сурах бичгүүдийг эрэгтэй, эмэгтэй зохиогчдын холимог бүрэлдэхүүнтэй багууд бичжээ.

Зураг 15 Сурах бичгийн зураг дүрслэл, текст дэх хүйсийн харьцаа, хувиар



Зураг 16 Хүн-Орчин 1 сурах бичиг дэх зураг дүрслэлийн жишээ (А.Энхтогтох, Г.Баярмаа)



Зураг 15-т сонгож судалсан Монгол хэл, нийгмийн ухааны сурах бичгүүдийн зураг дүрслэл болон эхэд туссан эрэгтэй эмэгтэй, хүмүүсийн хүйсийн харьцааг дундаж тоогоор харьцуулан харууллаа. Энэхүү баримт нь сурах бичигт дүрслэгдсэн эрэгтэй хүний тоо, эмэгтэйгээс бараг 2 дахин илүү болохыг харуулж байна. Энэ нь сурах бичгийн судлагдахууны ялгаа хийгээд дүрслэгдсэн хэлбэр (зураг эсвэл эхэд)-ээс төдийлөн хамаарахгүй болох нь ажиглагдав. Асуулгын судалгаагаар багш нараас энэ талаар тодруулахад 65 хувь нь тэнцвэртэй, 21 хувь нь анзаараагүй гэж хариулсан байв. Энэ нь зохиогчдын зүгээс санаатай гэхээсээ анзааралгүйгээр хүйсийн тэнцвэргүй дүрслэлийг оруулсан байх талтай. Иймд сурах бичгийн стандартад хүйсийн харьцааны шаардлага тусгаагүй нь сурах бичгүүд ийн бичигдэхэд

хүргэжээ гэж үзэх үндэслэл байна.

Бид сурах бичигт эрэгтэй, эрэгтэй эрдэмтдийн хэнийх нь тухай зураг, тайлбар зэргийг илүүтэй оруулдаг болохыг сонирхоход судлагдсан нийгмийн ухааны сурах бичгүүдэд нэг ч эмэгтэй эрдэмтний зураг байсангүй. Харин монгол хэлний сурах бичигт дүрслэгдсэн эмэгтэй эрдэмтний дундаж тоо 0.33 байхад эрэгтэй эрдэмтний дундаж тоо нь 10 (3.67) дахин илүү байлаа. Нийгмийн ухааны сурах бичгүүдэд дунджаар 17.0 тооны эрэгтэй эрдэмтдийн тухай тайлбарлан оруулсан бол эмэгтэйчүүдийн дундаж тоо 0.67 буюу 25 дахин цөөн байв. Монгол хэлний сурах бичигт үүнтэй төстэй (эрэгтэй-15.6, эмэгтэй- 1.0) дүр зураг ажиглагдав. Эндээс харахад судлагдсан сурах бичгүүд нь “эрдэмтэн судлаачид бол эрэгтэйчүүд” гэх ойлголтыг сурагчдад хүргэж байна.

Эрэгтэй, эмэгтэй хүний нэр хамгийн түрүүнд гарсан хуудасны дугаарыг харьцуулахад судлагдсан сурах бичгүүдэд эрэгтэй хүний нэр хамгийн түрүүнд 15 дугаар (дунджаар), харин эмэгтэй хүний нэр дунджаар 26 дугаар дугаар (дунджаар) хуудсанд гарсан байна. Судлагдсан сурах бичгүүдээс зөвхөн Нийгмийн ухаан – III буюу IX ангийн сурах бичигт эмэгтэй хүний нэр (19 дугаар хуудсанд, эрэгтэй нь 27 дугаар хуудсанд) эхэнд гарсан байна. Монгол хэл X сурах бичигт эрэгтэй хүний нэр 5 дугаар хуудсанд эхэлж гарсан атлаа эмэгтэй хүний нэр 41 дүгээр хуудсанд эхэлж дурдагдсан байх юм. Судалгааны дүнгээр, хэнийг эхэлж оруулах вэ гэдэгт жендэрийн өрөөсгөл хандлага ажиглагдаж байна.

Сурах бичигт ашигласан бүтээлүүдийн зохиогчдын хүйсийн харьцааг тодруулах оролдлого хийсэн юм. Зарим сурах бичигт ашигласан бүтээлийн жагсаалтыг оруулаагүй байсан нь дүн шинжилгээний хүрээг хязгаарлав. Гэхдээ ном зүйтэй сурах бичгүүдэд ашигласан бүтээлд эрэгтэй зохиогчтой бүтээл 18 (дунджаар) байхад эмэгтэй зохиогчтой бүтээл 3 (дунджаар), хамтарсан зохиогчтой бүтээл 2 (дунджаар) байлаа. Ер нь хэвлэгдсэн бүтээлүүдийн дийлэнхийг эрэгтэйчүүд зохиосон нь үүнд нөлөөлж байгаа ч, сурах бичиг зохиогчдын сонголт басхүү чухал үүрэгтэй.

Зураг 17 Сурах бичигт ашигласан эхийн жагсаалт (Өнөрбаян Ц, Жумдаан Л, Мөнхсайхан Ж нар (2015) Монгол хэл-VI, Улаанбаатар, 44 дүгээр тал



Тус сурах бичигт нийт 87 эхийг ашигласныг 144-р хуудсанд нэгтгэн гаргажээ. Үүнээс зөвхөн гурван эмэгтэй зохиолчийн бүтээлийг ашигласан байна. Жендэрийн тэгш эрх, тэгш байдлын асуудлыг хөндсөн бүтээл байгаагүй болно.

Ийнхүү сурах бичигт дүрслэгдсэн, өгүүлэгдсэн, ишлэгдсэн хүмүүст эрэгтэйчүүд хэт давамгайлж буй өрөөсгөл хандлага ажиглагдаж байна. Судалгааны үр дүнд тулгуурлан

зөвлөмжлөхөд сурах бичгийн стандартад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хүйсийн тэнцвэртэй харьцаатайгаар дүрслэх тухай заалтыг оруулах шаардлагатай байна.

### 3.3.3 Сурах бичиг дэх жендэрийн дүр-үүргийн шинжилгээ

Юуны түрүүнд зураг, дүрслэл дэх эрэгтэй, эмэгтэй хүний дүр үүргийг хэрхэн гаргасныг

тодруулахад хөвгүүн (32.99%), насанд хүрсэн хүн (15.19%), ажил хийж байгаа (11.6%), тоглож, хичээл хийж байгаа (9.15%), бусдыг халамжилж байгаа (6.83%), манлайлагч (5.26%)-ийн дүрээр дүрслэн харуулжээ. Харин эхэд яригч, илтгэгч (21.29%), хөвгүүн (10.57%), манлайлагч (10.09%), аав (8.74%), насанд хүрсэн эр хүн (7.93%), тоглож, хичээл хийж байгаа (6.58)-гаар дүрслэн харуулах нь бусад дүрээс илүү олон ажиглагдав. Харин эмэгтэйчүүдийн хувьд зураг, дүрслэлд охин (39.46%), насанд хүрсэн эмэгтэй (13.42%), гэрийн ажил хийж байгаа (9.38), хичээл хийж, тоглож байгаагаар (11.26%) дүрслэн харуулах нь бусад дүрүүдээс илүү зонхилж байна. Харин эхэд охин (16.03%), эмгэн (12.02), гэрийн ажил хийж буй (7.73%), насанд хүрсэн эмэгтэй (6.58%), манлайлагчаар (6.30%) дүрсэлсэн ажээ.

Хүйсээр харьцуулахад эмэгтэй хүний ээж, эмгэн (эмээ), охин, гэрийн ажил хийж буй хүн, хорон санаатны дүрүүдээр эх хийгээд зураг дүрслэлд эрэгтэйчүүдээс илүү дүрслэгдсэн байхад эрэгтэй хүний насанд хүрсэн эрэгтэй, манлайлагч, түүхэн зүтгэлтний дүрүүдээр эмэгтэйчүүдээс илүү олноор илэрч байна (Хүснэгт 3.7). Цаашлаад эхэд эрэгтэй хүнийг уламжлалт дүрээр илэрхийлсэн нь 49.98 хувь, эмэгтэй хүнийг ийнхүү дүрсэлсэн нь 31.49 хувийн дүнтэй байна. Зураг дүрслэлд эрэгтэй хүний дүрийн 23.2 хувь, эмэгтэй хүний 17.96 хувь уламжлалт дүрээр дүрслэгджээ. Зураг дүрслэлээр эрэгтэй, эмэгтэй хүнийг гол төлөв төвийг сахисан дүрээр илэрхийлж байгаа бол эхэд эрэгтэй хүнийг уламжлалт дүр төрхөөр голдуу харуулжээ. Мөн эмэгтэй хүнийг уламжлалт загвараар дүрслэх нь эрэгтэй хүнтэй харьцуулахад харьцангуй бага аж.

Харин зураг дүрслэл хийгээд эхэд зарим дүрүүд ялгаатайгаар дүрслэгдэж байна. Үүнд: зураг дүрслэлд эрэгтэй хүнийг ажил хийж байгаагаар дүрслэх нь эмэгтэйгээс олон бол эхэд эсрэг дүр зураг илэрлээ. Бусдыг асран халамжилж буй дүр төрх зураг дүрслэлд эрэгтэй, эхэд эмэгтэй илүүтэй ажиглагдав. Гүйцэтгэгч эрэгтэй дүр эхээсээ зураг дүрслэлд дүрслэгдэх нь олон байв. Ийнхүү ажиллагч эмэгтэйн дүр эхэд, халамжлагч эрэгтэйн дүр зураг, дүрслэлд илүүтэй харагдаж байна. Сонсогч, гүйцэтгэгчдийн хувьд үүнтэй төстэй дүн үзүүлж байгаа ч эрэгтэй, эмэгтэй хүнийг уламжлалт бус дүрээр харуулах нь уламжлалт дүрээр харуулахаас арай бага хувийн жин (зураг, дүрслэлд эрэгтэй - 12.96%, эмэгтэй – 8.34%, эхэд эр – 12.05, эм – 19.13%) эзэлж байна. Эхэд эмэгтэй хүнийг уламжлалт бус дүрээр дүрслэх нь эрэгтэйгээсээ, зураг дүрслэлд эрэгтэйг уламжлалт бус дүрээр дүрслэх нь эмэгтэйгээсээ их байна. Энэ бүхэн нь жендэрийн уламжлалт хэвшмэл дүр үүрэг тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж байгааг харуулах юм.

Хүснэгт 24 Сурах бичгийн зураг дүрслэл, эх дэх жендэрийн дүр үүргүүд (хувиар, агуулгын шинжилгээ)

Жендэрийн дүр үүрэг	Зураг дахь эрэгтэй дүрийн хувь	Эх дэх эрэгтэй дүрийн хувь	Жендэрийн дүр үүрэг	Зураг дахь эмэгтэй дүрийн хувь	Эх дэх эмэгтэй дүрийн хувь
<b>Уламжлалт</b>	<b>23.2</b>	<b>49.98</b>	<b>Уламжлалт</b>	<b>17.96</b>	<b>31.49</b>
Аав	1.97	8.74	Ээж	3.96	16.03
Ажил хийж байгаа	11.60	2.86	Гэрийн ажил хийж байгаа	9.38	7.73
Манлайлагч	5.26	10.09	Бусдыг асрамжилж байгаа	1.04	4.29
Түүхэн зүтгэлтэн	1.62	5.04	Сонсогч	1.74	1.72
Илтгэгч	0.82	21.29	Гүйцэтгэгч	1.82	1.72
Баатар, гавьяа байгуулагч	1.93	1.96			
<b>Уламжлалт бус</b>	<b>12.96</b>	<b>12.05</b>	<b>Уламжлалт бус</b>	<b>8.34</b>	<b>19.13</b>
Гэрийн ажил хийж байгаа	0.91	4.20	Ажил хийж байгаа	1.56	5.84
Бусдыг асрамжилж	6.83	1.96	Манлайлагч	1.56	6.30

байгаа					
Сонсогч	2.22	5.04	Түүхэн зүтгэлтэн	1.04	2.40
Гүйцэтгэгч	3.00	0.84	Илтгэгч	1.74	2.87
			Баатар гавьяа байгуулагч	2.43	1.72
<b>Төвийг сахьсан</b>	<b>63.84</b>	<b>37.97</b>	<b>Төвийг сахьсан</b>	<b>73.7</b>	<b>49.38</b>
Насанд хүрсэн эрэгтэй	15.19	7.93	Насанд хүрсэн эмэгтэй	13.42	6.58
Настай эрэгтэй	2.63	5.88	Охин	39.46	21.04
Хөвгүүн	32.99	10.57	Настай эмэгтэй	4.35	12.02
Хорон санаатан	0.68	1.68	Хорон санаатан	1.56	3.44
Амарч байгаа	3.21	5.32	Амарч байгаа	3.65	5.15
Бусад	9.15	6.58	Бусад	11.26	1.15
<b>Нийт</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>Нийт</b>	<b>100</b>	<b>100</b>

Зураг 18 Охид, хөвгүүдийг дүрсэлсэн байдал (Олзвой Л ба бусад (2014) Монгол хэл, Улаанбаатар, 60; 63 дугаар тал)

**"Адтай жаалууд" киноны Гэгээлэн буюу Ц.Хулан**  
 Цэрэндоржийн Хулан нь бага, дунд насныханд зориулсан "Адтай жаалууд" киноны Гэгээлэн нэртэй охины дүрд амжилттай тоглосон.  
 Тэрээр "Монгени" сургуулийн 8а ангид сурдаг бөгөөд "Лоолойгийн найзууд" нэвтрүүлгийн хөтөлгөчийн дугуйлангийн дэргэдэх "LN" нэртэй охидын хамтлагт дуулдаг аж. Мөн тэрээр Монголын хүүхдийн байгууллагын "Авьяас" алтан медаль хүртэж байжээ. Үе тэгийгхэндээ үлгэр дуурайлал болж буй Ц.Хулан хоёр дүүтэй бөгөөд гэр бүлийнхэндээ ч багагүй анхаарал тавьдаг, халамжтай хүүхэд гэнэ.

**"TV9" телевиз**

**2. Дээрх хоёр эхийг харьцууль.**  
 (1) Дээрх хоёр эхийг харьцуулан ялгаатай болон ижил талыг бичье.

Ялгаатай тал	Ижил тал	Ялгаатай тал
"Адтай жаалууд-3" кино нээлтээ хийлээ 1. Сонины мэдээ 2. ....	Хоёр эх 1. Мэдээ 2. ....	"Адтай жаалууд" киноны Гэгээлэн буюу Ц.Хулан 1. Телевизийн мэдээ 2. ....

**3. Уншсан хоёр эхийг харьцуулснаа дүгнэж бичье.**  
 (1) Батын дүгнэн бичсэнийг уншаад өөрийн дүгнэлтийг бичье.

Бат	Чинь дүгнэл
Уг хоёр эх нь "Адтай жаалууд" киноны тухай мэдээлснээрээ нэг сэдэвтэй. Харин сонин мэдээ, телевизийн мэдээ гэдгээрээ ялгаатай байна .... гэх мэт.	?

(2) Өөрийн бичсэнийг найддаа уншиж өгье.  
 (3) Найзынхаа уншсаныг сонсоод минийхээс өөр байвал тэмдэглэж авъя.

**Нэг сэдвийн хүрээнд үзсэн, сонссон зүйлээ харьцуулан дүгнэе.**

**1. Нэг сэдвийн хүрээнд үзсэн, сонссон хэд хэдэн зүйлийн тухай мэдээл цуглуулъя.**  
 (1) Нэг сэдвийн хүрээнд үзсэн, сонссон хэд хэдэн мэдээлэл цуглуулъя.  
 (2) Цуглуулсан мэдээллээ уншъя.

**2. Уншсан мэдээлэлүүдээ харьцуулъя.**  
 (1) Хоёр мэдээллийн ялгаатай ба ижил талыг ажиглая.  
 (2) Ялгаатай ба ижил талыг бичье.

Унших арга сонгохдоо имэдрэлд зэрэгтэй, шинэ, сонин авахвар, суримжтай мэдээг сонгоорой. Тухайлбал: илтгэл, хэлэлцүүлэг бичихэд хэрэгтэй, сонирхолтой санагдсан эх.

(4) Сонинд ахаа уншъя.  
 (5) Уншихдаа өөрт хэрэгтэй мэдээллийг тэмдэглэе.

**Есөн настай хүү найзынхаа амийг аварчээ**  
 Чингэлтэй дүүргийн 17-р сургуулийн сурагч Б.Тэмүүлэн хүү найзынхаа гэр бүлийг аюулаас аварчээ.  
 Тэр өдөр Б.Тэмүүлэн найзтайгаа тоглох гэж гэрл нь очивээ. Гэтэл түүний найз Бүрэнтөгс аав, ач, дүүгийн хамт бүгдээрээ галтай эргээд, дотроо нь муухайраад угзартсан байжээ. Эзж нь хагас ухаантай орон дээр хэвтэж байгаад Б.Тэмүүлэн хүүгээс утга гаргалж гуйжээ. Б.Тэмүүлэн хүү эзжийнх нь амьсгалыг дуулид уншсан байгаа гал дээр жаахан ус хийгээд хутган утга гаргажээ. Тэгээд найз Бүрэнтөгсийгөө босгож угаавар угсаа байна. Дараа нь 103 дуудан яаралтай арга хэмжээ авснаар найзынхаа гэр бүлийг аварчээ.

**Өдрийн сонин, 2013 он, №02, Солүүрт Н.Багираргал**

**2. Сониноос мэдээлэл хэрхэн цуглуулснаа найддаа танилцуулъя.**  
 (1) Дараах харилцан яриал утшаад хэрэгтэй мэдээлэл цуглуулах аргыг мэдье.

Сонинд хэрхэн тэй мэдээлэл цуглуулснаа ямар дарааллаар танилцуулъя?

1) Эхийг хоёр өсөнхөө авсан ба?  
 2) Сонинд хэдий нэрт?  
 3) Эхийн гол агуулга нь хуу аа?  
 4) Эхийг бичсэн сэтгүүлчийн нэрт?  
 5) Өөрт хэрэгтэй мэдээлэл нь хуу аа?  
 гэсэн дарааллаар танилцуулъя.

**3. Сонин сэтгүүлээс өөрт хэрэгтэй мэдээллийг цуглуулъя.**  
 1. Сонин уншиж хэрэгтэй эхийг сонгоё.  
 (1) Захиалагч сониндоо дуустал уншъя.  
 (2) Хэрэгтэй ахаа сонгоё.  
 (3) Сонгосон ахаа уншъя.  
 (4) Өөрт хэрэгтэй мэдээллийг олох тэмдэглэе.

“Адтай жаалууд” кинонд тоглосон Ц.Хулан охины тухай бичихдээ авьяас чадварыг нь онцолсны хамт түүний гэр бүлийнхэндээ халамжтай тухай өгүүлжээ. Мөн зургийн хэмжээ хүүгийн зурагтай харьцуулахад жижиг байв.

Найзынхаа амийг аварсан 9 настай Б.Тэмүүлэн хүүгийн найзынхаа гэр бүлийнхний амийг хэрхэн аварсан тухай бичсэн бөгөөд гэр бүлийнхэндээ хэр халамжтай тухай огт дурдаагүй аж. Зураг тод харагдахуйц бөгөөд хэмжээгээр том байв.

Харин гэрийн ажил хийж буй хүн, баатарлаг гавьяа байгуулагч, манлайлагчийн дүрд уламжлалт хандлага зураг, дүрслэлд төдийгүй эхэд бас ажиглагдаж байна. Харьцуулалт хийхэд эхэд зураг, дүрслэлээсээ эрэгтэй, эмэгтэй хүнийг уламжлалт дүрээр илэрхийлэх нь арай илүү харагдав. Энэ нь

Монгол хэлний хичээлд цаг хугацааны хувьд эрт бичигдсэн уран зохиолын дээжээс оруулдагтай холбоотой байж болох юм. Монгол хэлний сурах бичгүүдэд эх хэлний найруулга, бичлэгийн уламжлал шинэчлэлийг харуулах үүднээс түүхэн эх сурвалж, зохиол бүтээлийг ашиглах нь гарцаагүй ч, жендэрийн боловсролд эерэг нөлөөтэй “Чимбай нэрт Чамбай хатан” сэдэвт эхэд өгүүлсэнчлэн Их гүрний эзэн хаан Хувилай хаан хатныхаа ухааныг гайхан баясаж, хатныхаа өмнө буруугаа хүлээсэн тухай санаа бүхий эхээр дамжуулан жендэрийн эрх тэгш байдлын тухай санааг дамжуулах боломжтой<sup>60</sup>.

Зураг 19 Сурах бичиг дэх орос ардын үлгэр, бэлгэтэй сайхан үгсийн тухай дүрслэл (Оюунцэцэг болон бусад (2014) Монгол хэл I, УБ.,8; 145-р тал)

**Ойлог уншъя**

**Бэлгэтэй сайхан үгс**

Би зүүн хөдөө нэг, ороонгийндоо олон амраа,  
 тэвч намтай сайхалтын айлаар дагуулж явлаа.  
 Доной гуай гэрийнхээ гадна хонь хэрэгж суур,  
 Овоо Доной гуайтай мөндгээд  
 “Хайн нь хурц  
 Хаймалсан хонь нь мөнх түм хүрч бай” гэхэд  
 Доной гуай харьд нь “Мөр зохь” гэлээ.  
 Гэрт нь ортол Должин гуай цай саварч байв.  
 Пөөн малнь,  
 “Будалсан цай чинь бурал ботж  
 Буусан айл маань балч бол” гэв. Должин гуай  
 “Ерөөл бат оршиг” гэж хариуллаа. Намтайг хотоос  
 завчрсан “несэр жамсаа Должин гуайд өгөхөд  
 хурц гурдан авчад  
 “Уулзалс өндөр бэлгэтэй  
 Угшвалс түн эрдэмтэй болгоорой” гэж өргөмлөв.  
 Би харьд нь



“Хэн хэн юу гэж хэлсэн бэ?”

1. Хэн, юу гэсэн агуулгад хариулж/гэх үгсийг түүж бичье.

**Хүн**

**Юм**

2. Өгүүлбэрийг дугуйн биеээрэй.

*Ерөөл бат оршиг.*

**Угшвалс**

**Өргөмлөв**

145




8


Сурах бичиг дэх жендэрийн дүр үүргийн талаар шинжилгээ хийхдээ эрэгтэй, эмэгтэй хүний өрх гэр бүл дэх үүргийг хэрхэн дүрслэн оруулсан болохыг тодруулсан. Өрх гэр бүлдээ гүйцэтгэж байгаа эрэгтэй хүний үүрэг эмэгтэй хүнтэй харьцуулахад цөөн төрөлтэй байсан бөгөөд үүнд хүүхдийн боловсрол, хүмүүжилд анхаарал тавих (18.07%), мал хариулах (19.35%), хичээлээ хийх (15.48%), түлээ бэлтгэх (11.61%), мал саахад туслах (9.67%), хоол хийх (7.74%), эд хогшлоо засах (3.87%), хүүхэд асрах (2.59%) үүргүүдийг гүйцэтгэж байгаагаар дүрсэлжээ. Харин эмэгтэй хүн маш олон төрлийн үүрэг хүлээж байгаагаар сурах бичигт туссан аж. Үүнд хичээл хийж байгаа (19.73%), мал сааж байгаа (13.17%), хүүхэд асрах (10.05%), хүүхдийн боловсрол, хүмүүжилд анхаарал тавих (10.76%), хоол хийх (5.38%), хүүхдээ зөөх, хүүхэдтэйгээ тоглох, гэр цэвэрлэх, оёх, ус авах бүхий л төрлийн хөдөлмөр хийж байгаа нь туссан байна. Энэхүү дүн нь эрэгтэй, эмэгтэйчүүдийг дүрслэн харуулахдаа зарим талаар уламжлалт бус дүр төрхийг харуулж байгаа ч, дийлэнх тохиолдолд уламжлалт дүр үүргээр дүрсэлж байгааг нотолж байна. Дээрх зургаас (Фото зураг 3.3) хоол, цай бэлтгэж буй эмээ, өнхрүүш боов хийж өгнө үү хэмээж буй өвөө нарыг уламжлалт хэвшмэл загварын дагуу дүрслэн сурах бичигт оруулсныг жишээлэн харж болно.

<sup>60</sup>Өнөрбаян Ц, Жумдаан Г, Мөнхсайхан Ж (2013) Монгол хэл-6. УБ., 87-88 дугаар тал

Зураг 20 Сурах бичиг дэх жендэрийн дүр үүрэг (эсрэгцэлсэн дүрүүдээр, хувиар)



Зураг 21 Сурах бичгийн эх дэх нөхөн үржихүйн болон үйлдвэрлэлийн дүр үүрэг (хүйсээр, хувиар)




Сурах бичгүүдэд жендэрийн дүр үүргийг дэлгэрэнгүй хэлбэрээр авч үзсэнээс гадна эсрэгцэлсэн дараах дүрүүд эхэд хэрхэн илэрч байгааг тодруулсан. Энэхүү эсрэгцэлсэн дүрүүдээс харахад сурах бичигт уламжлалт хэвшмэл ойлголт тодорхой хэмжээгээр ажиглагдаж байна гэж үзэх үндэслэл байна. Учир нь халамжлан хүмүүжүүлэгч болон гүйцэтгэгчийг эмэгтэй, манлайлагчийг эрэгтэй гэж дүрслэх нь олонтаа байна. Харин эдийн засгийн идэвхтэй субъектэд хүйсийн ялгаа төдийлөн ажиглагдаагүй нь монгол эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин өндөр буюу “ажилтан эмэгтэй” нь эмэгтэйчүүдийн нийтлэг загвар болдогтой холбогдох юм. Сурах бичгүүдэд гэм буруутнаар дүрсэлсэн эмэгтэйчүүдийн дундаж тоо эрэгтэйчүүдийнхээс өндөр, эсрэгээрээ хохирогчоор эрэгтэйчүүдийг илүүтэй дүрсэлсэн байна (Зураг 3.10).

Хэдийгээр эрэгтэй, эмэгтэйчүүд хоёулаа үйлдвэрлэлийн үүрэгтэйгээр илүүтэй дүрслэгдэж байгаа ч, нөхөн үржихүйн үүрэгтэйгээр дүрслэгдсэн эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс 5 дахин илүү, үйлдвэрлэлийн үүрэгтэйгээр дүрслэгдсэн эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс бараг 2 дахин илүү байна. (Зураг 3.11). Энэ нь сурах бичиг дэх эрэгтэй, эмэгтэйчүүдийн дүрийг хэвшмэл ойлголтын үүднээс дүрсэлж байгааг тодорхой хэмжээгээр харуулах юм.

Сурах бичгүүдэд дүрслэгдсэн эрэгтэй хүний ажил мэргэжлийн нэр төрөл эмэгтэйчүүдийнхээс 2.5 дахин олон төрлийн байна. Эмэгтэйчүүдийг гол төлөв багш, саальчин, худалдагч, малчин, сэтгүүлч, үйлдвэрийн ажилчин, ажилтан, яруу найрагч, зохиолч, номын санч, судлаач (физикч, химич г.м), эмч зэрэг ажил мэргэжил эрхэлж байгаагаар харуулсан байна. Эдгээрийн дотор эрэгтэйчүүдийнх (физикчээс бусад) гэхүйц ажил мэргэжлүүдийг бараг багтаагаагүй ажээ. Харин эрэгтэйчүүдийг маш олон төрлийн ажил мэргэжил эрхэлж байгаагийн дотор улсын хаан, ерөнхийлөгчөөс эхлээд

жирийн ажилчин зэргээр олон янзын дүрээр дүрсэлсэн байна. Худалдагч, эмч, багшаас бусад нь эрэгтэйчүүдийн, аль ч хүйсийн хүмүүс эрхэлдэг ажлууд багтжээ. Эмэгтэйчүүдийн эрхэлж буй ажил мэргэжил дотор нэг ч удирдах түвшний ажил мэргэжил багтаагүй байв. Мөн л ажил мэргэжлүүдэд жендэрийн хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлага ажиглагдаж байна.

Зураг 22 Сурах бичиг дэх эрэгтэй, эмэгтэй хүнийг дүрсэлсэн газар (дунджаар)



Зураг 23 Жендэрчлэгдсэн зураг дүрслэл (Алтанзаяа ба бусад (2012) Нийгмийн ухаан IV. 23, 111, 131-р тал)



Эхэд эмэгтэй, эрэгтэй хүнийг хамгийн их дүрсэлсэн газар нь байгаль, нийтийн амралт, зугаалгын газар, эмэгтэй хүнийг албан хэргийн газар, эрэгтэй хүнийг гэрт хамгийн цөөнөөр дүрсэлжээ. Зураг дүрслэлд эрэгтэй хүнийг хамгийн ихээр дүрсэлсэн газар нь албан хэргийн газар болон байгаль, олон нийтийн зугаалгын газар, гэрт хамгийн цөөхнөөр харуулжээ. Гэтэл эмэгтэй хүнийг албан хэргийн газар хамгийн олонтаа, гэрт хамгийн цөөхнөөр дүрсэлсэн бөгөөд эх хийгээд зураг дүрслэлд бага зэргийн ялгаа ажиглагдлаа. Эрэгтэй хүний хувьд хэлбэрийн (зураг дүрслэл хийгээд эх) хувьд ялгаа бараг ажиглагдсангүй (Зураг 3.12). Эрэгтэйчүүдийг дүрслэхдээ илүү уламжлалт хандлагаар, эмэгтэйчүүдийг эхэд уламжлалт, зурагт уламжлалт бус хандлагаар харуулжээ. Ер нь албан хэргийн газар дүрслэгдэж буй эрэгтэй хүний тоо ямагт эмэгтэй хүнээс илүүрхэж байгаа тул жендэрийн хэвшмэл хандлага тодорхой

хэмжээнд ажиглагдаж байна гэж үзэх боломж буй. Нөгөө талаас судалгаанд хамрагдсан багш, сурагчдаас ”гэдний ашиглаж буй сурах бичигт эрэгтэй, эмэгтэй хүнийг хэрхэн дүрсэлсэн байдаг” талаар тодруулахад дээрх дүн шинжилгээний дүнгээс ялгаатай байсан бөгөөд тэнцвэртэй, адил тэгш эрхтэй, хэвшмэл бус дүр төрхөөр дүрсэлсэн гэх хариултауд зонхилж байв.

### 3.3.4 Сурах бичиг дэх жендэрийн ялгаанд холбогдох бусад асуудлууд


Бид сурах бичгийн зураг, дүрслэлд шинжилгээ хийхдээ эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг дүрслэн харуулж буй бие махбодийн дүр төрхөд хэр ялгаа илэрч байгааг тодруулахыг зорьсон юм. Ингэхдээ хэвлэлийн чанараас хамаараад гадаад дүр төрхийн нарийвчилсан шинжилгээ хийх нь хүндрэлтэй



байв. Эрэгтэйчүүдийг дүрслэхдээ ихэнх тохиолдолд богино халимагтайгаар, маш цөөхөн тохиолдолд урт үстэйгээр дүрсэлсэн бол эмэгтэйчүүдийг богино, урт үстэйгээр аль алианаар нь дүрсэлсэн ч, урт үстэй дүрслэл зонхилж байв. Өндөр, нам, тарган, туранхай, булчинлаг эсэхэд хүйсийн ялгаа төдийлөн ажиглагдаагүй ч, удирдах ажил эрхэлж буй хүнийг дүрслэхдээ “тарган” эрэгтэй хүнийг харуулсан нэлээдгүй тохиолдол таарч байв. Мөн эрчүүдийг дүрслэхдээ сахалтай, халзан зэрэг эрэгтэй хүйсэд илүү хамаатай онцлог дүр төрхийг багтаасан байхад эмэгтэй хүнийг царайлаг, хөөрхөнөөр дүрслэх нь давамгайлж байлаа.

Сурах бичиг дэх сэтгэл зүйн дүр төрхөд жендэрчлэгдсэн ялгаа ажиглагдсан юм. Ямар ч сурах бичигт эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг нь аймхай гэж, харин хов живэнд дуртай байдлаар эрэгтэй хүнийг дүрсэлсэн нэг ч тохиолдол таарсангүй. Эрэгтэй хүнийг ухаалаг, зоригтой, түрэмгий, хэрцгий талаас, эмэгтэй хүнийг дуулгавартай, хүнлэг энэрэнгүй, хов живэнд дуртайгаар дүрсэлсэн нь нийтлэг ажиглагджээ. Энэ нь уламжлалт хэвшмэл ойлголтоор дүрслэгдэж байгааг харуулж байна.

Зураг 24 Сурах бичиг дэх эрэгтэй эмэгтэй хүний оюуны болон сэтгэл хөдлөлийн шинжүүдийн дүрслэл (эхэд дүрслэгдсэн дундаж тоогоор)



Зураг, дүрслэл, эхэд эрэгтэй эмэгтэй хүмүүсийг нэг дор дүрслэхдээ зиндаа, зэрэглэл, шатлалын хувьд ямархуу дүр төрхтэйгээр дүрсэлсэн болохыг тодруулсан. Зураг, дүрслэлд эмэгтэйчүүдийг дээд шатлалд, эхэд эрэгтэйг дээд шатлалд байгаагаар дүрслэх нь давамгайлж байв. Эхэд доод шатлалд бичигдсэн хүмүүс хүйсээр зөрөөтэй байсангүй. Харин зураг, дүрслэлийн хувьд эрэгтэйчүүдийг доод шатлалд дүрсэлсэн нь 4 пунктээр илүү байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийг адил

тэгшээр дүрсэлсэн нь зурагт 13, эхэд 6 хувийг эзэлж байна. Эдгээр үр дүн нь нийгмийн зиндаачлал бүхий дүрслэлд жендэрийн тэнцвэртэй байдлыг хангах талаар анхаарах хэрэгцээ байгааг тодруулжээ.

Хүснэгт 25 Зураг дүрслэл, эх дэх жендэрийн шатлал (хувиар)

	Зураг, дүрслэл	Эх
Эрэгтэйг дээд шатлалд	25.54	59.15
Эмэгтэйг дээд шатлалд	40.42	23.94
Эрэгтэй, эмэгтэйг адил шатлалд	12.77	5.63
Эрэгтэйг доод шатлалд	12.77	5.63
Эмэгтэйг доод шатлалд	8.49	5.63

Жендэрийн тухай боловсрол олгоход судлагдсан Нийгмийн ухааны сурах бичгүүд тодорхой хэмжээгээр чиглэжээ. Ялангуяа нийгэм, нийгмийн харилцаа, хүний эрх ба эрх зүйн хамгаалал бүлгүүд нь хүний эрх, гэр бүлийн харилцаа, жендэрийн харилцаа, нийгмийн тэгш бус байдал, давхраажилт сэдвүүдийн хүрээнд анхаарчээ.


**А. Хүн ба нийгэм сурах бичиг-II-т** эрхэд суурилсан хандлага, зарчимд тулгуурласан нь цаад утгаараа жендэрийн тэгш байдлыг тогтоох үзэл санааг давхар агуулж байгаараа жендэрийн боловсролыг дамжуулахад ач холбогдолтой юм. Сурах бичигт тэгш эрх, хүмүүсийн хоорондын харилцаа, хүүхдийн эрх, үүрэг, хүний эрх, дүрэм журмын тухай мэдлэг чадвар эзэмшүүлэх, даалгавар гүйцэтгэх, улмаар охид хөвгүүдэд энэ талын хандлагыг төлөвшүүлэхэд эерэгээр нөлөөлөхүйц байна. Хүн ба нийгэм сурах бичгийн агуулга нийгэм, түүхийн хичээлийн агуулга хамт явдаг онцлогтой уялдаж түүхэн бие хүн, гавьяа байгуулагч, тусгаар тогтнол, хувьсгалч, тэмцэгчийн дүр нь эрэгтэйчүүд байна. Нөгөө талаар сурах бичиг жендэрийн тэгш эрх, эрхэд суурилсан хандлагад хувь нэмрээ оруулж байгаа ч жендэрийн хэвшмэл ойлголтыг уламжлуулсан хандлага бүхий сэдэв агуулгад багтахуйц дүрслэл, өгүүлэмжтэй байгаа нь ажиглагдаж байна. Хөвгүүдийг түрэмгий, хэрцгий, зодоонч, бусдыг эрхэндээ оруулдаг жишээ, гавьяа байгуулагч, төр засгийн зүтгэлтэн, баатарлаг эрэгтэй дүртэй хөшөө дурсгалуудын жишээ, түүхэн баатарлаг гавьяа байгуулагчид, удирдах түвшний дарга нар нь эрэгтэй дүртэйгээр, нөхөн үйлдвэрлэлийн шинжтэй ажил үүргийг ээж охин гүйцэтгэж байгаагаар, гүйцэтгэх түвшний ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэж байгаа эмч, багш, оёдолчин, цэцэрлэгийн багшийн үүргээр эмэгтэй дүр үүргээр дүрслэсэн нь цөөнгүй аж.

**Б. Нийгмийн ухаан-III** сурах бичгийн гуравдугаар бүлгийн 6-д гэр бүлийн гишүүдийн эрх, үүргийн талаар өгүүлсэн бөгөөд 82-р хуудсанд гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг хөндөж, жендэрийн тухай боловсрол олгосон байна. Ингэхдээ гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн ноцтой зөрчил болохыг тодорхойлж, эрх мэдлийн хуваарилалттай холбон тайлбарлаж, түүний төрөл хэлбэр, үйлдлийн хэв шинж, онцлогийг гаргасны хамт асуудал тохиолдсон үед ямар байгууллага, утсанд хандах тухай мэдээллийг багтаажээ. Цаашлаад, уг асуудлаар ярилцаж, “Гэр бүлийн хамгийн нандин үнэт зүйл” сэдвээр эсээ бичих даалгавар өгсөн нь сурч мэдсэнээ бататгах, үнэт зүйл хандлагыг төлөвшүүлэхэд ихээхэн нөлөөтэй. Мөн эрхээ хамгаалах, хүний эрхийн байгууллагад хандах, санал, гомдлоо гаргах, шийдвэрт оролцох талаар тусгасан нь хүний эрхийн боловсролд ач холбогдолтой.

Сурах бичигт цаашид анхаарвал зохих зарим асуудлууд тусгагдсан байна. Сурах бичгийн 44-45 дугаар болон 49 дүгээр хуудсанд эх дээр ажиллах даалгавар өгсөн бөгөөд тэдгээр эхэд хүүхдээ асрах, анхаарал тавих, халамжлах үүргийг зөвхөн ээжийн дүрээр гаргажээ. Эхийн тухай өгүүлж

болох ч эцгийн үүрэг, хайр, халамжийг орхих ёсгүй юм. Мөн 101-р тал дахь “Гэртээ хийгээрэй” даалгаврын өгөгдөлд эрэгтэй хүнийг ямар ч ажилд илүү бүтээмжтэй байхаар дүрсэлсэн тул жендэрийн хэвшмэл ойлголтын үүднээс боловсруулагдсан байна гэж үзэх үндэслэлтэй.

Зураг 25 Жендэрийн хэвшмэл ойлголт бүхий дасгалын хуулбар (Алтанзаяа Л, Алтангэрэл Ч, Нэмэхжаргал Т ба бусад (2012). Нийгмийн ухаан III, Улаанбаатар 101 дүгээр тал)



**В. Нийгмийн ухаан-IV** сурах бичгийн нэгдүгээр бүлэгт гэр бүлийн гишүүд, тэр дундаа эхнэр нөхөр харилцан бие биенээ хүндэтгэхийн ач холбогдол, тэгш эрхийн тухайн өгүүлжээ. 24-р хуудсанд “Монголчууд айл өрхийн тэргүүнийг гэрийн эр хүн гэж үздэг тул нүүдэл суудал, худалдаа арилжаа, эд хөрөнгө эзэмшлийг өрхийн тэргүүн зохион байгуулдаг ч, гэрийн эзэгтэй эмэгтэй хүнийг “Галын бурхан”, ... тулгуур баганын нэг хэмээн хүндэтгэж ирсэн уламжлалтай. ... эрэгтэй хүүхдийг хүмүүжүүлэх ...-ийг эцэг нь, эмэгтэй хүүхдийг эх нь хариуцдаг ёстой. Энэ асуудлын тухайд бие биеийнхээ хэрэгт хөндлөнгөөс оролцохыг цээрлэдэг заншилтай” тухай бичсэн байв. Хэдийгээр гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, харилцан хүндэтгэлийн тухай өгүүлээд байгаа атлаа зарим гишүүдийн худалдаа арилжаа хийх, эд хөрөнгө эзэмших эрхгүй байж болохыг сурталчилсан, дотоод зөрчилтэй агуулга бүхий байгаа нь харамсалтай.

Уг сурах бичгийн 96-97 дугаар талд хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголт, төрөл хэлбэр, өртөх эрсдэл, хэрхэн өөрийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар өгүүлжээ. Цаашлаад бататгах зорилго бүхий бүтээлчээр ажиллах дасгал, даалгавруудыг оруулж өгсөн байна. Мөргөлдөөн, хүчирхийлэл, энэ нөхцөлд хүний эрхийн хамгаалах тухай асуудлыг хөндсөн нь жендэрийн боловсролд ач холбогдолтой. 127-128-р хуудсанд “Өөрийгөө сориорой” даалгаварт “Үнсгэлжин бол үнэн хэрэгтээ хөөрхийлөлтэй охин уу, нэр алдар хөөцөлдөгч үү, эсвэл арчаа муутай охин уу?” гэсэн асуултыг багтаажээ. Энэхүү асуултын утга бүхэлдээ феминист хандлагатай юм.

Ийнхүү нэг талаас жендэрийн тухай боловсролд хамаарах агуулгыг бага ч гэсэн хөндөж байгаа боловч, зарим агуулгаараа зөрчилдөөд байгааг анхаарах ёстой. Энэ нь тухайн сурах бичиг нэгдмэл үзэл баримтлал, үнэт зүйлсэд тулгуурлалгүйгээр бичигдсэн болохыг харуулна..

**Г. Нийгмийн ухаан-VI** сурах бичигт хүйс, жендэр, жендэрийн тэгш бус байдлын тухай ойлголтуудыг багтаасан тул жендэрийн тухай боловсрол олгохоор зорьжээ гэж үзэх үндэслэл байна. Түүнчлэн бататгах, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх, баримтад жендэрийн дүн шинжилгээ хийх зорилго бүхий дасгал даалгавруудыг багтаасны хамт нийгмийн давхраажилд холбогдох харилцан нөлөөллийн асуудлыг хөндөж, дасгал даалгавруудыг багтаасан байв. Тус номны 137-138 дугаар хуудсанд Монголын улсын үндсэн хуулийн үл ялгаварлах тухай заалтыг оруулан утгыг нь тайлбарлах, жендэрийн тэгш эрхэд холбоотой асуулт бүхий өөрийгөө сорих даалгаврыг өгчээ. Сурах бичигт утга агуулгын хувьд зөрчилтэй зүйл илрээгүй боловч зураг, дүрслэл, эх дэх дүрүүдийн хувьд анхаарвал зохих асуудлууд бий.

Зураг 26 Хүйс ба жендэрийг тайлбарлан бичсэн хуудасны хуулбар (Алтанзаяа Л, Алтангэрэл Ч, Нэмэжаргал Т ба бусад(2014). Нийгмийн ухаан VI, Улаанбаатар, 19 дүгээр тал)



Зураг 27 Сурах бичиг орсон философич, сэтгэгчдийн зураг (мөн тэнд, 57; 70 дугаар тал)



Эцэст нь дүгнэхэд судлагдсан сурах бичиг нь нэг талаас хүүхэд бүрт суралцах, хичээлд оролцох, хөгжих боломжийг олгохуйц дасгал даалгавар, агуулга бүхий, цаашлаад жендэрийн тухай боловсролыг олгох зорилго бүхий агуулга тусгагдсан зэргээс харахад жендэрийн эерэг үнэт зүйлс, хандлага төлөвшихөд сайн нөлөөтэй гэж дүгнэж болно. Гэхдээ зохиогчдын үзэл хандлагаас хамааралтайгаар нэг сурах бичгийн дотоодод зөрчилдсөн санаа бүхий агуулга ажиглагдаж байна. Зураг, дүрслэл, эхэд эрэгтэйчүүд хэт давамгайлж байна. Цаашлаад эрэгтэй, эмэгтэйчүүдийн дүр үүрэг, сэтгэл зүйн шинжүүдийг жендэрийн хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагаар дүрсэлсэн нь нэлээдгүй хувийг эзэлж байгаа тул сурагчдад жендэрийн эерэг соёл төлөвшин хөгжихөд хүндрэл учруулж болзошгүй байна. Иймээс сурах бичгийн стандартад жендэрийн шаардлагуудыг нарийвчлан тусгах, сурах бичиг зохиогчид, редакторуудыг жендэрийн чиглэлээр бэлтгэх, чадавхжуулах шаардлагатай юм.

## БҮЛЭГ 4. ЖЕНДЭРИЙН НИЙЦЭМЖТЭЙ БАГШЛАХУЙ БА СУРАЛЦАХУЙ

Дөрөвдүгээр бүлэг нь багшлах, суралцах үйл явц дахь жендэрийн нөлөө буюу багш нарын нийтлэг ашигладаг заах арга барил, охид хөвгүүдийн тэгш оролцоог хэрхэн хангадаг, багш нар охид, хөвгүүдийн суралцах онцлог, хэрэгцээнд нь тохируулахын тулд хичээлээ хэрхэн төлөвлөдөг, жишээлбэл агуулгын хувьд, тараах материал, аргачлал, ангийн зохион байгуулалт болоод анги дах харилцаа зэрэг. Энэ хэсэгт охид хөвгүүдийн аль нэг хичээлдээ илүү дуртай байх хандлага болоод тухайн нэг хичээлийг зааж байгаа багшийн хүйс хичээлд нөлөөлдөг эсэхийг хүртэл хамруулан авч үзсэн. Тэрчлэн үүгээр багшийн боловсрол олгох хөтөлбөрт жендэрийн боловсролыг нэгтгэж оруулах хэрэгцээтэй байгааг онцолсон.

### 4.1 Жендэрийн мэдрэмжтэй багшлахуй

Багшлахуй гэдэгт суралцах үйл ажиллагаа, түүний орчинтой холбоотой, тухайлбал багш сурагчдын харилцаа, заах сургах үйл ажиллагаа, хичээлийн даалгавар, сурлагын үнэлгээ болон багш жендэрийн мэдрэмжтэй эсэх гэх мэт асуудал багтана. Багшлахуйн дидактик/заах арга зүйд ангид хичээлийг хөтлөн явуулах арга барил, заах аргууд, заах арга барил, ур чадвар багтдаг.

Энэ бүлэгт жендэрийн мэдрэмжтэй багш нар хичээлээ хэрхэн хөтлөн явуулдаг вэ, охид хөвгүүдийн суралцах онцлог хэрэгцээг хэрхэн тусгаж ажилладаг вэ, голлон хэрэглэдэг аргууд, чухам яагаад тийм аргыг сонгож байгаа тухай нь өгүүлнэ. Эрэгтэй, эмэгтэй багш нарын заах арга барилын ялгаа, эрэгтэй эмэгтэй сурагчдын сурлагын ялгааг тодруулан авч үзсэн.

#### *Багш нарын заах арга зүй*

Багш нар хичээлдээ хамгийн их ашигладаг аргуудаас бага, дунд, ахлах ангийн багш нарын хамгийн их сонголт хийсэн нь идэвхтэй сургалтын аргууд, болон шинжлэн судлах аргууд байна. Графикт үзүүлсэнчлэн идэвхтэй сургалтын аргуудыг бага ангийн багш нарын 50.4 хувь нь гол арга болгон сонгосон байхад, шинжлэн судлах аргыг ахлах дунд ангийн багш нар түлхүү хичээлдээ ашигладаг үзүүлэлттэй байна.

Хүснэгт 26 Охидтой харилцах ур чадвар аль хүйсийн багшид илүүтэй ажиглагддаг вэ? /багш нарын хариулт/

			Хүйс		Нийт
			Эрэгтэй	Эмэгтэй	
Охидтой харилцах ур чадвар	Эрэгтэй багш	Тоо	5	5	10
		Хувь	8.8%	1.9%	3.1%
	Эмэгтэй багш	Тоо	22	182	204
		Хувь	38.6%	68.4%	63.2%
	Хоёулаа	Тоо	30	79	109
		Хувь	52.6%	29.7%	33.7%
Нийт		Тоо	57	266	323
		Хувь	100.0%	100.0%	100.0%

Хүснэгт 27 Сурагчдын бодлоор эрэгтэй, эмэгтэй багшийн ялгаатай ур чадвар, сурагч болон багшийн хүйсээр

			Сурагчдын хүйс		Нийт	
			Хүү	Охин		
Эрэгтэй, эмэгтэй багш охид, хөвгүүдийн сонирхол болон хэрэгцээг харгалзах байдлын ялгаа	Эрэгтэй багш	Тоо	44	21	65	
		Хувь	19.0%	8.0%	13.2%	
	Эмэгтэй багш	Тоо	57	96	153	
		Хувь	24.7%	36.8%	31.1%	
	Хоёулаа	Тоо	128	143	271	
		Хувь	55.4%	54.8%	55.1%	
	Хариулаагүй		Тоо	2	1	3

		Хувь	0.9%	0.4%	0.6%
	Нийт	Тоо	231	261	492
		Хувь	100.0%	100.0%	100.0%

Хүснэгт 28 Эрэгтэй, эмэгтэй багшийн сурагчдыг чиглүүлэх ур чадварын ялгаатай байдал

			Сурагчдын хүйс		Нийт
			Хүү	Охин	
Эрэгтэй, эмэгтэй багшийн сурагчдыг чиглүүлэх ур чадварын ялгаа	Эрэгтэй багш	Тоо	29	19	48
		Хувь	12.6%	7.3%	9.8%
	Эмэгтэй багш	Тоо	90	131	221
		Хувь	39.0%	50.2%	44.9%
	Хоёулаа	Тоо	111	111	222
		Хувь	48.1%	42.5%	45.1%
	Мэдэхгүй	Тоо	1	0	1
		Хувь	0.4%	0.0%	0.2%
Нийт		Тоо	231	261	492
		Хувь	100.0%	100.0%	100.0%


Хүснэгт 29 Эрэгтэй, эмэгтэй багшийн сурагчидтай ганцаарчлан, ойр ажиллах байдал

			Сурагчдын хүйс		Нийт
			Хүү	Охин	
Эрэгтэй, эмэгтэй багшийн сурагчидтай ганцаарчлан ажиллах ур чадварын ялгаа	Эрэгтэй багш	Тоо	30	18	48
		Хувь	13.0%	6.9%	9.8%
	Эмэгтэй багш	Тоо	83	117	200
		Хувь	35.9%	44.8%	40.7%
	Хоёулаа	Тоо	118	126	244
		Хувь	51.1%	48.3%	49.6%
Нийт		Тоо	231	261	492
		Хувь	100.0%	100.0%	100.0%

Хүснэгт 30 Эрэгтэй, эмэгтэй багшийн ангийн нийт сурагчидтай ажиллах байдал

			Сурагчдын хүйс		Нийт
			Хүү	Охин	
Эрэгтэй, эмэгтэй багшийн нийт сурагчидтай ажиллах байдлын ялгаа	Эрэгтэй багш	Тоо	38	24	62
		Хувь	16.5%	9.2%	12.6%
	Эмэгтэй багш	Тоо	85	95	180
		Хувь	36.8%	36.4%	36.6%
	Хоёулаа	Тоо	108	140	248
		Хувь	46.8%	53.6%	50.4%
	Мэдэхгүй	Тоо	0	2	2
		Хувь	0.0%	0.8%	0.4%
Нийт		Тоо	231	261	492
		Хувь	100.0%	100.0%	100.0%

Зураг 28 Ахлах, дунд, бага ангийн багш нарын заах арга зүй, хувиар



Идэвхтэй сургалтын аргуудыг сонгон хичээлдээ ашигладаг багш нарын 44.1 хувь нь сурагчдын сурах барилыг хөгжүүлдэг учраас, 20 хувь нь сурагч бүрийг хичээлд татан оролцуулдаг учраас байнга ашигладаг гэж хариулсан. Харин шинжлэн судлах аргыг байнга ашигладаг хэмээн сонголт хийсэн багш нарын 51.9 хувь нь сурагчдынхаа сурах арга барилыг хөгжүүлэхийн тулд, 21.3 хувь нь сурагчдад сэдвийн агуулгыг бүрэн ойлгуулахын тулд байнга ашигладаг гэж хариулсан байна. Хүүхдүүд ямар багшийг сайн багш гэдэг тухайд дараах мэдээллийг өгч байна.

...”Жишээн дээр ажиллуулдаг. Бүх хүүхдүүдэд ойлгуулах гэж хичээдэг, гэрийн даалгавар сайн өгдөг. Би шилжиж ирсэн. Энд ирээд багш нар нь сайн хүүхдүүдтэй тулж ажилладаг. Муу байсан хичээлдээ сайжирсан. Учир нь хичээлээ сонирхолтой заадаг. Хичээлдээ дуртай болж эхэлсэн.”

*Завхан. Ургамал сум. Хүүхэдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас*

...”Нэг хэвээр хичээлээ явуулах нь бие биенээ хараад суух уйтгартай хичээл хийх сонирхол буурдаг. Бүлгээр ажиллуулах, хооронд нь мэтгэлцүүлэх, уралдуулах нь сонирхолтой.”

*Завхан. Улиастай сум. Хүүхэдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас*

...”Тогтвортой байдаггүй ш дээ. Нэг өдөр дуртай байсан хичээлдээ нөгөө өдөр дургүй болчихно.

Багш тухайн хичээлийг хэрхэн өрнүүлж байгаагаас л шалтгаалж дуртай, дургүй болдог.”

*Хүүхэдтэй хийсэн бүлгийн ярилцлага. Багануур дүүрэг Гүн галуутай цогцолбор*

...”Нээлттэй хичээл дээр бол хүүхдүүд арай идэвхтэй оролцдог. Яагаад гэхээр математикийн хичээл дээр зөвхөн тоо бодоод л байдаг бол нээлттэй хичээл дээр цаас хайчлах ч юм уу арай өөр аргыг бодлоготойгоо хавсаргаад заадаг. Тэр нь их хөгжилтэй. Бие биетэйгээ уралддаг.”

*УБ, Сүхбаатар дүүрэг. 2-р сургууль*

Багш хүн түүний хандлага, зан үйл, арга, байр байдал, бодол санаа нь хүүхдэд жендэрийн үүрэг төлөвшихөд чухал нөлөөтэй гэдгийг үргэлж санах хэрэгтэй. Үүний тулд багш хүн сурагчид эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай хамаагүй өөрийн зорилгоо тодорхойлж, түүндээ хүрэх бололцоог ижилхэн нөхцөлөөр хангагдахуйцаар олон янзын арга, аргачлалыг ашиглах боломжтой. Судалгаагаар жендэрийн ялгаатай байдал нь аль нэг хичээлийг илүүд үзэх, ангийн харилцаа, цаашлаад сурлагын амжилтад хоорондоо хамааралтай байгаа нь илэрсэн.


Бүлгээр ажиллах, бүлгийн ярилцлага, дүрд тоглох, мэтгэлцэх, тохиолдол судлах, танин мэдэхүй, туршлагын зэрэг заах арга зүй нь сурагчдын идэвхитэй оролцоог дэмждэг бөгөөд охидын оролцоог сайжруулахад тустай байдаг. Өмнө дурдсанчлан эдгээр арга нь жендэрийн тэгш байдлыг хангахтай шууд холбоотой биш юм. Энэ нь багшаас ангийг удирдах ур чадвар, мэдлэг туршлага шаардсан ажил, тухайлбал хичээлд давамгайлах оролцоотой сурагчид нь оролцоо тааруу бусдыгаа шахахаас сэргийлэх гэх мэт. Тэгэхээр багш нар заах арга зүйгээ хэрхэн жендэрийн мэдрэмжтэй

болгох вэ гэдэгт сурагчид сайн багш гэж хэн болох талаар өөрсдийн бодлоо хуваалцсан.

### Багш нарын ур чадварын тухайд

Багш нарын бодлоор эрэгтэй, эмэгтэй багш нарын жендэрийн ялгаа нь багшлах ур чадварын хувьд 2 тохиолдолд эрс ялгаатай байдаг гэж үзэж байна. Эмэгтэй багш нар эмэгтэй сурагчидтай харилцахдаа илүү чадварлаг байдаг бол эрэгтэй багш нар ангид дэг журам тогтоох тал дээр илүү давуу талтай байдаг гэжээ.

Зураг 29 Багш нарын ур чадвар, хүйсээр, хувиар



Уг графикаас заах ур чадвар, хүүхдийг хичээлд татан оролцуулах, удирдах ур чадварын хувьд эрэгтэй эмэгтэй багш нарт ялгаа байхгүй, харин охидтой харилцах, тав тухтай орчин бий болгох ур чадварын хувьд эмэгтэй багш нар илүү, сахилга бат дэг журам тогтоох ур чадварын хувьд эрэгтэй багш нар илүү гэж судалгаанд оролцсон багш нар үзлээ. Нийт багш нарын 75.8 хувь нь багшийн заах ур чадвар хүйстэй хамаарахгүй гэж дүгнэсэн. Тэдний заах ур чадварын хувьд хүйс ялгаагүй ур чадвар чухал гэдгийг чанарын судалгааны дүн ч бас давхар харууллаа.

...”Эмэгтэй хүн хүүхэд төрүүлэх гээд ажлаас холддогийг эс тооцвол тухайн хүний чадвараас хамаарах асуудал.”

*Эцэг эхийн бүлгийн ярилцлага. Сүхбаатар. Баруун урт сум*

...”Эрэгтэй эмэгтэй хүйстэй холбож багшийг дүгнэж болохгүй тэр хүн яаж ажилдаа хандаж байна түүнийг нь хүүхдүүд хэр ойлгож байна гэдэг нь чухал.”

*Эцэг эхийн бүлгийн ярилцлага. УБ, Сүхбаатар дүүрэг*

...”Эмэгтэй багш зоддоггүй, эрэгтэй багш зодсон ч өөр хүүхдүүдээс өмөөрдөг. Эмэгтэй багш эрэгтэй багшийг бодвол ухаантай, чадвартай, эелдэг.”

*Сурагчдын бүлгийн ярилцлага. Сүхбаатар аймаг. Асгат сум*

...”Миний бодлоор эрэгтэй багш дээр гэж боддог. Эмэгтэй багш байхаар ангид хүүхдүүд үймүүлээд байдаг. Харин эрэгтэй багш орохоор анги томоотой байдаг.”


*Сурагчдын бүлгийн ярилцлага. УБ, Сүхбаатар дүүрэг. 2-р сургууль*

Багш нарын зааж буй судлагдахууны хөтөлбөрүүдэд жендэртэй холбоотой, жендэрийн тэгш байдлыг хангах талаар тусгасан эсэхийг судлахад мэдэхгүй гэж 90.1 хувь нь хариулсан байна. Харин нийт багш нарын дөнгөж 15.7 хувь нь жендэрийн асуудал тусгасан байдаг үлдсэн хэсэг нь



үгүй гэж 49.8 хувь, мэдэхгүй 34.6 хувь нь тус тус хариултыг өгснөөс дүгнэхэд багш нар энэ талаар маш бага мэдлэг мэдээлэлтэй байгаа нь илт байна.

Зураг 30 Багшийн хөтөлбөрт жендэртэй холбоотой агуулгыг тусгадаг эсэх, хувиар



Жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг хөтөлбөртөө тусгадаг гэсэн багш нар үзэхдээ, сурагчдыг хичээлд эрх тэгш оролцуулах, багшийн ёс зүйг баримтлах замаар гэж 6.1 хувь, нийгмийн ухаан, гадаад хэл, иргэний боловсрол зэрэг хичээлийн хөтөлбөрт жендэрийн талаар тусгадаг гэж 2.0 хувь, технологийн хичээлийн судлагдахуунд охид хөвгүүдийн сурах зүйлийг тусад нь авч үзсэнээрээ гэж 1.8 хувь тус тус хариулсан байна.

Жендэр, жендэрийн тэгш байдал хэмээх нэр томъёог хэрэглэдэггүй ч гэсэн, багш нар сурагчдынхаа хэрэгцээ сонирхлыг харгалзан үзэж хөтөлбөрөө боловсруулдаг, тэр дагуу ажиллахаар үйл ажиллагаагаа төлөвлөдөг гэж нийт багш нарын 51.8 хувь нь хариулсан байна. Бага ангийн багш нар сурагч бүрийн хэрэгцээ сонирхлыг тусгаж хөтөлбөрөө боловсруулдаг бол, дунд ахлах ангийн багш нар тухайн насны сурагчдын нийтлэг хэрэгцээ сонирхлыг тусгадаг гэсэн хариулт хамгийн олон давтагдсан байна. Үүнээс дүгнэхэд багш нар хөтөлбөр боловсруулахдаа жендэр гэдэг үгийг нь оруулаагүй ч гэсэн, хөтөлбөр боловсруулахдаа охид хөвгүүдийн хэрэгцээ сонирхлыг тусгах, хүүхэд бүрийн авьяас чадварыг дэмжин ажиллаж байгаа нь сайшаалтай байна. Өмнөх бүлгээс харахад судалгаанд хамрагдсан багш нарын дунд хөтөлбөртөө хүүхэд бүрийн хэрэгцээ, онцлогийг харгалзах тухай тусгасан нь харьцангуй цөөхөн байсан ба багш нарын аман хариулт ба хөтөлбөртөө тусгасан байдал хооронд зөрөө ажиглагдаж байна.

...”Хүүхдийн сайн сайхан зан чанар, дадал хэвшил, ялангуяа төрмөл авьяас чадварыг зориуд ажиглан судлах, эцэг эхтэй нь хамтарч, түүнийг нь дэмжин хөхүүлэх.”

*Сүхбаатар аймаг, Асгат сум. Бага ангийн багшийн монгол хэлний хичээлийн хөтөлбөр*

Идэвхитэй сургалт гэдэг нь сурагч чимээгүй суугаад сонсох биш оролцохыг хэлнэ. Оролцоонд сууррилсан заах арга барил гэдэг нь санаатай болон санамсаргүй байдлаар сурагчийг аливаа зүйлийг суралцах боломжоос хоцроохгүй байхыг хэлнэ. Жендэрийн мэдрэмжтэй багш байна гэдэг охид хөвгүүдийн заах болон суралцах онцлог хэрэгцээг ойлгож, хариу үзүүлдэг байх явдал юм. Ингэхдээ охид хөвгүүдийн онцлог хэрэгцээний талаар мэддэг байхын зэрэгцээ, хичээлд охид хөвгүүдийн оролцоо эн тэнцүү байх, сургалтын хэрэглэгдэхүүнийг ижил хүртээмжтэй байлгах хэрэгтэй.

**Хичээл дээр охид хөвгүүдэд ялгаатай даалгавар өгдөггүй.** Ажиглалтын үеэр ямар ч багш сурагчийн хувийн онцлогоос хамааруулж ялгаатай даалгавар өгөөгүй бүгдэд адилхан хандсан байна. Ангид тэгш байдлыг дэмжинэ гэдэг нь заавал бүгдэд ижил хандах ёстой гэсэн үг биш. Хэдийгээр энэ нь бүгдэд амжилтад хүрэх ижил нөхцөл олгож байгаа хэрэг мөн боловч нөгөө талаас сурагчдын оролцоог өргөн болгох үүднээс зарим сурагчдад арай илүү урам зориг өгөх ёстой гэж харж болохоор байна. Дуу багатай сурагчдыг илэрхий онцолж сайшаах юмуу бүлгээр ажиллаж тэднийг оролцоход арай айдас багатай, хялбар санагдуулах гэх мэт арга хэмжээ бол тэгш байдлыг хангахын тулд тусгайлан хандах хэрэгцээ байдгийн нэг жишээ. Ангид жендэрийн өөрчлөлт, өрнөлийг анхаарч харах нь багшлах арга барилд ч, эрэгтэй эмэгтэй сурагчдын суралцах үйл явцад ч эергээр нөлөөлнө.

Бага насны хүүхдийн төлөвшилд багшийн үүрэг оролцоо маш их бөгөөд багшийн үзэл санаа, итгэл үнэмшил нь балчир сурагчдын бодол, зуршилд их нөлөө үзүүлж өөрчлөх боломжтой. Жендэрийн ялгаатай хэвшмэл зан үйл, хандлага нь хувь хүний хөгжлийг хязгаарлаж, охид хөвгүүд өөрийн нөөц бололцоогоо бүрэн дайчлахаас нь хойш татдаг. Тийм учраас тэдний байгаа байдал, хандлага, зан үйл нь сурагчдын хөгжилд шууд нөлөөлдгийг анхаарууштай.

## **4.2 Хичээлийн танхимын зохион байгуулалт ба багш сурагчдын харилцан үйлдэл**

### **4.2.1 Жендэрийн нийцэмжтэй хичээлийн танхим**

Ангийг хэрхэн зохион байгуулах нь заах, суралцах үйл явцад эерэг болон сөрөг нөлөөтэй. Сургалтын орчны орон зайг төлөвлөсөн байдал нь хөтлөн явуулж байгаа хичээлийн чанар, жендэрийн мэдрэмжтэй байдалд нөлөөлдөг болохыг багш нар (сургуулийн захирлууд) ойлгох хэрэгтэй.

Жендэрийн мэдрэмжтэй анги танхим нь охид хөвгүүдийн онцлог хэрэгцээг тусгаж нийцүүлсэн байх ба дараах аргуудыг авч үзсэн байдаг. Үүнд:

- Ангид охид хөвгүүд холимог байх.
- Ангийн үйл ажиллагаанд охид хөвгүүдийн оролцоог дэмждэг байх.
- Ширээний байрлал нь охидыг ичимхий байдлаа дийлж, өөрийгөө илэрхийлэхэд дэмжихүйц байх.
- Лабораторийн ширээнүүд хэлбэр, хэмжээний хувьд охид хөвгүүд хамтдаа идэвхитэй оролцоход тохиромжтой байх.
- Ханан дах үзүүлэн, таниулах материал нь жендэрийн тэгш байдлыг илэрхийлсэн утга агуулгатай байх.
- Хичээлийн ширээ, сандал хэлбэр, хэмжээ, хүнд хөнгөний хувьд тохиромжтой байх.


Ажиглалт судалгаагаар ангиуд зүй зохистой дэд бүтэцтэй (гэрэлтүүлэг, дулаан, агааржуулалт гм) бөгөөд тавилга, ширээ сандал нь хангалттай тоотой байсан. Бүх сурагчид суралцахад шаардлагатай өөрийн гэсэн орон зайтай байлаа. Ажигласан ангиудын дундажаар 26 сурагчтай, хамгийн цөөндөө орон нутгийн сургуульд 15 сурагчтай байсан бол хамгийн олондоо Улаанбаатар хотын сургуулиуд 49 сурагчтай анги байсан. Хэт олон сурагчтай ангид хүүхэд төвтэй оролцооны аргаар сургалт явуулахад зориулж суудлаа засахад нилээд бэрхшээлтэй байна.

Ангийн тохижилтод ихэвчлэн мэдээллийн самбар, ханын самбар, эрдэмтэд болоод түүхэн алдартай хүмүүсийн хөргөөр чимсэн байна. Ажиглалт хийсэн 48 сургуулийн хананд өлгөсөн нийт 199 хөрөгт эрэгтэйчүүдийн хөрөг давамгай буюу зөвхөн 13.5 хувь нь л эмэгтэйчүүдийн хөрөг байна. Ханын самбарууд нь тухайн хичээлээсээ хамаараад янз бүр байсан ба эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг дүрсэлсэн зурмал зураг харьцангуй цөөн байсан. Ханын самбар дахь зургууд нь жендэрийн буруу ойлголт төрүүлэхээр зүйл байхгүй бөгөөд охид эмэгтэйчүүдийг хөвгүүд эрчүүдээс доогуур мэтээр

дүрсэлсэн хүйсийн үүргийн талаарх уламжлалт хэвшмэл хандлагыг илэрхийлсэн буюу эрчүүд нь гэрийн “эзэн”, эмэгтэйчүүд нь хүүхэд хөгшидөө асардаг байдлаар дүрсэлсэн зүйл байгаагүй. Гэхдээ жендэрийн үүргийн талаар дэвшилтэт санаа дэвшүүлсэн, эрэгтэйчүүд эмэгтэйчүүд нийгмийн болоод хувийн харилцаандаа эрх тэгш оролцоотой байгааг харуулсан үзүүлэн ч гэсэн байсангүй. Жишээлбэл эмэгтэй автобусны жолооч гэх мэт хуучин эмэгтэй хүн хийх зохимжгүй гэдэг мэргэжлийг сонгоод ажиллаж байгаа эмэгтэй, гэрийн ажил хийгээд хүүхдээ асарч байгаа эрэгтэйн дүрслэл огт байсангүй.

Сургалтанд хэрэглэж байгаа гол хэрэглэгдэхүүн бол самбар, сурах бичиг байна. Сурагчдаа идэвхитэй байлгах, татан оролцуулахын тулд интерактив заах арга зүйг ашиглах нь тохиромжтой ч мультимедиа технологийн дутагдалтай байдлаас болоод тэгэж чадахгүй байгаагаа багш нар хэлж байлаа. Энэ байдал нь ангийг идэвхитэй суралцахад хөтлөх багшийн ур чадварыг хязгаарлаж байгаа хүчин зүйл болж байна. Хэдий энэ мэт саад байгаа ч багш нар хичээлээ хөтлөх байдлаар ангиа зохион байгуулж байна.

Зураг 31 Ажиглалтын үеэр зурсан хичээлийн танхимын суудал засалт  
Уламжлалт Уламжлалт бус



Тайлбар: Тасархай шугамаар багшийн хөдөлгөөнийг дүрсэлсэн, "X" хөвгүүн, "O" охин

#### 4.2.2 Жендэрийн мэдрэмжтэй ангийн динамик

Ангийн динамик гэдэгт багш, сурагчдын хоорондын харилцааг илэрхийлж байна. Анги дах багш, сурагчдын хоорондын харилцааг ажиглах зорилго нь багш нар сурагчдаа охид, хөвгүүд ялгаагүй өөрийн хүйсээсээ үл хамааран суралцахдаа дуртай таатай бөгөөд бусад сурагчидтайгаа чөлөөтэй харилцах орчинг бүрдүүлж чадаж байгаа эсэхийг тодорхойлох явдал байлаа. Анги доторх сайн харилцаа гэдэгт ангид бүгд аливаа үйл ажиллагаа, ярилцлагад оролцдог жендэрийн ялгаатай хэрэгцээг нь харгалзан бүгдийн оролцоог хангадаг байх багтана. Сурагч бүр өөрийн гэсэн сонирхол, авьяастай учраас тухайн анги сурагчдынхаа онцлогт зохицохоор уян хатан байх ёстой. Сурагчид анги хамт олны харилцаа тэдний зорилго, сонирхолтой нийцэж байх үед илүү урам зоригтой болдог. тийм учраас багш хүн сурагч бүртээ анхаарч ангийн үйл ажиллагаанд оролцоход нь урамшуулах хэрэгтэй.

Хүснэгт 31 Анги доторх багшийн хөдөлгөөний дундаж, сурагчдын хүйсээр

		Дундаж	Охид	Хөвгүүд
Багшийн хүйс	Эрэгтэй	16.2	7.4	8.8
	Эмэгтэй	13.0	6.3	6.7
	Дундаж	14.2	6.7	7.5
Хичээл	Байгалийн шинжлэх ухаан	17.7	7.6	10.1
	Гадаад хэл	11.0	6.0	5.0
	Нийгмийн ухаан	12.1	6.2	5.8
	Дундаж	14.2	6.7	7.5
Анги	Ахлах анги	13.4	6.6	6.8
	Дунд анги	16.4	8.1	8.3
	Бага анги	11.8	5.0	6.8
	Дундаж	14.2	6.7	7.5
Танхимын байгуулалт зохион	Уламжлалт эгнээгээр	10.8	4.9	5.9
	Уламжлалт бус	23.8	12.0	11.8
	Дундаж	14.2	6.7	7.5

Хүснэгт 32 Багш сурагчдын хоорондын харилцан үйлдлийн тоо, багшийн хүйсээр

		Дундаж		Эрэгтэй багш		Эмэгтэй багш	
		Ганцаарчлан харилцсан	Ангид бүхэлд нь хнадсан	Ганцаарчлан харилцсан	Ангид бүхэлд нь хнадсан	Ганцаарчлан харилцсан	Ангид бүхэлд нь хнадсан
Анги	Ахлах анги	19.5	18.7	17.2	17.8	21.8	19.5
	Дунд анги	19.3	18.2	18.6	19.8	20	16.5
	Бага анги	15	16.7	10	5	15.4	17.6
	Дундаж	18	17.8	17.6	18.2	18.3	17.6
Сурагчдын тоо	20 хүртэлх	22.7	17.4	21.5	16.5	23.3	17.9
	21-30 сурагч	17.9	21.4	18.8	20.9	17.4	21.8
	31-40 сурагч	12.9	10.6	11	14	14.8	7.3
	40 ба түүнээс дээш	14.3	11.3	-	-	14.3	11.3
	Дундаж	18.0	17.8	17.6	18.2	18.3	17.6
Хичээл	Байгалийн шинжлэх ухаан <sup>61</sup>	19.0	15.4	18.9	18.2	19.2	8.2
	Гадаад хэл	21.7	30	17	21	31	48
	Нийгмийн ухаан	16.9	18.1	9.5	15.5	17.6	18.3
	Дундаж	18	17.8	17.6	18.2	18.3	17.6
Заах арга	Бүлгээр ажиллуулах	21.9	13.3	21.3	13.3	23.5	13
	Ганцаарчлан ажиллуулах	21	26	21	26	0	0
	Идэвхитэй сургалтын арга	18.3	18	24.5	17.5	17.7	18
	Лекцлэх, асуух	16.4	22.3	14.4	20.9	23.5	27.5

<sup>61</sup> Байгалийн шинжлэх ухааны хичээлд математик, физик, хими, газарзүй, биологийн хичээлүүд, нийгмийн ухааны хичээлд түүх, нийгэм судлал, иргэний боловсрол, монгол хэл зэрэг хичээлүүдийг авч үзсэн.

	арга						
	Бусад	13.2	14.8	0	23	16.5	12.8
	Дундаж	18	17.8	17.6	18.2	18.3	17.6

Багш, сурагчдын харилцаанд жендэр нөлөөлдөг гэж үздэг байлаа. Өөрөөр хэлбэл ангийн багш, сурагчдын хүйс нь ангийн харилцааны чанар, тоо хэмжээнд нөлөөлдөг гэсэн үг. Сурагчидтай харилцах харилцаандаа эрэгтэй, эмэгтэй багш нар ялгаатай байдаг уу? 4.5 дугаар хүснэгтэд харуулснаар онц ялгаа ажиглагдаагүй.

**Сургалтын орчны харилцаа.** Багш, суралцагчид өөр хоорондоо олон аргаар харилцдагийн нэг нь харилцан ярилцах юм. Судалгааны дүнгээс харахад багш нар жендэрийн динамикийн талаар ойлголттой байснаар жендэрийн буруу хандлагаас сэргийлэхийн зэрэгцээ зөвхөн жендэрийн мэдлэгтээ үндэслээд сурагчаа зөв залах боломжтой ажээ. Грейс, Грейвсток (2009) нарын судалгаагаар багш нарын жендэрийн мэдрэмжтэй туршлагыг дараах байдлаар жагсаажээ. Тэдний зарим нь жендэрийн тэгш байдлыг хангахын тулд тухайн нэг аргаа ашиглаж байгаагаа эсвэл жендэрийн хэвшмэл хандлагыг үүсгээд байгаагаа ч мэддэггүй байна. Зарим багш нар дараах үйлдлийг гаргадаг. Үүнд:

- Эрэгтэй сурагчдаа илүү олон дууддаг
- Эрэгтэй сурагчдаа асуултанд хариулахыг арай удаан хүлээдэг.
- Асуулт асуухдаа эрэгтэй сурагчдаа илүү анхааралтай тогтож хардаг.
- Эрэгтэй сурагчдынхаа нэрийг санадаг.
- Тэднийг нэрээр нь дууддаг
- Эрэгтэй сурагчдын хэлсэн жишээг ангийн ярилцлагын үеэр цохож ярьдаг.
- Эмэгтэй сурагчдыг хариулж дуусаагүй байхад тасалдуулдаг.
- Эрэгтэй сурагчдаас “дээд эрэмбийн” буюу шүүмжлэлт сэтгэлгээ шаардсан хариулт бүхий асуулт асууж, харин охидоос баримт тоочих маягийн асуулт асуух.

Хүснэгт 33 Багш сурагчийн харилцсан хугацаа, хүйсээр

		Багш сурагчийн харилцсан хугацаа (мин)		
		Хөвгүүд	Охид	Дундаж
Багшийн хүйс	Эрэгтэй	6.1	6.7	12.9
	Эмэгтэй	5.3	4.2	9.5
	Дундаж	5.6	5.1	10.7
Хичээл	Байгалийн шинжлэх ухаан	8.1	6.7	14.8
	Гадаад хэл	6.5	5.7	12.2
	Нийгмийн ухаан	3.7	3.9	7.6
	Дундаж	5.6	5.1	10.7
Анги	Ахлах анги	4.6	4.3	8.9
	Дунд анги	6.1	6.0	12.1
	Бага анги	5.9	4.5	10.4
	Дундаж	5.6	5.1	10.7
Танхимын зохион байгуулалт	Уламжлалт эгнээгээр	5.3	4.5	9.8
	Уламжлалт бус	6.5	6.8	13.3
	Дундаж	5.6	5.1	10.7

### 4.3 Суралцах үйл ажиллагаан дахь жендэрийн хэв шинж

Бид харилцан адилгүй суралцах хэв маяг бүхий сурагчдыг нэг ангид хуваарилсан гэдгээ ямагт ойлгож, хэдийгээр тэдэнд ижил бололцоог олгож байж болох ч хувь сурагч нэг бүрийн суралцах онцлогт нийцүүлж ажиллаж чадахгүй байгаа гэдгээ санаж байх хэрэгтэй. Болдогсон бол багш нар сурагч нэг бүрийн суралцах хэв маягт харгалзуулан, тухайн сурагчийн аливаа зүйлийг хүртэх, боловсруулах онцлогт тохируулж мэдээллийг хүргэж ажиллах байсан. Заах, суралцах арга зүй жендэрийн мэдрэмжтэй байх нь чухал.

#### 4.3.1 Суудал хуваарилалт сургалтад нөлөөлөх нь

Хичээлийн шинэ жил эхлэхэд анги удирдсан багш сурагчдын суудлыг хуваарилдаг. Бага дунд ангийн сурагчид багшийн хуваарилсан суудалдаа л тухайн хичээлийн жилийн турш суух ба хааяа нэг хоёр хүүхдийн суудлыг солих нь бий. Харин ахлах ангийн сурагчид өөр өөрсдийнхөө хүслээр хаана суухаа чөлөөтэй шийдэх талтай байдаг. Ажиглалт хийсэн хичээлүүд дээр багш нар нь бүлгээр ажиллуулах үедээ л сурагчдыг хуваарилснаас бусдаар суудал оноож хуваарилахгүй байсан. Сурагчид өөрсдөө ангийн багшийнхаа хуваарилсан суудлаар, эсвэл өөрсдийнхөөрөө чөлөөтэй суудал сонгож сууж байв.

Суудлын хуваарилалт нь сурагчдын сурлагын амжилтад томоохон үүрэг гүйцэтгэдэг юм. Урд эгнээний сурагчид хойд эгнээний сурагчдаас арай илүү анхааралтай байдаг. Багштай ойрхон ширээнд суудаг сурагчид багшийн анхаарлыг илүү их хүртэж, арай олон удаа нэр дуудагдаж асуугддаг. Сурагчийн талаас авч үзвэл ангийн зохион байгуулалт нь тухайн хувь сурагчийн онцлогийг илэрхийлэх зүйл гэж үзэж болно. Ихэвчлэн нямбай, анхааралтай сурагчид багштай ойр сууж хичээлийн холбогдолтой чухал мэдээллийг алдахгүйг хичээдэг бол бусад хойргодуу сурагчид аль болох багшид анзаарагдахгүйг хичээн хойд эгнээний суудлыг сонгох талтай байдаг.<sup>62</sup>

Багшийн юу хэлж ярьж, хийж байгаа нь бүгд жендэрийн үлгэр загвар болдог. Энэ онолын дагуу бол сурагч өөрийнхөө ижил хүйсний хүнтэй харилцахдаа арай нааштай, илүү амар хялбар, заасан хичээл дээр нь амжилт гаргадаг гэж үздэг. Бид сурагчдын сурлагын амжилтын тухай багш нарын бодлыг, тухайн нэг хичээлийг зааж байгаа багшийн талаарх бодлыг тус тус судалсан.

Хүснэгт 34 Багштай харилцахад суудлын зохион байгуулалт нөлөөлөх байдал, охид болон хөвгүүдийн хувиар

		Багштай ойр суудал		Багшаас хол суудал	
		Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид
Хичээл	Байгалийн шинжлэх ухаан	50.4%	40.2%	35.5%	38.7%
	Гадаад хэл	57.9%	61.5%	42.1%	29.0%
	Нийгмийн ухаан	37.1%	37.1%	34.7%	31.8%
	Дундаж	43.7%	39.9%	35.5%	34.4%
Анги	Ахлах анги	39.6%	46.5%	44.8%	28.9%
	Дунд анги	47.8%	36.6%	32.6%	37.1%
	Бага анги	41.3%	39.0%	31.7%	35.0%
	Дундаж	43.7%	39.9%	35.5%	34.4%
Багшийн хүйс	Эрэгтэй	51.5%	38.9%	34.4%	40.0%
	Эмэгтэй	39.1%	40.5%	36.1%	31.0%

<sup>62</sup> <http://k12teacherstaffdevelopment.com/tlb/do-seating-arrangements-have-an-impact-on-student-learning/>

	Дундаж	43.7%	39.9%	35.5%	34.4%
--	--------	-------	-------	-------	-------

Охид хөвгүүд ангид багштай ойрхон суудалд суух нь зааж байгаа хичээл, хичээлийг зааж байгаа багшийн хүйс, сурагчийн хэддүгээр анги болохоос хамаардаг учраас суралцах үйл явц дах жэндэрийн ялгаатай байдлыг харуулж байж ч болох юм. Цаашлаад охид хөвгүүдийн адил тэгш оролцоог хангахад саад болж болно. Суудал хуваарилалт нь байнгын өөрчлөгдөшгүй байх ёсгүй. Энэ нь хичээлийнхээ онцлогоос хамаараад өөрчлөгдөж байх ёстой ба урд эгнээний, хойд эгнээний гэж ангилагдталаа байх нь зохимжгүй. Сурагч бүрт урд, дунд, хойд эгнээнд суух бололцоо нь ижил олгогдсон байх ёстой. Энэ нь хүн бүрт, ялангуяа тааруу сурлагатай хүүхдүүдэд суралцах ижил тэгш бололцоог олгож байгаа хэрэг юм. Багш нар суудал хуваарилалтыг сургалтанд үр дүнтэй ашиглахын тулд эргэлдэх зарчмыг ашиглаж болох юм.

#### 4.3.2 Охид хөвгүүдийн суралцах үйл ажиллагаан дахь ялгаатай байдал

Энэхүү хэсэгт багш ба сурагчдын хоорондох харилцаанд, багшлах болон суралцах үйл ажиллагаанд жэндэрийн хэвшмэл ойлголт ямар байгааг судалгааны үр дүнд тулгуурлан тодруулахыг оролдов.

#### Судлагдахуун ба охид, хөвгүүдийн ялгаа

Хүснэгт 4.2-г үзүүлсэнчлэн тодохой асуудлуудаар багш нарын заадаг судлагдахуунд охид хөвгүүдийн ялгаа илэрдэг эсэхийг эрэгтэй эмэгтэй багш нарын хариултаар үнэллээ. Амжилттай суралцах, хичээлийг хэн нь илүү сонирхон судалдаг, идэвх санаачилгын талаар охид хөвгүүд хоёулаа адилхан гэдэг дээр эрэгтэй эмэгтэй багш нар санал нэгтэй байна. Харин хөвгүүдийн хувьд хичээлийн явцад илүү сануулга авдаг, нэг нэгнийгээ шоглох, зохисгүй үг хэллэг хэлэх зэрэгт хөвгүүд охидоос илүү гэдэгт эрэгтэй эмэгтэй багш санал мөн адил өндөр хувьтай байна. Охидын хувьд хичээлийн бэлтгэлээ илүү хангадаг, бусад суралцагчдын суралцах үйл ажиллагаанд охид илүү туслах хандлагатай гэж эрэгтэй эмэгтэй багш нар үзсэн. Харин охидыг гэрийн даалгавараа сайн хийдэг гэдэгт эмэгтэй багш нар илүү санал өгсөн байна.

Хүснэгт 35 Хэн нь хичээлээ илүү сонирхолтой хэлбэрээр заадаг вэ?

			Багш нарын хүйс		Нийт
			Эрэгтэй	Эмэгтэй	
Хичээлээ илүү сонирхолтой заадаг багш эрэгтэй юу? эсвэл эмэгтэй юу?	Охид	Тоо	6	44	50
		Хувь	10.5%	16.5%	15.5%
	Хөвгүүд	Тоо	12	17	29
		Хувь	21.1%	6.4%	9.0%
	Хоёулаа	Тоо	38	196	234
		Хувь	66.7%	73.7%	72.4%
	Мэдэхгүй	Тоо	1	9	10
		Хувь	1.8%	3.4%	3.1%
Нийт		Тоо	57	266	323
		Хувь	100.0%	100.0%	100.0%

Хүснэгт 36 Хэн нь таны хичээлийг илүү суралцаж байна вэ?

			Хичээлүүд			Нийт
			Нийгмийн ухаан	Байгалийн ухаан	Бага сургуулийн багш	
Эрэгтэй багш нар	Охид	Тоо	3	3	0	6
		Хувь	15.8%	10.0%	0.0%	10.5%
	Хөвгүүд	Тоо	4	7	1	12

	Хоёулаа	Хувь	21.1%	23.3%	12.5%	21.1%	
		Тоо	11	20	7	38	
	Мэдэхгүй	Хувь	57.9%	66.7%	87.5%	66.7%	
		Тоо	1	0	0	1	
	Нийт	Хувь	5.3%	0.0%	0.0%	1.8%	
		Тоо	19	30	8	57	
Эмэгтэй багш нар	Охид	Хувь	100.0%	100.0%	100.0%	100.0%	
		Тоо	18	14	12	44	
	Хөвгүүд	Хувь	23.4%	16.9%	11.3%	16.5%	
		Тоо	5	5	7	17	
	Хоёулаа	Хувь	6.5%	6.0%	6.6%	6.4%	
		Тоо	52	63	81	196	
	Мэдэхгүй	Хувь	67.5%	75.9%	76.4%	73.7%	
		Тоо	2	1	6	9	
	Нийт	Хувь	2.6%	1.2%	5.7%	3.4%	
		Тоо	77	83	106	266	
			Хувь	100.0%	100.0%	100.0%	100.0%

Хүснэгт 37 Багш нарын заадаг судлагдахуунд охид хөвгүүдийн ялгаа, хувиар

Ойлголтууд	Эрэгтэй багш нарын хариултаар				Эмэгтэй багш нарын хариултаар				Нийт
	Охид	Хөвгүүд	Хоёу Лаа	Мэдэх гүй	Охид	Хөвгүүд	Хоёу Лаа	Мэдэх гүй	
Хэн нь илүү амжилттай суралцдаг вэ?	22.0 %	25.5%	51.1%	1.4%	33.0 %	12.0%	52.7 %	2.3%	<b>100.0</b>
Хичээлийн явцад хэн нь илүү анхааруулга сануулга авдаг вэ?	7.8%	71.6%	19.9%	0.7%	4.3%	80.3%	14.8 %	0.6%	<b>100.0</b>
Хичээлийн бэлтгэлээ хэн нь илүү хангаж ирдэг вэ?	52.5 %	7.1%	39.0%	1.4%	72.4 %	1.4%	23.9 %	2.3%	<b>100.0</b>
Гэрийн даалгаварыг хэн нь илүү гүйцэтгэдэг вэ?	42.6 %	9.9%	45.4%	2.1%	59.3 %	2.6%	37.3 %	0.9%	<b>100.0</b>
Таны хичээлийг хэн нь илүү сонирхон судалдаг вэ?	9.2%	28.4%	57.4%	5.0%	21.7 %	8.0%	67.8 %	2.6%	<b>100.0</b>
Хэн нь бусад сурагчдын суралцах үйл ажиллагаанд илүү тусалдаг вэ?	37.6 %	23.4%	34.8%	4.3%	57.0 %	7.4%	34.5 %	1.1%	<b>100.0</b>
Хэн нь илүү сурах идэвх санаачилгатай вэ?	27.0 %	15.6%	55.3%	2.1%	42.7 %	11.7%	45.0 %	0.6%	<b>100.0</b>
Хичээлийн явцад нэг нь нэгнийгээ шоглох, зохисгүй үг хэллэгийг хэн нь илүү хэрэглэдэг вэ?	2.1%	68.8%	19.9%	9.2%	2.6%	78.3%	12.3 %	6.8%	<b>100.0</b>

...”Одоо бол эрэгтэй эмэгтэй хүүхдүүдийн идэвх санаачилга, сонирхол нь адилхан шүү дээ. Зорилгоо ухамсарлсан л хүйс хамаагүй нь анзаарагддаг. Жишээ нь Японд 1000 инженер бэлтгэнэ, сургана гээд яриад эхэлснээс хойш, маш олон охидууд энэ чиглэлийг сонирхож байгаа.”

*Ганцаарчилсан ярилцлага. УБ. Багануур дүүрэг. Нийгмийн ажилтан*  
...”Хичээлийн явцад эрэгтэй хүүхдүүд л ихэнхдээ сануулга авдаг, тэд ном дэвтрээ авчрахгүйгээс авахуулаад л асуудал гаргаад эхэлдэг, тэгээд хичээлийн бэлтгэлээ авчраагүй хүн чинь яахын хүнээс гуйна, хичээл дээр ярина, нэг охиныг дуудна гээд л эхэлдэг дээ.”


*Охидтой хийсэн бүлгийн ярилцлага. Сүхбаатар аймаг, Баруун урт сум, 4-р сургууль*

Хөвгүүд тухайн нэг хичээлийг зааж байгаа багш эрэгтэй байх тохиодолд илүү сонирхдог болох нь



тодорхой болсон. Тухайлбал нийгмийн ухааны эрэгтэй багш нарын 21.1 хувь, байгалийн ухааны эрэгтэй багш нарын 23.3 хувь, бага ангийн эрэгтэй багш нарын 12.5 хувь нь өөрсдийнх заадаг хичээлд хөвгүүд сонирхолтой байдаг гэж хариулсан бол ямар хичээл заадгаас үл хамааран эмэгтэй багш нарын хичээлд сонирхдог хөвгүүдийн тоо нь 6.4 хувь хүртэл доошилж байгаа статистик хамаарал байгаа юм. Хүснэгт, зургийг харна уу.

Зураг 32 Эрэгтэй, эмэгтэй багшийн ялгаа, 6-12 дугаар ангийн сурагчдын хариултаар (хувиар)



Сурагчдын хариултаас харахад багш-сурагч хоорондын харилцаанд багшийн хүйс чухал биш гэсэн хариулт нийтлэг ажиглагдаж байна. Гэхдээ сурагчдын хэрэгцээ, сонирхлыг тандах, сурагчдад туслан зөвлөх, сурагчидтай тулж ажиллах, сурагчдын оролцоог хангах талаар эмэгтэй багш эрэгтэй багшаас илүү гэсэн хандлага ажиглагдаж байна (Зураг 5.5). Харин сахилга батыг тогтоохдоо хүч хэрэглэх нь эрэгтэй багшид ажиглагддаг гэсэн хариултыг сонгосон нь эмэгтэй багш гэсэн хариултын хувийн жингээс 2 дахин их байна. Энэ бүхэн нь эрэгтэй, эмэгтэй багшийн сурган хүмүүжүүлэх арга барилын ялгааны талаарх эцэг эхчүүдийн хандлагатай төстэй илэрч байгаа аж.

Хүснэгт 38 Эрэгтэй багш нарын багшлах үйл ажиллагаан дахь жендэрийн ялгаатай хандлагын талаарх сурагчдын үзэл баримтлал

Асуулт	Хариултууд	Эрэгтэй сурагч	Эмэгтэй сурагч
Танай ангид хичээл ордог эрэгтэй багш хэний асуусан асуултад илүү хариулдаг вэ?	Охид	12.1	7.3
	Хөвгүүд	7.8	5.4
	Охид хөвгүүд хоёулангийн	69.7	76.2
	Мэдэхгүй	10.0	10.7
	Байхгүй	0.4	0.4
Танай ангид хичээл ордог эрэгтэй багш хэнд илүү их даалгавар өгдөг	Охид	3.5	3.1
	Хөвгүүд	12.6	7.7
	Охид хөвгүүд хоёуланд	71.4	76.6
	Мэдэхгүй	11.7	11.9
	Байхгүй	0.9	0.8

Танай ангид хичээл ордог эрэгтэй багш хэнийг илүү урамшуулан дүгнэдэг вэ?	Охид	11.7	5.7
	Хөвгүүд	13.0	9.6
	Охид хөвгүүд хоёуланг	66.2	70.9
	Мэдэхгүй	8.7	13.4
	Байхгүй	0.4	0.4
Танай ангид хичээл ордог эрэгтэй багш хэнд илүү анхааруулга өгөхдөө доромж үг хэллэг хэрэглэдэг вэ?	Охид	1.7	2.3
	Хөвгүүд	30.7	42.5
	Охид хөвгүүд хоёуланд	15.6	10.3
	Мэдэхгүй	45.0	36.8
	Байхгүй	6.9	8.0

Судалгааны үр дүнгээс харахад дунд, ахлах ангийн сурагчид эрэгтэй багш нарт жендэрийн өрөөсгөл хандлага илт мэдэгдэхүйц ажиглагддаггүй гэжээ. Гэхдээ судалгаанд хамрагдсан сурагчдын хариултаас харахад эрэгтэй багш хөвгүүдэд илүү даалгавар өгдөг, урамшуулан дэмждэг, анхааруулга өгөхдөө доромж үг хэллэг хэрэглэдэг гэж хариулсан байна. Энэ нь хичээлийн үйл явцад хөвгүүд илүү сахилгагүйтэх, гэрийн даалгавраа хийхгүй ирэх, багшийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхгүй байх зэрэг шалтгаанаас болдог байх талтай. Чанарын судалгааны явцад эрэгтэй багш нар хөвгүүдтэй хатуу гараар харилцдаг гэсэн яриа нэлээдгүй таарч байсан нь тоон судалгааны дүнг давхар баталж байна.

Багш нар охид, хөвгүүдийг хувь хүмүүс болохынх нь хувьд хандах ёстой болохоос биш хүйсээс хамаарч харилцах ёсгүй. Багш нар суралцагч хувь хүн бүрийн ур чадвар эсвэл сул тал дээр анхаарч хичээлийг жендэрийн ялгаатай байдал талаас нь хөтлөхгүй байвал зохино. Тэрчлэн багш нар сурагчдад хүйсийн байдлаас үл хамааран ижил тэгш хандах ёстой. Дор харуулсан хүснэгтэд багш нар охид хөвгүүдэд ижил тэгш ханддаг эсэхийг харуулсан байна.

Хүснэгт 39 Эмэгтэй багш нарын багшлах үйл ажиллагаан дахь жендэрийн ялгаатай хандлагын талаарх сурагчдын үзэл баримтлал

Асуулт	Хариултауд	Эрэгтэй сурагч	Эмэгтэй сурагч
Танай ангид хичээл ордог эмэгтэй багш хэний асуусан асуултад илүү хариулдаг вэ?	Охид	15.2	11.1
	Хөвгүүд	8.7	5.4
	Охид хөвгүүд хоёулаа	68.8	77.8
	Мэдэхгүй	7.4	5.7
	Байхгүй		
Танай ангид хичээл ордог эмэгтэй багш хэнд илүү их даалгавар өгдөг	Охид	6.5	4.2
	Хөвгүүд	8.2	2.7
	Охид хөвгүүд хоёулаа	77.5	82.0
	Мэдэхгүй	7.8	11.1
	Байхгүй		
Танай ангид хичээл ордог эмэгтэй багш хэнийг илүү урамшуулан дүгнэдэг вэ?	Охид	14.3	10.7
	Хөвгүүд	7.4	3.8
	Охид хөвгүүд хоёулаа	71.9	75.1
	Мэдэхгүй	6.5	9.6
	Байхгүй		0.8
Танай ангид хичээл ордог эмэгтэй багш хэнд илүү анхааруулга өгөхдөө доромж үг хэллэг хэрэглэдэг вэ?	Охид	3.5	5.8
	Хөвгүүд	22.5	30.8
	Охид хөвгүүд хоёулаа	21.2	14.6
	Мэдэхгүй	45.0	41.5
	Байхгүй	7.8	7.3

Дунд, ахлах ангид хичээл заадаг эмэгтэй багш нар охид хөвгүүдийн асуусан асуултад хариулахдаа хүйсээр илт ялгаварлан гадуурхах хандлага гаргадаггүй болохыг сурагчдын хариултаас харж болно.

Хичээлийн явцад идэвхтэй оролцсон охид, хөвгүүдийг эмэгтэй багш эн тэнцүү урамшуулан сайшаадаг ч, анхааруулга өгөхдөө хөвгүүдэд илүү доромж үг хэллэгийг (тэнэмэл, арчаагүй, хулигаан, новш г.м.) хэрэглэдэг гэж сурагчид үзжээ. Хөвгүүдийн зүгээс хичээлийн үеэр сахилгагүйтэх, үймүүлэх хандлага түлхүү ажиглагддагтай холбоотойгоор эрэгтэй, эмэгтэй багш нарын аль алианаас нь зэмлэл, шийтгэл, цаашлаад доромж үг бүхий зэмлэлийг хүртдэг.

...”Эрэгтэй багшийн давуу тал нь сурагчдыг нам суулгаж байгаад дэлгэрэнгүй сайн ярьж өгдөг. Загнадаггүй. Эмэгтэй багш ч гэсэн сайн тайлбарлаж, зөвлөгөө өгдөг. Хоёулаа л адилхан юм байна.”

*Улаанбаатар хот, Охидын бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*

...”Эмэгтэй багш орж байхад хүүхдүүд хэлсэн үгийг нь сонсохгүй их шуугидаг. Харин эрэгтэй багш хичээл орвол арай дээр бусад нь хичээлээ ойлгоод, эрэгтэй хүүхдүүд үймүүлэхгүй бусадлаа саад болж чадахгүй. Ур чадварын хувьд эмэгтэй багш нар илүү, хичээлээ ойлгомжтой заадаг. Одоогийн байдалд эмэгтэй багш илүү чадвартай байна. Манай сургуульд эрэгтэй багш цөөн, эрэгтэй багшийн ордог хичээл гэвэл технологи болон биеийн тамирын хичээл байна.”

*Завхан аймаг, Охидын бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*

...”Ер нь бол эрэгтэй багш орвол арай хөгжилтэй. Гэхдээ багш бол багш. Эрэгтэй, эмэгтэй хамаагүй. Гэхдээ эрэгтэй багшийн заах арга барил, эмэгтэй багшийн арга барил 2 ондоо. Манай ангид эрэгтэй багш ганцхан л хичээл ордог. Тэр нь химийн багш. Тэр багш илүү чөлөөтэй, нээлттэй үздэг. Гэхдээ одоо бүх сургуулиудад эрэгтэй багш нар ховор. Ихэвчлэн эмэгтэй багш нар байдаг.”

*Улаанбаатар хот, Хөвгүүдийн бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*

...”Эрэгтэй багшаар заалгах дуртай. Учир нь илүү нээлттэй, тоглоомын аргаар хичээл заадаг. Эмэгтэй багш эрэгтэй багшаасаа илүү бүтээлч байдаг.”

*Сэлэнгэ аймаг, Хөвгүүдийн бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*

Судалгааны үр дүнгээс харахад бага ангийн охид, хөвгүүд хоёулаа (62.2 хувь) хичээлийн бэлтгэлээ сайн хангаж ирдэг боловч хөвгүүдийг бодоход охид илүү (32.1 хувь) багшийн гэрт өгсөн дасгал ажлуудыг нягт нямбай, бүрэн гүйцэд хариуцлагатай гүйцэтгэдэг байна. Харин дунд болон ахлах ангийн сурагчдын хувьд хичээлдээ аль аль нь сайн бэлтгэж ирдэг (41.7%) болон хөвгүүд илүү сайн бэлтгэж ирдэг (3.5%) гэсэн хариултын жин тус тус буурч байна. Сурагчдын хариултаас харахад анги ахих тусам хөвгүүдийн хичээлийн бэлтгэл буурч байхад охид тогтвортойгоор хичээлээ давтаж, гэрийн даалгавраа сайтар гүйцэтгэдэг байдал ажиглагдаж байна. Энэ нь охид, хөвгүүдийн суралцах үйлийн ялгааны талаарх эцэг эхчүүдийн дүгнэлттэй төстэй байгаа ба хөвгүүдийн хичээлийн бэлтгэлгүй, гэрийн даалгаврын гүйцэтгэл тааруу байгааг онцгойлон анхаарч, энэхүү онцлогийг багш нар багшлах үйл ажиллагаандаа анхаарвал зохино.

Судалгаанд хамрагдсан бага ангийн нийт 246 сурагчдаас хөвгүүдийн 84.2 хувь, охидын 87.4 хувь нь хичээл огт тасалдаггүй бол эрэгтэй, эмэгтэй сурагчдад улиралд 1 удаа хичээл таслах тохиолдол гардаг байна. Сард 1 удаа таслах тохиолдол хөвгүүд охидыг бодоход 2 дахин их байна. Энэ нь хүргэх хүнгүйгээс, ажил хийдэг, өвдсөнөөс шалтгаалж хичээлээ тасалдаг аж. Эрэгтэй сурагчдын 84.2 хувь, эмэгтэй сурагчдын 87.4 хувь нь хичээл хийх цаг зав гардаг байна. Харин охид, хөвгүүдийн хичээл хийх цаг зав гардаггүй үндсэн шалтгааныг сурагчид үзэхдээ хичээлээс гадуурх дугуйлантай холбон тайлбарлажээ.

Дунд, ахлах ангийн сурагчдын 274 буюу 55.7 хувь нь үүнээс хөвгүүдийн 49.4 хувь, охидын 61.3 хувь нь хичээлээ огт тасалдаггүй байгаа нь охид хөвгүүд хичээлдээ идэвхтэй, хариуцлагатай ханддаг гэж дүгнэлээ. Харин улиралд 1 удаа тасалдаг хөвгүүдийн эзлэх хувь 19.0, охидын эзлэх хувь 15.7, харин хөвгүүдийн 14.3 хувь нь сард 1 удаа тасалдаг, 8.7 хувь нь сард 2-3 удаа тасалдаг байна. Хичээл таслалтын үндсэн шалтгаан нь унтаад хичээлээс хоцордог, гэр хол учраас, найзууд тасалдаг, өвдөх тохиолдолоос болдог гэжээ. Судалгаанд хамрагдсан эрэгтэй сурагчдын 87.9 хувь, эмэгтэй сурагчдын 85.4 хувь нь гэрийн даалгавраа хийх хангалттай цаг байдаг, харин хичээл хийх цаг зав гардаггүй нь охид хөвгүүдийн хувьд дугуйланд явах, цагийн ажил хийх, дүүгээ харах асрах зэрэг шалтгаантай холбоотой ажээ.

### Хичээл таслалтын шалтгаан

...”Сүүлийн цагийн хичээл дээр хүүхдүүд, ялангуяа хөвгүүд их тасалдаг.”

*Улаанбаатар хот, Охидын бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*  
 ...”Ер нь хөдөөний, эрэгтэй хүүхдүүд хичээл тасалдаг. Ялангуяа гэр нь хөдөө байдаг тохиолдолд 5 өдрийн сүүлийн цагийн хичээл дээр суудаггүй. Хөдөөнөөс аав ээж эсвэл хамаатан садан нь ирээд аваад явдаг. Багш нар хөвгүүд тасалсан байхад нэг их загнаад байдаггүй, харин охид тасалсан бол илүү анхааруулга өгдөг. Охин юм байж гээд л загнаад байдаг.”

*Завхан аймаг, Охидын бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*

...”Эрэгтэй хүүхдүүд хичээлээ их тасалдаг. Охидын хувьд таслах нь ховор.”

*Орхон аймаг, Охидын бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*  
 ...”Тэмцээнтэй үед чөлөө аваад зарим үед нь багш нар тас гээд биччихдэг. Манай ангийн нэг охин 10 сараас хойш хичээлдээ суухгүй байж байгаад багшид хэлэлгүй, холбоо ч барилгүй Солонгос явчихсан байсан. Тэгээд 1 сард ирээд шууд хичээлдээ ороод ирсэн. Тэгэхэд багш тэр охиныг асуудал болгоогүй. Харин хөвгүүдийг нэг цаг тасалвал бөөн юм болдог. Охидуудыг нэг цаг таслахад ямар нэг шалтгаантай байгаа гээд л тас тавихгүй хүлээн, ирэхээр нь шалтгааныг асуугаад өвчтэй л байж таарна гэдэг. Хөвгүүдийг бол өвчтэй гэхэд худлаа магадлагаа авчир гэж шаарддаг. Уг нь бол үнэнгээ хэлээд байдаг, тэгэж худлаа яриад хашраасан зүйл бол баймааргүй л юм гайхмаар санагдах үе байна.”

*Улаанбаатар хот, Хөвгүүдийн бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*

...”Хөвгүүд илүү тасалдаг. Хөвгүүд гэрийн ажил, нүүдэл суудал хийх, хавар намар тариа ногооны ажил, мал төллөх үеэр их тасалдаг. Охид тасалбал охидод ажил гарсан гэж багш нар бодоод чөлөөтэй гэж тавьдаг. Хөвгүүдийг шууд тасаар авдаг. Эрэгтэй эмэгтэй багшийн аль аль нь ингэж ханддаг.”

*Ховд аймаг, Хөвгүүдийн бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*

Хөвгүүд үзэхдээ ар гэрийн болон бусад шалтгаанаар хичээл таслах тохиолдолд багш нар шууд тасалсанд тооцон, харин охид тасалбал чөлөөтэй гэж бүртгэх зэрэг ялгаатай байдал эрэгтэй эмэгтэй багш нарын аль аль нь гаргадаг байна. Сургуулийн орчинд багш нарын зүгээс охид хөвгүүдэд ялгаатай хандах байдал гарсаар байгааг анхааран, тэдэнд ялгаварлан гадуурхалтаас зайлсхийх, сурагчдад жендэрийн мэдрэмжтэй хандах ур чадварыг эзэмшүүлэх нь чухал байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох тухай их яригдах боллоо. Сурагчдын байгалиас заяагдсан өгөгдөл болон авьяас, хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд суурилсан мэргэжил сонголт хийх нь хамгийн чухал, амжилт гаргах үндэс болдог.

Хүснэгт 40 Сурагчдын хамгийн дуртай хичээлийг анги, хүйсээр харьцуулсан байдал

Бага ангийн хичээлийн нэр	1-5 ангийн сурагчид		Дунд, ахлах ангийн хичээлийн нэр	6-12 ангийн сурагчид	
	Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Математик	34.1	40.2	Математик	21.0	46.0
Монгол хэл	15.8	19.5	Монгол хэл, уран зохиол	9.7	15.2
Англи хэл	2.0	5.3	Газар зүй	2.2	3.8
Биеийн тамир	21.1	11.4	Зураг зүй, технологи	7.0	6.0
Хүн ба орчин	4.5	3.6	Мэдээлэл зүй	2.0	1.6
Дүрслэх урлаг, технологи	14.6	14.2	Түүх	3.4	2.2
Дуу хөгжим	1.6	2.8	Дуу хөгжим	0.6	1.2
Иргэний боловсрол	0.8	0.4	Англи хэл	8.1	11.1
Шатар	0.8	1.6	Хятад хэл		1.0
Казак хэл		0.4	Орос хэл	0.8	4.6
Хүн ба нийгэм		0.4	Биеийн тамир	19.3	12.0

			Биологи	5.2	4.0
			Хими	4.4	8.1
			Физик	4.6	5.2
			Нийгмийн ухаан	4.6	7.7
			Монгол бичиг		0.6
			Иргэний боловсрол	0.2	0.2
			Сонгон хичээл: даам	0.4	

Судалгаанд хамрагдсан 1-5 ангийн сурагчдын хариултаас үзэхэд математик, монгол хэл, биеийн тамир, дүрслэх урлаг, технологийн хичээлд дуртай, сонирхолтой гэсэн хариултын эзлэх хувь нь өндөр байна. Охид хөвгүүдтэй харьцуулахад маш олон хичээлд хөвгүүдээс илүү сонирхолтойгоо илэрхийлсэн бол хөвгүүд охидоос илүү биеийн тамирын хичээлд сонирхолтой байх хандлага харагдаж байна. Мөн хөвгүүдийн хамгийн дуртай, сонирхолтой хичээл нь математик, биеийн тамир, харин охидын хувьд математик, англи хэлний хичээлийг хамгийн дуртай, сонирхолтой гэж хариулсан хариултын эзлэх хувь бусад хичээлүүдийг бодвол өндөр байна. Гэхдээ математикийн хичээлд дуртай гэж хариулсан охидын хувь хөвгүүдээс ямагт их байгаа нь охид ч математикт дуртай биш гэсэн ойлголтыг няцаахуйц үр дүн байна.

Хүснэгт 41 Сурагчдын хамгийн дургүй хичээлийг анги, хүйсээр харьцуулсан байдал

Бага ангийн хичээлийн нэр	1-5 ангийн сурагчид		Дунд, ахлах ангийн хичээлийн нэр	6-12 ангийн сурагчид	
	Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Математик	4.0	3.6	Математик	7.1	10.3
Монгол хэл	10.5	5.2	Монгол хэл, уран зохиол	5.2	5.4
Англи хэл	1.2	0.4	Газар зүй	1.6	3.6
Биеийн тамир	3.6	4.0	Зураг зүй, технологи	4.2	6.0
Хүн ба орчин	11.7	8.9	Мэдээлэл зүй	1.4	0.6
Дүрслэх урлаг, технологи	4.8	2.8	Түүх	2.2	1.2
Дуу хөгжим	7.7	5.6	Дуу хөгжим	0.4	1.2
Иргэний боловсрол	5.2	3.2	Англи хэл	5.4	3.6
Казак хэл	0.8	0.8	Орос хэл	2.0	1.6
Хүн ба нийгэм	4.4	5.6	Биеийн тамир	2.2	7.9
			Биологи	4.2	4.6
			Хими	5.8	3.4
			Физик	5.8	7.7
			Нийгмийн ухаан	2.6	1.2
			Монгол бичиг	1.6	4.0
			Иргэний боловсрол	0.8	2.6

Бага ангийн эрэгтэй, эмэгтэй сурагчдын дургүй гэж нэрлэсэн хичээлүүдийг харахад хөвгүүдийн хувьд монгол хэл, хүн ба орчин, харин охидын хувьд хүн ба орчин, хүн ба нийгэм зэрэг хичээлүүдийг түлхүү нэрлэж байна. Харин дунд, ахлах ангийн хөвгүүд нь хамгийн дургүй, сонирхолгүй хичээлээр математик, хими, физик, англи хэл, монгол хэл, уран зохиол зэрэг хичээлүүдийг нэрлэсэн ба энэ нь хөвгүүд байгалийн ухааны хичээлд дуртай гэх жендэрийн хэвшмэл ойлголтыг басхүү няцааж байна.

Бага ангийн эрэгтэй сурагчдын 83.3 хувь, эмэгтэй сурагчдын 93 хувь нь хамгийн дуртай багшаар эмэгтэй багшийг сонгосон нь анги удирдсан болон хичээл ордог багш нь гол төлөв эмэгтэй багш нар байдагтай холбож болох юм. Хамгийн дуртай багш нь математик, монгол хэл, дүрслэх урлаг, англи хэлний хичээл, дуу хөгжим, шатрын хичээл заадаг байна. Судалгаанд хамрагдсан дунд, ахлах ангийн эмэгтэй сурагчдын 81.2 хувь нь эмэгтэй багшаар хичээл заалгах дуртай байдаг бол хөвгүүдийн ойролцоогоор 1/2 нь эрэгтэй багшаар хичээл заалгах дуртай гэжээ. Эрэгтэй, эмэгтэй сурагчид үзэхдээ багшийн заадаг хичээл ойлгомжтой (44.3 хувь), багш тоглоомын аргаар (22.0 хувь), багш сурагчидтай ярилцаж, санаа бодлоо солилцдог, оролцуулдаг (15.4 хувь) байдлаар явагддаг нь илүү тухайн багшид

дуртай байх үндэслэл болдог гэжээ. Энэ нь 6-аас дээш ангийн сурагчдын дунд басхүү илэрч байна. Охид эмэгтэй багшдаа, хөвгүүд эрэгтэй багшид илүү дуртай байх хандлага судалгааны явцад ажиглагдаж байсан.

#### **Сурагчдын хамгийн дуртай, сонирхолтой болон дургүй, сохирхолгүй хичээлүүд**

....”Биеийн тамир, англи хэл, математик, хими, физикийн хичээлд илүү сонирхолтой байдаг. Өөрөө ч сонирхдог, багш сонирхолтой заадаг, мөн ирээдүйд эзэмших мэргэжилтэй холбоотой юм. Сонирхолгүй, ойлгодоггүй, мэргэжил эзэмшихэд шаардлагагүй хичээл байдаг. Тухайлбал, монгол хэл, уран зохиол, биологи гэх мэт.”

*Завхан аймаг, Охидын бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

....”Хамгийн дургүй, сонирхолгүй хичээл бол физик, хими, орос хэлний хичээлд дургүй. Уг нь физикийн хичээлд сайн байсан багш нь солигдоод хичээлээ ойлгохгүй эрс муудсан.”

*Сүхбаатар аймаг, Охидын бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

... ”Бид нарын хамгийн дуртай, сонирхолтой хичээл нь биеийн тамир юм. Уг хичээл дээр сагс, хөгжилтэй тоглоом тоглодог. Хамгийн дургүй хичээл бол дуу хөгжим, уйтгартай байдаг.”

*Орхон аймаг, Хөвгүүдийн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

....”Хамгийн дуртай хичээл бол математик, монгол хэл, биеийн тамир, зураг зүй, технологи, биологи, түүх юм. Гэхдээ хүүхдийн сонирхол өөр өөр байдаг. Харин монгол бичгийн хичээлд дургүй, анхнаасаа сайн ойлгоогүйтэй холбоотой байх.”

*Улаанбаатар хот, Хөвгүүдийн бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс*

#### **4.4 Багш бэлтгэх, давтан сургахад жендэрийн агуулгыг тусгах хэрэгцээ ба хэрэгжүүлэх арга зам**

Өмнөх бүлэгт өгүүлсэнчлэн заах, суралцах үйл явцад багш нар голлох үүрэгтэй тухай, тэдний жендэрийн талаар ойлголт, мэдлэг нь сурагчдын адил тэгш оролцоог хангахад шийдвэрлэх нөлөөтэй байдаг. Цаашлаад багш нар сурагчдын жендэрийн үүргийн талаарх ойлголт хэрхэн төлөвших, жендэрийн хэвшмэл үзэгдлийг тээгч байх уу, түүнийг шинэчлэгч болох уу гэдэгт нөлөө үзүүлж чадах гол хүн билээ. Багш нар жендэрийн мэдрэмжтэй, багшлах үйл ажиллагаандаа ч жендэрийн баримжаатай ханддаг байх ёстой. Үүний тулд өнөөгийн болоод ирээдүйн багш нар ажил дээр гарахын өмнө болоод ажил дээр гарсан хойноо жендэрийн боловсрол олгох сургалтад хамрагдах шаардлагатай байна. Ингэснээр тэд сургуулийн орчинд болоод нийгэмд жендэрээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг арилгахад оролцож, боловсролын салбарын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж чадах юм. Монгол Улсын Засгийн Газар багш нарын боловсролыг дээшлүүлэх, сурган хүмүүжүүлэх мэргэжлийн хөгжлийг тасралтгүй үргэлжлүүлэх, багш мэргэжилдээ дур сонирхолтой байхад нь дэмжих шаардлагатай байгааг онцлон авч үздэг.

Энэ бүлгийн зорилго нь багшлах боловсон хүчний сургалтанд ажил дээр гарахын өмнө болоод хойно жендэрийн боловсрол олгох сургалт хөтөлбөр ямар байдлаар хэрэгждэг тухай судалсан ба орхигдсон цоорхойг илрүүлэх тал дээр анхаарч авч үзлээ. Юуны өмнө багшийн мэргэжил олгох боловсролын хөтөлбөр жендэрийн асуудал хэрхэн тусгагдсаныг, дараа нь хөдөө орон нутгийн болоод хотод ажиллаж байгаа багш нарт зориулсан сургалт, түүний агуулгыг багш мэргэжлийн тасралтгүй сургалтанд жендэрийн асуудлыг хэр зэрэг оруулсан байгааг судаллаа. Эцэст нь судалгааны үр дүн болоод ажлын талбарт гарахын өмнө болоод дараа нь жендэрийн мэдлэгийг нэмэх зорилгоор авч хэрэгжүүлж болох арга хэмжээ, саналыг нэгтгэн бичлээ.

##### **4.4.1 Багш бэлтгэх сургуулиудын хөтөлбөрт жендэрийн агуулгыг тусгасан байдал**

Одоогоор манай улсад нийт улсын болоод хувийн нийлсэн 30 орчим багшлах боловсон хүчин

бэлтгэх институтийг жил бүр ойролцоогоор 5000 оюутан багшлах эрхтэй төгсөж байна.<sup>63</sup> Хамгийн том нь Монгол Улсын Боловсролын их сургууль (МУБИС) багшийн боловсролд 65 жилийн туршлагатай бөгөөд жил бүр 14 мэргэжлээр 2000 оюутныг бакалаврын зэрэгтэй төгсгөж байна. Багшийн мэргэжил олгох боловсрол нь 4 жилийн танхимын сургалт, 4-8 долоо хоногийн дунд сургууль дээр хийх дадлага хичээлээс бүрдэнэ. Багш нарын шагнал урамшуулал, ажил дээр нь барьж тогтоох арга хэмжээ нь энэ салбарын хувьд хөшингө хойрго байгааг мөн багш боловсон хүчнийг бэлтгэл, сургалт цаашид ч дорвитой сайжрах төлөв ажиглагдахгүй байгаа талаар дэлхийн банкнаас явуулсан судалгааны дүнд бичсэн байна.<sup>64</sup>

Багш бэлтгэх хөтөлбөрт жендэрийн агуулга төдийлөн тусгагдаагүй гэж хэлж болохоор байна. Багш мэргэжил олгох бусад их, дээдл сургуулийн нэгэнд нь ч жендерийн талаар заасуудлахвал хичээл байхгүй ба сонгон судлах хичээлд байгаа боловч түүнтийг сонгон суралцаж байгаа суралцагчдын мэдээлэл байхгүй байна. Багш мэргэжлийн суурь хичээлийн хөтөлбөрийн агуулгад дүн шинжилгээ хийхэд Боловсролын сэтгэл судлал хичээлийн агуулгад охид, хөвгүүдийн суралцахуйн ялгааг хөндсөнөөс бусад хөтөлбөрт ажиглагдсангүй. Харин “Нийгмийн ухааны багш” болох оюутнууд жендэрийн агуулгыг дараах хичээлүүдээр судалдаг ажээ. Үүнд: заавал судлах хичээл болох социологи, хүний эрх, нийгмийн давхраажилт г.м, сонгон судлах хичээлүүд болох Жендэр ба нийгэм, Жендэр ба улс төр гэсэн жендэрийн асуудлыг шууд хөндсөн хөтөлбөрүүдийг судлах боломжтойгоор боловсруулагджээ. БСШУ-ы сайдын 2014 оны 4 сарын 28-ны А/174 тоот тушаалын хавсралтаар “Дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ыг баталсан ба үүнд ерөнхий суурь хичээлийн чиглэл, агуулгыг ерөнхийлөн зөвлөмжилсөн. Ерөнхий суурь хичээлийн хөтөлбөрт жендэрт дам холбогдох агуулгыг тусгаснаас биш, жендэрийн асуудлыг хөндсөн агуулгыг огт тусгаагүй байна

Жендэрийн сэдэв багшийн мэргэжил олгох сургалтанд шинэ тутам байгаа учраас судалгаанд оролцсон багш нарын дөнгөж 5.3 хувь нь жендэртэй холбоотой тусгай хичээл үзсэн байна. Дийлэнх нь (89.5 хувь) багшийн коллеж, их сургууль жендэрийн тухай тусгай хичээл үзэж байгаагүйгээ гэжээ.

“...Би 1983 он Багшийн коллежийг төгсөөд, 1990 онд Гадаад хэлний сургуулийг орос хэлний багш мэргэжлээр төгссөн. Түүнээс хойш дунд, ахлах ангиудад орос хэл зааж байна. Намайг суралцаж байх үед жендэрийн тухай тусдаа хичээл байтугай аль нэг хичээлийн сэдэв болгож ч орж байгаагүй. Миний насны үеийн багш нар жендэрийн талаар сайн мэдэхгүй байхаа гэж бодож байна. Тэглээ ч би 3 жил болоод 55 хүрч тэтгэвэртээ гарлаа даа, миний үеийн багш нарын зарим нь 4 хүүхэд төрүүлж өсгөсөн гээд 50 насандаа чөлөөндөө гарсан нь ч байна.”

*Орос хэлний багшаар 26 жил ажилласан ахлах сургуулийн багштай хийсэн ярилцлага*


Багш мэргэжлээр суралцаж байгаа оюутнууд заах хичээлийнхээ талаар мэдлэгтэй байхын зэрэгцээ мэргэжлийн ур чадварт суралцах ёстой байдаг. Тэдний мэргэжлийн хичээл нь онолын (сургах, сэтгэл зүй г.м) хичээлээс гадна дунд сургууль дээр хийх дадлагаас бүрдэнэ. Заах арга зүй (багшлах боловсролын онол) ба сэтгэл судлал бол багш мэргэжилтэн бэлтгэдэг их сургууль, коллежид үндсэн хичээл болж ордог боловч жендэрийн ялгаатай байдлын тухай хичээлийн хөтөлбөрт хангалттай тусгаагүй байна. Судалгаанаас үзэхэд дөрвөн багш тутмын гурав нь охид, хөвгүүдийн онцлог ялгаатай хэрэгцээг ойлгож, суралцах бололцоог адил тэгш олгох, ангид охид хөвгүүдийн оролцоог ижил байлгаж, жендэрийн мэдрэмжтэй багш байх тал дээр эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварыг эзэмшээгүй байна. Судалгаанд оролцсон багш нарын дөнгөж 23.4 хувь нь л дээрх сэдвүүдийг хичээлээр үзэж байсан гэж хариулсан байна.

<sup>63</sup>2015 оны байдлаар 22,664 оюутан багш мэргэжлээр зэрэг олгох сургалтанд хамрагдаж байсан ба тэдний 12.7 хувь нь коллежид суралцаж байжээ. Багш мэргэжилт бол худалдаа, бизнесийн удирдлага (21.4 хувь), инженер (14.1 хувь)-ийн дараагаар гурав дугаарт бичигдэх нийтлэг мэргэжил юм.

<sup>64</sup>Дэлхийн банк 2014, Боловсролын чанарын хувьсгал төсөл, Төслийн хавсралт бичиг, 3 дугаар хуудас

Судалгаанд оролцогчдоос багш мэргэжлээр суралцаж байхад болон багшлах эрхийн сургалтад суухад жендэртэй холбоотой хичээл орж байсан эсэхийг тодруусан. Багш нарын 85.9 хувь нь орж байгаагүй, 5.3 хувь нь орж байсан, 8.9 хувь нь мэдэхгүй гэж хариулснаас ийм төрлийн мэдээлэл мэдлэгийг суралцаж байхад нь бараг олгоогүй гэж дүгнэж болохоор байна.

Зураг 33 Багшаар суралцаж байхад жендэрийн талаарх мэдлэг олгогдсон эсэх, нас, хувиар




Бидний таамагласнаар хамгийн залуу багш нар жендэрийн талаарх мэдлэг мэдээллийг нилээдгүй үзэж сонссон гэсэн хариултыг сонгох байх гэж бодсон ч, эсрэгээрээ үр дүн гарлаа. 22-30 насныхны хувьд учир дутагдалтай байсан, олгогдож чадаагүй гэдэг нь нийлээд 78.7 хувьтай байгаагаас энэ ойлголт өнөөдрийн багш бэлтгэх боловсролын системд дурьдагдаад өнгөрч

байна гэж дүгнэж байна. Харин олгогдож чадсан гэж үзсэн хариулагсдаас суралцаж байх үедээ ямар төрлийн хичээлээр гэдгийг тодруулахад сэтгэл судлал, боловсрол судлал, багшийн хөгжил, эрүүл мэнд, менежмент, эрхийн харилцаа, нийгэм, хүүхдийн эрхийн боловсрол зэрэг судлагдахууныг нэрлэсэн байна.

Жендэр, жендэрийн тэгш байдлын талаар тусгайлан хичээл орж байгаагүй ч, ямар нэг судлагдахууны хүрээнд энэ талын ойлголт өгсөн эсэхийг судаллаа. Багш нарын 60.0 хувь нь орж байгаагүй, 28.5 хувь мэдэхгүй, дөнгөж 11.6 хувь нь орж байсан гэж хариулсан байна. Сэтгэл судлал 2.8 хувь, нийгэм хүн орчин, улс төрийн хичээлүүд 2.6 хувь нь, гар оёдол, эрх зүй, хүүхдийн эрх, анагаах эрүүл мэнд, багш боловсролын үндэс зэрэг судлагдахууны хүрээнд жендэр, жендэрийн тэгш байдлын талаар орж байсан ажээ.

Зураг 34 Жендэрийн ойлголт сэтгэл судлал, сурган, дидактикийн хичээлүүдэд



Багшийн мэргэжил эзэмшихэд заавал судлах шаардлагатай сэтгэл судлал сурган хүмүүжүүлэх ухаан, боловсрол судлал, дидактикийн хичээлүүдэд охид хөвгүүдийн ялгааг харгалзах, адил тэгш оролцох боломжийг бүрдүүлэх талаар мэдлэг чадвар хандлага олгогдож байгаад шинжилгээ хийсэн.

Багшаар суралцагсдын хувьд дээрх судлагдахууны агуулга, арга зүйд жендэр, жендэрийн тэгш эрхийн



асуудлууд учир дутагдалтай заагддаг гэдэгт 65 хувь нь санал өгснөөс одоогийн багш бэлтгэх хөтөлбөрийн заавал үзэх судлагдахууны цөмд жендэрийн талаарх ойлголтууд хангалттай тусгаагүйг харуулж байна.

”...Би Монгол Улсын Боловсролын их сургуулийг 2013 онд бага ангийн багш мэргэжлээр төгссөн. Их сургуульд үзсэн хичээлд жендэрийн тухай ерөөсөө байгаагүй. Би сурагчдын онцлог, ялгаатай хэрэгцээг таньж, насанд нь тохируулж зааж сургах хэрэгтэй гэж заалгаж байснаас хүйсийн онцлог ялгаа гэж заалгаж байгаагүй.”

*Гурав дах жилдээ ажиллаж байгаа залуу багштай хийсэн ярилцлагаас, Улаанбаатар*

Судалгааны үр дүнгээс үзэхэд багш нар анх багш мэргэжил олгох сургалтандаа жендерийн тухай, жендэрийн мэдрэмжтэй заах арга зүйн талаар зохих сургалт мэдээллийг авч байгаагүй гэж дүгнэж болохоор байна. Жендэрийн тухай багш мэргэжил олгох сургалтын хөтөлбөрт тухайлж оруулсан сэдэв бага, энэ сэдвийн хичээл нь ирээдүйн багш боловсон хүчнийг жендэрээр ялгаварлан гадуурхдаггүй, охид хөвгүүдэд ижил бололцоо олгодог, жендэрийн тэгш байдлыг дэмждэг, боловсрол дахь тэгш оролцоог чухалчилдаг мэргэжилтэн болгон төлөвшихөд хангалттай хичээл орж чадахгүй байна.

#### **4.4.2 Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд жендэрийн агуулгыг тусгасан байдал**

Багш бол насан туршийн суралцдаг мэргэжил, тийм ч учраас багш нар байнга өөрийн зааж байгаа хичээлийн талаарх мэдлэг болоод заах арга барил, ур чадвараа сайжруулж байх шаардлагатай байдаг. Засгийн газрын зүгээс ажиллаж байгаа багш нараа сургах тал дээр анхаарч, боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад тохиодолж байгаа саад бэрхшээл, хөгжүүлэн сайжруулах хэрэгцээг нь харгалзаж хичээлийн шинэ хөтөлбөр боловсруулах зэргээр ажлын байран дээрээ хөгжих бололцоог олгодог байх шаардлагатай. Боловсролын шинэчлэл хийх бодлогын хүрээнд багш мэргэжлийн тасралтгүй сургалтыг албан ёсны болгосноор<sup>65</sup> сүүлийн жилүүдэд нилээд ахиц гараад байна. Боловсролын яамны сайд “Сургуулийн өмнөх, бага дунд ангийн багш боловсон хүчний мэргэжлийн хөгжлийг зохицуулах тухай” (2013 оны 8 дугаар сарын 9-ны өдрийн А/287 тоот тушаал) ба “Багшлах эрх, мэргэжлийн зэргийг олгох, эргэн сэргээх тухай” (2013 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн А/305/3 тоот тушаал), “2012-2016 оны багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийг гаргасан. Эдгээр бодлогын баримт бичиг нь багш мэргэжлийн чанарыг сайжруулах, ажлын талбарт байгаа багш, сургуулийн удирдах ажилтнуудыг өөр хоорондоо хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэх, орон нутаг, бүс нутаг, улсын хэмжээнд сайн туршлагаа солилцох үйл ажиллагааг зохион байгуулахад нь дэмжсэн үйл ажиллагаа хөгжих таатай нөхцлийг бүрдүүлж ажил хэрэг болсон юм.

Багш нарыг шалгах нь тэднийг сургах, хөгжүүлэх, чанартай заах ур чадвар эзэмших үйл явцыг дэмжиж байгаа юм. Багш нарыг магадлан итгэмжлэх, мэргэжлийн ур чадварын зэрэг олгох<sup>66</sup> ба мэргэжлийн ур чадвараа ахиулах хооронд нь харилцан уялдаатай болсон. 3 жил ба түүнээс урт хугацаагаар сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон дунд сургуульд багшлах үйл ажиллагаанаасаа хөндийрсөн тохиолдолд багш нар итгэмжлэх зөвлөлөөр орно, мөн ажиллах үедээ эхний жил, тав дах болон арав дах жилдээ багшлах эрхээ сунгахын тулд мөн тус зөвлөлөөр орж эрхээ авахын зэрэгцээ мэргэжлийн зэргээ үнэлүүлж ахиулах боломжтой.

<sup>65</sup>Багшийн хөгжлийн газар нь 2010 онд Монгол Улсын Засгийн Газрын 180 тоот тогтоолоор бие даасан институт болж зохион байгуулагдсан.


<sup>66</sup>Багшийн мэргэжлийн зэрэг олгох эрэмбэ нь багш, заах арга зүйч багш, ахлах багш, зөвлөх багш гэсэн дараалалтай. Ажиллаж эхэлснээс хойш тав дах жилдээ заах арга зүйч багш, арав дах жилээ ахлах багш, 15 дах жилдээ зөвлөх багш болно. Заах арга зүйч багш, ахлах багшийн зэрэг нь 5 жилийн хүчинтэй, зөвлөх багшийн зэрэг 10 жилийн хүчинтэй.

Хүснэгт 42 Багш нарыг дахин бэлтгэж буйд байдал, хүйс болон байршлаар

		Хот		Хөдөө		Нийт
		Male	Female	Male	Female	
Гадаадын сургалт	Тоо	158	937	544	2054	<b>3693</b>
	Хувь	4%	25%	15%	56%	100%
Үндэсний хэмжээний сургалт	Тоо	13	142	167	651	<b>973</b>
	Хувь	1%	15%	17%	67%	100%
Бус нутгийн сургалт	Тоо	400	2832	1212	5921	<b>10365</b>
	Хувь	4%	27%	12%	57%	100%
Орон нутгийн сургалт	Тоо	945	4521	198	1533	<b>7197</b>
	Хувь	13%	63%	3%	21%	100%
Нийт	Тоо	1516	8432	2121	10159	<b>22228</b>
	Хувь	7%	38%	10%	46%	100%

Эх сурвалж: ҮСХ, Боловсрол, соёл, шинжлэх ухааны статистик, УБ 2015

Ажиллах явцдаа мэргэжлээрээ суралцаж хөгжих 3 төрлийн сонголт байна. Үүнд: тухайлсан мэргэжилдээ нарийсгаж сурах, ингэхдээ Засгийн газрын агентлагаас явуулж байгаа сургалтанд хамрагдах, төрийн бус байгууллагууд болоод бусад сургалтын газруудад хандах, олон улсын байгууллагаас хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрт хамрагдах боломжтой.



Ажлынхаа хажуугаар багшийн мэргэжлээ сайжруулах, хөгжүүлэх сургалт нь дараах хэд хэдэн зорилттой байна. Үүнд:

- багшийн зааж байгаа хичээл дээр тухайн салбарт гарсан ололт нээлттэй холбоотой гарсан шинэ мэдлэг мэдээллээр багш нарын мэдлэгийг нэмэх
- заах арга зүйд гарсан ололт, боловсролын чиглэлээр хийгдсэн шинэ судалгаа, нөхцөл байдал, зорилтод үндэслсэн багшлах ур чадвар, хандлага, арга барилыг шинэчлэх
- хичээлийн хөтөлбөр болоод сургах үйл явцад гарсан өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд туслах
- хичээлийн хөтөлбөр, сургах үйл явцын шинэ арга барилыг сургуульд нэвтрүүлэх

#### Мэргэжил дээшлүүлэх

Охид, хөвгүүдийн ялгааг харгалзах, адил тэгш боломжийг бүрдүүлэх талаар мэдлэг ойлголт мэргэжил дээшлүүлэх сургалтаар маш бага олгогддог. Багш нарын 83.1 хувь нь мэргэжил дээшлүүлэх хүрээнд жөндөртэй холбоотой ямар нэгэн сургалтад хамрагдаагүй гэж хариулснаас дүгнэж байна. Харин бага зэрэг олгогддог гэж хариулагсад дараах сургалтуудыг нэрлэсэн

байна. Үүнд: Сургуулийн захиргаанаас явуулсан сургалт (1.6 хувь), багшийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан сургалтыг (1.6 хувь) багш нар үзсэн. Нийт хариултын дотор маш бага хувийг эзэлж байсан ч тодорхой сургалтыг явуулсан гэдэгт Үйлдвэрчний эвлэлийн хороо, Нийслэлийн боловсролын газар, Тогтвортой хөгжлийн боловсролын төсөл, Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг төв, Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх төв, Хүний эрх төв, Боловсролын үндэсний төв болон олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтуудыг гэж тус тус нэрлэсэн байна.


## БҮЛЭГ 5. ЖЕНДЭРИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА

### 5.1 Эцэг эхчүүдийн жендэрийн талаарх хандлага

#### 5.1.1 Эцэг эхчүүдийн жендэрийн үүрэг, жендэрийн хэвшмэл ойлголт

Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн өгсөн мэдээллээс харахад, нийгмийн амьдрал, шийдвэр гаргах түвшин дэх эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог жендэр гэж ойлгогдоо 80 хувь, “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм соёлын ялгааг тусгаж байгаа ойлголт”-гэсэн зөв хариултыг 3.8 хувь нь сонгон хариулжээ. Жендэрийн талаарх эцэг эхчүүдийн ойлголтод боловсролын түвшин нөлөөтэй байгаа нь дээд боловсролтой эцэг эхчүүд зонхилж зөв хариултыг сонгосноор тайлбарлагдаж байна. Монгол улс Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг баталж хэрэгжүүлснээс хойш 10 гаруй жил өнгөрч байгаа билээ. Судалгаанд оролцсон аав, ээжүүдийн 60 орчим хувь нь Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн талаар мэдэхгүй аж. Уг хуулийн талаар мэдээлэлтэй гэж хариулагчдын дотор хүйсийн хувьд ээжүүд, боловсролын шатлалын хувьд дээд боловсролтой эцэг эхчүүдийн эзлэх хувийн жин зонхилох төлөвтэйг тоон баримт харуулж байна.

Зураг 35 Гэр бүл дэх ажил үүргийн хуваарилалт



Эрэгтэй эмэгтэйчүүдийн үүргийн талаарх хэвшил ойлголтыг зурагт харуулснаар хэмжихэд, гэр бүлд мөнгө олж гэр бүлээ тэжээх, гэрийн ажил, хүүхэд асрах, өмч хөрөнгө эзэмших нь эхнэр нөхрийн аль алиных нь үүрэг болохыг чухалчлан үзэх хандлага нийтлэг илэрч байгаа ч мөнгө олж, гэр бүлээ тэжээх эдийн засгийн идэвхтэй үүргийг эрэгтэй хүнд хамааруулан чухалчлан үзсэн нь эмэгтэйтэй харьцуулахад даруй 5 дахин илүү байхад нөхөн үйлдвэрлэлийн шинжтэй үйл хоол хийх, гэр цэвэрлэх, гэр бүлийн гишүүдээ асрах үүргүүдийг эмэгтэй хүнд оногдуулж хариулсан нь эсрэгээрээ эрэгтэйтэйгээс 10 дахин өндөр дүнтэй байлаа. (Зураг 5.2) Ийнхүү ерөнхийдөө өрх гэр бүлд дэх үүргийг тэгш хуваарилах хандлага зонхилж байгаа ч, эдийн засгийн идэвхтэй дүр үүргийг эрэгтэй хүнд (21%), нөхөн үйлдвэрлэлийн шинжтэй дүр үүргийг эмэгтэй хүнд илүүтэйгээр (21.7-23.1%) хамаатуулах уламжлалт хандлага эцэг эхчүүдийн дунд тодорхой хэмжээгээр илэрч байна.

Гэр бүлд эхнэр, нөхрийн хүлээж буй үүргийг судалгаанд оролцогчдын хүйсээр харьцуулж шинжлэхэд дараах дүр зураг ажиглагдаж байгаа юм.

Хүснэгт 43 Гэр бүлд нөхөр, эхнэрийн үүргийн талаар судалгаанд оролцогчдын үзэл хандлага, хүйсээр (n=290)

	Мөнгө олж, гэр бүлээ тэжээх		Хүүхэд асрах		Өрхийн өмч хөрөнгө эзэмших		Гэрийн ажил хийх	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Нөхрийн үүрэг	29.8	14.8	3.3	0.6	11.6	7.1	29.8	14.8
Эхнэрийн үүрэг	1.7	5.3	20.7	22.5	4.1	6.5	1.7	5.3
Хамтын үүрэг	54.5	66.3	55.4	51.5	64.5	66.3	54.5	66.3
Хэн ч хийж болно	14.0	13.6	20.7	25.4	19.8	20.1	14.0	13.6
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Зураг 35-т харуулснаар, гэр бүлд эхнэр нөхрийн хамтын үүрэг оролцоог чухалчилсан нь нийтлэг илэрсэн байдаг. Хүснэгт 5.4-т судалгаанд оролцсон аавууд мөнгө олж гэр бүлээ тэжээх нь нөхрийн үүрэг гэж үзсэн нь ээжүүдийн хариултаас 2 дахин их, эхнэр мөнгө олж гэр бүлээ тэжээхийг дэмжсэн нь 1.7 хувьтай (n=2) болохыг харж болно. Эрчүүдтэй харьцуулахад судалгаанд оролцсон ээжүүдийн хувьд мөнгө олж, гэр бүлээ тэжээхийг эхнэрийн үүрэгт хамааруулсан хувь 2.5 дахин их үзүүлэлттэй байх жишээтэй ялгаатай хандлага ажиглагдаж байна. Судалгааны дүнгээр гэр бүлийн хөрөнгийг өмчлөх эрхийг 11.6 хувь нь нөхрийн үүрэг, 4.1 хувь нь эхнэрийн үүрэг гэж үзэж буй ялгаатай хариултыг өгчээ. Өмчлөх эрхийг нөхрийнх гэж хариулсан нь 3 дахин илүү байгаа юм. Тэрчлэн судалгаанд оролцсон ээжүүд эхнэр, эмэгтэйчүүд голлон хийдэг хөлсгүй ажлын төрөл болох гэрийн ажлыг нөхрийн үүрэг гэж 1.8 хувь нь, эхнэрийн хүлээх үүрэг гэж үздгээ 23.1 хувь нь илэрхийлсэн байхад судалгаанд оролцсон аавуудын 2.5 хувь нь нөхрийн үүрэг, 23.1 хувь нь эхнэрийн үүрэг гэсэн хариултыг өгчээ. Эндээс харахад “эмэгтэйчүүд гэрийн ажлын давхар ачаа үүрэх ёстой” гэх жендэрийн хэвшмэл ойлголт бүхий соёлыг хүлээн зөвшөөрдөг хандлага судалгаанд оролцогч эцэг эхчүүдийн тодорхой хэсэгт байна.

Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн үзэж байгаагаар өрх гэр дэх хөдөлмөрөө хуваарилан гүйцэтгэж буй шалтгааныг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн зав боломжоос хамаардаг гэж 51.4 хувь нь зөвшөөрч хариулсан бол гэр бүлийн уламжлал, зан заншлаараа гэр бүлийн гишүүд үүргээ хуваарилдаг гэж 24.8 хувь нь тайлбарласан байна. Харин 16.2 хувь нь эрэгтэй, эмэгтэй хүний төрөлхийн шинжтэй холбоотойгоор ялгаатай үүрэг гэж гүйцэтгэдэг, үлдсэн 7.6 хувь нь мэдэхгүй гэжээ. Тоон судалгааны баримтад түшиглэн авч үзэхэд гэр бүл дэх хүүхэд асрах, гэрийн бусад ажлыг жендэрийн хэвшмэл ойлголтоос хамааруулан гүйцэтгэдэг гэхээсээ гэр бүлийн гишүүдийн зав боломжоос шалтгаалан гүйцэтгэж байгаа нь жендэрийн хандлагын хувьд эерэг төлөв ажиглагдаж байна. Гэхдээ чанарлаг мэдээллийн шинжилгээгээр эрэгтэй эмэгтэй хүмүүс гэр бүлдээ гүйцэтгэх үүрэг хүйсээс үл хамаарч тэгш эрхтэй байхыг дэмжиж байгаа ч бодит амьдрал дээр тэгш байж чадахгүй байгааг эцэг эхчүүдтэй хийсэн бүлгийн ярилцлагын дүн харуулах юм. (Матриц 5.1)

Хүснэгт 44 Эрэгтэй, эмэгтэйчүүд гэр бүлдээ ялгаатай үүрэг хүлээж буй талаарх эцэг эхчүүдийн үзэл хандлага

	Эмэгтэйчүүдийн хариултаар	Эрэгтэйчүүдийн хариултаар
<b>Казак (Ховд аймаг)</b>	-Өрх толгойлсон эмэгтэй тул гэрийн гаднах дотных бүх ажлаа хийдэг -Эрэгтэй нь гэрийн гаднах, эмэгтэй нь гэрийн доторх ажлаа хийж ирсэн казак эмэгтэйчүүдийн уламжлал, зан заншлаа дагадаг <i>Залуу эмэгтэй:</i> Эмэгтэй, эрэгтэйн ажил гэж оноохгүйгээр гэрийн ажлаа хийж, үр хүүхдээ асрах боломжтой. Нөхөр байхгүй үед эхнэр гэрийн гадуурх ажлаа хийнэ. <i>Дунд насны эмэгтэй:</i> Эмэгтэй хүн ямар ажил хийхийг аав ээжээсээ суралцдаг. Ээж эмэгтэй хүүхдэдээ гэрээ цэвэрлэх, хоол хийхийг хэлж өгдөг.	-Эхнэр байхгүй үед хоол хийдэг (сард 3 удаа) -Эмэгтэй, заавал эмэгтэй хүн хийх ёстой ажил үүрэг гэж ханддаггүй -Эрэгтэй хүн жудагтай байх ёстой. Гэр орноо авч явах ёстой, сайн аав байх ёстой. -Эмэгтэй хүн сайн ээж байх ёстой, эхийн үүргээ сайн гүйцэтгэх ёстой.

	-Эмэгтэй хүн учраас чи гэрээ цэвэрлэх нь чиний ажил, охин хүүхэд учраас хийх ёстой гэж ханддаг.	
<b>Хот суурин</b>	-Ээжүүд гэртээ байх нь элбэг тул гэрийн ажлаа хийдэг -Эрэгтэй, эмэгтэйчүүд өөрсдөө сонгоод гэрийн ажлаа хийдэг. -Гэр орноо авч явах, тэжээх нь эрэгтэй хүний ажил байх ёстой. -Хэн түрүүлж ирсэн, завтай байгаа нь гэрийн ажил, хоолоо хийнэ.	-Цаг үеэ дагаж эрэгтэй нь гэрийн ноён нуруу гэрийн ажил хийхгүй, эмэгтэй хүн хийх ёстой уламжлалт хандлага өөрчлөгдөж, амьдралаа зохицуулахын тулд эрэгтэй, эмэгтэй хүмүүс зав чөлөөндөө тохируулж, гэрийн ажлаа хийдэг болсон. -Эхнэр эзгүй үед гэрийн ажлаа хийдэг
<b>Хөдөө орон нутаг</b>	-Хөдөөд малд явах гадуур ажлаа эрчүүд, ээжүүд хүүхдээ асрах, гэрийн ажлаа хийдэг -Амьдрал дээр эмэгтэйчүүд гадаа гэртгүй бүх ажлаа хийж зохицуулдаг. -Бүх ажлыг эмэгтэй хүн хийх ёстой юм шиг ханддаг -Заавал эмэгтэй учраас гэр орны ажил, эрэгтэй учраас гэр орны ажил хийхгүй гэх зүйл байх ёсгүй -Ажил хуваарлалтанд эрэгтэй эмэгтэй тэгш эрхтэй байх хэрэгтэй ч манай гэр бүлүүдийн нийтлэг жишгийн хувьд тэгш байж чаддаггүй -Ажил үүргээ хуваарилах биш хэн боломжтой нь мөнгөө олно, гэрийн ажлаа хийнэ	-Эхнэр нөхрийн үүрэгт ажил гэж хатуу зааглаж хуваарилдаггүй ч амьдралын нөхцөл ахуйтай холбоотойгоор ажлаа хуваарилж хийдэг. Аавууд эзгүй байх үед ээжүүд гэрт гадаагүй ажлаа хийж амжуулдаг. -Түрүүлж ирсэн нь гэрийн ажлаа хийнэ -Хөдөө явдаг ажилтай тул эхнэр бүх ажлаа хийдэг -Заавал эрэгтэй хүний ажил, эмэгтэй хүний ажил гэж хуваарилаад байх шаардлагагүй -Эрэгтэй, эмэгтэй хүний ажил гэж оноох нь буруу, орчин үед эрэгтэй, эмэгтэй хүний ажил гэж хуваарилах нь бага болсон

Эх сурвалж: Эцэг эхчүүдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас

### 5.1.2 Эцэг эхчүүдийн охид, хөвгүүдийн боловсролд хандах жендэрийн хандлага

Энэ хэсэгт охид, хөвгүүдийн суралцах үйл ажиллагаа (суралцах үйл явц дахь охид, хөвгүүдийн ялгаа, сургалтын үйл ажиллагааны охид, хөвгүүдэд тусаж буй үр нөлөө), сургалтын үйл явц дахь багш-сурагчийн харилцаа охид хөвгүүдийн ялгаатай хэрэгцээг харгалзаж буй байдал) охид, хөвгүүдийн ирээдүйд эзэмших мэргэжил, боловсрол зэрэгт эцэг эхчүүдийн зүгээс хэрхэн хандаж байгааг судлан шинжилснийг танилцуулах юм.

Эцэг эхчүүд хүү, охиныхоо боловсролын асуудалд ихэд анхаарч, хүйс харгалзахгүйгээр дээд боловсрол эзэмшүүлэхийг чухалчлан үзэж буй хандлага нийтлэг (76.7-80.5%) илэрч байна.

Хүснэгт 45 Ирээдүйд хүү охиндоо боловсрол эзэмшүүлэх талаарх эцэг эхчүүдийн хүлээлт, хүйсээр(n=290)

Сонгосон үзүүлэлт	Хүүгээ сургана		Охиноо сургана	
	Аавын хариулснаар	Ээжийн хариулснаар	Аавын хариулснаар	Ээжийн хариулснаар
Уншиж бичүүлж сургана	1.5	1.7	0.0	0.9
9-р анги төгсгөнө	0.0	0.0	2.3	0.0
12-р анги төгсгөнө	4.5	0.0	1.1	3.5
МСҮТ төгсгөнө	1.5	4.3	1.1	0.0
<b>Дээд боловсрол эзэмшүүлнэ</b>	<b>78.8</b>	<b>76.7</b>	<b>78.4</b>	<b>80.5</b>
Хүүхэд өөрөө шийднэ	13.6	17.2	17.0	15.0
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Аав ээжүүд үр хүүхдийнхээ ирээдүйн боловсролын талаар анхаарал хандуулахдаа хүйс бус хүү, охины хэн амжилттай суралцаж байгаагаас хамаарч үргэлжлүүлэн сургах сонголт 44.8 хувьд илэрсэн ч эцэг эхчүүдийн охиноо сургахыг дэмжсэн хариулт 3 дахин их байсан юм. Тодруулбал аав

ээжүүдийн 11 хувь нь хүүгээ, 31 нь хувь нь охиноо үргэлжлүүлэн сургах хандлагатай аж. Энэ хариултын тухайд аавуудын охиноо үргэлжлүүлэн сургахыг дэмжсэн хариулт ээжүүдтэй харьцуулахад 3.5 пунктээр илүү байлаа. Чанарын баримтаар эцэг эхчүүд охиноо цааш нь үргэлжлүүлэн суралцуулна гэсэн хандлага нотлогдож байв. Мэргэжил сонголтын хувьд охиноо ажлын байртай эмч, багш, урлаг, хуульч, орчуулагч, хэл судлаачийн мэргэжил эзэмшүүлнэ, хүүгээ уул уурхай, барилгын инженер, цэрэг цагдаа, банк санхүү, хуульч, техникийн мэргэжил, төрийн захиргаа, удирдлага, бизнесийн чиглэл, архитектур, эмч, багшийн мэргэжилтэй болгохыг зорьж байгааг тоон судалгааны баримт харуулж байна.

Хүснэгт 46 Охин, хүүгийнхээ хэнийг нь үргэлжлүүлэн сургах талаарх эцэг эхчүүдийн санаа бодол, хүйсээр

Сонгосон үзүүлэлт	Аавуудын хариулснаар	Ээжүүдийн хариулснаар	Нийт	Эрэмбэ
Хүүгээ	6.6	14.2	11.0	
Охиноо	33.1	29.6	31.0	II
Ганц хүүхэдтэй тул	14.0	11.2	12.8	
Хэн амжилттай суралцаж байгааг нь	46.3	43.8	44.8	I
Хамгийн том хүүхдээ	0.0	0.6	0.3	
Нийт	100.0	100.0	100.0	

Судалгаагаар эцэг эхчүүд охид хөвгүүдийн боловсролд хандахдаа юуг чухалчлан үздэг болохыг тодорхойлоход ерөнхийдөө аав ээжүүд охин, хүүгээ боловсролтой болгохыг чухалчлахдаа ажилтай байх, үр хүүхдээ зөв хүмүүжүүлэх үүргээ хэрэгжүүлэх, санхүүгийн эрх чөлөөтэй амьдрах, улс орны хөгжилд хувь нэмрээ оруулж чадах баталгаа болох талаас хандсан нь нийт хариултуудын дотор өндөр хувьтай илэрч байна.

Хүснэгт 47 Эцэг эхчүүдийн охид хөвгүүдийн боловсролд хандах хандлага, хүйсээр

Сонгосон үзүүлэлт	Хүүгийн хувьд		Охины хувьд	
	Аавуудын хариулснаар	Ээжүүдийн хариулснаар	Аавуудын хариулснаар	Ээжүүдийн хариулснаар
Ажлын байртай болно	<b>61.2</b>	<b>57.8</b>	43.2	28.6
Санхүүгийн эрх чөлөөтэй амьдарна	<b>46.3</b>	<b>41.4</b>	30.7	27.2
Мөнгө олж чинээлэг сайхан амьдарна	11.9	10.3	15.9	15.8
Юм үзэж нүд тайлна	28.4	33.6	18.2	19.2
Ирээдүйд үр хүүхдээ зөв хүмүүжүүлнэ	<b>62.7</b>	<b>63.8</b>	48.9	43.0
Улс орны хөгжид хувь нэмэр оруулна	<b>44.8</b>	<b>44.0</b>	30.6	21.9
Эцэг эх ах дүүдээ тустай хүн болно	20.9	20.7	18.2	21.9
Хүний дор орохгүй, дээрэлхүүлэхгүй амьдарна	13.4	13.8	12.5	12.3
Хэн нэгнээс хамааралгүй хүссэнээрээ амьдарна	17.9	30.2	25.3	21.1

Судалгаанд хамрагдсан 4 ээж тутмын 3 нь охиндоо дээд боловсрол эзэмшүүлэхийг чухалчлахдаа мэргэжил, ажлын байртай болно гэдгийг чухалчлаад, багш, эмч, хуульч, офис менежер зэрэг ажлын байрны олдоц сайтай мэргэжил эзэмшүүлэх хариултыг сонгожээ. Хэдийгээр эцэг эхчүүд хүүхэддээ боловсрол эзэмшлүүлэхдээ хүйсээс илүү хүүхдийн сонирхол чухлыг онцолсон ч охин хүүхэд хүний хүн болно, хүний дор орохооргүй өөрийгөө авч явах боловсролтой байх ёстой хэмээн биеэ даасан, хэн нэгнээс хараат бус болгохыг эрхэмлэж байв. Энэ нь тоон судалгааны дүнгээр ч давхар батлагдаж байна. Харин эрэгтэй хүүхэд бол хар бор ажил хийгээд амьдарч чадна гэж хариулснаас харахад эцэг эхчүүдийн дунд “охин бол сул дорой” гэж үздэг жендэрийн хэвшмэл ойлголт нөлөөтэй хэвээр болохыг чанарын судалгааны дүн харуулаад байна. ЕБС-ийн удирдах албан тушаалтнуудын өгсөн ярилцлагаар эцэг эхчүүд охиноо хүний гар харж амьдрахааргүй мэргэжил, боловсролтой хүн болгоно, байдгаа шавхаад ч болов түүнийгээ мэргэжилтэй болгоно гэж ярьдаг

тухай өгүүлсэн нь эцэг эхчүүдэд жендэрийн хэвшмэл ойлголт байгааг давхар баталгаажуулж буй хэрэг юм.

Судлагдсан эцэг эхчүүд хүүхдийн хүйсээс хамаарч тэдний боловсролд ялгаатайгаар хандах байдал илэрч байгаа нь аавууд охин, хүүгээ ялгалгүй МСҮТ-д сургаж төгсгөнө гэж хариулсан байхад охиноо МСҮТ-д сургана гэж нэг ч ээж хариулсангүй, харин хүүгээ МСҮТ-д сургана гэжээ. (Хүснэгт 5.2) Эцэг эхчүүдэд техник, инженерийн чиглэлийн мэргэжил охидод тохиромжгүй, харин хөвгүүд илүү авьяастай гэж үздэг жендэрийн хэвшмэл ойлголт охид, хөвгүүдийнхээ боловсролын талаарх шийдвэрт багагүй нөлөөтэй хүчин зүйл болох нь ажиглагдлаа.

“...Бүх хүүхдээ сургахыг бодно. Гэхдээ зөвхөн нэг хүүхдийн сургалтын төлбөртэй байгаа тохиолдолд охиноо сургана. Эмэгтэй хүүхэд хар бор ажил хийж чадахгүй харин хөвгүүд бол өөрсдийгөө болгоод явчихна. Айлд очсон ч боловсролтой байх шаардлагатай, хүний дор орохгүй.”  
(Бүлгийн ярилцлага, Өвөрхангай аймаг, Есөнзүйл сум, эцэг эхчүүд)

### 5.1.3 Охид хөвгүүдийн суралцах болон багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд хандах эцэг эхчүүдийн хандлага

Судалгаа охид, хөвгүүдийн сурах үйлийн ялгаа болон багш нарын үйл ажиллагааны талаарх эцэг эхчүүдийн хандлагад холбогдох асуудлуудыг энэхүү хэсэгт судаллаа.

Хүснэгт 5.5-т харуулснаар, эцэг эхчүүд багшлах үйл ажиллагаанд багшийн хүйсийн ялгаа бус, харин мэдлэг, ур чадвар хамгийн чухал гэж үзсэн нь тоон болон чанарын баримтаар нийтлэг илэрч байна. Гэхдээ багшийн ур чадвартай холбоотой зарим үзүүлэлтийн хүрээнд багшийн хүйсээс хамаарсан ялгаа илэрдэг гэж эцэг эхчүүд үзсэн юм. Жишээ нь, эцэг эхчүүдийн өгсөн хариултаар эмэгтэй багш охид хөвгүүдийн сонирхлыг харгалзан оролцуулах, сурах үйл явцад охид хөвгүүдийг урамшуулж зөвлөн дэмждэг гэж үзсэн байна.

Хүснэгт 48 Хүүхдэд хичээл заадаг эрэгтэй, эмэгтэй багшийн багшлах үйл ажиллагааны талаарх ээж, аавуудын жендэрийн төсөөлөл (n=290)


Ойлголтууд	Аавуудын хариултаар				Ээжүүдийн хариултаар				Нийт
	Эрэгтэй багш	Эмэгтэй багш	Аль аль нь	Мэдэхгүй	Эрэгтэй багш	Эмэгтэй багш	Аль аль нь	Мэдэхгүй	
Хэн нь илүү туслан зөвлөдөг вэ?	2.5	31.4	36.4	29.8	2.4	43.2	38.5	16.0	100.0
Хүүхэд бүртэй хэн нь илүү тулж ажилладаг вэ?	4.1	42.1	33.1	20.7	2.4	54.4	27.2	16.0	100.0
Хэнийх нь өгсөн даалгаврыг хүүхэд хийх дуртай байдаг вэ?	5.0	14.9	49.6	30.6	0.6	27.8	50.9	20.7	100.0
Хүүхэд аль багшийгаа гэртээ эерэгээр магтаж ярьдаг вэ?	6.6	31.4	33.9	28.1	4.7	38.5	38.5	18.3	100.0
Аль багшийнхаа талаар гомдож таагүй ханддагаа гэртээ ярьдаг вэ?	5.0	15.7	16.5	62.5	7.7	14.8	18.3	59.2	100.0
Хэн нь хүүхдийн сурлагын амжилтыг шударгаар үнэлдэг вэ?	8.3	14.0	43.8	33.9	4.7	24.3	43.8	27.2	100.0
Хэн нь илүү багшлах	7.4	23.1	43.8	25.6	3.0	26.0	49.7	21.3	100.0



чадвартай гэж үзэж байна?									
---------------------------	--	--	--	--	--	--	--	--	--

Эцэг эхчүүдийн 55.9 хувь нь багшийн хүйс чухал биш, харин тэдний чадвар, заах арга зүйг чухалчилж байна. (Зураг 5.3)

Зураг 36 Эцэг эхчүүдийн хүүхдийн багшаа сонгох сонголт, судалгаанд оролцогчдын хүйс болон нутагшилтаар (n=290)



Дээрх зурагт харуулснаар, судалгаанд оролцсон ээжүүдийн 50 гаруй хувь нь эмэгтэй багшийг чухалчлах хандлага, аавуудтай харьцуулахад даруй 10.3 пунктээр илүү байгааг үзүүлж байна. Нутагшилтаар нь шинжлэхэд аймаг, сумдаас судалгаанд оролцсон эцэг эхчүүдээс эмэгтэй багшийг илүүтэйгээр үнэлж байгаагаа илэрхийлсэн хариулт өгсөн нь хот сууринг төлөөлж судалгаанд оролцсон эцэг эхчүүдээс 6.7 пунктээр илүү дүнтэй байгаа юм. Түүнчлэн ЕБС-ийн бага боловсролд эмэгтэй багш олон талын давуу талтай болохыг ганцаарчилсан ярилцлагад оролцсон ЕБС-ийн удирдах түвшний хүмүүс тэмдэглэсэн. Хэдийгээр судалгааны дүнгээр эрэгтэй багшийг сонгосон хувийн жин бага илэрсэн ч ээжүүдтэй (5.3%) харьцуулахад аавуудын эрэгтэй багшийг сонгосон сонголт (7.5%) илүү байв. Ийнхүү эцэг эхчүүдийн дунд “багшийн ажилд эмэгтэйчүүд илүү тохиромжтой” гэх хандлага ажиглагдаж байна. Чанарын судалгааны баримтаас харахад эрэгтэй, эмэгтэй багш нарт ялгаатай давуу болон сул тал ажиглагддаг гэж судалгаанд оролцогчид дүгнэж байна.

Хүснэгт 49 Эцэг эхчүүд хүүхдийнхээ багшаар сонгохдоо аль хүйсийн багшийг илүүд үзэж буй талаарх үзэл хандлага

	Аавуудын хариултаар	Ээжүүдийн хариултаар
Эрэгтэй багшийг илүүд үзэх хандлага	<ul style="list-style-type: none"> <li>- Сурагчдаар дэг журам сахиулж чаддаг</li> <li>- Зарчимч</li> <li>- Эрэгтэй багшид эрэгтэй хүүхдийг даатгаж сургах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Чанга хатуу</li> <li>- Эр хүн учир хүүхэдтэй илүү сайн ойлголцдог</li> <li>- Эрэгтэй хүн шударга, илүү потенциалтай</li> <li>- Эрэгтэй багшид эрэгтэй хүүхдийг даатгаж сургах хээргтэй</li> <li>- Шударга, тууштай</li> <li>- Тулж харьцдаггүй,</li> <li>- Үглэж хүүхэд залхаах нь бага</li> </ul>
Эмэгтэй	- Чадвартай	- Хүүхдэд тавих шаардлага өндөр

багшийг илүүд үзэх хандлага	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдэд сайн</li> <li>- Хариуцлагатай, хичээнгүй</li> <li>- Эх хүн тул хүүхэдтэй ойр дотно харилцдаг, ханддаг</li> <li>- Хүүхэдтэй ажиллах арга барил сайн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Аав ээжтэй холбоотой ажилладаг</li> <li>- Хүүхдийн төлөө сэтгэлтэй</li> <li>- Бага ангийн сурагчтай эмэгтэй багш илүү тулж эелдэг харьцдаг</li> <li>- Чадвартай</li> <li>- Хүүхэдтэй илэн далангүй харьцдаг</li> <li>- Эмэгтэй хүн нарийн мэдрэмжтэй тул хүүхэдтэй ажиллахад уян зөөлөн ойлголцдог</li> <li>- Хүүхдийн төлөө санаа зовж хүүхдийн төлөө явж чаддаг</li> <li>- Хариуцлага өндөр</li> <li>- Зөвлөгөө сайн өгдөг</li> <li>- Охин хүүхэдтэй эмэгтэй багш илүү ойлголцоно</li> </ul>
-----------------------------	--	---

**Эмэгтэй багшийн хувьд:** хүүхдийг ойлгож, хүүхэдтэй илүү ойр дотно, эх хүн, эмэгтэй хүн гэдэг утгаараа хүүхэдтэй зөөлөн харилцдаг, хүүхдийн төлөө сэтгэл гаргадаг, хүүхэдтэй ажиллах арга барил сайн, хариуцлагатай, хүүхэд бүртэй тулж ажилладаг зэргээр заах арга зүй, багшлах ур чадвар, хүүхэдтэй харилцах ур чадвар талаас нь илүү үнэлж байв.

**Эрэгтэй багшийн хувьд:** сургуулийн орчинд хүүхдүүдийг дэг журамтай байлгах, шударга, чанга хатуу, ялгаварлахгүйгээр харилцдаг сайн талтай ч хүүхэдтэй тулж ажилладаггүй сул талтай гэжээ. Эцэг эхчүүдийн бүлгийн ярилцлагаар “цөм хөтөлбөрийн шинэчлэлээр хүүхэд нэг бүрийг би чадна, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд анхаарах болсон атлаа багш нар олимпиад уралдаан тэмцээнд сайн цөөн тооны сурагчдад онцгойлон ханддагт ихээхэн шүүмжлэлттэй хандаад ийм ялгаварласан хандлага ньбусад хүүхдийн сурлагын амжилтад нөлөөлдгийг дурдлаа.

“...Манай хүүхдийн хувьд Монгол хэлний хичээлд дур сонирхолтой, олимпиадад явна гээд л хөөрөөд байсан. Гэтэл багш нь дэмжихгүй болохоор бүр хаячихдаг юм байна. Одоо ямар хичээлд дуртай юм бол бүү мэд. Нэг хэсэг математикийн хичээлдээ сайн, сонирхолтой болсон гэсэн, удаагүй дургүй болсон гэж ярьсан. Жоохон хичээгээд ирэхэд нь багш нар нь дэмждэггүй болохоор дургүйцээд хаячихдаг юм байна гэж ажиглагдсан. Хичээлийн агуулгаас илүү багш нарын дэмжлэг хангалтгүй байна. Ганц хоёр хүүхдийг л сайн гээд байхаар бусад хүүхдүүдийн хувьд тэр л сайн бусад нь хичнээн хичээсэн ч сайн сурагч болж үнэлэгдэж чаддаггүй.”

*Завхан аймаг, Ургамал сум, Эцэг эхийн фокус бүлгийн ярилцлага, ээжийн ярианаас*

**Удирдах ажилтнуудын хувьд:** Чанарын судалгаагаар ЕБС-ийн шийдвэр гаргах түвшин дэх хүйсийн тэгш байдлыг тогтоох асуудлаар эрэгтэй, эмэгтэй багш, захирал, сургалтын менежерүүдэд ялгаатай үзэл баримтлал бүхий хандлага илэрч байгаа. Эрэгтэй удирдах ажилтнуудад нийгмийн бүтэц дэх патриарх соёлын нөлөө илэрч байгаа нь анзаарагдсан бол эмэгтэй удирдах ажилтнуудын хувьд эл хандлагыг сөргөсөн, удирдах албыг заавал эрэгтэй линзээр харах бус, адил тэгш боломжоор хангагдахыг чухалчилсан санааг дэвшүүлсэн. Харин бага боловсролын шатанд багшлах үйл ажиллагаан дахь эрэгтэй багшийг илт дэмжихгүй байх үзэл хандлагатай гарын арван хуруунд багтах тооны эмэгтэй удирдах ажилтан таарч байлаа. Эрэгтэй багшийг дэмжихгүй байгаа шалтгаанаа эрэгтэй багшид хүүхэд нэг бүртэй тулж ажиллах, хүүхэд нэг бүрийн онцлог, ялгааг харгалзах, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх ур чадвар, арга барил эмэгтэй багштай харьцуулахад учир дутагдалтай, дэлхийн нийтийн чиг хандлага ч манайхтай төстэй гэдэг үндэслэлээр тайлбарласан юм.

**Удирдах албан тушаалд эмэгтэй багшийг дэмжих хандлага**

...”Эрэгтэй хүн ерөнхий рамаа хардаг, цаг хугацаанд ажлаа хийдэггүй, хичээлийн бэлтгэл хийдэггүй. Бага ангийн эрэгтэй багш шалчигнаад эмэгтэйдгээсээ дор, олон эмэгтэйн халамжид

орчих гээд. Багын багшийг эрэгтэй хүнээр төсөөлдөггүй.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

**Удирдах албан тушаалд эрэгтэйчүүдийг дэмжих хандлага**

...”Эрэгтэй хүн эмэгтэй хүнийг бодвол оновчтой шийдвэр гаргадаг ба төрөлхийн шинж чанартай нь холбоотой.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...”Олон хүн удирддаг тул эрэгтэй хүний ноён нуруу хэрэгтэй. Хаа ч удирдах албан тушаалд эрэгтэйчүүд байна.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

Судалгаанд оролцсон эцэг эхчүүд охид хөвгүүдийнхээ сонирхол, чадвар, хувийн зан үйлээр дамжуулж эрэгтэй, эмэгтэй хүүхдэд хандаж буй хандлагад хийсэн жендэрийн дүн шинжилгээг дараах хүснэгтэд харуулж илт онцлох ялгаа илэрч буй аав ээжүүдийн үзэл хандлагыг тодруулсан юм. Аавын өгсөн хариултаар хөвгүүд удирдан манлайлах авьяастай, хөвгүүд техникийн зүйлд илүү чадварлагтай санал нийлсэн хувийн жин өндөр байхад охид хэл болон нийгмийн ухааны хичээлд илүү сайн, охидыг гэрийн ажил хийхдээ илүү чадварлагт тооцсон хариултын эзлэх хувийн жин өндөр илэрч байна. Тэрчлэн ганцаарчилсан ярилцлагын үеэр зарим нэг ЕБС-ийн багш охид хөвгүүдийн IQ, сэтгэлгээний хурд, охид хөвгүүдийн зан чанарын төлөвшилт, хөвгүүд охидын сурах үйлийн ялгаатай байдалтай (охид бүх хичээлдээ жигд сайн, хичээлийн жилийн турш жигд суралцдаг, хөвгүүд сонгосон, сонирхсон чиглэлийн хичээлдээ анхаарч илүү суралцдаг, бэлддэг, хөвгүүдийн хувьд дунд, ахлах ангид сурлагын амжилт, гүйцэтгэл эрс ахидаг) холбон тайлбарлах нь мэр сэр анзаарагдсан.

...“Хөвгүүд зөвхөн нэг төрлийн хичээлдээ илүү бэлддэг. Охид өөрсдийгөө нухдаг, удаан суудаг.

*(Ганцаарчилсан ярилцлага, Боловсролын хүрээлэн, хөтөлбөр, сурах бичиг хариуцсан эрдэм шинжилгээний ажилтнууд)*

...” Хөвгүүд сурлагын амжилтаар илүү, авч байгаа сургуулийн чанарын хувьд ч хөвгүүд арай оюуны чадамж шаардсан сургуульд ороод манай багш бэлтгэх сургуульд охид орж байна.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...”Охид хичээлдээ сайн байдаг. Эмэгтэй хүүхэд хичээлдээ анхаарал тавих илүү, эрэгтэйчүүд хэнэггүй хандах тал байдаг. Эрэгтэй хүүхэд нэг хичээлд илүү сайн байдаг, Харин эмэгтэй хүүхэд бүх хичээлдээ ижил суралцдаг”

*(Бүлгийн ярилцлага, Хөвгүүд)*

Хүснэгт 50-д харуулснаар, ээж охид хөвгүүдийг бодвол өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, нээлттэй байж чаддаг, охид гэрийн ажил хийхдээ илүү чадварлаг, хөвгүүд техникт илүү чадварлаг гэж хариулсан нь өндөр хувьтай үзүүлэлт болж байна. Энэхүү хандлага чанарлаг мэдээллээс давхар ажиглагдаж байна.

Хүснэгт 50 Охид хөвгүүдийн талаарх дараах ойлголтуудтай санал нийлж буй байдал, хүйсээр

Ойлголт	Аавын хариултаар				Ээжийн хариултаар				Нийт
	Бүрэн санал нийлнэ	Зарим талаар санал нийлнэ	Огт санал нийлэхгүй	Мэдэхгүй	Бүрэн санал нийлнэ	Зарим талаар санал нийлнэ	Огт санал нийлэхгүй	Мэдэхгүй	
Охид хөвгүүдийг бодвол аливааг оновчтой шийдэж чаддаг	22.3	57.9	14.0	5.8	24.9	53.3	10.1	11.8	<b>100.0</b>
Хөвгүүд удирдах манлайлах авьяастай	<b>38.8</b>	43.0	10.7	7.4	26.6	50.3	11.2	11.8	<b>100.0</b>
Хөвгүүд байгалийн ухааны хичээлд илүү сайн	25.6	35.5	11.6	27.3	14.8	46.2	13.0	26.0	<b>100.0</b>
Охид хэл болон нийгмийн	<b>40.5</b>	35.5	11.6	12.4	27.8	42.6	10.1	19.5	<b>100.0</b>

ухааны хичээлд илүү сайн									
Хөвгүүд сэтгэл хөдлөлөө илэрхийлэх дуртай биш	24.0	44.6	13.2	18.2	23.1	43.2	14.2	19.5	<b>100.0</b>
Охид хөвгүүдийг бодвол өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, нээлттэй байж чаддаг	30.6	47.1	10.7	11.6	<b>37.3</b>	42.0	9.5	11.2	<b>100.0</b>
Охид гэрийн ажил хийхдээ илүү чадварлаг	<b>62.0</b>	24.8	7.4	5.8	<b>63.3</b>	23.7	5.9	7.1	<b>100.0</b>
Хөвгүүд техникийн зүйлд илүү чадварлаг	<b>63.6</b>	24.8	3.3	8.3	<b>58.0</b>	28.4	5.9	7.7	<b>100.0</b>
Хөвгүүд хүчтэй, зоригтой, түрэмгий	29.8	46.3	11.6	12.4	30.2	48.5	10.7	10.7	<b>100.0</b>
Охидууд сул дорой, хүлцэнгүй, өрөвч энэрэнгүй	14.9	27.3	47.1	10.7	14.8	43.8	31.4	10.1	<b>100.0</b>

Охид хөвгүүдтэй холбогдох дээрх ойлголтуудыг эцэг эхчүүдийн судалгаанд хамрагдсан байршлаар шинжлэхэд сонирхолтой ялгаа ажиглагдлаа. Ховд, Орхон, Дундговь аймгаас судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд охид хэл, нийгмийн ухааны хичээлд илүү сайн, Сүхбаатар, Орхон аймгаас судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд охид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэгийг дэмжсэн хувийн жин илүүрхсэн байхад Завхан, Улаанбаатараас бусад аймагт хөвгүүд техникийн зүйлд чадварлаг гэх ойлголттой огт санал нийлэхгүй гэсэн нэг ч тохиолдол байсангүй, харин охид гэрийн ажил хийхдээ чадварлаг гэх ойлголтыг орон нутгаас судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 60-85 хувь, Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 52 хувь нь дэмжсэн хариултуудыг өгчээ.

...” Манай дунд охин, хүү 2 дандаа барьцана. Ахыгаа аяга угаасангүй гэхэд нь би “Чи охин хүүхэд, барьцах шаардлагагүй. Эр хүн чинь аяга таваг угаадаг хүн биш. Амьдралд сургах үүднээс л угаалгаад байгаа юм” гэж хэлдэг. Мөн л ах шал угаахгүй байна гэнэ, битгий барьцаад бай л гэдэг. Шал угаах ёсгүй хэрнээ угаалгаад байгаа шүү гэж хэлдэг. Хүний эрх, тэгш эрх бас харьцангуй ойлголт”

*(Бүлгийн ярилцлага, Эцэг эх)*

...”Охиндоо сургахдаа ажлыг сайн гүйцэд хийж сур, юмаа сайхан угаагаад цэвэр цэмцгэр бай. Ажил л сайн хий гэдэг. Зүгээр залхуу шалхайгаад хэвтэж байдаг авгай болчихов гэж хэлнэ. Угаасаа эмэгтэй хүүхэд айлд очих учир өөрийгөө аваад явчихдаг хүнд муу хэлүүлэхгүй ажил төрөлтэй хадамдаа гологдохгүй л байх ёстой. Хүүдээ сургахдаа ирээдүйд өрхийн тэргүүлэгч болох учраас аливааг алсаас харж бодлоготой ханд тэгж л захидаг. Ялгаатай байдлаар захидаг”.

*(Бүлгийн ярилцлага, Эцэг эх)*

...”Хүү нартаа бол хоол хийж болохгүй гэр цэвэрлэж хэрэггүй гэж хэлдэггүй. Нийгэм ийм болчихсон хүн юм юмыг л хийж сурах хэрэгтэй гэж үздэг. Гэрийн ажлыг би ч хийдэг, манай хүү ч хийдэг. Эр, эмийн ажил гэж ялгаж үздэггүй.”

*(Бүлгийн ярилцлага, Эцэг эх)*

...”Аав: Охид унших бичих дуртай байдаг. Хөвгүүд сэтгэхүйгээрээ ханддаг.

Аав: Математик, физик, химийн хичээлдээ хөвгүүд илүү, монгол хэл, нийгмийн хичээлдээ охидууд илүү сайн байдаг.

*(Сэлэнгэ аймаг, аавуудтэй хийсэн бүлгийн ярилцлага)*

...”Манай хүү байгалийн ухааны хичээлдээ дуртай. Манай охин тоондоо их дуртай. Химийн хичээлдээ их сайн. Багш нь сайн заадаг юм уу, их идэвхтэй байдаг. Багшаасаа л болдог.”

*(Сэлэнгэ аймаг, ээжүүдтэй хийсэн бүлгийн ярилцлага)*

...”Манай охин хэлний хичээлдээ их дуртай. Математикийн хичээлдээ тааруухан байгаад байх шиг байдаг. Хичээл зааж байгаа багшаасаа, хүүхдийн өөрийн оролдлогоос хамаардаг. Манай хүү дүрслэх урлаг, технологийн хичээлдээ илүү сайн байдаг.”

*(Баянгол дүүрэг, ээжүүдтэй хийсэн бүлгийн ярилцлага)*

Эцэг эхчүүдийн охид хөвгүүдийн суралцах үйлд хандах жендэрийн төсөөллийг чанарлаг баримтад тулгуурлан шинжилсэн юм. Эцэг эхчүүд хөвгүүд математикийн хичээлд, охид аман буюу хэлний хичээлд сайн гэх хандлага нийтлэг илэрч байгаа ч хүүхдийн сонирхол, хүүхдийн суралцах үйл ажиллагааг хэр дэмждэг, урамшуулдаг, зөвлөгөө өгдөг, охид хөвгүүдийн онцлог хэрэгцээг харгалздаг эсэх зэрэг багшийн заах арга барилтай холбон тайлбарлах хандлага эцэг эхчүүдийн дунд цөөн бус таарч байлаа. Охид хөвгүүдийн суралцах үйл ажиллагаанд тэдний нас, хүйс тодорхой хэмжээгээр нөлөөлдөгийг эцэг эхчүүд, сургуулийн удирдах ажилтнуудын өгсөн баримтад тулгуурлан дараах байдлаар багцлан илэрхийлье.

**а. Хөвгүүд математик, байгалийн ухаан, техник, инженерийн чиглэлд илүү чадварлаг гэх хандлага.** Тоон судалгааны дүнгээр эцэг эхчүүдийн 63.6 хувь нь хөвгүүд техникийн зүйлд илүү чадварлаг, чанарын баримтаар хөвгүүдийн техникийн сэтгэлгээ сайн хөгжсөн гэж хариулсан жендэрийн ойлголтоор тайлбарласан эцэг эх байхад түүх, нийгмийн ухаан, математик, физик, химийн хичээлд сонирхолтой, тэр чиглэлээр амжилттай суралцдаг охидтой эцэг эхчүүд хүйс бус хүүхдийн сонирхлыг чухалчилж үздэг ялгаатай хандлагатай эцэг эх байна. Бүлгийн хэлэлцүүлгийн үеэр зарим эцэг эх охид хэлний хичээлдээ илүү сайн байж амжилт үзүүлж байгааг тухайн хичээлийг зааж буй багшийн ур чадвартай холбон тайлбарлаж байлаа. Эцэг эхчүүдийн өгсөн энэхүү мэдээллийг бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон охид, хөвгүүд басхүү баталгаажуулсан байдаг. Тодруулбал, “хичээлээ унш, хуулж бич” гээд орхидог багшийн хичээлд дургүйгээ илэрхийлж, хичээлээ ойлгомжтой, сонирхолтой хэлбэрээр явуулдаг багшийн хичээлд дуртайгаа илэрхийлжээ.

“...Эрэгтэй хүүхэд байгалийн ухаан, эмэгтэй хүүхэд нийгмийн ухааны хичээлд сайн гэдэг ойлголт догматик ойлголт юм. Энэ бол тухайн хүүхдийн сонирхлыг дагасан сурлагын амжилт, мэргэжил сонголт байдаг. Багш ёс зүйтэй байх ёстой. Багш хүүхэд бүрийг хөгжүүлэх зарчим баримталж ажилласнаар хүүхэд бүрийг нээж чадна.”

*(Ганцаарчилсан ярилцлага, Улаанбаатар, Налайх дүүрэг, сургалтын менежер)*

Гэхдээ эцэг эх, удирдах ажилтан, сурагчидтай хийсэн бүлгийн бүх хэлэлцүүлгийн зарим оролцогчдын дунд “хөвгүүд сэтгэлгээний хурдболон сэтгэн бодох чадвараар илүү, ахлах ангидаа огцом цойлж суралцдаг гэсэн хариулт нийтлэг илэрсэн нь анхаарал татсан үр дүн мөн. Жендэрийн хэвшмэл ойлголтоор эрэгтэй хүүхэд математик, байгалийн ухаан, охид нийгэм-хүмүүнлэгийн ухааны хичээлд сайн гэж хариулсан нь эцэг эх, багш, удирдах ажилтнууд ч цөөн бус байхад энэхүү ойлголтын няцаасан хариулт өгч байгаа эцэг эх, багш, удирдах ажилтан ч таарч байсныг чанарлаг баримт харуулсан. Хөвгүүд бүтээх, судалгаа шинжилгээ хийх, гүнзгий утга бүхий асуулт асуух чадвар сайн хөгжсөн байдаг, охид бүх хичээлдээ жигд сайн, нямбай, зүтгэлтэй, идэвхтэй ч гүнзгийрүүлсэн асуулт асуух, сонирхох нь сул зэргээр хөвгүүдийн оюун ухааны хөгжлийн түвшин охидоос өндөр гэсэн жендэрийн хэвшмэл ойлголттой удирдах ажилтан, эцэг эхчүүд нэлээдгүй байлаа.

**б. Хөвгүүдийн сурах үйл, сурлагын амжилтад шилжилтийн нас, төлөвшилтийн онцлог нөлөөлдөг гэх хандлага.**

Эцэг эхчүүдийн олонх нь хөвгүүдийн бага ангиас дунд ангид дэвшин суралцах үетэй шилжилтийн насны нийгэмшилт давцдаг бөгөөд энэ үед хөвгүүдийн сурлагын амжилт буурч эхэлдэг гэж тайлбарлаж байв. Харин багш, удирдах ажилтнууд хөвгүүд ахлах ангид дэвшин суралцах үед хичээлдээ эрс сайжирч охидыг гүйцэж түрүүлдэг, ялангуяа сонирхсон чиглэлийн хичээл, математик, физик зэрэг байгалийн ухааны хичээлд гаргууд сайжирдгийг тэмдэглэсэн.

Бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон ахлах ангийн охидын зүгээс охид бүх хичээлээ жигд анхаарч санаа зовдог, хөвгүүд сонгосон хичээлүүдээр сурлагын амжилт нь өндөр, бага ангийн охидын төлөөлөл охид илүү сайн суралцдаг, харин дунд ангийн охид бага ангид охид, дундаас дээш ангид хөвгүүд сайн суралцдаг гэж ялгаатай хариулсанаас насны хүчин зүйл сурах үйлд нөлөөтэй байж болохыг

харуулна. Ийнхүү чанарын баримтаар нийтлэг ажиглагдсан нэг зүйл бол бүх хичээлд жигд идэвх чармайлттай, хичээл зүтгэлтэй шинжийг охидод, суралцах чадвараар сайн, цойлж суралцдаг шинжийг хөвгүүдэд хамааруулж тайлбарласан нь анхаарал татаж байгаа юм. Хөвгүүд хэрэгтэй гэж үзсэн хичээл, гүнзгийрүүлж судлах хичээлдээ түлхүү анхаардаг, хэрэггүй хичээлээ тасалдаг, анхаарал хандуулдаггүй, олон төрлийн хичээлээс залхдаг, анхаарал суларч ирдэг онцлогтой болохыг бүх бүлгийн ярилцлагад дурджээ.

“...Ээж: Охидууд унших бичих дуртай байдаг. Хөвгүүд сэтгэхүйгээрээ ханддаг.

Аав: Математик, физик, химийн хичээлдээ хөвгүүд илүү, монгол хэл, нийгмийн хичээлдээ охидууд илүү сайн байдаг.

Аав: Хувь хүүхдийн хүсэл сонирхол, хичээл зүтгэлээс шалтгаална. Эрэгтэй эмэгтэй нь хамаагүй болов уу.”

(Бүлгийн хэлэлцүүлэг, Сонгинохайрхан дүүрэг, эцэг эхчүүд)

“...Ээж: Манай охин шатар болон технологийн хичээлд сайн. Би анх бодохдоо охидууд нийгэм, хэлний чиглэлээр сайн сурдаг гэсэн чинь өөрийн хүүхдээ харахаар бүгд адилхан биш байна.

Аав: Хөвгүүд зохион бүтээх талдаа их авьяастай, тэр чиглэлийн хичээлдээ илүү амжилт гаргаад байдаг.

Эрэгтэй хүүхэд олон хичээл ороод, олон өөр багштай харьцаад ирэхээр, өөрийн онцлогоос болоод уу ихэнх хичээлээ хаяж эхэлдэг. Тэгээд л заримдаа хөвгүүдийн сурлага дунд ангиас муудаж эхэлдэг. Тийм болохоор нэгэнт хичээлдээ муу учраас багш нар ч нэг их тулж ажиллахаа болиод арай ялгаатай хандаад байх шиг байдаг.”

(Бүлгийн хэлэлцүүлэг, Багануур дүүрэг, эцэг эхчүүд)

#### **в. Хүүхдийн суралцах үйл ажиллагаа, мэргэжил сонголтод эцэг эхийн шийдвэр нөлөөтэй байна.**

Бүлгийн хэлэлцүүлгийн үр дүнгээр сүүлийн жилүүдэд эцэг эх хүүхдийн сонирхдог чиглэл, мэргэжил сонголтод хүүхдийн сонирхлыг харгалзсаны үндсэн дээр чиглүүлэх, зөвшилцөх хэлбэрээр нөлөөлж шийдвэр гаргадгийг эцэг эх, сургуулийн удирдлага, хүүхдүүдтэй хийсэн бүлгийн хэлэлцүүлгийн дүн харууллаа.

Ерөнхийдөө эцэг эх хүүхдийнхээ суралцах үйл ажиллагаанд тааруухан анхаарал хандуулж байгааг “хэн ч оролцдоггүй” гэх хариултын эзлэх хувь өндөр байгаагаар тайлбарлаж болох юм. Судалгаанд оролцсон ээжүүдийн өөрийн оролцоогоо эерэгээр үнэлсэн хувийн жин их байх хандлага ажиглагдаж байна. Ээжүүдийн хариултаар, сургуулиас зохион байгуулагддаг үйл ажиллагаанд ээж буюу эмэгтэйчүүд оролцдог гэж 52.7 хувь нь, харин аавууд оролцдог гэж 8.3 хувь нь хариулснаас харвал ээжүүд өөрийн оролцоогоо өндрөөр үнэлсэн байх жишээтэй. Доорх хүснэгтэл харуулснаар сургуулиас зохион байгуулсан үйл ажиллагаанд эцэг, эхийн хэн нь ихээхэн оролцоотой болохыг тодорхой хэмжээгээр харуулж байна. Энэхүү тоон үр дүн чанарын баримтуудыг баталгаажуулж буй юм. Сургуульд хандав өргөх, эцэг эхийн зөвлөлийн гишүүнээр ажиллах, хичээлд суух зэрэгт эцэг эхийн оролцоо харьцангуй тааруу байна.

Хүснэгт 51 Хүүхдийнхээ суралцдаг сургуулийн үйл ажиллагаанд дахь эцэг эхчүүдийн оролцоо, хүйсээр

Үйл ажиллагаа	Аавуудын хариултаар				Ээжүүдийн хариултаар				Нийт
	Нөхөр	Эхнэр	Аль аль нь	Хэн ч оролцдоггүй	Нөхөр	Эхнэр	Аль аль нь	Хэн ч оролцдоггүй	
Сургуулиас зохион байгуулдаг бүх ажил	39.7	28.1	12.4	19.8	8.3	52.7	9.5	29.6	100.0
Хандив өгдөг	17.4	12.4	14.0	56.2	9.5	30.2	4.7	55.6	100.0
Эцэг эхийн зөвлөлийн гишүүнээр ажилладаг	15.7	17.4	0.8	66.7	4.1	26.6	2.4	66.9	100.0
Эцэг эхийн хуралд суудаг	29.8	36.4	17.4	16.5	14.2	63.3	8.9	13.6	100.0
Хүүхдийн хичээлд	14.9	22.3	5.0	57.9	3.0	42.9	1.8	52.7	100.0

суудаг									
Сургуулийн УЗ-ийн гишүүнээр ажилладаг	2.5	3.3	2.5	91.7	1.2	3.0	1.2	94.7	<b>100.0</b>

Сургуулийн удирдлага, багш нартай хийсэн ярилцлагын үеэр бага ангид суралцдаг хүүхэдтэй эцэг эхчүүдийн сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоотой, анги ахих тусам эцэг эхчүүдийн оролцоо буурч ирдгийг тэмдэглэсэн.

Охид хөвгүүдийн онцлог, тэдэнтэй хэрхэн харилцах, хүмүүжүүлэхдээ юунд анхаарах талаар мэдлэг ойлголт дутмаг байгаагаа судалгаанд хамрагдсан ээжүүдийн 85.2 хувь нь, аавуудын 76 хувь нь илэрхийлсэн юм. Төслийн зүгээс эцэг эхчүүдийн жендэрийн боловсрол, сурган хүмүүжүүлэх арга ухаанд чиглэсэн сургалт болон чадавч бэхжүүлэх бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгцээг анхаарах нь зүйтэй.

## 5.2 Сурагчдын жендэрийн талаарх ойлголт мэдлэг, хандлага

Энэхүү дэд бүлэгт ЕБС-ийн сурагчдын эрэгтэй, эмэгтэй хүний дүр үүрэг, багшлах ба суралцах үйл ажиллагаан дахь жендэрийн ялгаатай байдлын талаарх сурагчдын ойлголт, хандлагыг тодруулахыг зорьсон юм.

### 5.2.1 Сурагчдын жендэрийн үүрэг, жендэрийн хэвшмэл ойлголт

Нийгмийн соёл, бүтэц нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн биеэ авч явах байдал, эрх, үүргийг ялгаатайгаар тодорхойлдог бөгөөд энэ нь үеэс үед уламжлагдан ирсэн байдаг. Үүнтэй холбоотойгоор охид, хөвгүүдэд эрэгтэй, эмэгтэй хүний үүрэг, шинжийн талаарх хэвшмэл ойлголт хэр зэрэг илэрч байгааг судлан үзэв. Юуны түрүүнд сурагчид “жендэр” гэж юуг ойлгож байгааг авч хэлэлцье. Судалгаанд хамрагдсан дунд, ахлах ангийн сурагчдын өгсөн мэдээллээр жендэрийг нийгмийн амьдралд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш оролцох тухай гэж ойлгогдоо 35.8 хувь нь илэрхийлсэн бол жендэрийн талаар зөв хариултыг хэлж мэдэхгүй байна гэж 1/3 нь хариулсан байгаагаас үзэхэд жендэрийн талаарх ойлголт мэдлэг хангалтгүй байна. Жендэр нь улс төр, эдийн засаг, эрх зүй, соёл ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй эмэгтэй хүний байр суурь, эрх, үүрэг, хариуцлагын талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл хандлага болохыг сурагчдад хүргэх нь чухал юм.

Хүснэгт 52 Охид, хөвгүүдийн гэртээ хийдэг ажлууд (олон сонголттой хариултаар)

Гэртээ хариуцаж хийдэг ажил	1-5 ангийн сурагч		6-12 ангийн сурагч	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Дүүгээ харах, асрах	49.1	54.7	32.9	39.4
Хоол хийх	15.3	22.2	38.5	60.0
Хувцас хунар угаах	14.2	28.6	24.6	49.8
Өдөр тутмын хэрэглээний ус авах	21.7	13.5	36.7	15.3
Гэр орон цэвэрлэх	70.8	87.3	67.5	82.6
Мод түлээ хагалах, бэлтгэх, гал түлэх	10.8	5.6	29.4	3.0
Мал хариулах	8.3	0.8	3.5	0.9
Эмээ өвөөг асрах, халамжлах	10.8	14.5	1.7	1.7
Сааль сүү саах	0.0	1.6	0.0	1.3

Бага ангийн (1-5 анги) сурагчид гэртээ гол төлөв дүүгээ харах асрах, гэр орон цэвэрлэх зэргийг хийдэг нь нийтлэг хандлагатай байгаа бөгөөд тэр дундаа хоол хийх, хувцас угаах үүргийг охидод илүү даалгадаг байна. Хөдөө орон нутагт мал төллөх болон эцэг эх эзгүй үеэр охид, хөвгүүдийн аль аль нь хоол хийх, хувцас хунараа угаах, мод түлээ хагалах, бэлтгэх, гал түлэх ажлуудыг хийдэг. Өвөл, зуны амралтаараа мал хариулах ажлыг ихэвчлэн хөвгүүдэд даалгадаг ажээ. Хот суурин

газрын гэр хороололд амьдардаг сурагчдын тухайд өрх гэрийн өдөр тутмын хэрэгцээний усыг хөвгүүд зөөдөг аж. Харин дунд, ахлах ангийн (6-12 анги) сурагчдын хувьд гэртээ дүүгээ харах, гэр цэвэрлэх ажлыг охид хөвгүүдийн аль аль нь хийдэг. Ихэнх оролцогчид хоол хийх, хувцас хунар угаах үүргийг охидынх, мод түлээ бэлтгэх, хагалах, гал түлэх, ус авах, мал хариулах, болон мал хариулах нь хөвгүүдийн үүрэг гэж хариулжээ. Монголчуудын өрх гэр бүлдээ эрэгтэй, эмэгтэй хүмүүс ялгаатай үүргийг хүлээдэг нөхцөл байдал сурагчдад хадгалагдсаар байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Эдгээр гэрийн ажлуудыг хийх үндсэн шалтгааныг охид хөвгүүд дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

- Бага ангийн (1-5 анги) хөвгүүдийн 48.3 хувь, охидын 51.2 хувь нь гэрт оноогдсон үүрэгт ажлыг “би өөрөө хийх дуртай учраас гүйцэтгэдэг” гэж хариулснаас үзэхэд сурагчдын 1/2 хэн нэгний дарамт шахалт, шаардлагагүйгээр оноогдсон гэрийн ажлуудыг хийдэг байна. Харин хөвгүүдийн 17.8 хувь нь би хүүхэд учраас бусдын хэлснээр л хийх ёстой гэж хариулсан бол 18.4 хувь нь би эмэгтэй учраас хийдэг гэжээ.
- Дунд, ахлах ангийн (6-12 анги) хөвгүүдийн 36.4 хувь, охидын 31.8 хувь нь гэрийн ажлыг би өөрөө хийх дуртай гэж, цаашлаад хөвгүүдийн 26.0 хувь нь би эрэгтэй, миний үүрэг учраас гэж үзсэн бол охидын 54.4 хувь нь би эмэгтэй, миний үүрэг учраас гэж хариулсан байна.

Өрх гэр бүлд охид, хөвгүүд ялгаатай үүрэг хүлээж буй шалтгааныг “би эмэгтэй эсвэл би эрэгтэй учраас” гэх жендэрийн адилслын үүднээс үзэх хандлага нийтлэг харагдаж байна. Энэхүү байр суурийг охид хөвгүүдтэй хийсэн бүлгийн хэлэлцүүлгийн үр дүн хэр зэрэг батлан харуулж байгааг иш татан оруулав. Доорх ярианы 3-г нь охид, хөвгүүдийн дүр үүргийг жендэрийн хэвшмэл ойлголтын үүднээс дүгнэх хандлага аль хэдийн төлөвшсөн болохыг харуулж байгаа бол нэг нь энэхүү ойлголт, дүр үүрэг нийгэмшин тогтоход гэр бүл, хамаатан садны хүмүүс хүчтэй нөлөөлдөг болохыг илэрхийлж байна.

#### **Жендэрийн үүргийн талаарх талаарх хандлага**

...”Ахмад настай хүмүүс эмэгтэй хүнийг гэр орны ажилд илүү сайн бай гэж сургадаг. Манай гэрт аавын дүү ирээд гэр янзлахад ахаараа битий хийлгэ, гэр цэвэрлэх нь эмэгтэй хүний ажил. Гэр орондоо эрэгтэй хүн хаан, эмэгтэй хүн боол шиг байдаг. Бага байхдаа би инженер болно гэж мөрөөддөг байсан. Чи эмэгтэй хүн учраас хэрэггүй гэдэг байсан. Наадмаар хөдөө морь унаж ирсэн хүүхдүүдийг ирэхээр нь цуг тоглох гээд очихоор эмэгтэй хүүхдүүд байж явж аяга тавгаа угааж хоолоо хий гээд загнаад байсан. Тэр үед надад их эвгүй санагдаж байсан. Бас морины уяа руу эмэгтэй хүн байж битгий яв гэдэг. Гэтэл би моринд дуртай, сонирхолтой байдаг.”

*Сүхбаатар аймаг, Охидын бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*

...”Охидын, хөвгүүдийн ажил гэж байхгүй ч охид гэрээ цэвэрлээд байгаа нь хувийн зан чанартай нь холбоотой. Жишээ нь: эрэгтэй хүн цаанаасаа хүчтэй байдаг, буйр суурьтай байдаг болохоор гэрийн гаднах ажил, юм засах зэрэг ажлыг, эмэгтэй хүн уян хатан зөөлөн чанартай байдаг болохоор хүүхдээ асрах, гэр орноо цэвэрлэх, хоол хийх ажлаа хийдэг.”

*Улаанбаатар хот, Охидын бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*

...”Биеийн хүчний ажил бол эрэгтэй хүнийх гэж боддог. Эмэгтэй хүүхдүүд гэр орноо цэвэрлэх, хувцас угаах гэх мэт ажлыг хийдэг. Хөвгүүдийг хүүхэд байхаас л ээж аав чи эмэгтэй хүнийг хүндлэх хэрэгтэй, хүнд хүчир ажил хийлгэж болохгүй, эгч нарыгаа аль болох хүнд юм өргүүлэхгүй гэж сургадаг, заадаг. Гэртээ хааяадаа хог хаяна. Харин жорлон цэвэрлэдэггүй ихэвчлэн ээж л цэвэрлэдэг. Жорлон цэвэрлэвэл эр хүний хийморьт муу гэдэг. Ээж, эгч, охин дүү нар л цэвэрлэдэг.”

*Улаанбаатар хот, Хөвгүүдийн бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс*

...”Эрэгтэй хүн алсын бодол холч ухаантай байх ёстой. Айл гэрийг авч явах хүн учраас. Эрийн нэрээр орж, эмийн нэрээр гардаг гэж үнэн. Миний нэрээр ороод миний эхнэрийн нэрээр л гарна гэсэн утгатай. Тухайн айл ямар болохыг гэрийн эзэгтэйгээс их харна. Биеийн онцлогт нь тохирсон учраас л ажлууд хуваагдаж байгаа. Санал нийлдэг.”



Өвөрхангай аймаг, Хөвгүүдийн бүлгийн хэлэлцүүлэгийн тэмдэглэлээс

Ер нь чанарын судалгааны мэдээллээр эрэгтэй, эмэгтэй хүний байгалиас заяасан ялгаа нь гэр бүлийн ялгаатай үүргийг гүйцэтгэхэд хүргэдэг гэж охид хөвгүүд үзэж байна. Тухайлбал, эмэгтэй хүн нямбай, уян хатан, зөөлөн сэтгэлтэй учраас гэр цэвэрлэх, хүүхэд харах, хоол хийхдээ сайн, харин эрэгтэй хүн хүчтэй, буйр суурьтай, холч ухаантай тул гэр орноо авч явах, тэжээх, илүү хүнд хүчир ажлыг хийдэг тухай үзэл санаа нь жендэрийн хэвшмэл ойлголт охид, хөвгүүдэд байгааг илтгэн харуулж байна.

Гэр бүлийн гишүүдийн дүр үүргийн талаарх судалгаанд оролцогч сурагчдын ойлголт, хандлагыг хүйс болон ангиар харьцуулж шинжлэхэд дараах дүр зураг ажиглагдаж байгаа юм.

Хүснэгт 53 Гэр бүлийн гишүүдийн дүр үүргийн талаар сурагчдын ойлголт, хандлага

Гэр бүлийн гишүүдийн үүрэг	Хариултууд	1-5 анги		6-12 анги	
		эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
Мөнгө олж, гэр бүлийн гишүүдийг тэжээх	аав	21.7	19.1	13.9	18.0
	ээж	8.3	8.7	5.2	3.1
	аав ээж хоёулаа	58.3	64.3	57.6	60.2
	хэн ч хийж болно	11.7	7.9	23.4	18.8
Хүүхэд асрах	аав	1.7			0.4
	ээж	65.0	70.6	26.4	24.5
	аав ээж хоёулаа	16.7	15.1	22.1	21.5
	хэн ч хийж болно	16.6	14.3	51.5	53.6
Бидний амьдарч буй сууц, машин гээд өмч хөрөнгөө эзэмших	аав	49.2	38.9	22.1	21.5
	ээж	1.7	7.9	3.0	3.8
	аав ээж хоёулаа	34.1	42.9	46.3	45.2
	хэн ч хийж болно	15.0	10.3	28.6	29.5
Хоол хийх, гэр цэвэрлэх, гэр бүлийнхнийгээ асран халамжлах зэрэг гэрийн ажлыг хийх	аав	0.8	4.8	0.9	0.8
	ээж	36.7	39.7	26.0	29.5
	аав ээж хоёулаа	28.3	22.2	10.4	15.7
	хэн ч хийж болно	34.2	33.3	62.8	54.0
		<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Гэр бүлд гүйцэтгэдэг эцэг эхийн үүргийг бага ангийн (1-5 анги) сурагчдын хариултаас үзэхэд охид, хөвгүүдийн хувьд мөнгө олж, гэр бүлийн гишүүдийг тэжээх нь эцэг эхийн аль алиных нь үүрэг; хоол хийх, гэр цэвэрлэх, гэр бүлийнхнийгээ асран халамжлах зэрэг гэрийн ажлыг ээжийн үүрэг (26.0%-39.7%), харин амьдарч буй сууц, машиныг аав л өмчлөх ёстой (21.5%-49.2%) гэсэн хандлага тодорхой түвшинд ажиглагдаж байна. Харин бага ангийн охидын хувьд хүүхэд асрах нь аавын үүрэг гэж хариулаагүй нь анхаарал татаж байв.

Дунд, ахлах ангийн (6-12 анги) сурагчдын бодлоор гэр бүл дэх аав ээжийн ажил үүргийн хуваарилалтыг хүйсээр хуваарилах бус, харин тэгш оролцоотой байх ёстой гэсэн байр суурь харагдаж байгаа хэдий ч эмэгтэй, эрэгтэй сурагчдын хувьд хүүхэд асрах нь ээжийн үүрэг, өмч хөрөнгө эзэмших нь аавын эрх, мөнгө олж, гэр бүлийн гишүүдийг тэжээх нь аавын үүрэг гэж нийт судалгаанд хамрагдсан охидын 1/3 нь үзэж байна. Иймд гэр бүлд эрэгтэй, эмэгтэй эзэлдэг буюу эзлэх ёстой байр суурь, дагаж мөрдөх зан үйл, гүйцэтгэдэг үүрэг нь хүйсээс хамааран ялгаатай байх ёстой гэсэн хандлага охид, хөвгүүдийн тодорхой хэсэгт байгааг анхаарах хэрэгтэй юм. Цаашид жендэрийн үүргийг тодорхойлж буй хэвшмэл ойлголтын талаар сурагчдад илүү мэдээлэл өгөх хэрэгцээ шаардлага байна.

Зураг 37 Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ялгаатай үүрэг хүлээж байгаагийн шалтгааныг тайлбарлах байдал



Гэр бүл дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай үүрэг хүлээдэг шалтгааныг охид үзэхдээ эрэгтэй, эмэгтэй хүний төрөлхийн шинжтэй, харин хөвгүүдийн хувьд хүмүүсийн зав боломжоос хамааран ялгаатай үүрэг хүлээдэг гэх хариултын эзлэх хувь илүү байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай үүрэг хүлээж буй шалтгааныг ангиар нь авч үзвэл бага ангийн сурагчид хэн нь зав чөлөөтэй байгаатай холбон авч үзсэн. Дунд ба ахлах ангийн сурагчдын хувьд эрэгтэй, эмэгтэй хүний байгалиас заяасан ялгаатай шинж, ажил эрхлэлт болон гэр бүлийн уламжлал зан заншилтай холбон авч тайлбарлажээ. Тэр дундаа, гэр бүлд эрэгтэй эмэгтэй хүмүүс ялгаатай үүрэг хүлээж байгаагийн шалтгааныг уламжлалт хандлагаар тайлбарлах нь охид, хөвгүүдийн дунд оршоор байгааг судалгааны дүн харуулж байна.

Судалгаанд хамрагдсан 1-5 ангийн сурагчдын хувьд охид аливааг оновчтой шийддэг, нийгмийн ухааны хичээлд сайн, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, гэрийн ажилд сайн гэсэн бол хөвгүүд удирдах авьяастай, сэтгэлийн хөдлөлөө удаан илэрхийлдэг, техникийн зүйлд авьяастай, зоригтой, хүчтэй гэдэгтэй бүрэн санал нийлж байгаа нь жендэрийн хэвшмэл ойлголт охид, хөвгүүдэд байгааг давхар баталж байна. Харин дунд болон ахлах ангийн охид, хөвгүүд жендэрийн талаарх хэвшмэл ойлголтуудтай зарим талаар санал нийлэх нь зонхилж байна.

Судалгааны үр дүнгээр эмэгтэй сурагчдын 45.2 хувь нь охид хөвгүүдийг бодвол аливааг оновчтой шийдэж чаддаг гэдэгтэй бүрэн санал нийлдэг байна. Эрэгтэй сурагчдын 53.3 хувь нь хөвгүүд удирдах манлайлах авьяастай гэдгээ хүлээн зөвшөөрдөг бол эмэгтэй сурагчдын 38.9 хувь нь энэхүү дүгнэлттэй зарим талаар санал нийлдэг гэсэн хариултыг өгсөн байна. Хөвгүүд байгалийн ухааны хичээлд сайн гэдэгтэй охид, хөвгүүд зарим талаар санал нийлэх нь зонхилж байгаа ч, судалгаанд оролцогч охидын 1/4 нь огт санал нийлэхгүй байна гэжээ. Охидын 60.3 хувь нь өөрсдийгөө хэл болон нийгмийн ухааны хичээлд сайн гэж үзсэн үзүүлэлтийг хөвгүүдийн хариулттай харьцуулахад 2 дахин их байна. Охид хөвгүүдийг бодвол өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, нээлттэй байж чаддаг гэдэгтэй бүрэн санал нийлж байгаа эрэгтэй, эмэгтэй сурагчдын хариултын эзлэх хувь нь 51.2 ба 54.8 харьцаатай байна. Харин охид гэрийн ажил хийхдээ илүү чадварлаг гэж охидын 85.7 хувь, хөвгүүдийн 77.5 хувь үзсэн нь гэрийн ажил эмэгтэй хүнийх гэсэн үзэл хандлага эмэгтэй, эрэгтэй сурагчдын хэн хэнд нь харагдлаа. Хөвгүүд техникийн хичээлд илүү чадварлаг, хөвгүүд зоригтой, хүчтэй гэдэгтэй бүрэн санал нийлж байгаа охид хөвгүүдийн дундаж үзүүлэлт нь 74.8 хувьтай гарсан нь судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 2/3 байна. Охидыг сул дорой, хүлцэнгүй, өрөвч сэтгэлтэй гэх ойлголттой эмэгтэй сурагчдын 34.1 хувь буюу 1/3 нь бүрэн санал нийлж байгаа нь анхаарал татаж байв. Ийнхүү сурагчдын дунд эрэгтэй, эмэгтэй хүний давуу болон сул талуудын талаарх хэвшмэл ойлголт тодорхой хэмжээнд ажиглагдаж байна.


### 5.3 Багш нарын жендэрийн ойлголт, хандлага

Энэхүү хэсэгт судалгаанд оролцсон багш нарын жендэрийн талаарх ойлголт хандлагыг тодруулан хэлэлцэх юм.

Мөнгө олж гэр бүлээ тэжээх тухайд нийт оролцогсдын 84.7 хувь нь эхнэр нөхөр хоёулангийн үүрэг,

хэн ч хийж болно гэсэн хариултыг сонгосон. Энэ үзүүлэлтийг судалгаанд оролцогсдыг насны хувьд ангилсан (22-30, 31-40, 41-50, 51-59, 60 аас дээш) таван бүлэгтэй харьцуулахад багш нарын нас залуу байх тусам багш мөнгө олж гэр бүлээ тэжээхийг эхнэр нөхөр хоёулангийн үүрэг, энэ үүргийг хэн нь ч хийж болно гэдэг хариултад өндөр хувьтай хариулж, нас ахих тусам уг үзүүлэлт бага багаар буурсан байна. Эрэгтэй багш нарын 81.5 хувь, эмэгтэй багш нарын 61.3 хувь нь мөнгө олж гэр бүлээ тэжээх нь хоёулангийн үүрэг, хэн ч хийж болно гэж үзсэн. Бидний амьдарч буй сууц машин, гээд өмч хөрөнгө эзэмших тал дээр эрэгтэй багш нарын 91.4 хувь, эмэгтэй багш нарын 71.3 хувь нь эхнэр нөхөр хоёулаа, хэн ч байж болно гэдгийг сонгосон. Үүнээс эрэгтэй багш нар өөрсдийгөө өрхийн тэргүүн эд хөрөнгөө өөрийн нэр дээр эзэмших ёстой гэсэн уламжлалт ойлголтыг дагадаггүйг, эмэгтэй багш нар эд хөрөнгө эзэмшихийг заавал эр хүнтэй холбохгүй байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Зураг 38 Багш нарын жендэрийн дүр үүргийн талаарх хандлага, хувиар




Хүүхэд асрах нь нөхрийн үүрэг гэж 141 эрэгтэй багшаас нэг л хүн өөртөө үүрэг хүлээлгэсэн хариулт сонгосон. Харин энэ нь эхнэрийн үүрэг гэж эрэгтэй багш нарын 26.9 хувь нь, эхнэр нөхөр хоёулаа, хэн ч хийж болно гэж 73.1 хувь нь тус тус хариулсан байна. Хоол хийх гэр цэвэрлэх, гэр бүлийнхнийгээ асран халамжлах, зэрэг нь нөхрийн үүрэг гэдгийг 2 эрэгтэй багш л өөрсдийн үүргээ гэж хариулсан бол, зөвхөн эхнэрийн үүрэг гэж 26.1 %, эхнэр нөхөр хоёул хийж болно гэдгийг 73.9 хувь нь тус тус үзсэн байна. Эрэгтэй багш нарын хариултаас хүүхэд асрах, гэр орны ажил хийх үүргийг эрэгтэй хүний үүрэг гэж үзэх хандлага байхгүйг харуулж байна. Түүнчлэн хэдийгээр бага хувь эзэлж байгаа ч, өмч хөрөнгө өмчлөх, гэр бүлээ тэжээх үүргийг эрэгтэйд оногдуулах хандлага ажиглагдаж байна.

Нийт оролцогчдоос эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүлдээ өөр өөр үүрэгтэй байдаг нь тэдний зав боломжоос хамааралтай гэж 38.8 %, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гэр бүлийн уламжлал заншлаараа гэр бүлийн гишүүд үүргээ хуваарилсантай холбоотой гэж 33.3%, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн төрөлхийн шинжтэй холбоотой 24.6 % гэж гэсэн хариултауд давамгайлсан. Өрх гэр бүл дэх хөдөлмөрийн хуваарийн шалтгааныг уламжлалт зан заншил хийгээд төрөлхийн хүчин зүйлстэй холбон тайлбарлаж байгаа нь нийт **56 хувийг** эзэлж байгаа буюу судалгаанд оролцсон багш нарын тал хувьд жендэрийн дүр үүргийн талаарх хэвшмэл ойлголт давамгайлсаар байгааг илэрхийлж байна. Үүний нөгөө талд, багш нарын ахуй хангамж, нийгмийн асуудал, цалин хангамж бага байгаагаас тэд сонголтгүйгээр мөнгө олох гэр бүлээ тэжээх ёстойг сонгож байгаа нь анзаарагдаж байгаа юм. Мөн багш мэргэжилтэй эрэгтэйчүүд эхнэртээ нилээдгүй ачааг үүрүүлэх хандлагатай байна. Тэд мөнгө олж гэр орноо тэжээх үүргээ эрэгтэйчүүд эмэгтэйчүүд хамтран хийх ёстой гэдэг дээр 80 орчим хувь нь зөвшөөрсөн ч, хүүхдээ асрах гэр орны ажлаа хийх гэдгээс өөрсдийгөө чөлөөлсөн. Энэ нь тэдний гэр бүлийн эмэгтэйчүүд уламжлалт хандлагаар хүүхдээ асрах, гэр орноо цэвэрлэх дээрээс нь мөнгө төгрөг олж гэр бүлээ тэжээдэг, бүхий л ачааг нуруундаа үүрч яваа

байдал анзаарагдаж байна.


Охид, хөвгүүдийн талаарх хэвшмэл ойлголтуудтай багш нарын 60 орчим (дунджаар) хувь ямар нэг хэмжээгээр санал нийлж байгаа дүр төлөвийг доорх зургаас харж болно. Ялангуяа эмэгтэй багш нар (65.7%) эрэгтэйгээсээ (57.5%) илүүтэйгээр охид, хөвгүүдэд хэвшмэл ойлголтын үүднээс ханддаг ажээ. Хөвгүүд техникт авьяаслаг, хүчтэй зоригтой, охид гэрийн ажилд чадварлаг гэсэн ойлголт бусдаас түлхүү ажиглагдаж байлаа. Тодруулбал, гурван эмэгтэй багшийн 2 нь ийм хандлагатай байна. Харин охидын сул дорой, өрөвч, энэрэнгүй гэх хандлагыг хүлээн зөвшөөрөх байдал бусдаас бага ч, талаас дээш хувь нь үүнтэй санал нийлж байна. Эдгээр нь байршил болон ямар хичээл заадгаас төдийлөн хамаарахгүй байв.

Зураг 39 Охид хөвгүүдийн талаарх хэвшмэл ойлголт, эрэгтэй эмэгтэй багш нарын санал нийлж байгаа хариултын хувийн жингээр



Хөвгүүд математик, байгалийн ухааны хичээлд, охид нийгмийн ухааны хичээлдээ илүү гэдэгтэй эрэгтэй, эмэгтэй багш нарын талаас дээш хувь нь санал тодорхой хэмжээгээр нийлж байна гэсэн хариулт өгсөн. Мөн л эмэгтэй багш нарт “ямар хичээлд сайн” тухай хэвшмэл ойлголт эрэгтэйгээс түлхүү ажиглагдаж байна. Гэтэл сурагчдаас авсан мэдээллээс харахад охид математикийн хичээлд дур сонирхолтой байхад хөвгүүд эсрэгээрээ дургүй хичээлүүдийн тоонд юуны түрүүнд байгалийн ухаан, математикийн хичээлүүдийг нэрлэсэн байв. Түүнчлэн, чанарлаг аргаар авсан мэдээллээр ч гэсэн хүүхдүүд сонирхсон хичээлдээ илүү гэдгийг багш, сурагчид бүгд илэрхийлсэн. Ийнхүү багш нарын дийлэнх хэсэгт хөвгүүд, охидод хэвшмэл ойлголтын үүднээс хандах хандлага ажиглагдаж байгааг анхаарах шаардлагатай байна.

Зураг 40 Охид, хөвгүүдийн авьяаслаг хичээлүүд, багш нарын санал нийлж буй хариултын хувийн жингээр



...”Эрэгтэй хүүхэд байгалийн ухаан, эмэгтэй хүүхэд нийгмийн ухааны хичээлд илүү гэдэгтэй санал нийлэхгүй. Монгол хэл, хэлний талын хичээлд ой тогтоолт сайтай хүүхэд сайн байдаг ш дээ. Яриандаа сайн хүүхэд монгол хэлдээ сайн байдаг, хүйс хамаарахгүй.”

*Сурагчдын бүлгийн ярилцлага, УБ, Баянзүрх дүүрэг 84-р сургууль*

...”Эрэгтэй хүүхэд байгалийн ухаан, эмэгтэй хүүхэд нийгмийн ухааны хичээлд сайн гэдэг ойлголт догматик ойлголт юм. Энэ бол тухайн хүүхдийн сонирхлыг дагасан сурлагын амжилт, мэргэжил сонголт байдаг.”

*Ганцаарчилсан ярилцлага, Налайх дүүрэг 119-р сургууль дунд ахлах менежер*

Судалгаанд оролцогчдоос жендэрийн талаарх ойлголтыг тодруулахад дараах үр дүнгүүд ажиглагдлаа. Жендэр гэдгийг эмэгтэйчүүдийн **68.5 хувь** нь нийгмийн амьдрал дахь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоо, **12.8 хувь** нь сургууль байгууллагад хүйсийн харьцааны тэнцвэртэй байдлыг хангах тухай, **11.6 хувь** шийдвэр гаргах түвшинд эмэгтэй эрэгтэйчүүдийн тэгш оролцоо гэж гэж тус тус үзсэн. Харин багш нарын **0.8 хувь** нь жендэр гэдэг нь эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг тэмцэх үйл хэрэг, **3.9 хувь** нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм, соёлын ялгааг тусгах ойлголт гэж буюу **ердөө 19 хүн л зөв хариултыг** сонгосон байв. Энэ нь хүйсийн хувьд ялгаа багатай ч, зөв хариулсан эрэгтэй багш нарын хувийн жин эмэгтэйгээс бага зэрэг илүү ажээ. Үүнээс багш нарын “жендэр”-ийн талаар ойлголт, мэдлэг тун тааруухан болох нь харагдаж байна. Мөн нийт судалгаанд оролцогчид эрэгтэй эмэгтэй багш нарын жендэрийн тухай хуулийг мэдэхгүй гэж 68.5 % нь, мэднэ гэж 31.5 % хариулснаас уг хуулийн талаарх мэдлэг мэдээлэл багш нарт хангалтгүй байна дүгнэж байна.

#### 5.4 Сургуулийн удирдах ажилтнуудын жендэрийн ойлголт, хандлага

Энэ хэсэгт сургуулийн удирдах ажилтан болон аймаг, дүүргийн боловсрол соёлын газрын удирдах ажилтнуудын жендэрийн талаарх ойлголт мэдлэг, жендэрийн асуудалд ач холбогдол өгч буй байдлыг авч үзсэн. Энэ нь Ерөнхий боловсролын сургуулийн жендэрийн бодлогын орчинг босоо байдлаар бүхэлд нь харуулах боломжийг бүрдүүлсэн. Энэ хэсэгт 68 удирдах ажилтны анкетын судалгааны үр дүн, 32 удирдах ажилтны ганцаарчилсан ярилцлагын мэдээлэл багтсан.

##### *Удирдах албан тушаалтнуудын жендэрийн талаарх ойлголт*

2011 онд батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд “жендэр”-ийг улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага гэжээ. Тус тодорхойлолт нь жендэрийг өргөн

хүрээнд тайлбарлаж өгсөн. Сургуулийн удирдах ажилтнууд жендэрийг ойлгож буй байдлыг хүснэгтээс харна уу.

Хүснэгт 54 Сургуулийн удирдах түвшний ажилтнуудын жендэрийн талаарх ойлголт, хүйсээр

№	Жендэрийг ойлгож буй байдал	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
1	Сургуульд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах тухай	14.3	14.5	14.5
2	Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай	4.8	1.8	2.6
3	Эрэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай	0.0	0.0	0.0
4	Нийгмийн амьдралд эрэгтэй эмэгтэй хүмүүс тэгш оролцох тухай	71.4	60.0	63.2
5	Шийдвэр гаргах түвшин дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцооны тухай	9.5	16.4	14.5
6	Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг тэмцэх тухай	0.0	0.0	0.0
7	Эмэгтэйчүүд гэрийн ажлаа хийх, эрчүүд гадуур ажил хийх тухай	0.0	0.0	0.0
8	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм соёлын ялгааг тусгаж байгаа ойлголт	0.0	7.3	5.3
	Нийт	100	100	100

Сургуулийн удирдах ажилтнууд жендэрийг нийгмийн амьдралд эрэгтэй эмэгтэй хүмүүс тэгш оролцох, шийдвэр гаргах түвшин дэх болон сургууль/байгууллага дахь хүйсийн тэгш харьцааны тухай асуудал гэж ойлгож (Хүснэгт 2.1.) байна. Өмнө дурдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд жендэрийг өргөн хүрээнд тодорхойлсон бол сургуулийн удирдах ажилтнуудад жендэрийн талаар тогтсон ойлголт хараахан байхгүй байна. Түүнчлэн тэдний 2.6 хувь нь жендэрийг зөвхөн эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай ойлголт гэж үзсэн нь жендэрийн хувьд таатай сургуулийн орчинг бүрдүүлэх субъектүүд жендэрийн талаар өрөөсгөл ойлголттой байгааг харуулж байна. Иймд сургуулийн удирдах ажилтнуудад жендэрийн талаарх нэгдмэл ойлголтыг бий болгох сургалт явуулах, жендэр нь сургууль дахь хүйсийн тэгш харьцааны тухай ойлголтоос илүү өргөн хүрээний асуудал болохыг таниулах нь зүйтэй.


*Удирдах албан тушаалтнуудын жендэрийн хэвшмэл үзэл, хандлага*

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.3. дахь хэсэгт “жендэрийн хэвшмэл үзэл” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлага хэмээн тодорхойлсон.

Монголчуудын уламжлалт зан заншилтай холбоотойгоор охид хөвгүүд болоод эрэгтэй эмэгтэй хүмүүст тодорхой дүр үүрэг ногдож ирсэн байдаг. Охин хүүхэд ээжийгээ даган оёдол үйл хийх нь эмэгтэй хүний зайлшгүй суралцах эрдэм байсан бол хүү нь эцгээ даган адуугаа хураах зэргээр эрэгтэй, эмэгтэй хүний уламжлалт дүр үүргийг бага балчир наснаас нь уламжлуулж ирсэн байдаг. Суурин соёл иргэншилд шилжснээр мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогтой уялдсан хөдөлмөрийн хуваарь өөрчлөгдөж байгаа ч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм болон гэр бүлдээ гүйцэтгэх үүргүүдэд жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрийн өрөөсгөл хандлага олон нийтийн дунд хадгалагдсан хэвээр байгаа билээ.

Сургуулийн удирдах ажилтнууд гэр бүл дэх эхнэр, нөхрийн ажил үүргийн хуваарийг (зураг 41)-ээс харна уу.

Зураг 41 Нөхөр, эхнэрийн гэр бүл дэх ажил үүргийн хуваарилалт



Тухайн субъектын жендэрийн хэвшмэл үзлийг тогтоохдоо гэр бүлд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүргийн талаарх байр суурийг судалснаар илрүүлэх боломжтой. Сургуулийн удирдах ажилтнуудын дунд мөнгө олж, гэр бүлийн гишүүдийг тэжээх болон орон сууц, машин гээд өмч хөрөнгөө эзэмших үүргийг эхнэрийн үүрэг гэж үзсэн оролцогч байхгүй байна. (Зураг 2.1.) Энэ нь гэр бүлээ эрэгтэй хүн авч явж, өмч хөрөнгө гэрийн эзний буюу нөхрийн нэр дээр бүртгэдэг уламжлалт зан заншил тодорхой хэмжээгээр нөлөөтэй хэвээр байгааг харуулж байна.

Харин хоол хийх, гэр цэвэрлэх, гэр бүлийнхнийгээ асран халамжлах, хүүхдээ өсгөх үүргийг эхнэрийн үүрэг гэж үзсэн оролцогчид нөхрийн үүрэг (Зураг 2.1) гэж үзсэн оролцогчдоос даруй 4-5 дахин их хувьтай байна. Учир нь уламжлалаар гэр цэвэрлэх, хоол хийх, хүүхдээ хүмүүжүүлэх ажлууд нь эхнэр хүний хийх ажлын хүрээнд багтдаг байснаас хамаарч байна гэж үзэж болох юм.

Дээрх үр дүнг хүйсээр харьцуулан үзэхэд хоол хийх, гэр цэвэрлэх, гэр бүлийнхнийгээ асран халамжлах ажлыг нөхрийн үүрэг гэж үзсэн эмэгтэй оролцогч байхгүй байна. Эндээс сургуулийн эмэгтэй удирдах ажилтнуудад гэр бүл дэх ажил үүргийн талаарх уламжлалт хандлага, жендэрийн хэвшмэл үзэл илүү хадгалагдаж байна гэж үзэж болно. Тухайлбал эрэгтэйчүүдийг үйлдвэрлэлийн үүрэгтэйгээр, эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн үүрэгт илүү хамааруулж ойлгож ханддаг жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрийн өрөөсгөл хандлага удирдах ажилтнуудын дунд байсаар байна.

*Сургуулийн шийдвэр гаргалт дахь тэгш оролцоо болон жендэрийн мэдрэмжтэй сургуулийн орчныг бүрдүүлэхэд ач холбогдол өгч буй байдал*

Жендэрийн мэдрэмжтэй сургуулийн орчин нь аль нэг хүйсийг хязгаарласан, хориглосон үйл ажиллагаа явуулахгүй, үйл ажиллагаандаа хүйсийн тэгш харьцаа, тэгш боломжийг олгож буй байдлаас хамаарна. Тухайлбал сургуульд шийдвэр гаргахад багш, ажилтан, сурагч, эцэг эхийн оролцоог хангах нь жендэрийн мэдрэмжтэй сургуулийн орчинг үнэлэх үзүүлэлт болох юм. Энэхүү тэгш оролцоо нь охид хөвгүүдийн, эрэгтэй эмэгтэй багш ажилтны ялгаатай хэрэгцээ, шаардлагыг харгалзсан шийдвэр гарах үндэс болно.

Хүснэгт 55 Сургуулийн удирдлагын зүгээс шийдвэр гаргахад багш, ажилтан, сурагч, эцэг эхчүүдийг оролцуулж буй байдал, хувиар

№		Багш	Ажилтан	Сурагч	Эцэг эх	Нийт
1	Сургуулийн удирдах зөвлөлөөс шийдвэр	30.8	21.1	22.7	25.4	100

	гаргахад төлөөлөл багтаах					
2	Захиргааны зөвлөлөөс шийдвэр гаргахад төлөөлөл багтаах	39.1	33.0	13.9	13.9	100
3	Бичгээр хүсэлтээ гаргасан бол шийдвэрт тусгах	25.0	23.9	25.0	26.1	100
4	Сурагчид өөрсдийн төлөөллөөрөө дамжуулах	19.3	14.7	50.5	15.6	100
5	Эцэг эхийн зөвлөл	21.1	11.9	11.0	56.0	100
6	Ангийн багшаар дамжуулах	23.5	11.8	36.1	28.6	100
7	Сурагчид эцэг эхээрээ дамжуулах	31.2	8.3	31.2	29.2	100
8	Нийгмийн ажилтнаар дамжуулах	20.3	20.3	33.3	26.1	100

Сургуулийн шийдвэр гаргах үйл явцад эцэг эхчүүд эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан оролцдог бол сурагчид “Сурагчдын зөвлөл” (Хүснэгт 2.2.) буюу өөрөө удирдах байгууллагаар дамжуулан сургуульд санал хүсэлт гаргаж байна. Зарим сургуулиудын хувьд хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа нээлттэй байдлаар санал авдаг болох нь ярилцлагын судалгааны үр дүнгээр илэрсэн.

Судалгаанд хамрагдсан сургуулиуд сургуулийн дотоод дүрэм, журмыг багш нарын зөвлөгөөний хурлаар, сурагчдын дүрмийг сурагчдын зөвлөлийн хурлаар баталж байгаагаас үзвэл тухайн дүрмийг батлахад дүрмийг мөрдөх субъектүүдийн оролцоо сайтар хангагдсаныг харуулж байна. Мөн зарим сургуулийн удирдах ажилтнуудын зүгээс шийдвэр гаргах явцад сурагчид болон багш нараас санал авах ажиллагааг тогтмол зохион байгуулж хэвшээд байгаа нь сайшаалтай хэрэг юм.

...“Өмнө нь сурагчийн зөвлөл төлөвлөгөөгөө гаргаж хэлэлцээд багш нарын зөвлөлөөр санал асуусан болоод шийддэг байсан. Энэ хичээлийн жилээс эцэг эхийн хурал хийсэн, багш сурагчдаас, дүүргийн ТББ, төрийн байгууллагыг оролцуулж, тэдний саналыг сонсож асуудлыг шийддэг болсон. Бид зөвхөн хүснэгт өгч багш нар санал бичиж дүүргэдэг болсон. Сургуулийн төлөвлөгөө, бүтэн жилийн ажлын төлөвлөгөө, өдөр тутмын, 14 хоногийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хамт олны оролцоонд тулгуурлаж боловсруулдаг. Үйл ажиллагаа төлөвлөхдөө, урлагийн үзлэг зохион байгуулахдаа эмэгтэй, эрэгтэй хослолтой байхаар зохион байгуулдаг.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

...“Бидний баримталдаг зарчим бол ямарваа асуудлыг доороос нь эхэлж шийдэхийг оролддог. Тухайлбал багшийг шагналд тодорхойлох, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулахад ЗАН-ийн саналд үндэслэдэг. ЗАН 4-8 хүний бүрэлдэхүүнтэй, ЗАН-ын нэгдлээрээ яриад ур чадварын нэмэгдэл, шагнал урамшилд тодорхойлох багш нараа шийдээд дараа нь захирлын дэргэдэх зөвлөлд \бүх ЗАН-ийн ахлагч нар, менежерүүд, нийгмийн ажилтан, захирал\ дороос гарсан саналыг танилцуулж зөвшилд хүрч шийддэг.”


*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

Ярилцлагын мэдээллээс үзвэл сургуулийн орчинд гарч буй шийдвэр нэгжээс гарсан саналд үндэслэгдэн олон талын байр суурьт түшиглэн гарч байна. Сургуулиудын шийдвэр гаргалтад нийтлэг илэрсэн шинэлэг тал нь шийдвэр гаргахын өмнө багш, ажилчид, сурагчдаас санал авч ажиллаж эхэлсэн явдал байна. Санал авахдаа сургуулийн удирдлагууд өөрсдийгөө үнэлүүлж, үйл ажиллагаагаа сайжруулж буй сайн жишиг тогтож байгаа нь ярилцлагын явцад ажиглагдлаа.

Судалгаанд хамрагдсан удирдах ажилтнууд сургуулийн орчин дахь жендэрийн асуудлыг багшлах боловсон хүчний хүйсийн харьцаа тэнцвэргүй байгаа явдал хэмээн үзэж байна. Гэвч хүйсийн харьцаа тэнцвэргүй байгаа нь зайлшгүй бөгөөд багшийн ажил эмэгтэй хүнд илүү тохиромжтой гэсэн жендэрийн хэвшмэл үзэл бүхий байр суурийг илэрхийлсэн байна. Удирдах ажилтнуудын 38.2 хувь нь өмнө нь жендэрийн сургалтад хамрагдаж байсан гэжээ.



Зураг 42 Жендэрийн сургалтад хамрагдсан байдал, хувиар



Сургуулийн боловсон хүчний хүйсийн харьцаа тэнцвэртэй байх нь сургуулийн соёл болоод багш нарын хоорондын харилцаанд эергээр нөлөөлөх боломжтой асуудал юм. Удирдах ажилтнуудаас аймаг, дүүргийн боловсролын газраас жендэрийн талаар баримтлах бодлого, зөвлөмж өгдөг үү? гэж асуухад 100 хувь үгүй гэсэн хариултыг өгсөн бол аймаг, дүүргийн боловсролын газрын төлөөллөөс Боловсрол соёл, шинжлэх ухааны яамнаас ЕБС-ийн орчинд жендэрийн талаар баримтлах бодлого, чиглэл өгдөг үү? гэж асуухад мөн 100 хувь үгүй гэж хариулсан юм. Босоо тогтолцоо бүхий тус салбарын бодлогод буюу цөм хөтөлбөр, боловсролын шинэчлэлд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үзэл баримтлал, бодлого туссан ч түүнийг хэрэгжүүлэх заавар, чиглэл өгөх явдал дутагдалтай байна.

...“ Цөм хөтөлбөрийн хүрээнд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үзэл баримтлал зарчим суусан. Сургалт, хүмүүжлийг найз нөхөд, гэр бүлийн орчинд хөгжүүлж төлөвшүүлэхийг зорьж байгаа. Сургалтыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд Иргэний боловсрол, ёс суртахуунаар сэтгэл зүрхний боловсрол олгож байна. Аав хүн ямар байх вэ, ээж хүн ямар байх вэ гэх мэт. Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хүүхдийн идэвх оролцоонд тулгуурласан зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Жишээ нь хүүхэд жендэрийн асуудлыг сонгоод ороод ирвэл үүнд чиглэсэн үйл ажиллагааг сургууль явуулна. Эцэг эхийн оролцоог хүүхдээр дамжуулж нэмэгдүүлж байна. Цөм, үндэсний хөтөлбөрт жендэрийн асуудал туссан. 8-р ангийн хичээлээс гадуурх үйл ажиллагааг хүүхэд сагсан бөмбөг гэдгийг сонгож оруулсан. Ингэснээр аавуудын оролцоо нэмэгдсэн. Иргэний боловсрол, Ёс суртахууны хичээлд аавуудын тухай сэдэв орсон байгаа.”

*(Ганцаарчилсан ярилцлага, ЕБС-ийн удирдах ажилтан)*

Сургуулийн удирдах ажилтнууд салбартаа хийгдэж буй шинэчлэлийг харьцангуй эергээр хүлээн авч, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажилладаг болохоо илэрхийлж байв. Ярилцлагын тэмдэглэлээс үзвэл жендэрийн хувьд ээлтэй сургуулийн орчныг бий болгох асуудлаар тодорхой бодлого, чиглэлийг бодлого боловсруулагчдын зүгээс өгсөн тохиолдолд сургуулиуд үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллахаар байна.

Сургуулийн удирдах ажилтнууд сургуулийн орчин дахь жендэрийн асуудлыг авч үзэхдээ сургуулийн удирдах ажилтан эрэгтэй хүн байх нь тохиромжтой, багш нар эмэгтэй хүн байх нь тохиромжтой гэсэн хэвшмэл үзэлтэй байна. Тэдний хувьд охид, хөвгүүд ялгаатай ур чадвар, хэрэгцээ, шаардлагатай байдаг учир одоогийн багшлах боловсон хүчнүүдэд жендэрийн хариуцлагатай багш бэлтгэх сургалт явуулах, охид хөвгүүдийн ялгаатай хэрэгцээг мэдэх, энэ чиглэлээр чадавхжих шаардлага байгааг онцолсон.

## 5.5 Сургууль дахь жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт ба хүчирхийллийн талаарх үзэл, хандлага

Монгол улс боловсролын орчинд жендэрт суурилсан хүчирхийллийн аливаа төрлийг устгах, түүнээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байна. Боловсролын тухай хуулинд (2002, нэмэлт өөрчлөлт 2006) боловсролын салбар дахь эрх тэгш байдлыг хангах суурь зарчмыг тусгасан байдаг. Энэхүү хуулинд боловсролын үйлчилгээ үзүүлэхдээ аливаа төрлийн алагчлах үзлээс ангид байхаас гадна сэтгэл санаа болон бие махбодод шийтгэл оногдуулахгүй байх, боловсролын үйл ажиллагаанд хүч хэрэглэх, шийтгэл хүлээлгэх үйлдлийн бүх хэлбэрийг хатуу хориглоно гэж заажээ<sup>67</sup>. ЕБС-д эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйс, нийгмийн байр сууриар ялгаварлан гадуурхах, үгүйсгэх, эрхийн хязгааралах болон бие махбод, сэтгэл санааны хохирол учруулж болзошгүй эрсдэлээс ангид байх нь багш ба сурагчдын хөгжих, оновчтой сонголт хийх үндэс юм.

Судалгааны үр дүнд тулгуурлан Улаанбаатар хотын 9 дүүргийн 9 сургууль болон хөдөө орон нутгийн 14 сургуулиудад сургуулийн баримт бичгийн дүн шинжилгээ, сургуулийн удирдах ажилтан, 1-5 ба 6-12 ангийн сурагчид, багш нарын зэрэг асуулгаар авагдсан судалгааны мэдээллийн үр дүнд үндэслэн сургууль дээр жендэрээс хамаарсан ямар нэгэн хүчирхийлэл, дарамт шахалтанд өртдөг эсэхийг олж тогтоохыг оролдсон.

Судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд сургуулийн эрх зүйн баримт бичгүүдэд жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийн талаар тусгасан эсэхийг тодруулсан юм.

Хүснэгт 56 Сургуулийн холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлтэй холбоотой заалтуудыг тусгасан байдал

<i>Хөдөө орон нутагт</i>	<i>Улаанбаатар хотод</i>
<p>Дотуур байрны сурагчдыг хараа хяналтгүй орхихгүй байх нөхцлийг хангаж ажиллах ба хүүхдийн хүчирхийлэл, хорт зуршил, авто замын болон болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх</p> <p><i>ЕБС-ийн дотоод журмаас</i></p> <p>Сургуулийн орчин, сургалтын цаг суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, бэлгийн дарамт, гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, үе тэнгийнхэн болон гэр бүл, нийгмийн орчны сөрөг нөлөөнд автахгүй байхад анхаарах</p> <p>Суралцагчдын нийгэм-соёлын ялгаатай байдал, нийгмийн гарал, эцэг эх асран хамгаалагчдынх нь боловсрол, амьжиргааны түвшин, өөрийн нь суралцах чадвар, гадаад өнгө үзэмжээр ялгаварлахгүй хандан сурлагын амжилтыг бодитой үнэлэх</p> <p><i>ЕБС-ийн ёс зүйн дүрмээс</i></p>	<p>Дүрмийн 12 хуудас дахь 5.1.6 зааснаар багш суралцагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрийг нь хүндэтгэн хамгаалах.</p> <p><i>ЕБС-ийн ёс зүйн дүрмээс</i></p> <p>Суралцагчийг бие махбодийн аливаа дарамт, шахалт үзүүлэх, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, өөр сургуульд суралцахыг шаардахыг хатуу хориглоно.</p> <p><i>ЕБС-ийн сурагчийн дүрмээс</i></p>

Судалгаанд хамрагдсан сургуулийн хувьд сургуулийн дотоод журам, ёс зүйн дүрэм, сурагчийн дүрэм зэрэгт жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт ба хүчирхийллийн эсрэг заалтуудыг тодорхой хэмжээнд тусгаж өгсөн байна. Гэхдээ сургуулийн орчинд хүйсээс хамааран ялгаварлан гадуурхалтад эсвэл бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хариу ямар

<sup>67</sup> Боловсролын тухай хууль /www.legalinfo.mn/.

арга хэмжээг авах талаар зарим сургуулийн эрх зүйн баримт бичигт тусгаагүй байв. Энэ нь сургуулийн эрх зүйн баримт бичгийг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэгдсэн сургалт, зөвлөгөө, удирдамж дутмаг байгааг харуулж байна.

Сургуулийн удирдах ажилтнуудаас авсан асуулга судалгааны үр дүнгээс харахад эрэгтэй ба эмэгтэй багш нар, охид, хөвгүүд сургууль дээр бие мабодийн хүчирхийлэл, сэтгэл санааны дарамт, бэлгийн мөлжлөг, хүйсээс хамааран ялгаварлан гадуурхалтанд өртөх асуудал бараг байдаггүй. Харин эмэгтэй багш нар (17.6 хувь) ажлын байранд, хөвгүүд (13.2 хувь) сургууль дээр сэтгэл санааны дарамтанд орох тохиолдол гардаг байна. Судалгаанд хамрагдсан нийт 68 удирдах ажилтны 58.8 хувь нь хэрэв багш, сурагч, ажилтны хэн нэгэн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд мэдээлэх, бүртгэх, хариу арга хэмжээ авах талаар сургуулийн дүрэм журамд тусгагдсан гэж хариулсан байв. Мөн удирдах ажилтнуудын 80.9 хувь нь сургуулийн орчинд багш, ажилтан, сурагч, эцэг эхчүүдийн зүгээс хүчирхийлэл, хүйсийн ялгаварлал, бэлгийн дарамтад өртсөн талаар гомдол огт гаргаж байгаагүй гэж хариулснаас үзэхэд нэг талаас хүчирхийлэлгүй, ялгаварлан гадуурхалтаас ангид сургуулийн орчин манай улсад бий болжээ гэж үнэлэгдэхээр, нөгөө талаас энэ асуудал хөшигний цаана, нууцлагдмал, гарсан тохиолдолд нууцлалыг чандлан хадгалах, шуурхай арга хэмжээ авах таатай орчин сургуульд бий болоогүй, энэ талаарх ойлголт мэдлэг багш, сурагч, эцэг эхчүүдэд хангалтгүй байгаатай холбоотой байж магад юм. Энэ талаарх багш нарын хариултыг дэлгэрэнгүй авч үзье.

Хүснэгт 57 Сургуулийн орчинд бие махбодийн хүчирхийлэлд өртөх байдал

Тохиолдлууд	Эрэгтэй багш			Эмэгтэй багш			Нийт
	тийм	үгүй	мэдэхгүй	тийм	үгүй	мэдэхгүй	
Эмэгтэй багш нар бие махбодийн хүчирхийлэлд өртдөг	2.8	95.0	2.1	4.0	91.2	4.8	100.0
Эрэгтэй багш нар бие махбодийн хүчирхийлэлд өртдөг	6.4	87.9	5.7	5.1	91.7	3.1	100.0
Охидууд бие махбодийн хүчирхийлэлд өртдөг	2.1	92.9	5.0	5.4	89.5	5.1	100.0
Хөвгүүд бие махбодийн хүчирхийлэлд өртдөг	3.5	92.2	4.3	10.8	84.9	4.3	100.0

Багш нарын асуулга судалгааны үр дүнгээс харахад эрэгтэй, эмэгтэй багш нар ажлын байранд бие махбодийн хүчирхийлэлд өртөх тохиолдол бараг гардаггүй гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан нийт 492 багш нарын 19.3 хувь нь эмэгтэй багш нар сэтгэл санааны дарамт, шахалтанд өртдөг талаар мэдээлсэн.

Сургуулийн орчинд, хичээл дээр хөвгүүд охид бие биенээ шоглох, хүйсийн ялгаатай байдал илт гаргах, бие биенээ дооглох тохуурхах үед судалгаанд оролцсон эмэгтэй багш нарын 82.1 хувь, эрэгтэй багш нарын 65.2 хувь нь сурагчдад анхааруулга өгч, ийм үйлдэл яагаад гаргаж болохгүйг тайлбарлан өгдөг байна. Үүнээс үзэхэд эмэгтэй, эрэгтэй багш нарын дийлэнх нь жендэрт суурилсан ялгаварлан гадуурхал, хүчирхийлэлд үйлдлийг таслан зогсоох, цаашид гаргахгүй талаар анхаардаг болохыг харуулж байна. Гэхдээ эрэгтэй багш нарын багагүй хэсэг нь ийм үйлдлийг үл тоох хандлага гаргаж байгааг анхаарууштай.

Хүснэгт 58 Сургуулийн орчинд бага ангийн сурагчдын ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт, хүчирхийлэлд охид хөвгүүд өртөх байдал (сурагчдын хариултаар)

Асуултын чиглэл	Эрэгтэй				Эмэгтэй			
	Охидын зүгээс	Хөвгүүдийн зүгээс	Багшийн зүгээс	Мэдэхгүй	Охидын зүгээс	Хөвгүүдийн зүгээс	Багшийн зүгээс	Мэдэхгүй
Хөвгүүнийг “Охин шиг” гэж гадуурхах, дарамтлах	16.7	29.2	3.3	50.9	18.3	22.2	2.4	57.1
Охиныг “Хөвгүүн шиг” гэж гадуурхах, дарамтлах	10.8	29.2	0	60.0	13.5	33.3	1.6	51.6
Охины бие, гадаад төрхийг өөлөх, шоглох	7.5	36.7	0.8	55.0	10.3	42.9	1.6	45.2
Хөвгүүний бие, гадаад төрхийг өөлөх, шоглох	29.2	16.7	1.7	52.5	22.2	13.5	0	64.3
Хөвгүүний бие эрхтэнд хүрэх, илж таалах	6.7	11.7	1.7	80.0	11.1	7.1	0	81.7
Охины бие эрхтэнд хүрэх, илж таалах	5.0	5.8	1.7	87.5	7.9	12.7	0	79.3
Хөвгүүд бие биетэйгээ зодолдох, дээрэлхэх	2.5	69.2	0.8	23.0	8.7	63.5	1.6	26.2

Бага ангийн хувьд сургуулийн орчинд хөвгүүнийг “охин шиг”, охиныг “хөвгүүн шиг” гадуурхах, дарамтлах, бие гадаад төрхийг өөлөх шоолох, бие эрхтэнд хүрэх асуудлыг охид хөвгүүдийн аль алиных нь зүгээс нэлээд гардаг болох нь судалгааны үр дүнгээс харагдлаа. Судалгаанд оролцсон эрэгтэй сурагчдын хариултаас харахад 36.7 хувь нь хөвгүүдийн зүгээс охины бие гадаад төрхийг өөлөх шоолох, 29.2 хувь нь охидын зүгээс хөвгүүний бие, гадаад төрхийг өөлөх шоолох асуудал гардаг. Харин эмэгтэй сурагчдын (42.9 хувь) үзэж байгаагаар хөвгүүдийн зүгээс охид бие, гадаад төрхийг өөлөх шоолох асуудалд өртдөг байна. Охидоос илүү хөвгүүд бие биенийгээ “охин шиг” гэж гадуурхах, дарамтлах явдал гаргадаг.

Эрэгтэй, эмэгтэй сурагчдын мэдээлснээр сургуулийн орчинд хөвгүүд бие биетэйгээ зодолдох, дээрэлхэх, мөнгө төгрөг нэхэх, муудалцах тохиолдолд их байдаг аж. Харин багшийн зүгээс эрэгтэй, эмэгтэй сурагчдыг мэдэгдэхүйц ялгаварлан гадуурхах, дарамт шахалт үзүүлэх, бие махбодь, сэтгэл санаа, бусад хэлбэрийн хүчирхийллийн үйлдлийг гаргадаггүй болох нь сурагчдын хариултаас харагдаж байна.

Хүснэгт 59 Сургуулийн орчинд дунд, ахлах ангийн сурагчдын ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт, хүчирхийлэлд охид хөвгүүд өртөх байдал (сурагчдын хариултаар)

Асуултын чиглэл	Эрэгтэй				Эмэгтэй				Нийт
	Охидын зүгээс	Хөвгүүдийн зүгээс	Багшийн зүгээс	Мэдэхгүй	Охидын зүгээс	Хөвгүүдийн зүгээс	Багшийн зүгээс	Мэдэхгүй	
Хөвгүүнийг “Охин шиг” гэж гадуурхах, дарамтлах	16.5	36.8	1.7	45.0	19.9	33.0	2.3	44.8	100.0
Охиныг “Хөвгүүн шиг” гэж гадуурхах, дарамтлах	13.4	29.4	3.0	54.1	11.9	39.1	1.9	47.1	100.0

Охины бие, гадаад төрхийг өөлөх, шоглох	6.9	46.8	2.2	44.2	13.0	57.1	1.5	28.3	100.0
Хөвгүүний бие, гадаад төрхийг өөлөх, шоглох	30.3	16.0	2.6	51.1	28.7	16.5	2.3	52.5	100.0
Хөвгүүний бие эрхтэнд хүрэх, илж таалах	8.2	7.8	2.2	81.8	6.5	10.3	1.1	82.0	100.0
Охины бие эрхтэнд хүрэх, илж таалах	4.8	15.2	1.7	78.3	2.7	25.3	0.8	71.3	100.0

Сургуулийн орчинд 6-12 ангийн сурагчдын хувьд хөвгүүнийг “охин шиг”, охиныг “хөвгүүн шиг” гадуурхах, дарамтлах, хүү, охины бие, гадаад төрхийг өөлөх шоолох асуудал охид, хөвгүүд аль алиных нь зүгээс нэлээд гардаг гэж хариулсан байна. Энэхүү хариултаас харахад охид, хөвгүүд бие биенээ буруутгаж буй өнгө аяс ажиглагдлаа.

Дунд, ахлах ангийн эрэгтэй сурагчдын 36,8 хувь нь хариулахдаа хөвгүүд хооронд нэг нэгнийгээ “охин шиг” гэж гадуурхах, дарамтлах асуудал гардаг байна. Судалгаанд хамрагдсан эрэгтэй сурагчдын 1/2 нь сургуулийн орчинд охины гадаад төрхийг өөлөх шоолох тохиолдол байдгийг мэдээлсэн. Үүнээс үзэхэд эрэгтэй хүн эрэгтэй шинжийг агуулах ёстой, эмэгтэй хүн эмэгтэй шинжийг агуулах ёстой гэсэн ойлголт өнөөг хэр нь охид хөвгүүдэд уламжлагдан тогтсон байгаа нь сургуулийн орчинд бие биенийгээ гадуурхах, дарамтлах үйлдлийг хийхэд түлхэц болдог аж.

Эцэг эхийн асуулга судалгааны үр дүнгээс харахад хөвгүүдийг “охин шиг”, охидыг “хөвгүүн шиг” гэж гадуурхах дарамтлах, охид хөвгүүдийн гадаад дүр төрхийг өөлөх шоолох, бие эрхтэнд хүрэх, илж таалах асуудлын талаар мэдэхгүй гэх хариултын хувь дунджаар 74.2 байгаа ба сурагчдын хариултаас нөлөөдгүй зөрүүтэй байгаа тул сурагчид гэртээ энэ талаарх мэдээллийг эцэг эхтэйгээ хуваалцдаггүй, гарсан ч нуун дарагдуулдаг төлөв байдал байна гэж үзэх үндэслэлийг бүрдүүлж байна. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн олонх нь сургууль дээр хөвгүүдийн зүгээс охидын, харин охидын зүгээс хөвгүүдийн гадаад дүр төрхийг өөлөх шоолох асуудал цөөнгүй тохиолдол гардаг гэж үзжээ. ЕБС-ийн орчин дахь багшлах болон суралцах үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо хангалтгүй, үр хүүхэдтэйгээ сургууль дээр болсон явдлын талаар нээлттэй ярилцаад байдаггүйг судалгааны үр дүн тодорхой хэмжээгээр харуулж байна.

## ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүн, дүгнэлтийг дараах агуулгын хүрээнд хийж байна.

### **Нэг. Жендэрийн нийцтэй сургуулийн орчин**

1. Ерөнхий боловсролын сургуулиудад эмэгтэйчүүд зонхилон ажиллаж байгааг боловсролын суурь статистикийн үзүүлэлтүүд харуулж байна. Жилээс жилд ЕБС-иудын удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өсч ирснийг боловсролын салбарын экспертүүд, судлагдсан ЕБС-ийн удирдах ажилтнууд дүгнэсэн билээ.
2. Салбарын статистик мэдээгээр, өвчин, амьдралын гачигдал, сургуульд сурах дургүй, тодорхойгүй шалтгаанаар хүүхэд сургууль завсардаж байна. Ялангуяа хөдөөд хөвгүүд сургууль завсардаж байгааг салбарын статистик харуулж байна.
3. Сургуулийн орчны ариун цэвэр, эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар МУ-ын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүд зохих ёсоор анхаарчээ.
4. Сургуулиудын задгай биеийн тамирын болон тоглоомын талбайд суурилуулсан хэрэглэгдэхүүнүүд хүртээмж, аюулгүй байдлын хувьд асуудалтай байна.
5. Хөдөө орон нутгийн зарим сургуулиудад бие засах газар нь эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт шаардлагыг бүрэн хангаагүй байна. Биеийн тамир, номын сан болон урлагийн зааланд ашиглагддаг хэрэглэгдэхүүнүүд хүртээмжийн хувьд учир дутагдалтай, мөн эмчийн үзлэгийн өрөө охид, хөвгүүдэд тусгайлан зориулж тохижуулаагүй үзлэгийн нэг өрөөтэй байгааг анхаарах шаардлагатай.
6. Хичээлээс гадуурх сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад охид хөвгүүдийн оролцоог дам байдлаар хангаж, охид хөвгүүдийн хэрэгцээнд нийцсэн хүмүүжлийн ажлыг зохион байгуулж байна.
7. ЕБС-ийн удирдлага, багш, нийгмийн ажилтнуудын жендэрийн хандлагаас хүмүүжлийн ажлын агуулгад жендэрийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлэхүйц үйл ажиллагаа төлөвлөгдөн, хэрэгжиж байна.
8. ЕБС-иудад мэргэжил сонголтын үйл ажиллагаа тогтмолжиж, хүүхдүүдийн сонирхсон мэргэжил, эрэлтэй мэргэжлүүдийн талаар яриа таниулга хийх, их дээд сургууль, МСҮТ-тэй хамтарч мэргэжил сурталчлах, эцэг эхчүүдтэй уулзалт хийх зэрэг үйл ажиллагааг явуулдаг байна.
9. Нийгмийн ажилтан, сургуулийн удирдлага, мэргэжлийн багш нар мэргэжил сонголтод голлох үүрэгтэйгээр оролцож байгааг тоон болон чанарын судалгааны дүн харуулав.
10. Сургуулийн зүгээс өгч буй зөвлөх үйлчилгээний агуулгад жендэрийн хэвшмэл ойлголтыг хадгалсан хийгээд өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагааны аль аль нь тусгагдаагүй байна.

### **Хоёр. Ерөнхий боловсролын сургуулийн бодлогын орчин**

1. Аймаг, дүүргийн боловсролын газраас ЕБС-иудад жендэрийн талаар баримтлах чиглэл өгдөггүй нь жендэрийн тэгш байдлыг хангах, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хэрэгжихгүй орхигдоход хүрч болзошгүй байна.
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны тайланд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн, гарсан зөрчил, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээг тусгах бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн нь сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлтийн нэг байна гэж заасан ч сургуулийн удирдах ажилтнууд тус хуулийн талаар хангалттай ойлголт, мэдээлэлгүй байна.
3. Хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн байгууллагын зүгээс Ерөнхий боловсролын сургуулиудаас хуулийн хэрэгжилтийн тайлан мэдээ авч, удирдах албан тушаалтанг үнэлэх тус заалтыг хууль батлагдсанаас хойш хэрэгжүүлээгүй байна.
4. Ерөнхий боловсролын сургуулиудын бодлого, хөтөлбөр жендэрийн мэдрэмжтэй боловсруулагдах нь сургуулийн удирдах ажилтнууд жендэрийн асуудлыг хэрхэн ойлгож, хандаж буйгаас шууд хамааралтай байна.

5. Багшлах боловсон хүчний хүйсийн тэнцвэртэй харьцаа алдагдаж эмэгтэйчүүд зонхилон ажиллаж байна.
6. Удирдах албан тушаалтнуудын хувьд эмэгтэй багш хүүхэдтэй тулж ажиллах, заах арга зүй, хичээлээ урьдчилан төлөвлөх зэрэгт эрэгтэй багшаас илүү чадвартай байдаг гэсэн жендэрийн хэвшмэл үзэл хадгалагдаж байна.
7. Эрэгтэй багшийг анги удирдсан багшаар томилж анги хариуцуулахад хүүхэдтэй тулж ажиллах, асуудал бэрхшээлийг нь ойлгон, туслан зөвлөх тал дээр дутмаг байдаг учраас зарим удирдах албан тушаалтны зүгээс эрэгтэй багшийг анги удирдсан багш болгохоос татгалзах тохиолдол байна.

### **Гурав. Цөм хөтөлбөр, сурах бичгийн шинжилгээ**

1. Бага, суурь боловсролын цөм хөтөлбөрүүд нь сурагч төвт сургалтаар хүүхдийн хэрэгцээ, сонирхолд тулгуурлан хүүхэд бүрийг хөгжүүлэхээр зорьж байгаагаараа охид, хөвгүүдэд суралцах адил тэгш боломжийг олгоход анхаарчээ. Түүнчлэн хөтөлбөрийн агуулгад хүйсээр тусгаарлагдан судлах хийгээд нэмэлт төлбөртэйгээр судлах судлагдахуунууд байхгүй байна. Мөн бага боловсролын түвшинд жендэрийн ялгааг харгалзах тухай санааг хөтөлбөрт тусгасан нь боловсролоор дамжуулан жендэрийн тэгш байдалд хүрэх зорилтод эерэг нөлөө үзүүлэх юм. Гэхдээ хүүхдийн хэрэгцээ, сонирхолд хэрхэн тулгуурлах, сурах үйл явцад хүйсийн ялгаа хэрхэн илэрдэг, түүнийг сургалтад хэрхэн харгалзах тухай тодорхой аргачлал, шийдлүүд орхигдсон байна.
2. Монгол хэл, нийгмийн ухааны боловсролын сургалтын хөтөлбөрүүд нь ерөнхий хөтөлбөрийн үзэл баримтлал, арга зүйн дагуу боловсруулагджээ. Монгол хэлний боловсролын агуулгын хувьд олон ургальч хандлагыг дэмжсэн бөгөөд жендэрийн өрөөсгөл хандлагыг хадгалсан агуулга байхгүй ч, хичээлд хэрэглэх эхийг сонгоход жендэрийн шалгуурууд дутмаг байгааг анхаарвал зохино. Түүнчлэн монгол хэл, нийгмийн ухааны хөтөлбөрт үндэсний соёл, уламжлал, зан заншилд суралцах зорилт дэвшүүлж байгаа ч, хүйсийн аль нэг бүлгийг дорд үзсэн агуулга сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тусгагдахаас сэргийлж чадахааргүй байна. Нийгмийн ухааны боловсролын хөтөлбөр нь жендэрийн тухай боловсролыг олгоход зохих түвшинд анхаарсны хамт олон ургальч хандлагыг төлөвшүүлэхэд бүрэн анхаарч чаджээ.
3. Үндэсний хөтөлбөрийн түвшинд тусдаа судлана гэж заагаагүй ч, сургуулийн түвшинд Дизайн, технологийн хичээл уламжлалт ёсоор охид, хөвгүүдэд тусдаа заагдаж байна. Цөөн тооны багш нар хүүхэд бүрт адил тэгш боломж олгох үзэл баримтлал, зарчим, эдгээрийг хэрэгжүүлэхэд туслах аргачлал, үйл ажиллагааг төлөвлөж чадсан бол олонхид нь нэрлэсэн сургалтын арга хийгээд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаа хооронд зөрөөтэй байдал ажиглагдаж байв. Судлагдсан багш нарын сургалтын хөтөлбөрийн дийлэнх нь хүүхэд бүрийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх сурагч төвт үйл ажиллагаанд суурилж чадаагүй байв. Багш нарын сургалтад хэрэглэгдэж буй хэрэглэгдэхүүний агуулгад жендэрийн өрөөсгөл хандлагыг бэхжүүлэхүйц эх, зураг дүрслэл ашиглагдахаас сэргийлэх нөхцөл бүрдээгүй байна.
4. Судлагдсан сурах бичиг нь нэг талаас хүүхэд бүрт суралцах, хичээлд оролцох, хөгжих боломжийг олгохуйц дасгал даалгавар, цаашлаад жендэрийн тухай боловсролыг олгох зорилго бүхий агуулга тусгагдсан зэргээс нь харахад жендэрийн эерэг үнэт зүйлс, хандлага төлөвшихөд эерэг нөлөөтэй гэж дүгнэж болно. Гэхдээ зохиогчдын үзэл хандлагаас хамааралтайгаар нэг сурах бичгийн дотоодод зөрчилдсөн санаа бүхий агуулга ажиглагдаж байна. Түүнчлэн зураг, дүрслэл, эх, ишилж, тайлбарлан оруулсан эрдэмтдийн дунд эрэгтэйчүүд хэт давамгайлалтай байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн дүр үүрэг, сэтгэл зүйн шинжүүдийг жендэрийн хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлага бүхий дүрсэлсэн нь бага биш хувийг эзэлж байгаа тул сурагчдад жендэрийн эерэг соёл төлөвшин хөгжихөд нь саад учруулах нэгэн хүчин зүйл байж болзошгүй байна. Сурах бичгийн стандартад жендэрийн шаардлагуудыг тусгаагүй, сурах бичиг зохиогчид жендэрийн хувьд бэлтгээгүй зэрэг анхаарвал зохих асуудлууд судалгаагаар илэрлээ.

### **Дөрөв. Багшлахуй ба суралцахуй**

1. Жендэрийн мэдрэмжтэй багш байх, жендэрийн мэдрэмжтэй сургууль байхаас охид хөвгүүдэд энэ мэдрэмж аяндаа бий болно. Судалгаагаар эрэгтэй эмэгтэй багш нарын харьцаа сургуульд анхаарал татахуйцаар алдагдсан байна. Сургууль бүрт эрэгтэй багш нарын эзлэх тоо нь эмэгтэйчүүдийнхээс 2-3 дахин бага, төдийгүй нас ахих тусам эрэгтэй багш нар сургуульд ажиллах байдал буурсан үзүүлэлттэй, мөн багш мэргэжлээр төгсөж байгаа хүмүүсийн дотор эрэгтэй багш нарын эзлэх хувь сүүлийн жилүүдэд нилээд цөөрсөн байна. Эндээс багш мэргэжлээр элсэлт авахад хүйсийн хувьд хэрхэн эрэгтэй эмэгтэйгийн тоог ойролцоо авах вэ гэдгээс эхлээд, орон нутгийн хүүхдүүдийг хэрхэн татах вэ зэрэг бодлогуудыг шат дараалан бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх шаардлагатай болсон байна.
2. Багш нарын ахуй хангамж, нийгмийн асуудал, цалин хангамж нь бага байгаагаас багшаар ажиллаж байгаа хүмүүс ар гэрийн амьдрал, ахуй хангамжаа сайжруулах тал дээр сэтгэл дүүрэн биш байна. Ялангуяа эрэгтэй багш нар энэ салбарт орж ирэхгүй байгаагийн бас нэг шалтгаан нь цалин хөлс болоод байгааг анхаарах. Багш нар төрд ажиллаж байгаа бусад салбарынхан, цагдаа цэргийнхэн бага өртөгтэй байр сууцанд орж, зээлд олноороо хамрагдаж байгааг дурьдаж байсныг анхааралдаа авах шаардлагатай.
3. Мэргэжил сонголтын талаарх сургууль удирдлага багш сурагчийн үнэлгээнээс, сурагчдад мэргэжил сонголтын талаар өгч байгаа зөвлөгөө нь тэдний хэрэгцээг хангахгүй байна. Тиймд сурагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн, дээрх мэргэжил сонголтын асуудлуудыг багтаасан заавал үзэх хичээл юмуу, дагнасан зөвлөгөө өгдөг багш нарыг бэлтгэх, эсвэл сургуулийн нийгмийн ажилтнуудыг мэргэжил сонголтын талаар сурагчдад үйлчилгээ үзүүлдэг хөтөлбөртэй болгох, уг нэмэлт үүргийг нь цалин хөлстэй нь холбон шийдвэрлэх.
4. Жендэрийн мэдрэмжтэй багш бэлтгэх сургалт
5. Багшаар суралцагсдын хувьд сурган, сэтгэл судлал, дидактикийн судлагдахууны агуулга, арга зүйд жендэр, жендэрийн тэгш эрхийн асуудлууд учир дутагдалтай заагддаг гэдэгт 65 хувь нь санал өгснөөс одоогийн багш бэлтгэх хөтөлбөрийн заавал үзэх судлагдахууны цөмд жендэрийн талаарх ойлголтууд хангалттай тусаагүйг харуулж байна. Иймд энэ судлагдахууны хөтөлбөрүүдийг эргэн харж, жендэрийн агуулгаар баяжуулахад анхаарлаа хандуулах нь нэн тэргүүний зорилт гэж дүгнэж байна.
6. Охид хөвгүүдийн ялгааг харгалзах, адил тэгш боломжийг бүрдүүлэх талаар мэдлэг ойлголт мэргэжил дээшлүүлэх сургалтаар ч маш бага олгогддог нь тэдний 83.1 хувь нь энэ талаарх ямар нэгэн сургалтад хамрагдаагүй гэж хариулснаас дүгнэж байна. Сургуулийн бага дунд ахлах ангийн сургалтын менежерүүдийг хамгийн түрүүнд энэ чиглэлийн дагнасан сургалтад хамруулж мэдлэгийг түгээх ажил хийгдэх хэрэгтэй.
7. Жендэрийн мэдрэмжтэй багшийн заах арга зүй, хөтөлбөр
8. Багшийн ур чадварын хувьд эрэгтэй эмэгтэй багш нараар ялгаатай байдал ажиглагдаагүй. Заах ур чадвартай, мэргэжилдээ сонирхолтой эрэгтэй эмэгтэй багш нарыг хүйс хамаарахгүй чадвартай багш гэж үнэлдэг нь сурагчдын, эцэг эхчүүдийн бүлгийн ярилцлага болон багш нараас авсан асуулгаас дүгнэж байна. Бага ангийн багш нарын 50.4 хувь нь идэвхтэй сургалтын аргуудыг, шинжлэн судлах аргыг дунд болон ахлах ангийн багш нар илүүтэй ашигладаг байна. Багш нар зааж байгаа ангийнхаа охид хөвгүүдийн нөхцөл байдал хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулж, ашиглаж байгаа аргууддаа охид хөвгүүдийг жигд оролцуулах, тэгш боломжийг ойлгуулах зэрэг жендэрийн асуудлуудыг түлхүү тусгах шаардлагатай байна.



9. Судалгаанд багш нар сурагчдынхаа хэрэгцээ сонирхлыг харгалзан үзэж хөтөлбөрөө боловсруулдаг, тэр дагуу ажиллахаар үйл ажиллагаагаа төлөвлөдөг гэж нийт багш нарын 51.8 хувь нь үнэлсэн нь, сайшаалтай. Харин хөтөлбөр, төлөвлөгөөндөө, хичээлд хэрэглэгдэх материалууддаа жендэрийн хувьд ижил тэгш жишээ баримт, зураг дүрслэлийг оруулахаас энэ ажил эхэлдгийг анхаарч сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг баталж байгаа сургалтын менежерүүдэд мэдээлэл өгөх хэрэгтэй байна.

**Тав. Оролцогч талуудын жендэрийн талаарх ойлголт хандлага**

1. Өрх гэр бүлээ тэжээх болон хүүхдээ асрах, хөлсгүй хөдөлмөрийг хэн гүйцэтгэх талаарх хэвшмэл ойлголт эцэг эхчүүдийн дунд багасч байгаа ч, судалгааны оролцогч эцэг эхчүүдийн тодорхой хэсэгт гэр бүлээ тэжээх, хөрөнгө эзэмшихийг нөхөрт, хүүхэд асрах, гэрийн ажлыг гүйцэтгэхийг эхнэрт хамааруулах уламжлалт хандлага хадгалагдсан хэвээр байна. Энэхүү хандлага нь эмэгтэйдээ эрэгтэйд илүүтэй ажиглагдаж байна.
2. Түүнчлэн “хөвгүүд удирдан манлайлах авьяастай, техниктлүү чадварлаг бол охид хэл болон нийгмийн ухааны хичээлд илүү сайн, охид гэрийн ажилд илүү чадварлаг” гэсэн хэвшмэл ойлголт басхүү илэрч байгаа ба мөн эрэгтэйчүүдэд арай түлхүү байна.
3. Судалгаанд оролцсон аав ээжүүдэд хүү, охиныхоо боловсролд ихээхэн анхаардаг болох нь судалгааны олон баримтаар нотлогдож байна. Гэхдээ охидыг сул дорой гэдэг үүднээс хандаж, тэдний биеэ даасан байдлыг нэмэгдүүлэх, эрсдлээс хамгаалах зорилгоор дээд боловсрол эзэмшүүлнэ гэсэн хандлага ээжүүдийн дунд нийтлэг илэрч байна.
4. Эцэг эхчүүдийн зүгээс эмэгтэй багшийг охид хөвгүүдийн сонирхлыг харгалздаг, оролцуулдаг, урамшуулж зөвлөн дэмждэг, сурагчдад туслан зөвлөдөг, хүүхэд нэг бүртэй тулж ажилладаг гэж хүлээн зөвшөөрчээ. Цаашлаад эцэг эх, сургуулийн удирдах албан тушаалтнууд бага боловсролын шатанд эмэгтэй хүн багшаар ажиллах нь тохиромжтой гэжээ. Харин эрэгтэй багшийн хувьд анги танхимд сахилга бат, дэг журмыг тогтоох чадвараар сайн гэж үнэлжээ. Ийнхүү судалгаанд оролцогчдын хувьд багшийн ажилд эмэгтэй хүн тохиромжтой гэсэн хандлага тодорхой хэмжээгээр ажиглагдаж байна.
5. Судалгааны дүнгээр математик, техникийн хичээлд хөвгүүд, хэл, нийгмийн шинжлэх ухааны хичээлд охид илүү, хөвгүүд сэтгэлгээний хурд, оюун ухааны чадамжаар охидоос илүү гэх хандлага эцэг эх, багш, удирдах ажилтан, хүүхдүүдэд илэрч байхад хүйсээс хамаарсан ялгаа байхгүй гэж хариулсан эцэг эх, багш, удирдах ажилтан, хүүхдүүд ч байгааг чанарлаг судалгааны дүн харууллаа.
6. Судалгааны дүнгээр суралцах үйл ажиллагаанд жендэрийн ялгаа илэрч байгаад охид, хөвгүүдийн сургалтын амжилт, сурах чадварын ялгаагаар ялангуяа хөвгүүдийн сурах үйл, сурлагын амжилтад охид хөвгүүдийн зан төлөвийн ялгаатай онцлог нөлөөлж байна. Чанарлаг баримтаар хөвгүүд хэрэгтэй гэж үзсэн хичээлдээ анхаардаг, гүнзгийрүүлж судалдаг, сонгоогүй, дургүй хичээлээ тасалдаг, анхаарал хандуулдаггүй, олон төрлийн хичээлээс залхдаг, анхаарал суларч ирдэг, охид бүх хичээлд жигд амжилттай суралцдаг нямбай, зүтгэлтэй, идэвхтэй суралцдаг, охид сурлагын амжилтаар хөвгүүдээс илүүг эцэг эх, багш, удирдах ажилтан, хүүхдүүд хүлээн зөвшөөрсөн юм.
7. Судалгаанд оролцогч эцэг эхчүүд охид, хөвгүүдийн ялгаатай хэрэгцээ, сонирхол, хэрхэн харилцах талаар ойлголт, чадвар дутмаг байгаагаа илэрхийлсний хамт жендэрийн талаарх ойлголт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн талаарх мэдээлэл хангалтгүй байна.
8. Судалгаанд оролцогчдын дунд гэр бүлийн үүргийг эрх тэгшээр гүйцэтгэх хандлага зонхилж байгаа ч, аав гэр бүлийн өмчийг эзэмших ёстой, ээж хүүхэд асрах, гэрийн ажлыг хийх ёстой гэсэн уламжлалт хандлага тодорхой хэсэгт ажиглагдаж байна. Түүнчлэн, охидыг сул дорой, хүлцэнгүй, өрөвч сэтгэлтэй гэх хөвгүүдийг техникийн зүйлд илүү чадварлаг, хөвгүүд зоригтой, хүчтэй гэдэгтэй санал нийлсэн жендэрийн хэвшмэл ойлголт охид, хөвгүүдийн дунд ажиглагдаж байна.

9. Судалгаанд оролцсон дунд болон ахлах ангийн сурагчдын жендэрийн талаар ойлголт мэдлэг хангалтгүй байна.
10. Багш нарын цөөнх хэсэгт (10 гаруй хувь) өрх гэр бүл дэх жендэрийн байр суурь, дүр үүргийн талаар хэвшмэл ойлголттой, олонх хэсэг нь тэгш эрхийн хандлагыг дэмжиж байгаа хандлага ажиглагдаж байна. Гэхдээ эрэгтэй багш нарын хувьд өрх гэр бүлээ тэжээх үүргийг эхнэртэйгээ хуваалцах сонирхолтой атлаа, хүүхэд асрах, гэрийн ажлыг хамжилцан гүйцэтгэх сонирхол, хандлага төлөвшөөгүй байгааг асуулга судалгааны дүн харуулж байна.
11. Охид, хөвгүүдийн шинжүүдийн талаарх үзэл бодлыг нь тодруулахад талаас дээш хувьд нь хэвшмэл ойлголтоор хандаж буй байр суурь ажиглагдлаа. Тэр дундаа эрэгтэйгээсээ эмэгтэй багш нарт түлхүү ажиглагдаж байв. Мөн охид, хөвгүүдийн авьяаслаг хичээлийн талаар ч уламжлалт хандлагаар хандах нь талаас дээш хувьд нь илэрч байна. Хэвшмэл ойлголт нь хүйсээр ялгаварлан, хүйсийн тодорхой бүлгийн гишүүдийн боломжийг санаатай, санаандгүй хэлбэрээр хязгаарлахад хүрдэг гэдгийг анхаарууштай. Түүнчлэн багш нарын жендэрийн ойлголт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн талаарх мэдээлэл туйлын хангалтгүй түвшинд байгаа нь ажиглагдлаа.
12. Судалгаанд хамрагдсан сургуулийн эрх зүйн баримт бичиг болох сургуулийн дотоод журам, сургуулийн ёс зүйн дүрэм, сурагчийн дүрэм зэрэгт жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлтэй холбоотой заалтыг тусгасан ч, хариу арга хэмжээ, урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээнүүдийг тусгаагүй байна.
13. Охид хөвгүүд харилцан бие биенийгээ гадуурхах, дарамтлах, бие гадаад төрхийг өөлөх шоолох, бие эрхтэнд хүрэх тохиолдол байгаа ч хөвгүүд илүү хөвгүүнийг “охин шиг” гэж доромжлох, дарамтлах, бие биетэйгээ зодолдох, дээрэлхэх, мөнгө төгрөг нэхэх, муудалцах хандлага байна.
14. Багшийн зүгээс эрэгтэй эмэгтэй сурагчдыг илт мэдэгдэхүйц ялгаварлан гадуурхах, дарамт шахалт үзүүлэх, бие махбодь, сэтгэл санаа, бусад хэлбэрийн хүчирхийллийн үйлдлийг гаргадаггүй болох сурагчдын хариултаас харагдаж байна.
15. Сургуулийн удирдах ажилтнууд багш, сурагчдын дунд хүчирхийлэл, дарамтад өртөх асуудал бараг гардаггүй гэж, багш нарын тодорхой хэсгийн хувьд сургууль дээр сэтгэл санааны дарамтанд өртөх тохиолдол гардаг гэж хариулах нийтлэг төлөв ажиглагдаж байхад эцэг эхчүүдийн хувьд энэ талаарх мэдлэг хомс, мэдээлэл авдаггүй, хүүхэдтэйгээ нээлттэй ярилцдаггүй хандлага ажиглагдаж байна.

## **ЗӨВЛӨМЖ**

### **Хууль, эрх зүй, бодлогод чиглэсэн:**

- 1) “Боловсролын салбарт жендэрийн тэгш байдлыг хангах бодлого боловсруулж, үе шаттай хэрэгжүүлнэ гэсэн бодлогын баримт бичгүүдэд туссан зорилтыг ажил хэрэг болгох,
- 2) Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах (боловсролын багц хуулинд зохих өөрчлөлтүүдийг тусгах),
- 3) Хяналт шинжилгээ, үнэлгээнд “Жендэр”-ийн тодорхой үзүүлэлтүүдийг тусгах
- 4) Сурах бичгийн стандартад “Жендэр”-ийн шалгуур үзүүлэлтийг оруулах
- 5) “Жендэр”-ийн хувьд нийцтэй материаллаг орчны үзүүлэлтүүдийг орчны стандартад тусгах
- 6) Сургуулийн эрх зүйн баримт бичиг, стратеги төлөвлөлт зэрэг бодлогын баримт бичигт тусгавал зохих “жендэр”-г холбогдох зүйл, заалтын үлгэрчилсэн загварыг боловсруулан, нэвтрүүлэх

### **Жендэрийн нийцтэй сургуулийн орчин бүрдүүлэхэд чиглэсэн:**

- 1) Эрэгтэй, эмэгтэй сурагчдын ялгаатай хэрэгцээг хангахад чиглэгдсэн, жендэрийн нийцтэй сургуулийн орчныг бүхий л сургуульд бүрдүүлэх талаар салбарын яам, орон нутаг, сургуулийн удирдлага хүчин чармайлт гарган ажиллах шаардлагатай байна.
- 2) Анги танхим, сургуулийн байр, коридор дахь эрэгтэй, эмэгтэй хүний зураг дүрслэл, ишилсэн үг, хэлц үг зэрэгт жендэрийн тэнцвэртэй байдлыг хангах, хэвшмэл ойлголтоос зайлсхийх тухай шаардлагыг холбогдох стандартад тусгах, хэрэгжүүлэх,
- 3) Хичээлээс гадуурх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд охид, хөвгүүдийн адил тэгш оролцоог хангах,
- 4) Охид, хөвгүүдийн ялгаатай хэрэгцээг харгалзсан, жендэрийн тэгш байдлыг тогтооход хувь нэмэр оруулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, энэ талаар нийгмийн ажилтан, багш нарын мэдлэг, чадавхийг дээшлүүлэх,
- 5) Мэргэжил сонголтод голлох үүрэгтэй оролцож буй багш, нийгмийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэхдээ нэгд, сурагчдын сонирхол хэрэгцээ, чадварт нийцүүлэн мэргэжлээ сонгох талаар зөвлөгөө өгөх, хоёрт, эцэг эхийн уламжлалт хандлагад нөлөөлөх чадвартай болгоход анхаарах,
- 6) Охид хөвгүүдийн уламжлалт бус мэргэжил сонголтыг дэмжсэн зөвлөгөө өгөх аргачлал, зааврыг бэлтгэн боловсруулж, түгээх.

### **Сургуулийн бодлогод жендэрийн мэдрэмжтэй байдлыг бий болгоход чиглэсэн:**

- 1) Сургуулийн удирдах ажилтнуудыг жендэрийн сургалтад хамруулах шаардлагатай. Сургалтын агуулга нь эрэгтэй, эмэгтэй багшийн ялгаатай хэрэгцээ, шаардлагыг таниулахад чиглэсэн байх.
- 2) Эрэгтэй, эмэгтэй багшийн онцлог хэрэгцээ, ажиллах ур чадвар болон давуу, сул талыг харгалзсан бодлого боловсруулах.
- 3) Охид, хөвгүүдийг онцлог хэрэгцээг хэрхэн харгалзах, сурах үйл явцад хүйсийн ялгаа хэрхэн илэрдэг, түүнийг сургалтад хэрхэн харгалзах, сургуулийн насны хүүхдүүдийн (6-18) ялгаатай хэрэгцээний тухай ойлголтыг олгох.
- 4) Сургуулийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулахдаа эрэгтэй, эмэгтэй багш нарын тэгш байдлыг хангах тухай болон Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн зохицуулалтуудыг тусгаж, аймаг, дүүргийн Боловсрол соёлын газраас хяналт, шинжилгээг тогтмол хийлгэх.
- 5) Аймаг, дүүргийн боловсрол соёлын газрын ажилтнуудын ажил байдлын тодорхойлолтод хамрах тойргийн Ерөнхий боловсролын сургуулиудын жендэрийн бодлогын орчинд хяналт тавих, хамтарч ажиллах үүргийг тусгах.

- 6) Сургуулийн захирлуудын аймаг, дүүргийн Засаг даргатай хийж буй Үр дүнгийн гэрээнд сургуульдаа жендэрийн бодлого хэрэгжүүлсэн байдлыг үнэлгээний нэг шалгуураар оруулах.
- 7) Сургуулиудын баримт бичигт шинжилгээ хийхэд багшийн ажлыг үнэлж, дүгнэхдээ багш олимпиадад хэр амжилттай оролцсон болон тухайн багшийн бэлтгэсэн сурагч олимпиадад хэр амжилттай оролцсоныг шалгуур болгон авч үзсэн байна. Энэ нь сурагч нэг бүрийг хөгжүүлэх, тэгш хамруулах боломжийг бууруулах боломжтой заалт юм. Харин Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 сарын 13-ний өдрийн А/293 дугаар тушаалаар батлагдсан “Багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-д хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилт, авьяасыг нээн хөгжүүлсэн байдал, боловсролын үйлчилгээний сэтгэл ханамж, эрүүл мэндийн байдал гэсэн 5 шалгуураар хүүхэд нэг бүрийн хөгжил, эзэмшсэн мэдлэг, суралцах үйл болон сайн дурын, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох хүсэл эрмэлзэл, боломжийг бүрдүүлсэн байдал зэргийг гүйцэтгэлийн үзүүлэлт болгон авч үзжээ. Сургуулиуд дотоод журамдаа багш, ажилчдын гэр бүл дэх үүргээ гүйцэтгэхтэй холбоотой тодорхой зохицуулалтыг оруулж өгсөн ч ихэнх сургуулиуд эхнэр нь төрсөн тохиолдолд шинэ аавын 5 хоногийн цалинтай чөлөө олгох зохицуулалтыг тусгаагүй байна. Эрэгтэй, эмэгтэй багш ажилтнуудын гэр бүл дэх үүргээ гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байгаа бөгөөд эрэгтэй багш, ажилтнуудын хувьд тус заалт нь гэр бүл дэх үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой ач холбогдолтой заалт юм. Иймд зарим сургуулиуд дотоод журмаараа зохицуулж буй тус асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулинд тусгаж, нийтлэг байдлаар мөрдүүлэх болон сургуулиудын дотоод журамд оруулах.

**Цөм хөтөлбөр, сурах бичгийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй, жендэрийн тэгш байдлыг боловсролоор дамжуулж хувь нэмэр оруулах чиглэлд:**

- 1) Үндэсний түвшний хөтөлбөр, сурах бичгийг зохиогчдын багийг нээлттэй шалгаруулалтаар сонгож ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх,
- 2) Суралцагчдын тэр дундаа охид, хөвгүүдийг хэрэгцээ сонирхлыг хэрхэн харгалзах, сурах үйл явцад хүйсийн ялгаа хэрхэн илэрдэг, түүнийг сургалтад хэрхэн харгалзах тухай тодорхой аргачлал, шийдлүүдийг хөтөлбөрт тусгах талаар анхаарч,
- 3) Үндэсний соёл, уламжлалд жендэрийн хэвшмэл ойлголтыг хадгалсан агуулга бий тул бурангуй үзэл тээсэн, ялгаварлан гадуурхсан, дорд үзсэн хандлага бүхий зан заншлыг оруулахгүй байхыг тодорхой тусгах,
- 4) Хөтөлбөрт ашиглах эхэд тавигдах шаардлагад хүний эрх, тэгш эрх, жендэрийн шаардлагыг нэмж оруулах,
- 5) Тодорхой нэг хандлага, үзэл баримтлал, дүгнэлтийг тулган хүлээлгэхгүй шаардлага, зарчмыг хөтөлбөрт нэмж оруулах,
- 6) Багш нарын хөтөлбөрт тавигдах шаардлагад жендэрийн шалгуурыг оруулах талаар анхаарах,
- 7) Сурагч бүрт адил тэгш боломж олгох, охид, хөвгүүдийг ялгаатай хэрэгцээг хэрхэн харгалзах, сургалтын үйл ажиллагааг хэрхэн төлөвлөх, хүйсээр ялгаварлан гадуурхахаас хэрхэн урьдчилан сэргийлэх, жендэрийн эерэг хандлага хэрхэн төлөвшүүлэх талаар багшийг бэлтгэх, дахин бэлтгэхэд анхаарах
- 8) Сурах бичгийн стандартад жендэрийн шаардлагуудыг тусгах,
- 9) Хөтөлбөрийг болон сурах бичгийг зохиогч, редакторууд, багш нарыг жендэрийн сургалтад хамруулан, ойлголт, хандлагыг өөрчлөх, жендэрт холбогдох үр чадварууд, хандлагыг эзэмшүүлэх,

**Дөрөв. Мэргэжилтнүүдийн ойлголт, хандлагыг өөрчлөх, бэлтгэх чиглэлд:**

- 1) Хөтөлбөр боловсруулагч, сурах бичиг зохиогч, редактор, багш, удирдах ажилтан, мэргэжилтэн, арга зүйчдийн жендэрийн ойлголтыг нэмэгдүүлэх,
- 2) Охид, хөвгүүдийн хэрэгцээ, ялгааг сургалтад хэрхэн харгалзах, тэдгээрт хөгжих адил тэгш боломжийг хэрхэн олгохуйц сурган хүмүүжүүлэх ур чадварт сургах,
- 3) Хүйсийн алагчлалын ойлголт, үйлдлийн төрөл хэлбэр, урьдчилан сэргийлэх боломж, нөхцлийн талаар мэдлэг, чадварыг хөгжүүлэх.
- 4) Боловсрол дахь жендэрийн асуудлыг ялгах, тодруулах, боловсролоор дамжуулан жендэрийн тэгш байдлыг тогтоож буй эсэхэд үнэлэлт өгөх чадамжит нөхцлийг бүрдүүлэх
- 5) Багшийг бэлтгэх, дахин бэлтгэх хөтөлбөрт жендэрт холбогдох хөтөлбөр, модулийг нэвтрүүлэх. Их, дээд сургуулийн багш нарын ойлголт хандлагыг өөрчлөх чиглэлээр ажиллах.

**Тав. Оролцогч талууд болон олон нийтийн жендэрийн ойлголт хандлагыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсрол олгох, суралцах үйл ажиллагаанд охид хөвгүүдийн ялгаатай хэрэгцээ, сонирхолыг анхаарч хөгжүүлэх чиглэлд:**

- 1) Эцэг эхчүүдийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, нөлөөллийн бусад ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна. Сургалт нөлөөллийн ажлын хүрээнд дараах агуулгыг тусгавал зохино. Үүнд:
  - Жендэр, хүйсийн ялгаварлан гадуурхалтын талаарх ойлголт, холбогдох хууль тогтоомжийн агуулга,
  - Хүүхдийн язгуур эрх ашгийг нэгд тавих хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр анхаарч ажиллах шаардлагатай байна. Эцэг эхчүүдийн өрөөсгөл хандлага, хүйсээр ялгаварлах нь охид, хөвгүүдийн чадавхжилтад нөлөөтэй болохыг ойлгуулах,
  - Охид, хөвгүүдийн дүр үүргийн уламжлалт бус сонголтыг дэмжих таатай нөхцөл бүрдүүлэх тухай агуулгыг зайлшгүй тусгах
- 2) Багш бэлтгэх хийгээд багшийг дахин бэлтгэхдээ эрэгтэй багшийг эмэгтэй багшид илэрч буй зан үйл, ур чадвар, арга барилыг төлөвшүүлэхэд анхаарч, багш бэлтгэдэг их дээд сургууль, багшийн мэргэжлийг дээшлүүлэх хөтөлбөрт жендэрийн ялгааг харгалзаж, тооцсон сурган хүмүүжүүлэхүйн талаар Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл анхаарах,
- 3) Суралцах үйл ажиллагаанд жендэрийн ялгаа байгааг судалгааны дүн харуулаад байна. Эцэг эх, багш, сургуулийн удирдах ажилтнууд охид хөвгүүдийн зан төлөвийн ялгаатай байдал, онцлог тэдний сурлагын амжилтад нөлөөлж буйг хэр анхаарч ажилладаг нь анхаарах асуудал мөн. Иймд эцэг эх, багшид чиглэсэн сургалт зохион байгуулах,
  - Ерөнхий боловсролын сургуулиудын багшлах боловсон хүчний хүйсийн тэгш байдлыг хангах хүрээнд цөөнх болж буй хүйсийн төлөөллийг нэмэгдүүлэх тухай холбогдох хуулийн заалтын хэрэгжилтийг сайжруулах,
  - Сургууль завсардалтыг “тодорхойгүй шалтгаанаар” үзүүлэлтээр бүртгэж байгааг салбарын яам болон холбогдох боловсролын институциуд анхаарч сургууль завсардалтын бүртгэлийг боловсронгуй болгох,
- 4) Охид, хөвгүүдийн жендэрийн талаарх ойлголтыг сайжруулах, хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагыг өөрчлөх талаар сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулга, хичээлээс гадуурх үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөлтөд анхаарах,
- 5) Охид, хөвгүүдийн уламжлалт бус дүр үүргийн сонголт, гүйцэтгэлийг дэмжих таатай орчинг бүрдүүлэх.

- 6) Сургуулийн холбогдох баримт бичгүүдэд хүчирхийлэл дарамтын үзэгдэл гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх талаар тодорхой арга хэмжээг тусгах, үлгэрчилсэн зааврыг боловсруулан хүргэх,
- 7) Сурагчид, багш нар, эцэг эхийн жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулах, сургуулийн нийгмийн ажилтныг мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжин ажиллах.
- 8) Олон нийтийн жендэрийн талаарх ойлголт, хандлага, жендэрийн тэгш бус байдлаас үүдэлтэй үр дагаврын талаарх ойлголтыг түгээх,
- 9) Сурагчдад жендэрийн эерэг соёл төлөвшүүлэх үүднээс сургалтын хөтөлбөр, сургуулийн орчны хүчин зүйлсэд анхаарч, зохих өөрчлөлтүүдийг тусгах.
- 10) Тусгай хэрэгцээг харгалзсан тэгш хамран сургах арга зүй, аргачлал, тэр дундаа жендэрийн ялгааг харгалзсан, тооцсон сургалтын арга зүй, аргачлалд сургах

## НОМЗҮЙ

### Хууль, эрх зүйн баримт бичгүүд

1. Боловсролын тухай хууль (2002).
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011).
3. Төрийн албаны тухай хууль (2002).
4. Хөдөлмөрийн тухай хууль (1999).
5. Эрүүл мэндийн тухай хууль (2011).

### Тогтоол, тушаал, дүрэм журмууд

1. Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээг тогтоох тухай. Засгийн газрын 2007 оны 219 дүгээр тогтоол
2. Сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам, БСШУ-ы сайдын 2009 оны 131-р тушаал
3. Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 сарын 15-ны өдрийн А/305 дугаар тушаал
4. Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм. БСШУЯ, 2010.10.25.
5. Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоол
6. Хүүхэд өсвөр үеийнхний сургалт хүмүүжлийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуйн үлгэрчилсэн дүрэм (1995).

### Норм, стандартууд

1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага (2015).
2. MNS ISO 8124. Тоглоомын аюулгүй байдал (2011).
3. MNS 5418:2008. Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичиг тавигдах шаардлага стандарт (2008).
4. БНБД /66-88 стандарт. Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламж барилгын норм ба дүрэм

### Ном, сурах бичиг

1. Алтанзаяа Л, Алтангэрэл Ч, Нэмэхжаргал Т ба бусад (2012). Нийгмийн ухаан III, УБ.
2. Алтанзаяа Л, Алтангэрэл Ч, Нэмэхжаргал Т ба бусад (2014). Нийгмийн ухаан VI, УБ.
3. Олзвой Л. ба бусад (2014) Монгол хэл, УБ.
4. Оюунцэцэг болон бусад (2014) Монгол хэл-I, УБ.
5. Өнөрбаян Ц, Жумдаан Г, Мөнхсайхан Ж (2013) Монгол хэл-6. УБ.
6. Promoting gender equality in education (2009) UNESCO.
7. Энхтогтох А., Баярмаа Г., Батчулуун Ю.болон бусад (2015) Хүн-Орчин-I. УБ.

### Судалгааны тайлан болон бусад мэдээллийн эх сурвалжууд

1. БСШУЯ (2014) Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр, УБ.
2. БСШУЯ (2015) Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр, УБ.
3. БСШУЯ (2012) Ерөнхий боловсролын сургуулийн X-XII ангийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж: Монгол хэл, уран зохиол, монгол бичиг, УБ.

4. БСШУЯ (2012) Ерөнхий боловсролын сургуулийн X-XII ангийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж: Түүх, нийгмийн ухааны сургалтын хөтөлбөр, зөвлөмж, УБ.
5. БСШУЯ (2015) Бага, дунд боловсролын 2014-2015 оны хичээлийн жилийн статистик
6. Монгол улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө
8. НҮБХХ, БСШУЯ (2011) Сургуулийн орчны судалгаа, УБ.
9. Сургалтын цөм хөтөлбөр боловсруулах багийн гишүүдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас, 2016 он 3 сар.
10. Тунгалаг Д. (2015) 7-11-р ангийн сурах бичиг, багшийн номонд жендэр ба орчны шинжилгээний багийн нэгдсэн санал дүгнэлт, зөвлөмж (хэвлэгдээгүй)
11. Цалин хөлсийн бүтцийн судалгаа (2013) Хөдөлмөрийн судалгааны институт (хуучнаар)
12. al, J. S. (2015 ). Transitions to k-12 education systems: experiences from five case countries. АХБ, Mandaluyong City .
13. UNGEI. (u.d.). Why are boys Under-Performance in education?
14. ДБ. (2014). Боловсролын чанарын хувьсгал, Төслийн үнэлгээний баримт бичиг
15. ЮНИСЕФ, С. о. (2014). Сургууль завсардаж буй хүүхдийн судалгаа.
16. ЮНЕСКО. (2015). Transforming our world: the 2030 Agenda for Sustainable Development, General Assembly Resolution.
17. Development, G. C. (u.d.). Social service of suburban areas.
18. ДБ. ЕСА. (2005). Монгол Улс дахь сургууль завсардалт.
19. БҮТ. (2013). Элсэлтийн ерөнхий шалгалтын тайлан. Улаанбаатар.

#### Цахим эх сурвалжууд

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын статистикийн эмхтгэл (2015) /<http://ubstat.mn/>
2. ЕБС төгсөгдчийн 2012-2013 оны тайлан /<http://www.meds.gov.mn/Generaledu-data/>
3. МУЗГ (2013) “Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр”  
/<http://www.legalinfo.mn/annex/details/5962?lawid=9349/>
4. <http://www.csc.gov.mn/faq/40> 2016.06.01
5. <http://www.meds.gov.mn/data/1503/BDB14-15.pdf>
6. <http://www.csc.gov.mn/uploads/SHalgaltZar/2016/0512/1.htm> 2016.06.01
7. <http://www.csc.gov.mn/uploads/SHalgaltZar/2016/0512/4.htm> 2016.06.01
8. <http://www.csc.gov.mn/uploads/SHalgaltZar/2016/0512/6.htm> 2016.06.01
9. (u.d.). Hämtat från <http://www.csc.gov.mn/uploads/SHalgaltZar/2016/0512/4.htm>
10. DA. (2016.06.01). Career selection. Hämtat från <http://www.csc.gov.mn/uploads/SHalgaltZar/2016/0512/4.htm>  
MEDS. (2016.06.01). Statistical data on Education . Hämtat från <http://www.meds.gov.mn/data/1503/BDB14-15.pdf>



# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ ТӨСЛИЙН ҮНДСЭН ЗОРИЛГО

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ МОНГОЛ УЛСЫН ЕБС-ИЙН СИСТЕМД НЭВТРҮҮЛЖ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА НОГООН ХӨГЖЛИЙН ТААТАЙ (ИНСТИТУЦИЙН, ЭРХ ЗҮЙН, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН) ОРЧИНГ БҮРДҮҮЛНЭ.

## БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1

ТХБ-ын үзэл санааг ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгаж, шинэчлэх

## БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2

Олон нийт болон шийдвэр гаргагч нарт тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн тухай мэдээлэл, мэдлэг, үзэл санааг хүргэж, төсөлд хамрагдсан аж ахуйн нэгж, компани, байгууллагуудад байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ISO 14001 баталгаажуулалт хийлгэнэ

### ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

Стандарт, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулж хэвлүүлсэн байна.

Ажиллаж буй болон шинэ багш нарыг сургалтанд хамруулж, тогтвортой хөгжлийн боловсролын агуулга тусгасан сургалт явуулах чадавхи эзэмшсэн байна.

Сургуулийн удирдлага болон үнэлгээний тогтолцоонд ТХБ-ыг нэвтрүүлэхэд сургуулиудыг дэмжинэ.

Тогтвортой хөгжлийн боловсролын сүлжээ байгуулах, үйл ажиллагааг нь идэвхижүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Сургууль, орон нутаг хамтран хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээг дэмжинэ.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн тухай мэдээллийг олон нийтэд хүргэж, ойлгуулна.

Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн талаарх сургалтыг шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд, хувийн хэвшил болон олон нийтэд зориулан зохион байгуулна.

Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн шинэлэг туршлага бүхий төсөл, төвүүд, эко сургуулиудыг сонгон үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.

Байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор зарим компани, байгууллагуудыг сургалтанд хамруулах, ISO 14001 баталгаажуулалт хийлгэхэд дэмжлэг үзүүлнэ.

### ТӨСЛИЙН ТУХАЙ

**ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:** 2015-2017 он (1-р үе шат)

**ТӨСЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ:** Монгол Улс

#### САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам  
Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам  
Швейцарийн Хөгжлийн Агентлаг (SDC)

**ЗОРИЛТОТ БҮЛЭГ:** Сурагчид, багш нар, эцэг эхчүүд, олон нийт, их дээд сургуулиуд, төр болон иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил

#### ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)  
Упсала Их Сургууль (UU)  
Боловсролын Олон Улсын Хамтын Ажиллагааны Хүрээлэн (IZB)

#### ХОЛБОО БАРИХ:

- Др (Ph.D.) Ц.Алтанбат, Төслийн мэргэжилтэн (Бүрэлдэхүүн хэсэг 1)  
e-mail: tsedevsuren.altanbat@giz.de
- Д.Одонхүү, Төслийн мэргэжилтэн (Бүрэлдэхүүн хэсэг 2)  
e-mail: daria.odonkhuu@giz.de
- А.Энхжаргал, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн  
e-mail: avid.enkhjargal@giz.de

## Тогтвортой Хөгжлийн Боловсрол төслийн хаяг:

Мидтаун оффис, 4-р давхар  
Энх тайвны өргөн чөлөө 15/2,  
Олимпийн гудамж, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар хот, Монгол улс



+976 75770989



[avid.enkhjargal@giz.de](mailto:avid.enkhjargal@giz.de)

